

# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

2024 оны хагас жил /өссөн дүнгээр/

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2024 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
<b>1. "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого</b>							
1	1.1.1. "Ковид-19" халдварт цар тахал, шинэ болон дахин сэргэж байгаа халдвараа урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэврийн дэглэм, эрүүл мэндийн сургалт сурталчилгааг зохион байгуулах	2021 - 2024	-	80/4500	<p>Аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад ХАБЭА тухай хуулийн хэрэгжилтэнд үнэлгээ хийхэд хүний нөөцийн дутмаг байдлаас эмч, мэргэжилтнүүд 2-3 ажил давхар хариуцсанаас ажлын ачаалал их, аюулгүй ажиллагааны өдөр тутмын зааварчилгааг тогтмол өгдөггүй, ХАБЭА дотоод журамгүй, химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэлгүй гэх мэт нийтлэг зөрчлүүд илэрсэн.</p> <p>Илэрсэн зөрчлүүдийг арилгуулахаар "MNS 4969:2000", "MNS 6231:2011", "MNS 6392:2013" стандартуудыг баримталж ажиллах, ажлын байрны орчин, аюулгүй байдлыг сайжруулах, ХАБЭА-тай холбоотой баримт бичгийг бүрдүүлэх зөвлөмж өгснөөр 2020 онтой харьцуулахад 2024 оны хагас жилийн үнэлгээгээр хэрэгжилт 80,9% болж, 18,4%-иар нэмэгдэж, үйл ажиллагаанд ахиц гарсан байна.</p> <p>Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн хороо, ХАБЭА-н зөвлөлтэй хамтран Эрүүл мэндийн байгууллагуудын ХАБЭА хариуцсан ажилтан, удирдлагуудад ХАБЭА-н мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулж, 53 хүн хамруулж, 12 албан хаагчдыг ХАБ-ын мэргэжлийн сургалтаар гэрчилгээжүүлсэн. Эрүүл мэндийн байгууллагуудын үйлчлэгч, асрагч 28 ажилчдад ХАБЭА тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зөвлөмж мэдээллийг өгч, ажлын байрны аюул эрсдэл, хэрхэн аюулгүй ажиллах талаарх мэдлэгийг эзэмшүүлснээр ажилчдын ажлын байрандаа хэрэгжүүлэн ажиллах эрх зүйн мэдлэг дээшилсэн.</p> <p>Төрийн өмчийн 20 эрүүл мэндийн байгууллага 2021-2024 оны хугацаанд эрүүл ахуй, ариун цэврийн дэглэмийн талаарх нийт 26 удаагийн сургалт, сурталчилгааг албан байгууллага, аж, ахуйн нэгж, иргэдэд хийж давхардсан тоогоор 8103 хүнийг</p>	100%

					<p>хамруулснаар эрүүл мэндийн боловсрол дээшилж, байгууллага бүр ХАБЭА хариуцсан ажилтантай болж, 60% нь сургалтад хамрагдаж чадавхжсанаар байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдлын үйл ажиллагаанд ахиц гарсан.</p> <p>Орчны эрүүл мэнд арга хэмжээний хүрээнд ЭМБ-ууд тайлант хугацаанд нийт 48 удаагийн сургалтаар 1804 иргэн, 189 удаагийн сурталчилгаанд 6243 иргэнийг хамруулж, 134 төрлийн гарын авлагыг шинээр хэвлүүлэн 3820 хүнд тарааж, цахимаар 270 төрлийн зөвлөмж мэдээлэл түгээснээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ээлтэй орчин бүрдэж, эрсдэл буурсан.</p>	
2	2. Шинэ болон дахин сэргэж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг иргэд, олон нийт болон мэргэжлийн байгууллагуудад зохион байгуулж, шаардлагатай дадлыг хэвшүүлж, чадавхжуулах	2021 2024	-	250	<p>“Ковид-19” халдварт цар тахал, шинэ болон дахин сэргэж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор сумдын тандалт судалгааны багийн гишүүдийг 1 удаа цахимаар, 8 сумын тандалт хариу арга хэмжээний багийн ажилтай газар дээр нь танилцаж, эрсдлийн үнэлгээ хийх арга зүйд сургаж, үнэлгээг хийж, “НЭМ ба Ковид”, “Багийн эмч нарыг чадавхжуулах сургалт”, “Тандалтын багийн гишүүдийг чадавхижуулах сургалт”-уудыг танхимаар зохион байгуулж, “Халдварын тандалт судалгааны багийн үйл ажиллагаа, ажиллах аргачлал, хавьтал илрүүлэлт, мэдээ мэдээлэл дамжуулалт” сэдвийн хүрээнд 120 хүнийг чадавхжуулсан.</p> <p>Халдварын нөхцөл байдал хүндэрсэн үеэр ТУТ-ны 4 багийг идэвхжүүлж, “Тандалт судалгааны баг”-ийг өргөтгөн, шинээр байгуулж, цахим болон танхимаар 3 удаагийн сургалтад 64 мэргэжилтэнг хамруулж, ХӨСҮТ-ийн тархвар судлаачаар арга зүйн зөвлөгөөг өгүүлснээр багуудын чадавх нэмэгдсэн.</p> <p>Тандалт хариу арга хэмжээг чадавхжуулах нарийн мэргэжлийн чиглэлээрх 6 төрлийн сургалтуудыг халдвар хамгааллын дэглэмийн дагуу танхим болон онлайн хэлбэрээр зохион байгуулан давхардсан тоогоор 320 гаруй эмч мэргэжилтэнг хамруулан чадавхжуулж, нийт 45.1 сая төгрөгийн төсөв зарцуулсан.</p> <p>Цар тахлаас сэргийлэх чиглэлээр 45 байгууллага, аж ахуйн нэгжүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж, хичээл сургууль эхлэхтэй холбогдуулан давхардсан тоогоор сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, эмч, багш нийт 140 хүнийг халдвар хамгаалал, дархлаажуулалтын чиглэлээр сургалтад хамруулж, арга зүйгээр хангасан байна.</p>	100%

						Аймгийн хэмжээнд 2024 онд коронавирусийн халдварын 8 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 1.1 болж 2021 оноос 2881.5-аар халдвар буурсан.	
3		3. Сургалтын байгууллагын багш нарын цахим хичээл боловсруулах арга зүйн сургалт зохион байгуулж, үр нөлөөг дээшлүүлэх.	2021 2024	-	2	<p>Цахим хичээл боловсруулах чиглэлээр 20 судлагдахуунаар 2941 удаагийн теле хичээл үзэж, улсын шилдэг багш нарын арга зүйгээс суралцсан ба 21 сургууль, 42 цэцэрлэгийн нийт 867 багш мэдээллийн технологи ашиглан 779 цахим хичээл бэлтгэн сурагчдынхаа мэдлэг, чадварыг бататгаж, бусад багш нартаа туршлагаа түгээсэн. “Сургалтын хоцрогдлыг нөхөх арилгахад дэмжлэг үзүүлэх”, “Бага ангийн сурагчдын математик чадварыг хөгжүүлэх арга зүй” цахим сургалтыг нийт багш нарт зохион байгуулж, “Цахим сургалтыг шинэлэг аргаар зохион байгуулж байгаа багш нарын арга зүй, туршлага”, “Бүтээлч багш” цахим уралдааныг зохион байгуулж, шилдэг 20 багшийн хичээлийг цахим хуудсанд байршуулан, сурталчилсан.</p> <p>Багш нарын цахим хичээл боловсруулах арга зүйн 7 чиглэлийн сургалтад ЕБ-ын 21 сургууль, 36 цэцэрлэгийн 1861 багш. удирдах ажилтныг бүрэн хамруулав.</p> <p>Medle.mn системийн "Ээлжит хичээлийн цахим контент" санд 5 судлагдахууны 41 цагийн ээлжит хичээл байршууллаа. Багш нарын тасралтгүй хөгжлийг дэмжих зорилгоор "Aplus" платформд байршуулсан 111 модульд цахимаар суралцахад 123.7 сая төгрөг зарцуулж, ЕБ-ын 717, СӨБ-ын 395 багш ажлын байран дээрээ хөгжих боломжоор хангалаа.</p> <p>"Цахим контент" боловсруулах 7 жишиг танхимыг 133.0 сая төгрөгийн өртгөөр БШУГ болон 2 сургууль, 4 цэцэрлэгт байгуулав.</p> <p>Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны цахим хичээл боловсруулах арга зүйг нэмэгдүүлэх чиглэлээр арга зүйн 18 сургалт зохион байгуулж, 1356 багш, нийгмийн ажилтан, удирдах ажилтан, албан хаагч хамрагдлаа. 2022 онд 27 модуль сургалтад 395 удирдах ажилтан багш нар хамрагдсан бол 2023 онд 35 модуль сургалтад 231 удирдах ажилтан багш нар хамрагдаж мэргэжил арга зүйгээ дээшлүүлсэн.</p> <p>Тайлант оны эхний хагаст Medle цахим сургуульд 6 багш багшилж, үндсэн болон модуль сургалтад 950 багш, удирдах ажилтан цахимаар хамрагдсан.</p>	100%
4		4. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдварын чиглэлээр хяналт шинжилгээ, тандалт	2021 2024	-	250	Аймгийн Засаг даргын 2021 оны А/470 дүгээр захирамжаар Гамшиг эрсдэлийн үеийн Тохиолдлын удирдлагын тогтолцооны 4 багийг Эрүүл мэнд, Цагдаа, МХГ, Тагнуулын байгууллагуудын төлөөлөлтэй томилон ажиллуулснаар салбар дундын хамтын	100%

		судалгаа, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх			<p>ажиллагаа, уялдаа холбоо сайжирч, арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхэд үр дүнтэй ахиц гарсан.</p> <p>2022 онд ЭМС-ийн А/36 тушаал шийдвэрийн хүрээнд Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа, хариу арга хэмжээ, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах 11 албан бичгийг төр хувийн хэвшлийн 66 ЭМБ-уудад хүргүүлж, арга зүйгээр хангаж ажилласнаар халдварын эрсдэлийг хүндрэл багатайгаар даван туулсан.</p> <p>Коронавируст халдварын Омикрон хувилбарын дэгдэлтийн үед эрдсэл өндөр 3 сумын Онцгой комиссийн гишүүд, 70 хүнд Ковид-19 халдварын цар тахлаас сэргийлэх, тандалт хариу арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр арга зүйн зөвлөгөөг өгч, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн, Ханги боомтын 400 жолоочид лабораторит суурилсан PCR хувилбар тогтоох тандалт хийж, цаг үеийн оновчтой шийдвэрүүдийг цаг тухай бүрт ТУТ-ын багаар гарган, хариу арга хэмжээг авч ажилласнаар халдварын тохиолдол эрчимтэй буурч, багийн үйл ажиллагаанууд чадавхжсан.</p> <p>ЭМГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 8 ЭМБ-д дэмжлэгт хяналтыг хийж арга зүйгээр ханган, зөвлөмжүүдийг хүргүүлэн хэрэгжилтийг эргэн шалгаж, алдаа зөрчлийг арилгуулан сайжруулах арга хэмжээг цаг тухай бүрт авч, үүрэг чиглэл өгснөөр тусламжийн чанарт ахиц гарч халдварын тархалт буурсан.</p> <p>2023 онд халдвараас сэргийлэлт, хяналтын чиглэлээр 5 сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалтуудыг хийж, эрсдлийг үнэлэн, зөрчил дутагдал илрүүлж, зөвлөмж өгч, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх талаар сургалт болон зөвлөн туслах үйлчилгээг сайжруулж коронавируст халдварын тохиолдол 2024 онд 8 бүртгэгдсэн нь 2020 онтой харьцуулахад 76.4%-иар буурч, “Ковид-19 цар тахлаас эрүүл мэндийн салбар олон сургамжийг авч, тусламж үйлчилгээний чадавх сайжирч, иргэдийн халдварт өвчнөөс сэргийлэх мэдлэг дадал нэмэгдсэн.</p>	
5		5. Зорилтод бүлгийн хүүхдүүдийг томуугийн вакцинд хамруулах	2021 - 2024	600	<p>Томуу, томуу төст өвчний халдварын дэгдэлт, бага насны хүүхдийн томуугийн халдвар, уушгины хатгалгаанаас сэргийлэх зорилгоор 2021 оноос жил бүр 0-12 насны хүүхдүүдийн дунд томуугийн эсрэг дархлаажуулалтыг уламжлал болгон хийж, санхүүжилтийг орон нутгийн нөөц хөрөнгөөс шийдвэрлэж хэвшсэнээр томуугийн шалтгаанаар эндэх хүүхдийн тоо буурсан.</p>	100%

					<p>Тайлант онуудад ЭМЯ, ХӨСҮТ-ээс 2021-2023 онуудад хийгдэх 328,7 сая төгрөгийн 24500 хүн тун, Орон нутгийн төсвөөс 2021-2022 онуудад 62,2 сая төгрөгийн 1700 хүн тун томуугийн вакцины санхүүжилтийг шийдвэрлүүлж, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хуваарилж, эрсдэлт бүлгийн хүн амыг хамруулах чиглэл өгснөөр 2021-2023 онуудад томуугийн дархлаажуулалтад нийт өссөн дүнгээр 23234 хүнийг хамруулж, хамралтыг 90,4%-д хүргэсэн. Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/358 дугаар тушаалаар 2023-2024 оны улирлын томууг угтуулан хийгдэх Солонгос улсын Грийн кросс үйлдвэрийн томуугийн эсрэг 4 цэнт вакциныг 5660 зорилтот бүлгийн хүн амыг дархлаажуулахаар татан авч, дархлаажуулалтын 19 нэгжээр зохион байгуулж, хамрагдвал зохих 2-5 насны 4595 хүүхдийн 2862 буюу 62,3%-ийг үнэ төлбөргүй дархлаажуулсан. Томуугийн дархлаажуулалтад хамрагдсан хүний 61,8%-ийг 1-12 насны хүүхэд эзлэж, томуугийн А болон В хүрээний вирусээр үүсгэгдсэн томуугаар хүүхэд өвчлөх, хүндрэх эрсдэлийг 35,6%-иар бууруулсан.</p> <p>Үүний үр дүнд 2020 онтой харьцуулахад 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлд уушгины хатгалгаа, сэргийлж болох эндэгдлийн шалтгаант нас баралт 26,7 хувиар буурсан үр дүнтэй байна.</p>	
6	6. Цэвэрлэх байгууламжийн эрүүл ахуйн аюулгүй бүсийг бий болгож, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ авах, хөрсний хяналт шинжилгээ хийх	2021 - 2024	30	<p>Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН3388/3713 төсөл”-ийн хүрээнд хоногт 3000м3 бохир ус хүлээн авах хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн угсралтын ажлыг улсын төсвийн 6350.8 сая төгрөгийн төсөвт өртгөөр “Компорт импекс” ХХК гүйцэтгэж, 2022 оны 07 сард барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан. Тус цэвэрлэх байгууламж нь механик, биологи, гүйцэд цэвэрлэгээний технологитой ба цэвэрлэгдсэн усыг цэцэрлэг, зүлэгжүүлэлт, зам талбай, хөрсний усалгаанд ашиглахад зориулагдсан цооногтой ба эргэн тойрон хэсэгт эрүүл ахуйн аюулгүй бүсийг үүсгэсэн.</p> <p>Мөн цэвэрлэгээний явцад гарсан лагийг боловсруулж бордоо, түлш гаргах тоног төхөөрөмжтэй жишиг байгууламжтай болсон. Үүний дүнд хөрсний бохирдол үүсэх эрсдэл буурч, цэвэрлэх байгууламжаас гарсан хаягдал усыг дахин ашиглах боломж бүрдээд байна.</p> <p>Орон нутгаас цэвэрлэх байгууламжийн эрүүл ахуйн бүсийг тогтоон мөрдүүлэх, ойр орчмын газрын хөрснөөс дээж авч</p>	90%	

					<p>итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэхээр бэлтгэл хангагдаж байна.</p> <p>Дорноговь аймаг, Япон улсын Шизоүка муж хоорондын хамтын ажиллагааны хүрээнд саарал усыг дахин ашиглах боломж, инженер техникийн ажилчдыг бэлтгэх, сургаж дадлагажуулах, туршлага судлуулах арга хэмжээг цахим болон танхимаар 6 удаа зохион байгуулж, 113 хүнийг хамруулж чадавхжуулав.</p> <p>Цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдээд гарч буй хаягдал ус нь MNS 4943:2015 стандартын шаардлага буюу ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэлтээс хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрэхгүй байгааг лабораторийн шинжилгээгээр тогтоосон байна.</p>	
7		7. Ундны усны эх үүсвэрийг бохирдлоос хамгаалах	2021 - 2024	40	<p>Эрүүл мэндийн яамны санаачилга, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр аймгийн "Ус, ариун цэврийн аюулгүй байдлыг ханган ажиллах нэгдсэн жишиг төлөвлөгөө" боловсруулагдсан.</p> <p>Сав газрын захиргаанаас усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуй бүс, ус хангамжийн эх үүсвэрүүдийн тэжээгдлийн мужийн зааг, зураглал, холбогдох мэдээлэл, судалгааг шинэчлэн тогтоож хамгаалалтад авах шаардлагатай газрын судалгааг гаргаж, 13 сумдын нутагт 69 булаг, 84 нуур тойром, 1 гол ашигт малтмалын ашиглалтын 27, хайгуулын 40 тусгай зөвшөөрлийн талбайтай давхцалтай байгаа компаниудад онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийн зааг, эдгээр бүсэд мөрдөх дэглэмийг хүргүүлж, хяналт тавьж байна.</p> <p>2021 онд "Чандмань илч ХХК инженерийн шугам сүлжээний гүн өрмийн 1 худаг, шугам сүлжээнээс салбарласан 2 ухаалаг худагт цэвэршүүлэх төхөөрөмж, 2022 онд Алтанширээ суманд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар "Чандмань-Илч" ОНӨХХК-ийн салбарын цэвэр усны шугам хоолойд 200,0 сая төгрөгөөр цэвэршүүлэх төхөөрөмж, Мандах суманд 2 цэгт ухаалаг худгийг 120,0 сая төгрөгөөр барьж ашиглалтад оруулсан.</p> <p>Эрдэнэ сум 2023 оны орон нутгийн хөгжлийн сангийн 100 сая төгрөгөөр төвийн 3 ус түгээх цэгт цэвэршүүлэх төхөөрөмж, Хатанбулаг сумын төвлөрсөн усан хангамжийн усан сангийн хамгаалалтыг сайжруулж, ундны ус түгээх 2 байр, 2 гүний</p>	100%

					<p>худгийн эх үүсвэрийг байшин барьж ундны усны эх үүсвэрийг бохирдлоос хамгаалах арга хэмжээг тус тус хэрэгжүүлж ажиллалаа.</p> <p>2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 1 худагт ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах ажлын гэрээг "Актив инженеринг" ХХК-тай 19,5 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлэхээр гэрээг байгуулсан байна. Сумын төвүүдийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг 10 худагт шинээр тогтоон хашаажуулж, тэмдэгжүүлэх ажил 100% хийгдсэн. өвчнөөс урьдчилан сэргийлэх, усны аюулгүй байдлыг хангах зорилгоор 14 сумын унд ахуйн хэрэглээний давхардсан тоогоор 95 цэгээс дээж авч, Мэргэжлийн лабораторид 82, Улаанбаатар хотын Геологийн төв лабораторид 6 дээж, "Ханлаб" лабораторид 7 дээжийг шинжлүүлсэн.</p> <p>Сайншанд, Замын-Үүд, Айраг сумдын ЕБ-ын 9 сургууль, 20 цэцэрлэгийн унд ахуйн хэрэглээний уснаас 54 сорьц авч, Мэргэжлийн хяналтын газрын сорилт шинжилгээний лаборатортид шинжлүүлж, шаардлага хангаагүй 2 ундны усыг илрүүлж, 11 дүгнэлт, 8 зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>Сумдад усны сан бүхий газар ус хангамжийн эх үүсвэрүүдийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, түүний ойр орчмын газрын хог хаягдлыг цэвэрлэх ажилд 200 ААНБ, 3500 иргэн, ажилтан, албан хаагчид оролцон 2500,0 га талбайн ахуйн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 29 автомашин техник хэрэгслээр 470,0 тн хог хаягдлыг цэвэрлэж эх үүсвэрийг бохирдохоос сэргийлсэн.</p>	
8		8. Сургуулийн багш, сурагч, ажилтнуудыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулах	2021 - 2024	0.9	<p>Сургууль, цэцэрлэгийн 1250 багш ажилтан, 12334 суралцагч эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамрагдсан. ЭМС-ын 2017 оны 145 тушаалын дагуу 2022 онд 36 цэцэрлэг, 21 сургуулийн үзлэгт хамрагдвал зохих албан тушаалын буюу 778 багш, ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 100% хамруулсан.</p> <p>Мөн 21 сургууль, 42 цэцэрлэгийн 9445 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж эмгэг өөрчлөлттэй 4759 /50.3%/ хүүхдийг илрүүлж 46.7%-ийг эрүүлжүүлжээ.</p> <p>2023 онд ЭМСайдын 2017 оны А/145 дугаар тушаалын дагуу урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд цэцэрлэгийн 482 багш ажилтан, ЕБС-ийн бага ангийн 300 багш, ажилтан, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 10640 сурагч хамрагдсан.</p>	100%

					<p>БШУСайд, ЭМСайдын хамтарсан “Багшийн эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2022 оны А/238, А/340 дугаар тушаал, БШУС-ын “Заавар батлах тухай” А/259 дугаар тушаалаар 4 багц үзлэгт сургууль цэцэрлэгийн 6 албан тушаалтаныг хамрагдахаар батлагдсаны дагуу урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог 2023 оны 08 сард аймгийн нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын эмнэлэгтэй хамтран зохион байгуулж ЕБС-ийн 627, цэцэрлэгийн 511, нийт 1138 багш ажилчид хамрагдсан.</p> <p>Үүнээс хеликобактерийн шинжилгээнд 682 хүн хамрагдаж 93 буюу 13.6% нь эерэг, бамбайн дааврын шинжилгээнд 119 хүн хамрагдаж 6.7% нь өөрчлөлттэй, дууны хөвчийн дурангийн үзлэгт 47 хүн хамрагдсанаас 100% өөрчлөлтгүй гарсан байна.</p> <p>2024-2025 оны хичээлийн жилийн эрүүл мэндийн үзлэгийг 2024 оны 08-09 сард багтаан зохион байгуулна.</p>		
9	1.1.2. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана.	9. Эрүүл мэндийн байгууллагуудын хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэх	2021 - 2024		0.1	<p>Эрүүл мэндийн байгууллагууд Коронавируст халдварын үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийн мэдээллийг "burtgel.mohs.mn", "Google drive" зэрэг программд 7 хоног бүр тогтмол оруулж, эрүүл мэндийн газар болон эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нөөцийн бэлэн байдалд хяналт тавьж, нөөц багассан эм, эмнэлгийн хэрэгслийн хугацааг алдалгүй бүрдүүлж, улсын хэмжээнд тасалдал үүсээд байсан "Окситоцин" эмийг 3 удаагийн татан авалтаар 1570 ширхэгийг авч эмнэлгийн тусламж үйлчилгээнд тасалдал үүсгэлгүй ажилласан.</p> <p>Мөн ЭМС-ын тушаал, ЭМГ-ын гамшгийн нөөц хөрөнгөөс 18 эрүүл мэндийн байгууллагуудад "Ковид 19" илрүүлэх түргэвчилсэн оношлуур, хросол, амьсгалын багтаамж хэмжих тоног төхөөрөмж нийт 165 сая төгрөгийн эм, багаж, тоног төхөөрөмжийг хуваарилж нөөцийг нэмэгдүүлэн, ЭМБ-ууд Коронавируст халдварын үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн 2-3 сарын нөөцтэй байна.</p>	100%
10		10. Сайншанд суманд зоонозын өвчин судлалын тандалтын нэгж байгуулах	2021 - 2024		2	<p>Монгол улсын Засгийн газрын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Зоонозын төвгүй аймгуудыг төвтэй болгох зорилгоор МУ-ын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/18 дугаар тушаалаар 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад 26,0 сая төгрөг тусгаж, Хүн амын суурьшил ихтэй Сайншанд сумын төвдөө “Зоонозын төв”-ийг байгуулах чиглэл ирсэн. Үүний дагуу Дорноговь аймгийн</p>	50%

					<p>Сайншанд сумын 2-р багт "Зоонозын төв" байгуулах чиглэл ирж, Зоонозын төв байгуулах барилгын газрыг орон нутгийн "Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөө"-нд тусгуулж, Эрүүл мэндийн яамруу "Батлагдсан нэг маягийн зураг"-т холболтыг зургийн даалгавар хүргүүлснээр барилгын зураг төслийг 2024 онд багтаан хийж, 2025 онд барилгын үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөж байна.</p> <p>Сайншанд суманд –"Зоонозын төв"-ийг байгуулснаар Замын үүд, Ханги хилийн боомтуудад "Зоонозын тандалтын нэгж"-үүдийг салбарлан байгуулахаар төлөвлөж, ЭМГ-т Зооноз хариуцсан нарийн мэргэжлийн эмчийг сургаж, хүний нөөцийг бэлтгэсэн.</p> <p>Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн Эмгэг судлалын лабораторид тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл худалдан авч, үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 182.0 сая төгрөгийг тусгуулсан.</p>	
11		11. Сайншанд сум болон Ханги хилийн боомтыг РТ-ПСР оношлуулаар хангах	2021 - 2024	300	<p>Халдварт өвчин судлалын үндэсний төвийн нэгдсэн лабораторийн баг аймгийн Нэгдсэн эмнэлгийн лабораторийн үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийж, 12 эмч мэргэжилтнүүдийг ажлын байрны сургалтад хамруулж, арга зүйгээр ханган ажилласнаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн молекул биологийн лаборатори нь "Бүсийн лавлагаа лаборатори" болж, олон төрлийн томуугийн вирус илрүүлэх шинжилгээг орон нутагтаа хийх боломжтой болсон.</p> <p>Аймгийн болон Замын Үүд сумын Нэгдсэн эмнэлэгт нийт 107,8 сая төгрөгийн лабораторийн оношлуурыг худалдан авч, нөөцийг жил бүрийн хэрэгцээнд тулгуурлан бүрдүүлж, хүлээгдэл тасалдал үүсгэхгүй байхад анхааран ажиллаж байна. Орон нутгийн төсвийн 121,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ханги хилийн боомтод "Молекул биологийн лаборатори"-ийг байгуулахаар дагалдах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тендер шалгаруулалтад "Медбуян ХХК" шалгарч 23 нэр төрлийн 70 ширхэг тоног төхөөрөмжийг нийлүүлж, тоног, төхөөрөмжийг ажиллуулах сургалтыг зохион байгуулан хүлээлгэн өгсөн.</p> <p>Одоогоор Ханги боомтод ПСР-ийн шинжилгээ хийгдээгүй бөгөөд тандалтын зорилгоор Хатанбулаг сумын Ханги, Замын-үүд сумын хилийн боомтын ажилчид, оршин суугч, хилээр нэвтрэх явган зорчигч, автобусны жолооч нараас 14 хоногт 1 удаа түүврийн аргаар 160 хамар залгиурын сорьцыг авч</p>	100%

					ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораторид хувилбарын тандалтад илгээж, лабораторид суурилсан тандалтыг тасралтгүй үргэлжлүүлж халдвар зөөвөрлөгдөхөөс сэргийлж ажилласнаар Ковидын халдварын тархалт, хүндрэл бүртгэгдээгүй байна.	
12		12. Шуурхай арга хэмжээний хамтарсан багийг чадавхжуулан, ажиллах нөхцөл, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах	2021 - 2024	2/68	<p>Аймгийн Засаг даргын 2021 оны А/470 дүгээр захирамжаар Гамшиг эрсдэлийн үеийн Тохиолдлын удирдлагын тогтолцооны 4 багийг Эрүүл мэнд, Цагдаа, МХГ, Тагнуулын байгууллагуудын төлөөлөлтэй томилон ажиллуулснаар салбар дундын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сайжирч, арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх маш үр дүнтэй байв.</p> <p>Сумдын тандалт судалгааны багийн гишүүдийг 2 удаа цахимаар, 8 сумын тандалт хариу арга хэмжээний багийн ажилтай газар дээр нь танилцаж, эрсдлийн үнэлгээ хийх арга зүйд сургаж, үнэлгээг хийлгэж, “НЭМ ба Ковид”, “Багийн эмч нарыг чадавхижуулах сургалт”, “Тандалтын багийн гишүүдийг чадавхижуулах сургалт”-уудыг танхимаар зохион байгуулж, “Халдварын тандалт судалгааны багийн үйл ажиллагаа, ажиллах аргачлал, хавьтал илрүүлэлт, мэдээ мэдээлэл дамжуулалт” сэдвийн хүрээнд 120 хүнийг арга зүйгээр хангаж чадавхжуулав.</p> <p>Халдварын тархалтын байдалтай уялдуулан аймгийн “Шуурхай штаб”-ын нэгдсэн ажиллагааг татан буулгаж байгууллагын хүрээнд хуваарийн дагуу Хариуцлагатай жижүүрийг томилгоожуулан ажиллуулж холбогдох мэдээллүүдийг цуглуулан, аймгийн ОК, ЭМЯ, ЭМХТ-ийг мэдээллээр шуурхай хангаж ажилласан.</p> <p>Аймгийн түвшинд “Томуугийн цар тахлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний чиглэл”-ээр хэлэлцүүлэг, ширээний дасгал сургуулилт зохион байгуулан, томуугийн цар тахлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, жишиг төлөвлөгөө гаргах зорилгоор ХӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт судалгааны баг сургалт зохион байгуулав.</p> <p>Тус сургалтад ЭМГ, АНЭ, ЗҮНЭ, ӨСЭМТ, БШУГ, ОБГ, МЭГ зэрэг байгууллагуудын нийт 17 мэргэжилтнүүд хамрагдаж, салбар хоорондын төлөвлөгөөг гаргаж, ажлын уялдаа холбоог сайжруулж ажилласнаар төлөвлөлтийг оновчтой болгож, хамтын ажиллагааны үр дүнд халдварын тохиолдол 2024 онд 8</p>	100%

					бүртгэгдсэн нь 2020 онтой харьцуулахад 76.4%-иар бууруулсан байна.	
13	1.1.3. “Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ	13. Орон нутгийн төсвийн нөөц сангийн санхүүжилтийг нэмэгдүүлэх	2021 - 2024	-	<p>Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т заасны дагуу Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн төсөвт 50.0 сая төгрөг, аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд зарцуулахаар орон нутгийн төсөвт өмнөх жилээс 2 дахин их буюу 1,2 тэрбум төгрөг тусган 655,8 сая төгрөг буюу 54 хувийг зориулалтын дагуу зарцуулжээ.</p> <p>Аймгийн Засаг даргын 2023 оны А/146 дугаар захирамжаар гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулахад 15.9 сая төгрөгийг орон нутгийн төсвийн нөөц хөрөнгөөс зарцуулсан байна.</p> <p>Онцгой байдлын ерөнхий газар, БНСУ-ын Сөүл хотын Гал, гамшгийн удирдах газрын хамтын ажиллагааны хүрээнд тус улсын “Good Neighbors International” олон улсын ТББ-аас буцалтгүй тусламжаар Онцгой байдлын газарт хуваарилсан түргэн тусламжийн "Старекс" маркийн автомашины гаалийн нэмэгдсэн өртгийн албан татвар, бусад холбогдох төлбөр хураамжийн зардал болох 938.2 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын 2023 оны А/236 дугаар захирамжаар шийдвэрлүүлсэн байна.</p> <p>Аймгийн орон нутгийн төсөвт 2020 онд орон нутгийн нөөц хөрөнгийн зардлыг 750,0 сая төгрөг төлөвлөж байсан бол 2024 онд 1,0 тэрбум төгрөг төлөвлөж 250,0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.</p>	100%
14		14. Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах зардлыг төсөвт тусгах	2021 - 2024	350 сая	<p>Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т заасны дагуу Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн төсөвт 50.0 сая төгрөг, орон нутгийн төсөвт гамшгаас хамгаалах зардал 1.2 тэрбум төгрөгийг тусган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан нь өмнөх онтой харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Иххэт, Даланжаргалан, Айраг сумдад гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургуулийг 2023 оны 04, 09 дүгээр сард, Алтанширээ суманд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг 04 дүгээр сард, Улаанбадрах суманд Команд штабын сургуулийг 04 дүгээр сард тус тус зохион байгуулсан.</p> <p>Гамшгаас хамгаалах дадлага, сургуульд дээрх 5 сумын Онцгой комисс, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн 329</p>	100%

					<p>томилгоот бүрэлдэхүүн, 594 иргэн, 71 техник хэрэгсэлтэйгээр ажиллан ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, аж ахуй нэгж, байгууллагын удирдлагын зүгээс сургуулийн бэлтгэл ажлыг сайн хангасан, нөөц бүрдүүлэлт, гамшгаас хамгаалах бүтээлч ажил, санал санаачлагыг харгалзан үзэж шалгасан.</p> <p>Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшигтай тэмцэх чадавхыг дээшлүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны А/146 дугаар захирамжаар “Гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах”-д 15,9 сая төгрөгийг шийдвэрлэж зарцуулсан байна.</p> <p>Орон нутгийн 2024 оны төсөвт гамшгаас хамгаалах зардалд 2,0 тэрбум төгрөг төлөвлөж гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хүн, малын гоц халдварт өвчин, байгалийн гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах нөхцөл боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Энэ нь 2020 онтой харьцуулахад 13,3 дахин их буюу 1,85 сая төгрөгөөр нэмэгдсэн.</p>	
15		15. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулах шинэчлэн барьж, ашиглалтад оруулах	2021 - 2024	-	<p>Ковид-19 халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021 онд Сайншанд сумын 3 дугаар багт "Тотал дистрибушин" ХХК-ийн хөрөнгө оруулалтаар хүнсний агуулахын барилгыг ашиглалтад хүлээн авсан.</p> <p>Энэхүү агуулах нь 750мкв талбайтай, 60 гаруй нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан нөхцөлд нөөцлөж, Дорноговь аймгийн хүн амын хүнсний хэрэгцээг тасралтгүй хангаж байна.</p> <p>Цаашид нийтийг хамарсан цар тахлын үед эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийг бүрдүүлэх боломжтой болсон.</p>	100%
16		16. Замын-Үүд, Ханги авто замын шалган нэвтрүүлэх боомтод ариутгал, халдваргүйтгэлийн байгууламжийг байгуулах	2021 - 2024	-	<p>Монгол Улсын Засгийн газрын 350,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ариутгалын байгууламжийг худалдан авч, 2021 онд Замын-Үүд боомтын экспорт, импортын зам дээр 2 байгууламжийг, орон нутгийн хөгжлийн сангийн 240.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ханги боомтын автозамын шалган нэвтрүүлэх хэсгийн экспорт, импортын 2 зурваст халдваргүйтгэлийн байгууламжийг тус тус суурилуулсан.</p> <p>Үүний дүнд орон нутгийн хилийн бүс орчимд халдваргүйтгэл, ариутгалын үйл ажиллагааг явуулж, эрсдэлээс сэргийлэх таатай нөхцөл бүрдсэн.</p>	100%

## 2. Хүний хөгжлийн бодлого

17	2.1.1. Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэн бүр эрт илрүүлгийн үзлэг, оношил гоонд тогтмол хамрагдах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийн боловсрол-ыг дээшлүүлж, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ	17. "Халдварт бус өвчинтэй тэмцэх" аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд "Эрүүл, идэвхтэй амьдрал" зорилтод хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрүүл мэндийн зөв мэдлэг дадлыг төлөвшүүлэн халдварт бус өвчнийг илрүүлэх явуулын үзлэг зохион байгуулах	2021 - 2024		55200/5000	<p>"Эрүүл, идэвхтэй амьдрал" арга хэмжээний хүрээнд иргэдийг идэвхтэй амьдралын хэв маягт хэвшүүлж эрүүл мэндийг хамгаалах зорилгоор 12778 удаагийн аян, өдөрлөг, уралдаан тэмцээн, сургалт, сурталчилгааг зохион байгуулж, давхардсан тоогоор 204 байгууллагын 135477 албан хаагчид, иргэд хамрагдаж, 1984 төрлийн 94204 зөвлөмж тараан, цахимд 16215 төрлийн мэдээлэл, зөвлөмж байршуулж, 228919 хандалт авснаар иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилсэн.</p> <p>Жил бүр аймгийн аварга шалгаруулах "Ажлын байрны дасгал", "Хийн дасгал", "Эмч спорт", "Флаш моб", "Цахим алхалт" зэрэг тэмцээнийг зохион байгуулж сүүлийн 4 жилийн хугацаанд нийт 152 багийн 2067 тамирчин оролцсон нь жил бүр 8-12 багийн 252 тамирчин нэмэгдсний үр дүнд хөдөлгөөнөөр тогтмол хичээллэдэг хүний тоо 13413 болж биеийн жингээ бууруулах, дархлаагаа дэмжих иргэдийн идэвх оролцоо, хандлага нэмэгдсэн.</p> <p>Замын-Үүд сумын эмнэлэгт ЭМЯ, АХБ-ны ЭМСХ-5 төслийн хөрөнгө оруулалтаар 1.8 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээг хийж "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийг байгуулсан.</p> <p>МУЗГ-аас санаачлан 2022 оны 05 сараас эхэлсэн эрүүл мэндийн "Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг шинжилгээ оношилгоо"-нд өссөн дүнгээр 32602 /45.6%/ иргэн хамрагдсанаас 63.5% (20693)-ийг 0-17 насны хүүхэд, 36.5% (11909)-ийг 18-аас дээш насны хүн ам эзэлж байгаа нь улсын дүнгээс 2.4%-иар, аймгуудын дүнгээс 4.8%-иар тус тус өндөр байна.</p> <p>"Эрүүл, идэвхтэй амьдрал" арга хэмжээний төлөвлөгөө сүүлийн 4 жилийн хугацаанд 94.6% -тай хэрэгжсэн нь жилд дунджаар 4.9%-иар нэмэгдэж, жил ирэх бүр хөдөлгөөнөөр хичээллэх иргэдийн тоо нэмэгдэж, иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилж байна.</p>	100%
18		18. "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" зорилтод хөтөлбөрийг хэрэгжүүлж, идэвхтэй тандалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулах	2021 - 2024		90%/27000	<p>Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх хөтөлбөр арга хэмжээ 91.6%-тай хэрэгжсэн нь өмнөх оноос 4.9%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 51 сургалт сурталчилгаанд 22119 хүн хамрагдаж, иргэдийн мэдлэг хандлага, идэвх оролцоо нэмэгдсэн.</p> <p>Хоёр хүртлэх насны хүүхдийн товллын вакцины хамралтыг 89,%-д хүргэж, 118,0 сая төгрөгийн хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж нийлүүлснээр тоног төхөөрөмжийн хангалтыг 100%, вакцинаруудыг мэргэшүүлэх сургалтад 2 хүнийг нэмж</p>	100%

					<p>хамруулснаар хүний нөөцийн хангалтыг 100%-д хүргэсэн. В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтын ач холбогдлыг олон нийтэд сурталчилснаар 2375 хүнийг хамруулж, 2021-2024 онд тархвар судлалын заалтаар элэгний В вирустэй эхээс төрсөн 46 нярайд В гепатитын иммуноглобулин эмчилгээг хийж, хяналтанд авснаар хүүхдүүдэд халдвар илрээгүй байна.</p> <p>“Сүрьеэгийн хавьтал илрүүлэг, уул уурхайн ажилчдын үзлэг”-ийг Глобаль сангийн ДОХ, Сүрьеэгийн төслийн 16.8 сая төгрөгийн санхүүжилтээр МСЭМХ-той хамтран 7 сумын 387 хавьтал, 4 сумын 12 уул уурхайн 1165 ажилчдыг үзлэгт хамруулж, 8 шинэ сүрьеэ, 1 хавдар илрүүлсэн. Эрт илрүүлэг, үзлэгийн үр дүнд 2024 оны эхний 06 сарын байдлаар 17 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд ногдох сүрьеэ 2.3 болж 2020 оны мөн үеэс 1.6 промилоор буурсан үр дүнтэй байна.</p> <p>БЗДХ илрүүлэх үзлэг, шинжилгээнд нийт 1456 хүнийг хамруулж, шинээр 98 БЗДХ-ыг илрүүлснээс жирэмсэн 12 эмэгтэйг хяналтад авч, 100% эрүүлжүүлсэн. “Сайн дурын зөвлөгөө шинжилгээний төв”-үүдээр нийт 419 хүнд үйлчилж, тэмбүү, ХДХВ-ийн халдвар илрүүлэх болон нян судлалын шинжилгээнд 160 хүнийг хамруулж, 158 хүнийг БЗДХ-ын нарийн мэргэжлийн эмчид илгээж, 57 БЗДХ-ын өвчлөлийг шинээр илрүүлж, 100% эрүүлжүүлж, 175 хүнд утсаар зөвлөгөө өгөв. Тайлант хугацаанд БЗДХ-ын 10000 хүн амд 13.6 болж 2020 оны мөн үеэс 6.6-аар буурч, нийт халдварт өвчин 10000 хүн амд 58.4 болж 2020 оны мөн үеэс 21-ээр нэмэгдсэн нь амьсгалын замын өвчлөл нэмэгдсэнтэй холбоотой байна</p>	
19		19. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” зорилтод хөтөлбөрийн хүрээнд эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслыг хөгжүүлэх, эмгэг нярайн тасгийг байгуулж, зайн оношилгоо, зөвлөгөөг өргөжүүлж, эх нярайн тусламж	2021 - 2024	98%/70%	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/590 дүгээр тушаалын дагуу “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл”-ийг, ажиллах чиг үүргийн аймгийн Засаг даргын А/621 захирамжаар 17 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 50 ортой төрөх эмнэлэгт эмгэг нярайн тасгийг нээж, 2 нярайн эмч ажиллуулж, нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтыг 95%-д хүргэж, нийт 380 нярайд эмчилж, сурфактант эмчилгээг 21 дутуу нярайд хийж, амь насыг аварсан байна.</p> <p>Эх, нярайн зайн оношилгоог хөгжүүлж, нэгдсэн эмнэлгүүд Realtime-аар ЭХЭМҮТ-тэй холбогдон, маш хүнд, онош тодруулах шаардлагатай 9 эмэгтэй, 26 нярайд зөвлөгөөг шуурхай авч, нөхөн үржихүйн насны 442 эмэгтэйг багажийн</p>	100%

		үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх			<p>шинжилгээнд хамруулж, эмгэг өөрчлөлттэй 24 тохиолдлын оношилгоо эмчилгээний асуудлыг шийдвэрлэв.</p> <p>Нярайн эрт илрүүлэг оношилгоонд түнхний ЭХО, дутуу нярайд ретинопатия илрүүлэх оношилгоог, дутуу нярайд сурфактант эмчилгээг амжилттай хийж байна.</p> <p>НҮБ-ын Хүн амын сангийн "Оношилгоо, зайн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх" төслийн хүрээнд нийт 279 жирэмсэн эхэд зөвлөгөө өгч, үүнээс эрсдэлтэй-16, хөгжлийн бэрхшээлтэй-27 эхчүүд байв.</p> <p>ЭМЯ, ДЭМБ-тэй хамтран ОХУ-ын санхүүжилтээр “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулснаар эх нярай, хүүхдийн эндэгдлийг бууруулах” төслийг ЗҮНЭ дээр хэрэгжүүлж, 2022 онд 46.0 сая төгрөгийн нэн шаардлагатай 12 төрлийн 26 ширхэг, Улсын төсвийн 53.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар АНЭ-т 4 төрлийн 5 тоног төхөөрөмж, сумын ЭМТ-дэд 76.4 сая төгрөгийн ургийн доплер, төрөх ор тус тус нийлүүлснээр төрөх тасгуудын тоног төхөөрөмжийн хангалт 95%-д хүрсэн.</p> <p>Шинээр 2 эх барих эмэгтэйчүүдийн эмчийг бэлтгэн ажиллуулж, мэргэжил дээшлүүлэх, олгох сургалтад 5, богино хугацааны сургалтад 17, танхим сургалтаар 281 эмч мэргэжилтэнг хамруулж, мэдлэг чадварыг дээшлүүлснээр 1000 амьд төрөлтөд ногдох перинатал эндэгдлийг 2024 оны 06 сарын байдлаар 5,9 промилд хүрсэн нь 2020 онтой харьцуулахад 2,8 промилоор буурсан үр дүнтэй байна.</p>	
20		20. “Хавдрын эсрэг” арга хэмжээг хэрэгжүүлж хавдрын эрт илрүүлэг, үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх	2021 - 2024	83%/36100	<p>“Хавдрын эсрэг” арга хэмжээний 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 5 зорилт 33 арга хэмжээг батлуулж хэрэгжилт 95%-тай байна. “Хавдрын эсрэг дэлхийн өдөр”-ийн хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж, ЭМБ-ууд ЭМ-ийн сургалт сурталчилгаанд 14427 хүнийг хамруулж, 86 төрлийн 4560 зөвлөмж сэрэмжлүүлэг тараан, цахимаар 159 төрлийн мэдээлэл түгээн, 20355 хандалт авч иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлсэн.</p> <p>Хавдрын 3 төрлийн эрт илрүүлэг үзлэгт давхардсан тоогоор 106058 хүн хамрагдаж, хамралт 54.5%-д хүрч шинээр хавдрын сэжигтэй 9 тохиолдлыг эрт илрүүлсэн.</p> <p>2023 онд хавдрын 3 төрлийн эрт илрүүлэг үзлэгт 35852 хүн хамрагдсан нь 2020 онтой харьцуулахад 450 хүнээр өсчээ. 2024 онд орон нутгийн төсвийн 10.5 сая төгрөгийн санхүүжилтээр ХСҮТ-ийн эмч нарыг урьж, хавдрын эрт илрүүлэг үзлэгийг</p>	100%

					<p>зохион байгуулж, МЭХ-той хамтран "Хавдаргүй монгол эмэгтэй" төслийн хүрээнд 14 сумдаар хөх, умайн хүзүүний хавдар илрүүлэг үзлэгүүдэд нийт 4625 хүн хамруулж, хорт хавдрын 14 тохиолдол, сэжигтэй 189 тохиолдлыг эрт илрүүлж, оношилгоо эмчилгээнд хамруулан хяналтад авав.</p> <p>АНЭ-ийн хавдрын 6 ортой тасгийг 2022 оноос өргөжүүлж, полихими эмчилгээг нэвтрүүлж, 2023 онд хөнгөвчлөх эмчилгээнд-289, хими эмчилгээнд 93 хүнийг хамруулсан нь 2020 онтой харьцуулахад хими эмчилгээ 85-аар, хөнгөвчлөх эмчилгээ 168-аар тус тус өсч, тусламж үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй үзүүлж байна.</p> <p>2024 оны 06 сарын байдлаар шинээр 62 хавдар, нас баралт 46 бүртгэгдэж, үүнээс 35.1% нь эрт үедээ оношлогдож, 42.3% нь 5-аас дээш жил амьдарч байгаа нь 2020 онтой харьцуулахад эрт үеийн оношилгоо 1.2%-иар нэмэгдэж, 5-аас дээш жил амьдарч байгаа өвчтний тоо 10.8 %-иар өссөн нь хавдар эрт шатандаа оношлогдсоноор амьдрах чадвар тодорхой хэмжээгээр уртасч байгаа үр дүн харагдаж байна.</p>	
21		21. “Элэг бүтэн Монгол” зорилтод хөтөлбөрийг хэрэгжүүлж, оношилгоо, эмчилгээний хамралтыг сайжруулах	2021 - 2024	85% 52,5%	<p>“Элэг бүтэн Монгол” арга хэмжээг 2023-2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлж байна.</p> <p>Арга хэмжээний хүрээнд Гепатитын В С вирусын халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд 2017-2020 онд 27316 хүн хамруулсан бол 2021-2024 онд нийт 35621 хүнийг хамруулж, үүнээс архаг В вирусын халдвартай 550 хүн, архаг С вирусийн халдвартай 380 хүнийг тус тус илрүүлж, хамралт 2020 оноос 8305-аар нэмэгдсэн байна. 2024 оны эхний хагас жилд цочмог гепатитын 1 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 0.1 болж 2020 оноос 0.3 тохиолдлоор буурсан. 2021-2024 онд “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний хүрээнд 2021-2024 онуудад 468 удаагийн сургалт сурталчилгаанд 11695 хүн хамрагдаж, 303 төрлийн мэдээллийг цахимаар иргэдэд дамжуулж 6990 хандалт авч, 366 төрлийн 7168 ширхэг гарын авлага тарааж В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтын ач холбогдлыг олон нийтэд сурталчилснаар дархлаажуулалтад 2375 хүнийг хамруулсан.</p> <p>2021-2024 онд тархвар судлалын заалтаар элэгний В вирустэй эхээс төрсөн 46 нярайд В гепатитын иммуноглобулин эмчилгээг хийж, хяналтандаа авснаар хүүхдүүдэд халдвар илрээгүй байна.</p>	100%

22		22. “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлж, эрэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	2021 - 2024		100% 78/800	<p>“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 23 ажлыг төлөвлөж, 91%-тай хэрэгжүүлсэн. Үүнд: Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр 22 удаагийн аян, өдөрлөг, сургалт, сурталчилгааг зохион байгуулж давхардсан тоогоор 2036 эрэгтэйчүүдийг хамруулж 29 төрлийн гарын авлагыг 1648 хүнд тараан, цахимд 68 төрлийн мэдээлэл, зөвлөмж байршуулж 6768 хүний хандалт авсан.</p> <p>Дээрх ажлын үр дүнд эрэгтэйчүүдийн эрүүл мэнддээ тавих анхаарал хандлага өөрчлөгдөж 2022 оны 5 сараас эхлэн зохион байгуулагдаж буй халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт 2024 оны 06 сарын байдлаар 32773 хүн хамрагдсанаас 14616 буюу 46%-ийг эрэгтэйчүүд эзэлж, эрт илрүүлэг үзлэг эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад 35,8%-аар нэмэгдсэн байна.</p> <p>Цэргийн ангийн албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор 4 цэргийн ангийн нийт 258 албан хаагчдад сургалт, мэдээлэл хийж, 320 хүнийг үзлэгт хамруулж 229 өвчлөлийг илрүүлснээс 49%-г эрүүлжүүлсэн.</p> <p>2024 онд УНТЭ-ийн Андрологи-Урологийн тасагтай хамтран, улсын төсвийн 151,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бөөр, шээс дамжуулах доод замын дурангийн мэс заслын 9 нэр төрлийн 10 ширхэг төхөөрөмж авч, дурангийн мэс заслын эмчилгээнд 21 хүнийг хамруулж, нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг 150 иргэнд хийн, 50 гаруй өвчлөл илрүүлж, тусламж үйлчилгээ үзүүлж зөвлөгөө өгөв.</p> <p>“Дэээрэт” ОУ-ын Энэрлийн байгууллагын 136 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр АНЭ-ийн амбулаторийн тасагт “Эрэгтэйчүүдийн кабинет”-ийг 2024 оны 2-р сард шинээр нээж, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй орон нутагтаа авах боломжийг бүрдүүлэв.</p> <p>Тус кабинет нээснээр Урологийн эмчийн үзлэгт 218 хүн хамрагдаж, үүнээс мэс засал шаардлагатай 12 хүнд хагалгаа хийж, тусламж үйлчилгээг үзүүлсэнээр андорологийн тусламжинд ахиц гарч, эрчүүд орон нутагтаа эмчилгээ оношилгоо хийлгэж, дээд шатлалруу явах чирэгдэл буурч байна.</p>	100%
23		23. “Эрүүл шүд” зорилтод	2021 - 2024		98% 12000	Иргэдэд “Амны хөндийн эрүүл ахуйн зөв мэдлэг дадал төлөвшүүлэх” 285 удаагийн сургалт, сурталчилгаанд 11259	100%

		<p>хөтөлбөрийг хэрэгжүүлж, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүлжүүлэлтийг нэмэгдүүлэх, амны хөндийн эрүүл мэндийн мэдлэг дадлыг олгох сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх</p>		88%	<p>хүүхэд, эцэг эхчүүдийг хамруулж, цахим орчинд 106 төрлийн мэдээлэл байршуулж, 3261 хүний хандалт авч, 38 төрлийн 2893 ширхэг зөвлөмж, санамж, гарын авлага тарааж, иргэдэд мэдлэг олгосон. “Шүд угаалтын аварга шалгаруулах” тэмцээнийг анх удаа 2022 онд орон нутагт зохион байгуулж, 72 сурагч хамруулж, цаашид жил бүр уламжлал болгон зохион байгуулж, орон нутгаас санхүүгийн дэмжлэг үзүүлж байна.</p> <p>Хувийн хэвшлийн 7 шүдний эмчийг нийгмийн хариуцлагын дагуу 2 суманд ажиллуулж, 471 хүнийг үзлэгт хамруулж, өвчлөлтэй 399 хүний 675 шүдэнд эмчилгээ хийж 76% эрүүлжүүлсэн.</p> <p>Аймгийн Засаг даргын 2023 оны А/228 дугаар захирамжийн дагуу нөөц хөрөнгөөс 29.7 сая төгрөг шийдвэрлүүлж, 13 суманд шүдний эмчийн явуулын үзлэг хийхээр төлөвлөж, одоогоор 11 суманд зохион байгуулж, 2710 хүнийг хамруулснаас 2161 нь хүүхэд байсан.</p> <p>Үүнээс 5170 шүдэнд эмчилгээ хийж, 1931 хүнийг /71.9/ эрүүлжүүлсэн үр дүнтэй ажилласан.</p> <p>Эрүүл мэндийг дэмжих бүлгэмийн дэмжлэгтэйгээр ХХ-ийн 2 эмнэлэгтэй хамтран 7 цэцэрлэгийн 299 хүнд “Амны хөндийн эрүүл мэнд” сэдвээр сургалт зохион байгуулж мэдлэгийг дээшлүүлсэн.</p> <p>Орон нутагт Шүдний 2 хувийн эмнэлэг шинээр нэмэгдэж, хувийн хэвшлийн шүдний эмнэлгүүд орон нутагт хийгддэггүй гажиг засал, мэс заслын чиглэлээр эмчилгээг нэвтрүүлсэн. “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” дэд хөтөлбөрийн хүрээнд хувийн хэвшлийн 7 шүдний эмчийг нийгмийн хариуцлагын дагуу Айраг, Зүүнбаян сумдад 7,7 хоногоор ээлжлэн ажиллуулж, 1105 хүнд үзлэг хийж, шүдний өвчлөлтэй 954 хүний 1654 шүдэнд эмчилгээ хийж 92.4% эрүүлжүүлж, ЭМД сангаас 73.8 сая төгрөг зарцуулсан.</p> <p>Төр, хувийн хэвшлийн 12 шүдний эмнэлэг, кабинетаар 0-18 насны нийт 18470 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 11706 хүүхэд буюу 84.3%-ийг эрүүлжүүлж, ЕБС-ийн Үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлж буй ангиудад “Ангидаа шүдээ угаах” уриалгыг гаргаж, хэвшүүлсэн.</p> <p>Хүүхдийн шүдний үзлэгийг 2020 онтой харьцуулахад үзлэг 7705 хүүхдээр өсч, эрүүлжүүлэлт 4.7%-иар буурсан, 4 зорилт, 28 үйл ажиллагааны хүрээнд хэрэгжилт 98%-тай байна.</p>
--	--	---	--	-----	--

24	2.1.2. Орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэнхувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг бодлогоор дэмжиж орон нутагтаа оношлогдон, эмчлүүлэх боломжийг бий болгоно	24. Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, автомашины парк шинэчлэлийг хийж тусламжийн чанар хүртээмжийг сайжруулах	2021 - 2024		2	<p>ЭМБ-д 100% хүчилтөрөгч өтгөрүүлэгч, монитор, тарианы шахуурга, 58,8% нь дефибрилятортой болсноор амилуулах болон лавшруулсан тусламж үйлчилгээг үзүүлэх чадавх бэлэн байдал сайжирсан.</p> <p>ДЭМБ, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар бүх ЭМБ-дад спиромертийн аппараттай болж, эмч нарыг сургалтад хамруулснаар эмнэлгүүдийн яаралтай тусламжийн хүний нөөцийн чадавх, тоног төхөөрөмжийн хангалт сайжирсан.</p> <p>Яаралтай тусламжийн тоног төхөөрөмж 2020 оноос хойш нийтдээ 1,960,4 сая төгрөгийн 325 ширхэг тоног төхөөрөмжөөр нэмэгдсэнээр хангалт анхан шатлалд 91,6%, лавлагаа шатлалд 98%-д болж, анхан шатлалд 14.4%, лавлагаа шатлалд 7.6%-иар нэмэгдсэн.</p> <p>Автомашины парк шинэчлэл 2021–2024 онуудад нийтдээ 1996,2 сая төгрөгийн 33 автомашины хөрөнгө оруулалт, шинэчлэлт хийгдсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>– Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 669,3 сая төгрөгөөр 9 автомашин,</li> <li>– Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 546,4 сая төгрөгөөр 9 автомашин,</li> </ul> <p>Хандив тусламжийн хөрөнгө оруулалтаар 803,5 сая төгрөгөөр 15 автомашин нийлүүлэгдэж, автомашины парк шинэчлэл хангалт лавлагаа шатлалд 90%, анхан шатны ЭМТ-88% -тай тусламж үйлчилгээний шуурхай бэлэн байдлыг ханган ажиллаж байна.</p>	100%
25		25. Босоо тэнхлэгийн автозам дагуух эрүүл мэндийн байгууллагуудын осол гэмтлийн үеийн яаралтай тусламж үзүүлэх чадавхийг сайжруулах	2021 - 2024		84%	<p>Осол гэмтэл ихээр гардаг замын хэсэг буюу “Хар цэг”-ийн судалгаанд Айраг сумын 64 дүгээр зөрлөг, Алтанширээ 35-34 дүгээр зөрлөг, Эрдэнэ сумын Хангинуурын даваа, Замын-Үүд сумын нартын хошуу гэсэн 4 хар цэг багтсан байдаг.</p> <p>Эдгээр хар цэгүүдийн ойролцоох эмнэлгийн ажилчдыг чадавхжуулахаар аймгийн нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламж, гэмтлийн эмч нартай хамтран “Осол гэмтлийн үеийн яаралтай тусламж үйлчилгээ” сэдэвт сургалтыг зохион байгуулж, нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг эмнэлгүүдэд олгосноор тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэж, осол гэмтлийн шалтгаан нас баралт өмнөх оны мөн үеэс 8,7%-иар, 2020 онтой харьцуулахад 6,3%иар буурсан үзүүлэлттэй байна. 2024 онд яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалтыг 23.2 сая төгрөгийн үнэ бүхий 7 төрлөөр нэмэгдүүлж дунджаар анхан шатанд 91,6%, лавлагаа шатлалд 98%-д хүрч өмнөх оноос 3.4%-иар нэмэгдэж, анхан шатны ЭМБ-д 100% хүчилтөрөгч өтгөрүүлэгч, монитор, тарианы шахуурга, 58,8% нь</p>	100%

					<p>дефибриляторы болсноор амилуулах болон лавшруулсан тусламж үйлчилгээ үзүүлэх чадавх бэлэн байдал сайжирсан.</p> <p>Улсын Яаралтай тусламж, Түргэн тусламжийн нийгэмлэгүүдтэй хамтран жил бүр Амилуулах болон лавшруулсан тусламжийн сургалтыг орон нутагтаа авч, эмч мэргэжилтнүүдийн мэдлэг чадавхыг нэмэгдүүлэхээс гадна "Яаралтай тусламжийг яг цагт нь" ажил мэргэжлийн уралдааныг 2 жил тутамд зохион байгуулж хэвшээд байна.</p>		
26		<p>26. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын лабораторийн тоног төхөөрөмжийн хангалтыг шат дараатай нэмэгдүүлж, сум орон нутагтаа оношлуулж эмчлүүлэх боломжийг бүрдүүлэх</p>	2021 - 2024		70%	<p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч нарын дүгнэлт гаргах чадварыг дээшлүүлэх, лабораторийн шинжилгээний нэр төрөл, хүртээмжийг сайжруулах зорилгоор орон нутгийн хөрөнгө оруулалт, хандив тусламжаар лабораторийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж 2024 оны хагас жилийн байдлаар 2,4%-аар нэмэгдэж, 87,7%-д хүрсэн нь 2020 оноос 29.7%-иар буюу 176,8 сая төгрөгийн тоног төхөөрөмж нэмэгдсэн байна.</p> <p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд 2024 оны байдлаар лабораторийн хөргөгч, электрон жин, ус нэрэгчээр 100% хангагдаж, гематологийн анализатор 2020 онд 0% байснаас 2024 онд 69.2 буюу 9 сум аппаратаар хангагдаж сум орон нутагтаа оношлуулж эмчлүүлэх боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Лабораторийн эмч, мэргэжилтнүүдэд "ISO 15189:2015 стандарт, магадлан итгэмжлэл, лабораторийн өнөөгийн байдал" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 45 лаборант нарыг хамруулж, чадавхжуулсан.</p> <p>Сум, өрхийн түвшинд лабораторийн чадавх сайжирснаар нотолгоонд суурилсан тусламжийн чанарт ахиц гарч, нэгдсэн эмнэлгүүдийн оношилгоо шинжилгээний хүлээгдэл буурч, иргэд сум орон нутагтаа оношилгоо шинжилгээ хийлгэж, лавлагаа шатлалруу ирэх чирэгдэл, санхүүгийн хүндрэл буурсан.</p>	90%
27		<p>27. Лавлагаа шатлалд орчин үеийн болон нэн шаардлагатай оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж,</p>	2021 - 2024		88%	<p>Нэгдсэн эмнэлгүүд мэргэшсэн тусламж үйлчилгээний багцын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутагтаа чанартай тусламж үйлчилгээ авах боломж нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч 2020-2024 онд орон нутаг, хандив тусламж, салбарын хөрөнгө оруулалтаар нийтдээ 3,6 тэрбум төгрөгийн 248 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмж шинээр нийлүүлснээр тоног төхөөрөмжийн хангалт 86.2% болж 2020 оноос 3%-иар нэмэгдсэн.</p>	100%

		хангалтыг нэмэгдүүлэх				<p>Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Ходоодны дурангийн иж бүрдэл, мэс заслын өрөөний тоног төхөөрөмж, мэс заслын хагалгааны гэрэл, иж бүрэн зөөврийн рентген аппарат худалдан авах 4 удаагийн тендерийг амжилттай зохион байгуулж, салбарын хөрөнгө оруулалтаар мэс заслын C-Arm рентген аппараттай болж оношилгоо, эмчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүллээ.</p> <p>Замын-Үүдийн нэгдсэн эмнэлэг шинээр компьютер томографын оношилгоог нэвтрүүлж, орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж бүхий “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг ашиглалтад оруулж, нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг улам өргөжүүлснээр нэгдсэн эмнэлгүүд хэвлийн диализ, полихими эмчилгээ, дурангийн хагалгаа, чих хамар хоолой, нүд, хөнгөвчлөх зэрэг 11 нэр төрлийн тусламж үйлчилгээг нэвтрүүлснээр иргэдийн Улаанбаатар хотын лавлагаа шатлалын эмнэлэгрүү явах урсгал буурсан.</p>	
28	2.1.3. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ	28. Иргэдийн эрүүл мэндийн цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх шаардлагатай арга хэмжээ авах	2021 - 2024	270000	<p>"Health.gov.mn" вэб сайтад суурилсан программд 38009 иргэдийн эрүүл мэндийн мэдээллийг шинээр бүртгэснээр аймгийн хэмжээнд хүний эрүүл мэндийн мэдээллийн 4 санд нийт давхардсан тоогоор 639385 мэдээлэлтэй болсон.</p> <p>"Hi info" V3.0 программд халдварт бус өвчин /АМ-6/, эмнэлгээс гаргагч /СТ-4/ мэдээллүүдийг үүсгэж санг баяжуулсан.</p> <p>Мэдээллийн сан бүрдүүлэхэд эрүүл мэндийн салбарт хэрэглэж байгаа программуудын хоорондын мэдээллийн хөрвүүлэлтийг сайжруулж боловсронгуй болох талаар ЭМЯ, ЭМТХ-үүдэд санал хүргүүлж, мэдээллийн санг статистик мэдээ мэдээлэл гаргах, шийдвэр гаргах түвшинд мэдээлэл хийх, иргэний хувийн мэдээллийг нууцалж, судалгаа шинжилгээний ажилд мэдээллийг ашиглан ажилладаг.</p> <p>Лавлагаа шатлалын 2 нэгдсэн эмнэлэг "E-Health" эмнэлгийн тусламж үйлчилгээ, үзлэг оношилгооны мэдээлэл солилцох программыг хэрэглэж 916753(давхардсан тоогоор) иргэний мэдээллийг, анхан шатны 17 ЭМБ-уудад "E-hospital" программыг 2022 оноос нэвтрүүлж 67537 мэдээллийг шинээр бүртгэсэн боловч 2023 оны 07-р сараас программыг ашиглалт цуцлагдаж, <a href="http://www.health.gov.mn">www.health.gov.mn</a> программд шилжсэн.</p> <p>Анхан шатны 17 байгууллагуудыг 2022 онд 38.6 сая төгрөгийн 17 зөөврийн компьютер, дагалдах хэрэгслээр хангаж, лавлагаа шатлалын 2 эмнэлэг нийт 19 ЭМБ-уудын</p>	100%	

					<p>дархлаажуулалтын мэдээллийн санд өссөн дүнгээр 48889 мэдээллийг бүртгэн цахимжуулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд цахим 4 санд давхардсан тоогоор 1638319 хүний эрүүл мэндийн мэдээлэл бүртгэгдсэн байна. Цахим эрүүл мэнд үйл ажиллагааны хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын цахимжилтыг илүү сайжруулж боловсронгуй болгох, мэдээлэл солилцох, хөрвүүлэлтийн алдаагүй байлгах ажлуудыг үе шаттай зохион байгуулж, ЭМБ-уудын компьютер, интернетийн хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж байна.</p>	
29	29. Анхан шатлалд явуулын болон алсын зайн тусламж үйлчилгээний цахим технологийг нэвтрүүлж, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлэх	2021 - 2024		13	<p>Алслагдсан хүн ам, хөдөөгийн малчид иргэд хаана байгаагаас үл хамааран эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх зорилгоор 2019-2021 онд 7 сумд ЭМЯ, ОНХС-ийн 90,7 сая төгрөгийн, 2022 онд 3 эрүүл мэндийн төвүүд ОНХС, улсын төсвийн 48,7 сая төгрөгийн, 3 ЭМТ-үүд ДЭМБ-ын 97,8 сая төгрөг, 2023 онд ОНХС-ын 43,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар мобайл технологийг 3 өрхөд нийлүүлснээр аймгийн хэмжээнд анхан шатны ЭМБ-ууд 100% Мобайл технологи нэвтэрсэн.</p> <p>Мобайл үзлэгт давхардсан тоогоор 31248 хүнийг хамруулж, 25309 шинжилгээ хийж, 1288 өвчлөл шинээр илрүүлж, дээд шатлалд 1046 хүн илгээж, 2311 хүний эмчилгээний асуудлыг шийдэж, 16 хавдар эрт шатанд нь илрүүлж, зүрх судасны эмгэгтэй 161 хүнийг зайн оношилгооны дамжуулалтаар оношилж, 256 хүнийг арьсны төвтэй холбогдож, эмчилгээг заалгаснаар хөдөөгийн малчид оношилгоо шинжилгээг орон нутагтаа хийлгэх боломж бүрдсэн.</p> <p>2019-2020 онуудад Мобайл технологи 4 суманд хэрэгжиж байсан нь 2024 онтой харьцуулахад зайн оношилгооны төрөл 2-оор нэмэгдэж, үзлэг 115812-оор нэмэгдсэнээр алсын дуудлага болон хөдөөгийн малчдыг дээд шатлалд илгээх хүний тоо тодорхой хувиар буурч, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын оношилгооны чадавх сайжирсан.</p> <p>НҮБ-ын ХАС-ын "Оношилгоо, зайн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх" төслийн хүрээнд 2021 онд 52,6 сая төгрөгийн багийн эмчийн 20 багц, зайн оношилгооны төхөөрөмжийг олгосноор алслагдсан газарт нөхөн үржихүйн тусламж үйлчилгээг бүрэн үзүүлэх, нарийн мэргэжлийн эмчээс зайнаас зөвлөгөө авах боломжийг бүрдүүлж, жирэмсэн эхчүүдийг давхар хянаж, нарийн мэргэжлийн тусламжид хамруулсан нь жирэмсний хяналтын чанарыг сайжруулж,</p>	100%

					<p>жирэмсэн эхчүүдэд үзүүлэх тусламжийн хүртээмжийг нэмэгдүүллээ.</p> <p>Нэгдсэн эмнэлгүүдийн төрөх, хүүхдийн тасагт “realtime” суурилуулж ЭХЭМҮТ-ийн эрчимт эмчилгээний тасагтай шууд холбогдож хүнд хүүхдэд зөвлөгөө авах боломжтой болж, тайлант онуудад нийт 32 хүнд нярай, хүүхдэд зөвлөгөөг шуурхай авснаар хүндрэл эндэгдлийг бууруулж, 2024 оны 6 сарын байдлаар 1000 амьд төрөлтөд перинатал эндэгдэл 5,9 промилд хүрч улс аймгийн дунджаас 4,2-оор доогуур үзүүлэлттэй болсон ба 2020 онтой харьцуулахад 2,8 промилоор буурсан үр дүнтэй байна.</p>	
30	2.1.4. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлнэ	30. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой аргыг нэвтрүүлэх	2021 - 2024	100%	<p>Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд 2021-2022 онуудад лавлагаа шатлалын 2 эмнэлэг, Уламжлалт анагаах ухаан рашаан сувилал, анхан шатны 17 эрүүл мэндийн байгууллагууд нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжин гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр санхүүжиж, санхүүгийн хагас бие даасан тогтолцоотой болсон.</p> <p>ЭМДҮЗ-ээс шинээр гарч байгаа тогтоол шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах, даатгалаас авах санхүүжилтийг нэмэгдүүлэхээр эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтан, нягтлан бодогч, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 2021-2024 онд давхардсан тоогоор 520 албан хаагчдад сургалт, мэдээлэл хийж гүйцэтгэлийн санхүүжилт нэмэгдүүлэх мэдлэг чадвар олгож, чиглүүлснээр ЭМБ-уудын санхүүгийн чадавх нэмэгдсэн ЭМД-ын сангийн санхүүжилт 2020 онтой харьцуулахад лавлагаа шатлалд – 11,4 тэрбум төгрөгөөр буюу 1,9 дахин, анхан шатлалд 9,2 тэрбум төгрөгөөр буюу 2,6 дахин нэмэгдэж, орлогын хүрээнд орон тоо батлан, хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэн, хэвтэн эмчлүүлэх орны зохицуулалтыг бүртгэгдсэн өвчлөлийн байдалтай уялдуулан зохицуулж, гүйцэтгэлийг үндэслэн цалинг нэмэгдүүлснээр албан хаагчдад ажлын үр дүнгийн урамшуулал олгож, нэн шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авах зэргээр тусламж үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөлийг сайжруулж, чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн үр дүнтэй байна.</p>	100%
31		31. Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлэх	2021 - 2024	16/80%	<p>ЭМДЕГ-тай ЭМБ-ууд жил бүр гэрээ байгуулснаар ЭМД-ын санхүүжилтийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, ЭМДЕГ-ын 2021 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан оношийн бүлгээр санхүүжиж, төр, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн тусламжийн тариф ижил болж, лавлагаа</p>	100%

					<p>шатлалын бүх эмнэлгүүд амбулаторийн тусламж үйлчилгээ, өндөр өртөгтэй оношилгоо эмчилгээ, өдрийн эмчилгээ, диализ, хэвтүүлэн эмчлүүлэх тусламж, хөнгөвчлөх, хими эмчилгээ, яаралтай, түргэн тусламж, урьдчилан сэргийлэх, жирэмсний хяналт зэргээр нийт 11 төрлөөр, анхан шатны эмнэлгүүд 4 багц үйлчилгээнээс гадна 4 тусламжийг даатгалаас санхүүжүүлэн иргэдэд санхүүгийн бэрхшээлгүй, хүртээмжтэй үйлчилгээг хүргэж байна.</p> <p>Нэгдсэн эмнэлгүүд үндсэн 11 төрлийн тусламж үйлчилгээгээр 13,8 тэрбум төгрөг, анхан шатны эрүүл мэндийн төвүүд 4 багц, 3 тусламж үйлчилгээгээр 1,8 тэрбум төгрөгийн санхүүжилт авч, Хувийн хэвшлийн эмнэлгүүд, УАРСТ-д хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр 711,6 сая төгрөгийн санхүүжилт авч, дутагдаж буй зардлуудад зарцуулахын зэрэгцээ цалинг нэмэгдүүлж, илүү цагийн хөлс, үр дүнгийн урамшуулалд зарцуулсан.</p> <p>Эм зүйн тусламж үйлчилгээний чиглэлээр үнийн хөнгөлөлттэй зайлшгүй шаардлагатай эм 680,5 сая төгрөгийн эмийг 47 эмийн сангаар олгосноор ЭМД сангаас санхүүжих тусламж, үйлчилгээ нэмэгдсэнээр иргэд санхүүгийн хүндрэлгүй, хүлээгдэл чирэгдэлгүй тусламж авах боломж бүрдсэн.</p>	
32	2.1.5. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.	32. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын стандартын хэрэгжилтийг хангуулна.	2021 - 2024	86%	<p>Аймгийн хэмжээнд 2021-2024 онуудад 13 сум болон аймгийн төвд 2 дугаар зэрэглэлийн нийт 20 эмийн санд шинээр тусгай зөвшөөрөл олгосноор нийтийн үйлчилгээтэй 53 эмийн сан, 4 ЭХНБ-ууд үйл ажиллагааг орон нутагт явуулж, ард иргэдэд эм зүйн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэж, чанарын шаардлага хангасан эм хэрэгслээр хангаж байна.</p> <p>Коронавируст халдварын тархалттай холбоотойгоор 2021 онд зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг нэмэгдүүлэх, ажлын цагийг уртасгасан цагаар ажиллах, хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцийг нэмэгдүүлэх, эм, эмнэлгийн хэрэгслийг үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байх, Коронавируст халдварын эмийн эмчилгээнд шаардлагатай вирусийн эсрэг эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх, үнийн дээд хязгаарыг баримтлан борлуулах чиглэлээр 2 удаа /цахим, танхим/ арга зүйгээр хангаж эмийн сангууд эмийн санд тавигдах нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандартыг 93%-тай хэрэгжүүлсэн байна.</p>	100%

					<p>Хуулийн дагуу тендерүүдийг 4 удаа нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулж, нийт 47 багцад хамгийн сайн үнэлэгдсэн 26 байгууллагатай гэрээ байгуулж, татан авалтууд хуваарийн дагуу хийгдэж хэвшсэн.</p> <p>Бүгд Найрамдах Словени улсын “Лек фармацевтикалс” компаний “5-НОК” 50 мг бүрхүүлтэй шахмал эм, Герман улсын Denkrharma-ийн Лозар-Денк 25, 50 мг шахмал эмүүдийн найрлага дахь эмийн үйлчлэгч бодис зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тул зах зээлээс эргүүлэн татах тухай мэдээллийг ЭМБ-ууд, эмийн сангуудад хүргүүлж, борлуулахгүй байхыг анхааруулж, Мэргэжлийн хяналтын байцаагчтай хамтран хяналт тавьж, эмийн аюулгүй байдлыг хангаж байна.</p> <p>Анхан болон лавлагаа шатлалын эмнэлгүүдийн жилийн хэрэгцээт эмийг хуулийн дагуу нээлттэй худалдан авах ажиллагаагаар болон ерөнхий гэрээгээр нийлүүлж, эмийн чанар аюулгүй байдлыг хангасан, эм, эмнэлгийн хэрэгслээр хангагдсан.</p> <p>Эм эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлж <a href="http://licemed.mohs.mn/">http://licemed.mohs.mn/</a> цахим программаас улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, эмийн түүхий эдийн мэдээ мэдээллийг цаг алдалгүй авч байна</p>	
33		33. Шинэчлэгдсэн цахим жорын программыг өргөжүүлж, эрүүл мэндийн даатгалын сангийн үнийн хөнгөлөлттэй эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх	2021 - 2024	46000	<p>ЭМД-ын үндэсний зөвлөлийн 2021-2024 онуудад 11, 8-р тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх 159 ерөнхий нэршлийн, 561 эмийн жагсаалтыг баталж, иргэд хурууны хээгээ уншуулан харьяалал харгалзахгүйгээр бүх шатлалын эмнэлгүүдээр хөнгөлөлттэй эм бичүүлэх боломжтой болсон бөгөөд ЭМДЕГ-аас 71-ээс дээш насны иргэд, бусдын асаргаанд байдаг, уналт таталт, саажилттай иргэд хурууны хээ уншуулахгүй хөнгөлөлттэй эм бичүүлэх боломжийг бүрдүүлж, эмийн хүртээмжийг нэмэгдүүлсэн.</p> <p>Тайлант хугацаанд тархины саажилт, хүүхдийн уналт таталтын эсрэг эмийн үнийг хүүхдэд /0-19 нас/ ЭМД-ын сангаас 100% хөнгөлөлттэй олгож байна.</p> <p>Хүн амын дунд зонхилон тохиолддог, нас баралтын хувь өндөртэй зүрх судас, чихрийн шижин, уушгины эмгэг болон хавдрын үеийн эмзүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор “Новартис эмийн хүртээмжийг сайжруулах” хөтөлбөрийг хэрэгжүүлж, 15 ерөнхий нэршлийн 24 тун, хэмжээ бүхий эмийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувийн хөнгөлөлттэйгээр олгосноор иргэдийн санхүүгийн хүндрэлийг бууруулсан.</p>	100%

					<p>Эрүүл мэндийн байгууллагууд нь ЭМДЕГ-аас тавигдсан шаардлагыг хангасан ZKТесо-ZK9500, FRT808 загварын 171 ширхэг хурууны хээ уншигч төхөөрөмжтэй болж, төрийн өмчийн 19 эрүүл мэндийн байгууллагын 79 эмч хөнгөлөлттэй эм бичиж, 2024 оны 3 сараас жороор олгох эмүүдийг цахимжуулсан ба 2021-2024 онуудад нийт 53 эмийн сан 153731 хүнд 4348,4 сая төгрөгийн хөнгөлөлттэй эмээр үйлчилсэн ба 2020 онтой харьцуулахад 8708 үйлчлүүлэгч, санхүүжилт 57.9%-р тус тус нэмэгдсэн байна.</p>	
34	<p>2.1.6. Эрүүл мэндийн ажилтны хөгжил, нийгмийн хамгааллын хөтөлбөрийн хэрэгжилт-ийг сайжруулж, хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлж, нөхцөл боломжоор хангана.</p>	<p>34. Эмч, мэргэжилтнүүдийг гадаад, дотоодын ахисан түвшний сургалтад хамруулж, мэдлэг чадварыг дээшлүүлэх</p>	2021 - 2024	3600	<p>Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн нэгдсэн төлөвлөгөөг 92,6%-тай хэрэгжүүлж 2021-2024 онуудад эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулж мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад 78, танхимын болон цахим сургалтад давхардсан тоогоор 8317, ЭМБ-ын дотоодын сургалтад давхардсан тоогоор 5347 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлэв.</p> <p>Лондонгийн "CIPD" их сургуульд 1 албан хаагч, Тайвань улсын их дээд сургуулийн үйл ажиллагаатай танилцах аялалд аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга оролцож, БНСУ-д ажлын байрны дадлагажуулах 3 сарын сургалтад 1 эмч, ОХУ-ын Москва хот дахь Эх барих эмэгтэйчүүд, перинатологийн эрдэм шинжилгээний төвд ажлын байрны дадлагажих сургалтад ОХУ-ын Засгийн газрын санхүүжилтээр Замын-Үүд нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүд, нярайн эмчийг, ЭМЯ-ны дэмжлэгээр БНСУ болон БНХАУ-д 2 эх баригч, 5 сувилагчийг тус тус хамруулж, мэдлэг чадавхыг нэмэгдүүлсэн.</p> <p>АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны сургуулийн Эм найруулагчийн ангид 2020-2023 онд суралцаж төгссөн 16 оюутан, тус онд шинээр элсэн орсон Эх баригчийн ангийн 11 оюутан, Их эмчийн ангийн 3, нийт 30 оюутантай орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах гэрээг байгуулж, сургалтын төлбөр болох 23,0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас 100% олгож, орон нутагт нэн шаардлагатай байгаа мэргэжлээр хүний нөөц бэлтгэх ажлыг дэмжиж ажилласан.</p> <p>Мөн Сайхандулаан, Өргөн сумын Засаг дарга орон нутгийн санхүүжилтээр 4 оюутны сургалтын төлбөр болох 18,7 сая төгрөгийг төлж 5 жилийн хугацаатай ажиллахаар гэрээ байгуулан ажиллуулж байна.</p>	100%

35		35. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулан тогтвор суурьшилтай ажиллуулах эдийн засгийн хөшүүргийг оновчтой, хүртээмжтэй болгох	2021 - 2024		97% 14	<p>Эрүүл мэндийн салбарын хэмжээнд “Нийгмийн хамгааллын хөтөлбөр”-ийг сүүлийн 4 жилийн хугацаанд дунджаар 93,4%-тай хэрэгжүүлж, сум орон нутгийн удирдлагуудтай "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулж, эмч мэргэжилтнүүдийг төрийн орон сууцаар хангах, тогтвор суурьшилтай ажиллах хөшүүргийг бий болгож, дэмжих зорилгоор:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Анхан шатны эрүүл мэндийн төвүүдэд ажиллаж байгаа 38 эмч мэргэжилтнийг төрийн албан хаагчийн орон сууцны түрээсийн төлбөрөөс чөлөөлж,</li> <li>- Хөдөө ажиллаж байгаа 1 гэр бүлд “эзэмшлийн газар” олгож,</li> <li>- “Малжуулах төсөл”-д 8 албан хаагчыг хамруулж 65 толгой бог мал,</li> <li>- 1 ажилтанд үнэгүй гэр олгож,</li> <li>- 2 сумын Засаг дарга орон нутгийн санхүүжилтээр 4 оюутны сургалтын төлбөр болох 18,7 сая төгрөгийг төлж, 5 жилийн хугацаатай ажиллах гэрээ байгуулан,</li> <li>- 3 сумын эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа 4 эмчид 15,4 сая төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлсэн.</li> </ul> <p>Монгол Улсын Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газраас хэрэгжүүлж буй “Төрийн албан хаагчийг орон сууцжуулах” хөтөлбөрөөр:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Аймгийн нэгдсэн эмнэлэгт шилжин ирж ажиллах 6 эмч, ажилтанг 2 өрөө байраар хангаж,</li> <li>- Түрээслээд өмчлөх байрны эрхийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн 14 эмч, сувилагч, асрагчид олгож,</li> <li>- Замын-үүд сумын нэгдсэн эмнэлэг нь 18 айлын орон сууцыг ашиглалтад оруулж албан хаагчдыг нийгмийн хамгааллыг нэмэгдүүлэв.</li> </ul> <p>“Эрүүл энхийн үйлстэн” хүндэтгэлийн арга хэмжээг 3 дахь удаагаа нутгийн зөвлөл, орон нутгийн удирдлагуудын дэмжлэгээр зохион байгуулж, Шилдгийн шилдэг 7 төрөлд эмч, мэргэжилтэн, хамт олныг шалгаруулж, цахим сүлжээгээр сурталчилж, нийтдээ 100,0 сая.төгрөгөөр шагнаж урамшуулав.</p> <p>Эмч эмнэлгийн мэргэжилтэнг тогтвор суурьшилтай ажиллуулах хөшүүргийг би болгож улсын болон орон нутгийн төсвөөс 1487,8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 4 жилийн хугацаанд шинээр 454 эмч мэргэжилтэнг ажлын байраар хангаж, нийгмийн хамгаалалд анхаарал хандуулснаар ЭМБ-уудын хүний нөөцийн хангалт анхан шатанд -89,8%, лавлагаа шатлалд -88,4%, салбарын хэмжээнд дунджаар – 89,1%-тай болж 2020 оноос 9,5%-иар нэмэгдсэн.</p>	100%
----	--	---	-------------	--	--------	--	------

36	2.1.7. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүд ийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	40. Уламжлалт анагаах ухаан, рашаан сувиллын үйл ажиллагааг өргөжүүлэн, орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай арга хэмжээ авах	2022 - 2024		-	<p>Аймгийн Засаг даргын 2022 оны А/76 дугаар захирамжаар “Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын төв”-ийн бүтэц орон тоог шинэчлэн баталсан. Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын төв нь 2023 оноос 28 орон тоо, 39 ор, сувиллын 60 ортой ажиллаж, тайлант онд 1371 хүнийг хэвтүүлж, амбулаторийн үзлэг 2081 хүнд үзүүлснээр өмнөх оноос хэвтүүлэн эмчлүүлсэн хүн 13.8%-иар, урьдчилан сэргийлэх үзлэг 14.4%-иар тус тус өсч, шинээр 2 төрлийн эмчилгээг нэвтрүүлж, 572 хүнд үйлчилсэн. Урьдчилан сэргийлэх үзлэгийг 3 сум, 5 албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд зохион байгуулж нийт 422 хүнд үзлэг, 500 гаруй хүнд хүчилтөрөгчийн коктейлоор үйлчилсэн нь өмнө оноос 26.4%-иар нэмэгдсэн байна.</p> <p>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 137,9 сая төгрөгөөр Халзан-Уул” рашаан сувиллын “Нийтийн бие засах газрын шинэчлэл” ажлын тендерт “Эрхэм бадрах” ХХК шалгарч бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өгснөөр амрагч, аялагчдын ая тухтай нөхцөлд үйлчлүүлэх боломжийг бүрдүүлж, орон нутгаас Уламжлалт анагаах ухаан, рашаан сувиллын үйл ажиллагааг хөгжүүлэхэд томоохон дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Халзан уул рашаан сувиллын үйл ажиллагааг орон нутгийн “Bmedia” сувгаар сурталчлан мэдээлэл өгч, 2023-2024 онд 21 төрлийн эмчилгээ сувилгаа хийж, шинээр 2 төрлийн эмчилгээ нэвтрүүлэн ажиллаж 682 сувилуулагч хүлээн авсан нь 2020 оныхоос 31.4%-иар нэмэгдсэн байна.</p> <p>Одоогоор Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын төвд нь 15 төрлийн эмчилгээг үзүүлэн ажиллаж байгаа ба хэвтүүлэн эмчлүүлсэн хүн 2020 оноос 33.8%-иар, урьдчилан сэргийлэх үзлэг 4.4%-иар тус тус өссөн.</p>	100%
37		2.1.7.3. Зарим сумдын эрүүл мэндийн төв, өрх, багийн эмнэлгийн барилгыг шинээр барих болон барилгын өргөтгөл, засвар үйлчилгээг хийнэ.	2021 - 2024	УТ-1,600,0 сая төгрөг	100%	<p>Эрүүл мэндийн салбарт улс, орон нутгийн төсвийн нийт 18,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2021-2023 онуудад 4 эрүүл мэндийн төвийг шинээр ашиглалтад оруулж, 9 эрүүл мэндийн төвд их засвар, өргөтгөл хийж, 133 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр ханган, 33 автомашин, иж бүрэн тоноглогдсон 4 автомашиныг тус тус олгож эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд дэмжин ажилласан.</p> <p>Аймгийн хэмжээнд 2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 8577,1 сая төгрөгийн 14 ажлын</p>	100%

					төсөв батлагдсанаас 9 ажил эхэлж, гүйцэтгэл 75%-тай байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Хатанбулаг өргөтгөл -1249,2 сая төгрөг</li> <li>- Мандах сумын ЭМТ-ийн их засвар – 257,0 сая төг</li> <li>- АНЭ-ийн гадна их засвар – 2400,0 сая төг</li> <li>- Өргөн сумын өргөтгөл барилга – 450,0 сая төг</li> <li>- Эрдэнэ сумын ЭМТ-ийн дулааны шугам засварлах ажил – 509,5</li> <li>- Замын-Үүд нэгдсэн эмнэлэг эмгэг судлалын барилга – 300,0 сая төг</li> <li>- Айраг сумын ЭМТ-1 давхарын их засвар – 355,7 сая төг</li> <li>- Эрүүл мэндийн байгууллагуудын тогтмол зардал – 2323,7 сая төгрөг</li> <li>- Эрүүл мэндийн байгууллагуудад автомашин -198,0 сая төгрөг</li> <li>- Эрүүл мэндийн байгууллагуудад тоног төхөөрөмж – 534,0 сая төгрөг байна.</li> </ul>	
38	37. Халдвартын эмнэлгийн барилга шинээр барих	2022 - 2024	2181,3 сая төгрөг	Гүйцэтгэлийн хувь	Орон нутгийн хөгжлийн сангийн 2181.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 2 дугаар багт Халдвартын эмнэлгийн барилга угсралтын ажлыг "Төгс-Өнөд" ХХК гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгснөөр аймгийн Нэгдсэн эмнэлгийн "Халдвартын тасаг" стандартын шаардлагад нийцсэн, тав тухтай эмнэлэгтэй болсон. Сүүлийн жилүүдэд цар тахлын халдвар, ялангуяа амьсгалын замын халдварууд нэмэгдэх хандлагатай байгаа энэ үед эрүүл ахуйн урсгал зохион байгуулалт сайтай шинэ эмнэлэг баригдсан нь тусламж үйлчилгээг чанартай үзүүлж, халдварын эрсдлийг бууруулах үр дүнтэй байна.	100%
39	38. Сумдын эрүүл мэндийн байгууллагуудыг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	2021 - 2024			Улс, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар Алтанширээ, Хөвсгөл, Хатанбулаг, Даланжаргалан, Дэлгэрэх, Улаанбадрах, Эрдэнэ сумдад төвлөрсөн инженерийн шугам сүлжээний ажлыг 2020-2023 онуудад ашиглалтад оруулснаар тус сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө Эрүүл мэндийн төвүүдийг төвлөрсөн шугам сүлжээнд бүрэн холбогдсон. Аймгийн хэмжээнд хөдөөгийн 13 сумдаас Мандах, Сайхандулаан сумаас бусад сумдын эрүүл мэндийн төвүүд инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд бүрэн холбогдож, ая тухтай ээлтэй орчин бүрдсэн.	100%
40	40. Аймгийн нэгдсэн эмнэлгийн ажиллах	2021 - 2024			Орон нутгийн төсвийн хөрөнгөөр аймгийн нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааг тогтмол дэмжиж, халдвартын эмнэлгийн угаалга, ариутгалын барилга–484,6 сая төгрөг,	100%

		<p>нөхцөл боломжийг сайжруулах болон хийн систем, хүчил төрөгчийн үйлдвэртэй болгох</p>			<p>серверийн шинэчлэл 64,1 сая төгрөг, зөөврийн рентген, компьютерын 5 ширхэг иж бүрдэл 97,8 сая төгрөг, Цахилгаан шатыг 691,4 сая төгрөг зэрэг нийт 1337,9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, үйлчлүүлэгчдэд ээлтэй, ажилчдын ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлж томоохон хөрөнгө оруулалтуудыг хийсэн.</p> <p>Шинэ халдвартын эмнэлэг болон аймгийн Нэгдсэн эмнэлгийн гадна автозогсоол байгуулах ажлыг 291,4 сая төгрөгөөр “Дэлгэр баясах зам” ХХК хийж гүйцэтгэж, эмнэлгээр үйлчлүүлж буй иргэдийн аюулгүй зорчих боломжийг хангасан.</p> <p>Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нийт 9 эмчийг гадаад улсад туршлага судлах сургалтад хамруулж, мэдлэг чадавхыг нэмэгдүүлсэнээс гадна шилжин ирж ажиллах 6 эмч, ажилтныг байраар хангасан төдийгүй түрээслээд өмчлөх орон сууцанд 14 эмч, сувилагч, асрагч нарыг хамруулснаар хүний нөөцийн нийгмийн асуудлыг шийдэж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдүүлэв.</p> <p>Нэгдсэн эмнэлгүүд мэргэшсэн тусламж үйлчилгээний багцын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутагтаа чанартай тусламж үйлчилгээ авах боломж нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, лавлагаа шатлалд нийтдээ 783.7 сая төгрөгийн 24 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмж шинээр нийлүүлэгдсэнээр тоног төхөөрөмжийн хангалт 86.2% болж 2020 оноос 608 ширхэг 7,409,6 сая төгрөгийн ТТ нэмэгдэж, 13,6%-иар өсч, оношилгоо тусламжийн чадавх сайжирсан. Үүний үр дүнд орон нутагт хийгддэггүй нарийн мэргэжлийн 11 нэр төрлийн тусламж үйлчилгээг шинээр нэвтрүүлж, иргэдийн дээд шатлалд илгээх хүний тоо 2020 онтой харьцуулахад 13,9%-иар буурчээ.</p> <p>Аймгийн нэгдсэн эмнэлэгт 732,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1 цагт (20 нанометр куб) 3 баллон дүүргэх хүчин чадалтай “Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр”-ийг 2022 онд барьж, хийн систем угсарч, суурилуулан эмнэлгийн дотор талын хийн хоолойн дамжуулах системийг бүрэн угсарч, холбогдох эмч мэргэжилтэнг ажлын байрны сургалтад хамруулж чадавхжуулснаар тусламж үйлчилгээнд ашиглаж эхэлсэн.</p> <p>Үүний үр дүнд АНЭ-ийн эрчимт эмчилгээ, дотор, мэс засал, халдварт, хүүхдийн тасгуудад ханын системээр хүчилтөрөгчтэй холбогдож, хүнд өвчтэй иргэд ерөөнөөсөө хүчилтөрөгчөөр хангагдах боломжтой болж, Улаанбаатар хотоос баллонтой хүчилтөрөгчийг зөөвөрлөх чирэгдэл, төсөв хэмнэгдэж, сумдад</p>
--	--	---	--	--	---

						хүчилтөрөгчийг шуурхай хүргэх зэрэг олон сайн боломж бүрдсэн.	
41	2.1.8. АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог сайжруулж, төгсөгчдийг орон нутагт мэргэжлээ-рээ ажиллах хөшүүргийг оновчтой хэрэгжүүлнэ.	41. Мэргэжилтэн бэлтгэх ангийн тоог нэмэгдүүлэн, орон нутгийн оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэн, тогтвор суурьшилтай ажиллах үр дүнтэй хөшүүргийг бий болгох	2021 - 2024		7 30	<p>Орон нутагт нэн шаардлагатай, дутагдалтай байгаа мэргэжлээр оюутан элсүүлэх, суралцаж байгаа оюутнуудын сургалтын төлбөрийг орон нутгаас шийдвэрлэхээр АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны сургуулийн Эм найруулагчийн ангид 2020-2023 онд суралцаж төгссөн 16 оюутан, тус онд шинээр элсэн орсон Эх баригчийн ангийн 11 оюутан, Их эмчийн ангийн 3, нийт 30 оюутантай орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах гэрээг байгуулж, сургалтын төлбөр болох 23,0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас 100% олгож, орон нутагт нэн шаардлагатай байгаа мэргэжлээр хүний нөөц бэлтгэх ажлыг дэмжиж ажиллав.</p> <p>Жил бүр төгсөгч нартай сумдын Засаг дарга нар, ЭМБ-ууд хамтран уулзалт хийж, орон нутгаа сурталчилснаар Сайхандулаан, Өргөн сумд орон нутгийн санхүүжилтээр 4 оюутны сургалтын төлбөр болох 18,7 сая төгрөгийг төлж, 5 жилийн хугацаатай ажиллахаар гэрээ байгуулан ажиллуулж байна.</p> <p>Мөн 3 сумын эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа 4 эмчид 15,4 сая төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлж, шинээр 105 эмч мэргэжилтэнг ажлын байраар хангаж, ЭМБ-уудын хүний нөөцийн хангалт анхан шатанд 89,5%, лавлагаа шатлалд 83,7%, салбарын хэмжээнд дунджаар 86,6%-тай байна.</p> <p>2020-2023 онуудад 97 эмч мэргэжилтэнг төрийн албан хаагчийн байраар хангаж, 856 эмч мэргэжилтэнд 134,3 сая төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлсэн нь 2020 онтой харьцуулахад байраар хангасан албан хаагч 38 хүнээр нэмэгджээ.</p> <p>Орон нутгийн санхүүжилт, тэтгэлэгээр суралцсан 14 эх баригч, их эмч, 11 эм найруулагч нар 8 сумын 15 ЭМБ-уудад томилогдон ажиллаж байна.</p>	100%
42	2.2.1. "Хөдөлгөөн - эрүүл мэнд" аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын	43. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн орчимд "Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн", хүүхдийн парк байгуулах	2022 - 2024		-	<p>Төв цэнгэлдэх хүрээлэнгийн орчмыг "Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн" болгох ажлын хүрээнд "Хүүхдийн парк"-ыг 6.3 га газарт төлөвлөж "Архидеа" ХХК, "Говь парк" цэцэрлэгт хүрээлэнг 108 га газарт төлөвлөж "Онч тэнхлэг" ХХК-ууд ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг боловсруулсан.</p> <p>Орон нутгийн хөгжлийн сангийн 707,4 сая төгрөгийн хөрөнгөөр аймгийн Төв цэнгэлдэх хүрээлэнд шаардлагатай засвар, сүүдрэвч хийх ажлын тендерт "Энержипарагон" ХХК</p>	100%

	хүртээмжгэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан бодлогыг хэрэгжүүлнэ.				<p>шалгарч, засварын ажлыг бүрэн дуусгаж 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдөр хүлээлгэн өгсөн.</p> <p>Улсын төсвийн 6.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 3-р багийн нутаг дэвсгэр төв цэнгэлдэх хүрээлэнгийн зүүн талд "Хүүхдийн парк" байгуулах ажлын тендерт "Дэлгэр баясах зам" ХХК, "Энержи парагон" ХХК, "Уртын уул" ХХК-иуд шалгаран ажлыг гүйцэтгэж 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдөр нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж байнгын ашиглалтад оруулсан.</p> <p>Хүүхдийн парк 30 метрийн өндөртэй, 20 кабинтай алсыг харагч, 24 хүүхдийн суудалтай далайн дээрэмчний завь, 24 хүүхдийн суудалтай морин тойруулга, 10 ширхэг мөргөлддөг машин, 24 хүүхдийн суудалтай агаарын эргэдэг гинжит тойруулга, 24 хүүхдийн суудалтай эргэдэг аяга 10 хүүхдийн суудалтай 5 ширхэг усны завь, 2500 м3 усны багтаамжтай хиймэл нуур, зургаан төрлийн нийтийн тоглоомын талбайтай, хоёр ширхэг тоглоомын элсний талбай бүхий орчин үеийн шийдэлтэй.</p> <p>Хүүхдийн парк ашиглалтад орсноор говь нутгийн хүүхдүүд чөлөөт цаг, амралтын өдрүүдээ сонирхолтой, үр дүнтэй өнгөрөөх боломж бүрдсэн.</p>	
43		44. Спортын төрлүүдийг хөгжүүлэхэд спортын холбоод, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах	2021 - 2024	44	<p>Аймгийн хэмжээнд 2024 оны хагас жилд үйл ажиллагаа явуулдаг 22 холбоод, клубуудийн тэргүүлэгчидтэй уулзалт зохион байгуулж одоогийн нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, чиглэлүүдтэй танилцан зөвлөгөө, чиглэл өгч ажилласан. 2024 оны хагас жилийн байдлаар 19 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан спортын 11 төрлөөр сургалт, дугуйлан явуулж, давхардсан тоогоор 24649 гаруй өсвөрийн болон насанд хүрэгчдийн дунд хичээллүүлсэн.</p> <p>Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор 37 байгууллагатай хамтран, батлагдсан хуваарийн дагуу заал танхимаар үйлчлэн, шүүгч, дасгалжуулагчдаар мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч, спортын төрлүүдээр хичээллэх таатай нөхцөлийг бүрдүүлэн ажилласан. Давхардсан тоогоор 7592 иргэнд тогтмол үйлчлүүлж байна.</p> <p>2022 онд 22 спортын холбоо, клуб, 25 аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллаж, бүс, аймгийн чанартай 545 медаль хүртэж медалийн тоо, чанар 2021 оноос 100%-аар өссөн.</p>	100%

					<p>2023 онд аймгийн хэмжээнд 80 тэмцээнд /аймгийн төвд 29/, /сумдад 51/ 11136 тамирчин хамрагдаж спортоор хичээллэгсдийн тоо 2022 оноос 20-30 хувиар өссөн үзүүлэлттэй байсан.</p> <p>2024 оны хагас жилийн байдлаар хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх спортын үйл ажиллагаанд 32,241 иргэн хамрагдсан. Хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 49 удаагийн тэмцээнд /аймгийн төвд 18, сумдад 31/ 5836 тамирчдыг хамруулан нээлттэй зохион байгууллаа. 2020 онд 25 спортын холбоод болон ААН-тэй хамтран ажиллаж байсан бол 2024 оны хагас жилийн байдлаар 56 болж өссөн.</p> <p>Орон нутагт кудо, явган аялал /уртын алхалт/ гэсэн спортын төрлүүд шинээр хөгжиж эхэлсэн.</p>	
44		46. “Унадаг дугуй” -г нийтийн хэрэглээ болгох	2021 - 2024	90% 90 450	<p>Аймгийн дугуйн спортын, аялалын "Хулан" клубээс санаачлан унадаг дугуйг нийтийн хэрэглээ болгохоор аймгийн хэмжээнд судалгаа хийж, судалгааны дүнд үндэслэн ойрын дугуйн аялал, зугаалгыг жил бүр явуулж хэвшсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд нийт 233 хүн унадаг дугуйг хэрэглээний болон спортын зориулалтаар тогтмол хэрэглэж дугуйн спортоор хичээллэгсдийн тоо 20-30 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>2024 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан "Сайншандын цом"-ын өсвөрийн дугуйчдын аварга шалгаруулах тэмцээнд 70, Уулын дугуйн өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 48 тамирчид оролцсон.</p> <p>Монголын дугуйн холбооноос Сэлэнгэ аймагт зохион байгуулсан Улсын өсвөр үе, Залуучуудын уулын дугуйн аварга шалгаруулах тэмцээнд аймгаас 13 хүний бүрэлдэхүүнтэй 12 тамирчин оролцож багаараа хүрэл медаль, 14 насны марафон төрөлд Б.Төгөлдөр хүрэл медаль авлаа.</p> <p>2020 онд унадаг дугуйгаар хичээллэгсдийн тоо 55, сонирхогчдын тоо 200 байсан бол энэ онд хичээллэгсдийн тоо 70, сонирхогчдын тоо 233 болж өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Тайлант хугацаанд 4,7 км дугуйн болон явган хүний замыг шинээр барьж ашиглалтад орууллаа.</p>	100%
45	2.2.2. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн	48. Сайншанд суманд стандартад нийцсэн хөл	2022 - 2024	-	<p>Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 07/04 дугаар тогтоолын үндэслэн Сайншанд сумын Засаг даргын 2022 оны 1 дүгээр</p>	50%

	хүрээнд иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, спортоор хичээллэх орчныг сайжруулна.	бөмбөгийн болон граундгольфын талбай байгуулах.				сарын 19-ны өдрийн А/14 дугаар захирамжаар Сайншанд сумын 8 дугаар багт нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх газрын байршлыг баталсан. Орон нутгийн төсвийн 80,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд суманд "Говь парк" цэцэрлэгт хүрээлэнгийн зураг төсвийн гүйцэтгэгч шалгаруулах тендерийн ажил зарлагдсан. Тус төлөвлөлтөд стандартад нийцсэн хөл бөмбөгийн талбай болон граундгольфын талбайг төлөвлөсөн.	
46		49. Зарим сумдад спортын ордон байгуулна.	2022 - 2024			Эрдэнэ сумын Соёл спортын цогцолборын барилгын зураг төслийг боловсруулах ажлыг 2022 онд "ТГТ" ХХК-аар гүйцэтгүүлсэн. Алтанширээ суманд спорт зал шинээр барих ажлын зураг төслийг 2023 онд "Би Өү Экс Экс" ХХК боловсруулж, орон нутгийн төсвийн 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Алтанширээ суманд Спорт заал барих ажлын тендер шалгаруулалтыг 2024 оны 05 сарын 22-ны өдөр нээж "Эйбол" ХХК шалгарч гэрээ байгуулсан.	30%
47	2.2.3. "Өсвөрийн шигшээ баг"- ийн үйлажиллагааг дэмжих арга хэмжээ (2021-2024)-ний хүрээнд их спортын төрөл, шигшээ багийг нэмэгдүүлж, гадаад, дотоодын тэмцээн уралдаанд оролцох тамирчдыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.	52. Их спортын төрөл, шигшээ багийг нэмэгдүүлж, олон улс, улс, бүсийн тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулна.	2021 - 2024		9/3	2020 онд спортын 8 төрөлд 370 тамирчин хичээллэдэг байсан өсвөр үеийн шигшээ багийг 2024 онд 11 төрлөөр хөгжүүлэн, үйл ажиллагааг дэмжин ажилласан. Тайлант хугацаанд өсвөр үеийн шигшээ багт 630 гаруй тамирчид хичээллэж байгаа нь тамирчид 36,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал: Жюү жицүгийн "Дорноговь опен" Дэлхийн чансааны 800 оноо олгох бүсийн зэрэглэлийн Олон улсын тэмцээнийг зохион байгууж 4 улсын 30-аад клубын 600 орчим тамирчин оролцсон. Өсвөрийн тамирчид, залууст зориулан "Хөгжлийн лиг-2024", "Шинэ эхлэл" хүүхдийн лиг, "Gobi guys" Сагсан бөмбөгийн лигийн тэмцээнийг зохион байгуулж 1500 гаруй тамирчид өрсөлдөж, 8000 гаруй хүн үзсэн. Шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээн, Дугуйн тэмцээн, чөлөөт бөх, жүдо бөх, Даам, шатрын өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, Боксын аймгийн аварга шалгаруулах тэмцээн, аймгийн ЕБ 1 дүгээр сургуулийн 100 жилийн ойд зориулсан сагсан бөмбөг, волейболын тэмцээн зэрэг Олон улсын болон аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд аймаг орон нутагтаа зохион байгуулж давхардсан тоогоор 25,772 тамирчин оролцсон.	100%

48		53. Өсвөрийн шигшээ багийн төрлийн тоо, медалийн чанарыг нэмэгдүүлж, багш дасгалжуулагчдыг урьж хамтран ажиллах	2021 - 2024		11 450 3	<p>Өсвөрийн шигшээ багийн төрлийн тоо, медалийн чанарыг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын спортын мастер боксын дасгалжуулагч Г.Баасанг 3 жилийн хугацаатай урьж хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. 2022 оноос аймгийн өсвөр үеийн шигшээ багт хичээллэгдэж буй тамирчид 36,5 хувиар өссөн.</p> <p>2024 оны хагас жилийн байдлаар өсвөр үеийн шигшээ баг Ширээний теннис, Хөл бөмбөг, Гандболын спортын холбоо, клубтэй хамтран ажиллаж, Сагсан бөмбөг, Жүдо бөх, Гандбол, Чөлөөт бөх, Хөл бөмбөг, Бокс, Хөнгөн атлетик, Волейбол, Ширээний теннис зэрэг 11 төрлөөр тогтмол үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>2024 оны хагас жилийн байдлаар аймгийн өсвөр үеийн шигшээ багт 635 гаруй тамирчид хичээллэж, Улсын аварга шалгаруулах тэмцээнд алтан медаль 12, мөнгөн медаль 6, хүрэл медаль 11 хүртсэн. Боксын өсвөрийн шигшээ багийн тамирчин алуучуудын азийн аварга шалгаруулах тэмцээнд хүрэл медаль авсан.</p> <p>2020 оноос 2024 оны хагас жил хүртлэх хугацаанд давхардсан тоогоор өсвөрийн 30 гаруй шигшээ багийг бэлдэж Олон Улс, аймаг, орон нутаг, бүсийн чанартай 100 гаруй тэмцээнд оролцож 214 орчим медалийг хүртсэн амжилт үзүүлсэн. Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд алтан медаль 36, мөнгөн медаль 34, хүрэл медаль 57, Улсын аварга шалгаруулах тэмцээнд алтан медаль 17, мөнгөн медаль 11, хүрэл медаль 18, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд алт 17, мөнгө 13, хүрэл 14 медаль хүртсэн амжилттай. Монголын Хүүхдийн спортын зуны VII наадмын шигшээ тэмцээнд өсвөрийн шигшээ багийн тамирчид спортын 8 төрлөөр 71 тамирчид оролцож, нийт алт 2, мөнгө 3, хүрэл 5 медаль хүртсэн амжилттай оролцсон. 2020-2024 оны хагас жилд өсвөрийн шигшээ баг давхардсан тоогоор 32 төрлөөр 1600 гаруй өсвөрийн тамирчид хичээллэж, 9 багш, дасгалжуулагчтай хамтран ажиллалаа.</p>	100%
49		54. Тив, дэлхий, олимп, улс, бүсийн чанартай тэмцээнд оролцох тамирчид, дасгалжуулагчдад	2021 - 2024		80	<p>Дорноговь аймгийн Засаг даргын 2021 оны А/171 дүгээр захирамжаар “Өсвөр үе, залуучуудын шигшээ баг”-ийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь үргэлжлүүлэн дэмжих арга хэмжээг батлан, тив, дэлхий, улсын хэмжээнд аймаг, орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөн, медаль хүртсэн тамирчид, бэлтгэл сургуулилтыг ханган оролцуулсан дасгалжуулагчдыг</p>	100%

		дэмжлэг, урамшуулал олгох			<p>урамшуулан, тэдний амжилтыг ахиулах зорилгоор: 2022 онд улс, бүс, аймгийн чанартай 32 тэмцээн, уралдаан зохион байгуулан оролцож, улсын чанартай тэмцээн, наадмаас 53, бүсийн тэмцээнээс 122, аймгийн тэмцээнээс 370, нийт 545 медаль хүртсэн амжилт үзүүлсэн нь медалийн тоо, чанар 2021 оноос 100%-аар өссөн.</p> <p>Спортын арга хэмжээ болон тамирчдын амжилтыг ахиулахад зориулж орон нутгийн төсвөөс 80,0 сая, байгууллагын төсвөөс 66,0 сая, нийт 146,0 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>2021 онд аймгийн Засаг даргын А/40 тоот захирамжаар 6,590,000₮-р 48 тамирчид, дасгалжуулагчдыг урамшуулсан. 2022 онд аймгийн Засаг даргын А/49 тоот 2,950,000₮-р 32 тамирчид, дасгалжуулагчдыг, 2023 онд аймгийн Засаг даргын А/191 тоот захирамжаар 23,500,000₮-р 100 тамирчид, дасгалжуулагчдыг дэмжин урамшуулсан нь 2022 оноос 68 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>2023 онд Тив, дэлхий, улсын хэмжээнд аймаг, орон нутгаа төлөөлөн оролцож оролцсон тамирчдад 16,220 сая төгрөгний замын болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. 2024 оны хагас жилд Олон улс, бүсийн тэмцээнд оролцох тамирчид, дасгалжуулагчдыг дэмжин 19.564.000₮-р замын зардла, унаа тэрэг, шатахуун болон холбогдох зардлуудыг шийдвэрлэж өгсөн.</p> <p>2024 оны хагас жилийн байдлаар аймаг орон нутагтаа бөхийн нэгдсэн холбоодын чуулган зөвлөгөөнийг зохион байгуулж 7,835,000₮, шагайн харвааны тэмцээнд зориулж 1,328,400₮, "Шинэ эхлэл" хүүхдийн лигийн тэмцээнийг 27,288,000₮-р зохион байгуулж 1000 гаруй өсвөрийн тамирчид, холбоодууд болон дасгалжуулагчдыг оролцуулсан.</p>	
50	2.3.1. "Чадварлаг багш" зорилтод хөтөлбөрийг хэрэгжүүлж, мэргэжлийн чадварыг дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг	55. "Хүүхэд бүр цэцэрлэгт" сургалтын арга хэмжээ зохион байгуулах	2021 - 2024	96%/99%	<p>Цэцэрлэгийн буюу 2-5 насны 6197 хүүхэд байгаагаас төрийн өмчийн цэцэрлэгт 5025, төрийн бус өмчийн 1 цэцэрлэгт 38, төмөр замын 6 цэцэрлэгт 714, нийт 5777 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж, СӨБ-ын хамран сургалтын бохир жин 93,3 хувьтай байна. Нийт 5 настай 1565 хүүхэд байгаагаас төрийн өмчийн цэцэрлэгт 1298 хүүхэд, хувилбарт сургалтад 43 хүүхэд, төмөр замын цэцэрлэгт 167 хүүхэд хамрагдсан. Мөн сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдвал зохих малчин өрхийн 842 хүүхэд, тусгай хэрэгцээт 31 хүүхдийг бүрэн хамруулсан.</p>	100%

	<p>бодитой болгож, нийгмийн баталгааг ханган, Боловсролын байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлж, орчин нөхцөлийг сайжруулна.</p>				<p>Аймгийн Засаг даргаас НҮБ-ын хүүхдийг ивээх сантай 2023 онд байгуулсан санамж бичгийн хүрээнд "Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих төв" ТББ-тай хамтран "Бага насны хүүхдийн цогц хөгжилд эцэг эх асран хамгаалагчийн оролцоо" сэдэвт 5 удаагийн цогц сургалтыг 2023-2024 онд зохион байгуулж, аймгийн хэмжээнд 20 сургагч багш бэлтгэн, бага насны хүүхэдтэй нийт 4202 эцэг, эхэд зөвлөгөө мэдээллийг хүргэн ажилласан.</p> <p>Мөн сургууль цэцэрлэгийн залгамж холбоог бэхжүүлэх зорилгоор бэлтгэл бүлгийн багш нар, сургуулийн бага боловсролын багш нар хамтран, сургуулийн 192 багш, 22 сургалтын менежер цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн 45 багш, давхардсан тоогоор 800 эцэг эх, 1100 гаруй хүүхдийг хамруулсан 32 удаагийн уулзалт, сургалт, арга хэмжээг зохион байгуулсан. СӨБ-ийн хамран сургалт 96.3% байгаа нь өмнөх оноос 2.1%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</p> <p>Үүнээс хамран сургалтын цэвэр жин 92.9%, 5 настай хүүхдийн хамрагдалт 96.4% болж, 2020 онтой харьцуулахад цэвэр жин 9.2%-иар, 5 настай хүүхдийн хамрагдалт 2.3%-иар ахисан.</p>	
51		<p>56. "Анги хамт олны олимпиад", "Зорилгын хүч", "Дэвжээ" зэрэг олон талт арга хэмжээ зохион байгуулах</p>	<p>2021 - 2024</p>		<p>8/39.1%</p>	<p>100%</p>

Элсэлтийн шалгалтад бэлтгэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, суралцагчдыг идэвхжүүлэх, шалгалтад амжилттай үнэлгээ авахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд уламжлал болгон зохион байгуулдаг "Зорилгын хүч" сургалт, үйл ажиллагааг жил бүр зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын 2024 оны А/259 захирамжаар 11,475,240 төгрөгийг шийдвэрлэн, "Зорилгын хүч-5" сургалт, үйл ажиллагааг зорилгын хуудас бөглүүлэх, танхимын сургалт зохион байгуулах, анги хамт олны бүтээлч ажил өрнүүлэх, дэвжээ тэмцээн зэрэг шинэлэг байдлаар зохион байгуулж, 10 сургуулийн элсэлтийн шалгалт өгөх 12-р ангийн 27 бүлгийн 711 суралцагчийг хамруулсан.

"Зорилгын-Хүч-5" үйл ажиллагааны хүрээнд 10 судлагдахуунаар мэргэжлийн зэрэгтэй 35 багш удирдан 278 цагийн сургалт хийж, давхардсан тоогоор 3128 суралцагчийг хамрууллаа.

Сурагчдын хоцрогдлыг арилгах, гүйцэтгэлийн үнэлгээнд ахиц гарган, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор 1-12-р ангид дизайн технологи, англи хэл, орос хэл, эрүүл мэнд, математик, физик, бага анги /монгол хэл, математик, хүн ба

					<p>байгаль/, үндэсний бичиг судлагдахуунаар “Анги хамт олны олимпиад”-ыг 2 үе шаттайгаар зохион байгуулж, давхардсан тоогоор 1098 бүлгийн 57111 суралцагч хамрагдаж, гүйцэтгэл 3,7 %-ийн ахицтай, судлагдахуун бүрийн гүйцэтгэлийн хувь жил бүр 1.5%-18.9%-иар ахисан.</p> <p>2020-2024 онд “Зорилгын хүч”, “Дэвжээ” тэмцээн “Анги хамт олны олимпиад”-ыг жил бүр зохион байгуулснаар ЭШ-д амжилттай дүн үзүүлж, 2021 онд 2-р байр, 2022 онд 5-р байр, математикийн судлагдахуунаар 2021 онд хэмжээст оноо 9,4-өөр ахиж 3-р байр, 2023 онд хэмжээст оноо 14-өөр ахисан үзүүлэлттэй байна.</p> <p>Элсэлтийн ерөнхий шалгалтад 2022, 2023 онд 800 оноо авсан 2 сурагч, бэлтгэсэн 2 багш, 700 ба түүнээс дээш оноо авсан 25 сурагч, 21 багшид нийт 20,5 сая төгрөгийн урамшуулал олгосон.</p>	
52		57. Багш нарын ур чадвар, сурган хүмүүжүүлэх илтгэлийн уралдаан, хичээл төрлийн олимпиад зохион байгуулах	2021 - 2024	3	<p>Багш нарын сурган хүмүүжүүлэх уншлагад бэлтгэх, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх, туршлага түгээн дэлгэрүүлэх зорилгоор шилдэг илтгэл шалгаруулах “Хамтын оролцоонд суурилсан сургалтын байгууллагын менежментийг хөгжүүлэх нь” сэдэвт аймгийн багш нарын эрдэм шинжилгээний хурлыг цахим болон танхим хосолсон хэлбэрээр 2 үе шаттай зохион байгууллаа.</p> <p>Эрдэм шинжилгээний хуралд 24 сургууль, цэцэрлэгийн багш, заах аргын нэгдэл, багш нарын хамтарсан багууд оролцож, туршлага, мэдлэгээ хуваалцсан.</p> <p>Мөн сургуулийн багш нар нэгдэн улсын шилдэг илтгэл шалгаруулах уралдаанд “Ментор эцэг эх”-ээр дамжуулан сургалтын байгууллагын менежментийг хөгжүүлэх боломж сэдэвт илтгэлээр амжилттай оролцлоо.</p> <p>Аймгийн хичээл төрлийн олимпиадын 2-ын даваанд амжилттай оролцож шалгарсан 11 судлагдахууны 16 багш, 46 сурагч улсын олимпиадад оролцсоноос 3 багш, 9 сурагч шагналт байруудад шалгарсан.</p> <p>Багш нарын ур чадвар, сайн хичээл-үйл ажиллагааг аймгийн хэмжээнд 40 цэцэрлэг, сумдын 4 бүсийн хэмжээнд 2 үе шаттайгаар зохион байгуулсан.</p> <p>Удирдах ажилтан, багш нарын мэргэжил онол, арга зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой эрхлэгч, арга зүйч, багш нарын бүрэлдэхүүнтэйгээр 7 төрлөөр зохион байгуулж,</p>	100%

					<p>сумдаас баруун бүсийн 10 цэцэрлэг багаараа шалгарч, арга туршлагаа түгээн дэлгэрүүллээ.</p> <p>2021-2024 онд “Сурган хүмүүжүүлэх илтгэл”, “Сайн хичээл” ур чадварын уралдаан, “Хичээл төрлийн олимпиад”-ыг СӨБ, ЕБС-ийн багш сурагчдын дунд жил бүр зохион байгуулснаар сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээнд 69.85%-тай шалгагдаж, өмнөх оноос 10 сургуулийн үнэлгээ ахисан.</p> <p>Цэцэрлэгийн гүйцэтгэлийн үнэлгээнд 89.05%-тай шалгагдаж, өмнөх оноос 6.4%-ийн ахиц гарсан.</p>	
53	58. "Алтан зул" арга хэмжээ зохион байгуулах	2021 - 2024	-	<p>Боловсролын байгууллагад үр бүтээлтэй ажиллаж, мэргэжлийн өндөр ур чадвар, эвсэг, хөдөлмөрч чанар, хамтын ажиллагаагаараа бусдадаа үлгэр жишээ болж буй шилдэг баг хамт олныг шалгаруулах "Алтан зул-2023" наадмыг шинэлэг хүртээмжтэй байлаар зохион байгуулсан.</p> <p>"Алтан зул-2023" арга хэмжээнд 24 сургууль, 33 цэцэрлэгийн 1300 гаруй багш ажилтан оролцож, 7 номинацийн хүрээнд шилдгүүдийг шалгаруулж урамшуулсан.</p> <p>"Аж ахуйн шилдэг баг"-аар Замын-Үүд сумын хүүхдийн 5-р цэцэрлэгийн хамт олон, "Шилдэг заах аргын нэгдлийн баг"-аар Сайншанд сумын ЕБ-ын 3-р сургуулийн бага ангийн заах аргын нэгдэл, "Судлагдахууны шилдэг баг"-аар Замын-Үүд сумын ЕБ-ын 1-р сургуулийн "Элсэлтийн ерөнхий шалгалтын баг", "Сургуулийн өмнөх боловсролын шилдэг байгууллага"-аар Сайншанд сумын 12-р цэцэрлэгийн хамт олон, "ЕБ-ын 9 жилийн шилдэг сургууль"-аар Улаанбадрах сумын ЕБ-ын сургуулийн хамт олон, "ЕБ-ын 12 жилийн шилдэг сургууль"-аар Замын-Үүд сумын ЕБ-ын 3-р сургуулийн хамт олон, "Шилдгийн шилдэг баг, хамт олон"-оор Замын-Үүд сумын хүүхдийн 4-р цэцэрлэгийн хамт олон шалгарч алтан зул цомын эзэд болсон.</p> <p>Мөн тус арга хэмжээгээр боловсролын салбарт хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөрүүд, шинэчлэлийг харуулсан биологийн бүс, химийн бүс, физикийн бүс, "STEAM", "Робот ба программчлалын бүс", "Гар урлалын бүс", "AR", "VR технологийн бүс", "Сэтгэлийн үг" уран зохиолын бүс зэрэг 9 судлагдахууны үйл ажиллагааг танилцуулах, туршилтын эвент арга хэмжээг зохион байгуулж, багш, сурагчид, олон нийтэд сурталчлан танилцуулсан.</p>	100%	
54	59. "Багш спорт", "Багш авьяас" арга	2021 - 2024	1	"Багшийн авьяас-2021" арга хэмжээг Сайншанд, Замын-Үүд сумын ЕБС, СӨБ-ын багш, ажилтнууд нийт 154 авьяастнуудыг	100%	

		хэмжээ зохион байгуулах			<p>хамруулан теле тоглолт хэлбэрээр бэлтгэн, 2800 үзэгчдийн хүртээл болголоо.</p> <p>“Багш спорт-2022” спортын наадмыг Сайншанд суманд зохион байгуулж, 59 боловсролын байгууллагын 25 багийн 470 тамирчдыг хамруулан спортын 5 төрлөөр зохион байгуулсан.</p> <p>Жил бүр уламжлал болгон улсын хэмжээнд зохион байгуулагддаг “Хөдөөгийн багш нарын спортын наадам”-д 2 удаа оролцоход зориулж аймгийн Засаг даргын захирамжаар 9,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн ба 42 хүний бүрэлдэхүүнтэй баг, тамирчид амжилттай оролцсон.</p> <p>Тус наадамд сагсан бөмбөг, волейбол, даам, шагайн харваа, теннис зэрэг спортын 5 төрлөөр баг, тамирчдыг бэлтгэн оролцуулж, харилцан туршлага солилцон, тамирчдын ур чадварыг нэмэгдүүлсэн.</p> <p>Мөн багш нарын ур чадвар, авьяасыг дэмжин олон улс, улс, бүсийн уралдаан, тэмцээнд амжилттай оролцсон багш нар болон шавь нараа бэлтгэн амжилттай оролцуулсан нийт 13 багшид 11,5 сая төгрөгийн дэмжлэг, урамшуулал олгосон.</p> <p>“Багш дор мөргөмүй” багшийн багшийн багшийг алдаршуулах арга хэмжээг зохион байгуулж, боловсролын байгууллагад гэр бүлээрээ хамтран зүтгэсэн 8 ахмад багшид хүндэтгэл үзүүлж, багшийн багшийн шавь 14 багшийг алдаршууллаа.</p>	
55		60. Орон нутагт нэн шаардлагатай багш нарыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх	2021 - 2024	15	<p>"Алсын хараа-2050" Монгол улсын Засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлогын “Хөдөөгийн сэргэлт” зорилтын хүрээнд боловсролын үйлчилгээ, хүртээмжийг сайжруулах, шилдэг мэргэжилтнүүдийг Дорнын говь нутагтаа урин ажиллуулах, мэдлэг, чадвар, арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Ирээдүйн төлөө” хөтөлбөрийн сонгон шалгаруулалтын шаардлагыг хангасан англи хэлний 3 багш, орос хэлний 1 багш, удирдах ажилтан 1, боловсролын салбарын нийт 5 багш, удирдах ажилтныг 5 жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах гэрээгээр орон сууцаар ханган ажиллуулж байна.</p> <p>Дуу хөгжмийн багш болон хөгжимчин мэргэжлээр суралцаж байгаа 9 оюутанд жил бүр сургалтын төлбөрийн 100%-ийн дэмжлэг үзүүлж, нийт 90.0 сая, бусад мэргэжлээр 10 оюутанд нийт 25.0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн.</p>	100%

					<p>Мөн цэцэрлэгийн хөгжмийн багш нарын мэргэжлийн хөгжлийн бүлгийг байгуулж, харилцан туршлага солилцон хамтран ажиллах, МУБИС-ийн хөгжмийн тэнхимийн багш нарын “Хөгжим заах арга зүй”-н сургалтыг орон нутагтаа 2 удаа зохион байгуулсан.</p> <p>ЕБС-ийн 144 багш, удирдах ажилтан магистр зэрэгтэй ба 2023-2024 оны хичээлийн жилд магистрын хөтөлбөрт 10 багшийг хамруулсан.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны яам, Сургуулийн судалгаа хөгжлийн “Шинэ Монгол төв”-өөс 2023-2024 оны хичээлийн жилд “Төрийн өмчийн сургуулийн менежментийг сайжруулах төсөл”, “Шинэ Монгол” сургуулийн сургалтын хөтөлбөрийг Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2, 6 дугаар сургууль, Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд хэрэгжүүлж, нийт багш нарыг чадавхжуулах сургалтад хамруулсан. “Шинэ Монгол” сургуулийн сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэхэд аймгийн Засаг даргын 2023 оны А/628 дугаар захирамжаар 12,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн ба төсөл нийт 1,5 жилийн хугацаанд хэрэгжинэ.</p> <p>Нийт багшлах боловсон хүчний хангалтын хувь 2024 онд 90,5 байгаа нь өмнөх оноос 1,8 хувиар өссөн байна.</p> <p>Мөн 2020 онд 94.2 хувьтай байсан нь сургуулийн тоо цөөн байснаас хамаарч багшийн дутагдал бага байсан.</p>	
56		61. Их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж магистр зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэх	2021 - 2024	2/6	<p>АШУҮИС-ийн Дорноговь дахь салбар сургуулийн 43 багшийн 98% нь магистр, Политехникийн коллежийн 43 багшийн 46.5% буюу 20 багш магистр зэрэгтэй байгаа нь өмнөх оноос 2 хувиар өссөн.</p> <p>Сургуулийн өмнөх боловсролын 60 багш, удирдах ажилтан магистр зэрэгтэй ажиллаж байгаа бөгөөд зөвхөн энэ жил 15 багш, удирдах ажилтан магистрын хөтөлбөрт, 1 эрхлэгч докторантад шинээр элсэн суралцаж байна.</p> <p>ЕБС-ийн 144 багш, удирдах ажилтан магистр зэрэгтэй ба энэ онд магистрын хөтөлбөрт 10 багш хамруулсан.</p> <p>Мөн аймгийн "Политехник коллеж" нь "ХААИС", "ҮТИС", "Техник технологийн дээд сургууль"-тай хамтран ажиллаж багш, оюутнуудаа суралцуулах гэрээ байгуулсан.</p> <p>Мөн Глобал удирдагч их сургууль, Улаанбаатар их сургууль, Отгонтэнгэр их сургуульд ЕБС болон СӨБ-ын 4 багш магистрт суралцаж, нийт шинээр 39 багш, удирдах ажилтан магистр зэрэгтэй болохоор ажиллаж байна.</p>	100%

					<p>“Гүүр” төсөл, хөтөлбөрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлж эхлээд байна.</p> <p>Төсөл, хөтөлбөрийн хүрээнд сум, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор Иххэт суманд “Оролцоонд суурилсан орон нутгийн стратеги төлөвлөгөө” боловсруулах ажил, сургалтын байгууллагын орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургууль, Политехник коллежийн лаборатори, практик сургалтын танхимыг сайжруулах төсөл болон гадаадын их, дээд сургуулиудын тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.Төлөвлөгөөний дагуу орон нутагт эрэлттэй мэргэжлээр гадаадын их, дээд сургуульд суралцах хүсэлтэй 132 суралцагчийн судалгааг гаргасан.</p> <p>Судалгаанд үндэслэн хөтөлбөрийн хүрээнд тэтгэлэгт хамруулах үйл ажиллагааг 2024 оны 09 дүгээр сараас зохион байгуулахаар төлөвлөсөн.</p> <p>“Гүүр” төсөл, хөтөлбөр нийт 2 жилийн хугацаанд хэрэгжих ба 2024 оны эхний хагас жилийн төлөвлөгөө 90%-тай байна.</p> <p>Боловсролын салбарт ажиллаж байгаа магистр зэрэгтэй удирдах ажилтан, багш нарын тоо 2020 онд 143 байсан бол 2024 оны байдлаар 197 болж 37.8 хувиар өссөн.</p>	
57		72. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн урлаг, биеийн тамирын танхимыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2021 - 2024	2	<p>Сайншанд сумын 2 ЕБС-д "ТИКА" олон улсын байгууллагын дэмжлэгээр сургуулийн урлаг заалны их засвар хийгдсэн.</p> <p>Дагалдах тоног төхөөрөмж болох 10 өнгийн гэрэл, 2 чанга яригч, 1 чадал, 1 өсгөгч худалдан авсан. Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургууль 5 төрлийн 6,1 сая төгрөгийн техник хэрэгсэл, биеийн тамирын спорт зааланд 7 төрлийн 9 ширхэг 7.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн.</p> <p>Мандах сумын ерөнхий боловсролын сургуульд чөлөөт бөхийн дэвжээ, сагсны бөмбөг 20 ширхэг, гар бөмбөг 20 ширхэг, хөл бөмбөг 10 ширхэг, теннисийн ширээ 1, модон морь, волейболын сетка, бөмбөгний сав, дасгалын бөмбөг, ханын шат, олс зэрэг нийт 11,3 сая төгрөгийн хэрэгцээт зүйл худалдан авсан. Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгт орон нутгийн хөгжлийн сангийн 19,9 сая төгрөгөөр гадна тоглоом, биеийн тамирын талбайн тохижилт хийгдсэн ба ерөнхий боловсролын сургуульд чөлөөт бөхийн 2 өмсгөл, 2 зодог шуудаг, 5ш сагсан бөмбөг, 9ш гар бөмбөг, 1ш онооны электрон самбар зэргийг худалдан авсан.</p>	100%

					<p>Замын-үүд сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгт засаг даргын нөөц хөрөнгөөс 3,5 сая төгрөгийн биеийн тамирын багц тоглоом нийлүүлсэн.</p> <p>Мөн Сайншанд сумын ерөнхий боловсролын 6 сургуульд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 29,4 сая төгрөгийн биеийн тамирын иж бүрэн сагсны шийд худалдан авсан. 2020 онд урлаг, биеийн тамирын танхимыг шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 60 хувьтай байсан бол 2024 онд 90 хувьд хүрсэн.</p> <p>2024 онд 4 сургууль, 2 цэцэрлэг тоног төхөөрөмжөөр хангагдсан.</p>	
58	73. Насан туршийн боловсролыг тэгш хүртээмжтэй хүргэх шинэлэг арга хэмжээг зохион байгуулах	2021 - 2024	2	<p>Насан туршийн боловсролын төвийн орчин нөхцөлийг сайжруулах, иргэдэд чиглэсэн олон талт сургалтыг зохион байгуулах анги танхимаар хангах зорилгоор монгол бичгийн кабинетыг байгуулж 10,000,000 сая төгрөгийн 8 нэр төрлийн 90 ширхэг тоног төхөөрөмж, сурах бичиг сургалтын хэрэглэгдэхүүн, Азийн хөгжлийн банкны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн хүрээнд 18,993,870 төгрөгний 18 нэр төрлийн 45 ширхэг сургалтын тоног төхөөрөмжөөр хангасан.</p> <p>ХГБХХЕГ-ын сургалтын албанаас "Гэр бүлийн боловсролын сургагч багш бэлтгэх 5 модуль хөтөлбөр"-тэй сургалтыг аймгийн Засаг даргын 7,0 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж, 20 багшийг сургагч багшаар бэлтгэж улмаар гэр бүл, хүүхэд хүмүүжил, гэр бүлийн харилцааны сургалт мэдээллийг 444 өдөрлөгөөр дамжуулан эцэг эхчүүд хүүхдүүд, байгууллагуудад тогтмол явуулж хэвшсэн.</p> <p>Тайлант хугацаанд амьдрах ухааны 82 удаагийн сургалтад 3753, Гэр бүлийн боловсрол олгох 62 сургалтад 3040, Иргэний боловсрол олгох 74 удаагийн сургалтад 2450 хүн, ёс суртахууны боловсрол олгох 68 удаагийн сургалтад 2900, Гоо зүйн боловсрол олгох 83 удаагийн сургалтад 1204, Шинжлэх ухаан, мэдээллийн технологийн 32 сургалтад 803, Тусгай хэрэгцээт боловсрол олгох 52 удаагийн сургалтад 1240, Санхүүгийн боловсрол олгох 5 удаагийн цахим сургалтад 805 хүн хамрагдсан.</p> <p>Цахим болон танхим хосолсон 458 удаагийн сургалтад 13984 иргэнийг хамруулсан.</p>	100%	

						Сургалтын тоо, чанар жил бүр 10%-35% өссөн үзүүлэлттэй байна.	
59		74. Насан туршийн боловсролын төвийн ажиллах нөхцөлийг сайжруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалтын танхим байгуулах	2021 - 2024		-	<p>Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1-р сургуульд 2022 онд нийт 30,4 төгрөгийн хөрөнгө оруулалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай хэрэгцээт хөтөлбөрийн хичээлийн танхимыг байгуулж, 2023-2024 оны хичээлийн жилд системд бүртгэлтэй 25 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас танхимаар 12 хүүхэд суралцаж байна.</p> <p>Энэ нь өмнөх оноос бүртгэл 4 хүүхэд, танхимаар суралцагч 3 хүүхэд нэмэгдсэн.</p> <p>Тусгай хэрэгцээт хүүхдийн кабинетын үйл ажиллагааг тогтмолжуулан, сургалтыг мэргэжлийн 2 багш хичээллүүлж, 12 сурагч тогтмол суралцаж байна.</p> <p>Хүүхэд бүрт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнийг гарын доорх материалаар хийн, сургалтад ашиглаж, бие бялдрыг чийрэгжүүлэх өрөөг тохижуулсан.</p> <p>Мөн Насан туршийн боловсрол төвөөс “Эрүүлжин хөгжих төв”-ийн 9 хүүхдэд сургалт зохион байгуулж, тус төвийн багш нартай хамтран ажиллаж, туршлага солилцон ажилласан.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамруулан сургах, спортоор дамжуулан хөгжүүлэх, авьяас чадварыг зорилгоор Монголын Тусгай Олимпын Хороотой хамтран “Family health forum” сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, биеийн тамирын багш, нийгмийн ажилтан, эмч, эцэг эх, асран хамгаалагч нарын 60 төлөөлөл, 17 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулсан.</p>	100%
60	2.3.2. Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монголын түүх, хэл, соёл, ёс заншлаа мэддэг, эх орноороо бахархдаг төлөвшсөн ухаалаг иргэдийг бэлтгэх арга	75. "Хутагтын нутгаар", "Торгон хил" сэдэвт болон бусад арга хэмжээг зохион байгуулж, оролцоог нэмэгдүүлэх	2021 - 2024		1200	<p>Сурагчдад эх оронч хүмүүжлийг олгох, эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх зорилготой “Торгон хил- Миний нутаг” орон нутгийн онцлогтой хөтөлбөрийн хүрээнд 14 сургуулийн 56 багш удирдлага, 776 сурагч, 37 эцэг, эхийг хамруулан зохион байгуулсан.</p> <p>2022 онд 42 сурагчийг хамруулан торгон хилээр аялж байсан бол 2023 онд сумд, сургуулиуд өөрсдийн нутгийн онцлогт тохируулан зохион байгуулж, 776 сурагч хамруулснаар 734 сурагчаар нэмэгдсэн.</p> <p>Мөн 2024 онд “Орон нутгийн онцлогтой хөтөлбөр”-өөр Замын-Үүд сумын ЕБ-ын 1-р сургууль, “Үлэмж тэнгэр” ЕБ-ын сургууль болон Зүүнбаянгийн сургууль “Торгон хил-Эх орон”</p>	100%

	хэмжээг цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ.					сэдвээр 658 суралцагч, 110 багш ажилчид болон эцэг эх, иргэд 56 нийт 824 хүнийг хамруулан зохион байгуулсан.	
61		76. Байгаль орчин, шинжлэх ухаан, танин мэдэхүйн олон талт арга хэмжээнд хүүхдүүдийг өргөнөөр хамруулан, орон нутгийн түүх, соёлыг таниулах	2021 - 2024		1000	<p>Монгол улсад Азийн физикийн 23-р олимпиадыг 2023 онд зохион байгуулах ажлын хүрээнд БШУЯ, БЕГ, ЕБС-иуд зэрэг 12 байгууллага хамтран “Физик танин мэдэхүйн” өдөрлөгийг зохион байгуулсан.</p> <p>Тус өдөрлөгөөр багш, сурагчдад 2 өдөр 8 сэдвээр МУИС-ийн 4 доктор сургалт зохион байгуулан 70 багш, сурагч хамруулж физикийн хичээлийн туршилтуудыг 7 өртөөгөөр үзүүлэн, 1000 гаруй сурагч туршилтыг үзэж сонирхон, өөрсдөө туршилт хийсэн.</p> <p>“Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд Бага боловсролын эх хэл, математик чадварыг ахиулахад дэмжлэг болох зорилготой “Унших ба тоо бодох” чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаанд нийт 20 сургууль, бага ангийн сурагчдын хоцрогдлыг нөхөх, сурах идэвхийг нэмэгдүүлэх зорилготой “Тоглонгоо суралцъя” хөтөлбөрт 4 сургууль хамруулж, “Стем” хэрэглэгдэхүүнийг ЕБС-н бага ангийн сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах чадварыг дэмжих, багш нарын шилдэг арга зүй туршлагыг илрүүлэн түгээн дэлгэрүүлэх зорилгоор үндэсний хэмжээнд зохион байгуулсан.</p> <p>“Бүтээлч багачууд,шилдэг арга зүй” уралдаанд төрийн өмчийн 20 сургуулийн 200 гаруй бага ангийн багш, 5000 гаруй сурагчид амжилттай оролцсон.</p> <p>Аймгийн төв музей, Данзанравжаагийн музей, аймгийн сүм хийд, кино театр зэргээр зугаалга хийж, олж мэдсэн зүйл, хүүхэд өөрийн санаа бодлоо зургаар илэрхийлэн бусдадаа тайлбарлан ярих, үзэсгэлэн гаргах, илтгэл тавих зэрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон.</p> <p>“Хүүхдэд ээлтэй орон нутаг” зорилтот хөтөлбөрийн хүрээнд сургууль, цэцэрлэгүүд “Орон нутгийн онцлогт тохирсон хүүхэд хөгжлийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан нийт 76 үйл ажиллагаанд 9528 хүүхдийг хамруулсан.</p> <p>Шинжлэх ухаан, танин мэдэхүйн тэмцээн, уралдаанд 2021-2024 онуудын зохион байгуулсан арга хэмжээнүүдэд нийтдээ 546 сурагч хамрагдаж шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдлэгээ дээшлүүлсэн.</p>	100%

62	<p>2.3.3. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг дэмжихүндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж сургуулиудыг үе шаттай “Үдийн хоол” үйлчилгээнд шилжүүлэн, шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангана</p>	77. “Үдийн хоол” арга хэмжээг хэрэгжүүлэх	2021 - 2024		23	<p>Ерөнхий боловсролын 9 сургууль түрээсийн гал тогоогоор, 13 сургууль дотуур байрны гал тогоонд хоол үйлдвэрлэлээ явуулж сурагчдад үйлчилж байна.</p> <p>Бага насны хүүхдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор Сайншанд сумын 1, 2, 9, 12-р цэцэрлэг, Замын-Үүдийн 2, 4, 5, 6-р цэцэрлэг “Өдөр бүр 100 гр сүү” аяныг эцэг эхчүүдийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж хэвшсэн.</p> <p>“Хүүхдийн хоол” сэдэвт хэлэлцүүлгийг БШУГ, ХХААГ, ЭМГ хамтран цахим болон танхимаар зохион байгуулж 22 сургууль, 36 цэцэрлэгийн нийт 150 гаруй эцэг эх, асран хамгаалагчийг оролцуулсан.</p> <p>БЕГ, ШУТИС болон Монголын ложистикийн холбооны “Хүнсний хангамж”-ийн 5 төрлийн судалгаанд ЕБ-ын 22 сургуулийн 733 багш, 8623 эцэг эх хамруулсан.</p> <p>“Алсын хараа-2050” МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан чанартай амьдралын баталгаа, эрүүл монгол хүний суурь үндэс болсон хүүхдийн хоол хүнсний чанар, хүртээмжийг сайжруулах, хоол шим тэжээлийн боловсрол олгох нийгмийн олон талт асуудлыг шийдвэрлэх боломжийн хүрээнд зохион байгуулсан “Хүүхдийн хоол-Хөгжил” сэдэвт 3 удаагийн үндэсний чуулганд 19 удирдлага, мэргэжилтэн оролцсон.</p> <p>Ерөнхий боловсролын 22 сургуулийн бага ангийн 7800 гаруй хүүхэд үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байна.</p> <p>Үдийн хоолны зардал нэг өдрийн 1500 төгрөг, дотуур байранд 745 хүүхэд хамрагдаж хоолны зардалд 4300 төгрөг, цэцэрлэгийн хүүхэд өдөрт 2475 төгрөгийн зардлаар хоол үйлдвэрлэлийн үйлчилгээнд бүрэн хамрагдаж, сургууль цэцэрлэгтээ авбал зохих хоолны илчлэг нормоо авч байна.</p> <p>“Хяналт шалгалт зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2024 оны А/233 дугаар захирамжаар Сайншанд, Замын-Үүд сумын хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нийт 32 объектод “Үдийн хоол”, дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний чанар, аюулгүй байдал, стандартын хэрэгжилт, сургууль орчмын хүнсний бүтээгдэхүүний худалдаа үйлчилгээний 6 объектод стандартын хэрэгжилтэд хяналт шалгалтыг зохион байгуулж, зөвлөмж чиглэл хүргүүлсэн.</p>	100%
63		78. Сургуулийн гал тогооны тоног	2021 - 2024		3	<p>Улаанбадрах сумын хүүхдийн цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн гал тогоонд "Бадрах энерги" компанийн</p>	100%

		төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах				<p>хөрөнгө оруулалтаар 15.4 сая төгрөгийн 5 нэр төрлийн гал тогооны тоног төхөөрөмжийг хандиваар хүлээн авсан. Үүнд: 1-р хоолны тогоо 1 ширхэг, Замын-Үүд сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгт 1 ширхэг 2.1 сая төгрөгийн 1-р хоолны тогоог сумын засаг даргын нөөц сангаас шийдвэрлэж өгсөн. Сайншанд сумын хүүхдийн 12 дугаар цэцэрлэг, Замын-Үүд сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь 2023 оны нөхөн хангалтын зардлаас 3.7 сая төгрөгөөр гал тогооны нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авсан.</p> <p>БШУЯамнаас Айраг сумын сургуулийн үдийн хоол хөтөлбөрт зориулж 2.9 сая төгрөгийн үнэ бүхий 4 ширэмтэй шарах шүүгээ үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн. Зүүнбаянгийн ерөнхий боловсролын сургуульд Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтын газраас 15.3 сая төгрөгийн 7 нэр төрлийн гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлсэн.</p> <p>Даланжаргалан сумын 1985 оны төгсөгчдөөс сургуулийн гал тогоонд 84,0 сая төгрөгийн хөлдөөгч 1ш, 16,0 мянган төгрөгийн үнэ бүхий ус буцалгагч 1ш хандивласан.</p> <p>Сайншанд сумын 6-р сургууль 2022 онд 12 нэр төрлийн 20,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Даланжаргалан сумын сургууль 7 нэр төрлийн 17,8 сая төгрөгийн тоног төхөөрөмж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, Замын-Үүд сумын 2-р сургууль 4 ширэмтэй пийшин 3,9 сая төгрөгийн 2 хаалгатай хөргөгч 5,3 сая төгрөгийн тоног төхөөрөмж орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан.</p> <p>Тайлант хугацаанд давхардсан тоогоор 10 сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмжийг сайжруулсан.</p> <p>Сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийн хангалт 2020 онд 50,0 хувьтай байсан ба 2024 онд 65,0 хувь болж өссөн.</p>	
64		79. Ерөнхий боловсролын сургуулиудыг ундны усны шүүлтүүрээр хангах	2021 - 2024		4	<p>2021-2024 онд 6 сургууль, 16 цэцэрлэг улс, орон нутгийн төсөв болон хандивын нийт 11,8 сая төгрөгийн 12 ширхэг ус цэвэршүүлэгчээр хангагдаж, ерөнхий боловсролын 22 сургууль, 33 цэцэрлэг буюу нийт 55 байгууллага нийт 64 ширхэг ундны усны шүүлтүүртэй болсон.</p> <p>Мөн эцэг эхийн оролцоонд тулгуурлан анги танхим бүр цэвэр ус уух боломжтой болсон ба нийт сургууль, цэцэрлэг цэвэр ус уух нөхцөлөөр бүрэн хангагдсан.</p>	100%
65		2.3.3.1. Сургууль, цэцэрлэг бүрт орон нутгийнхаа онцлогт	2021 - 2024			<p>2021-2022 онд Боловсролын салбарт орон нутгийнхаа онцлогийг таньж мэдэх, судлах, баялаг өв соёлоороо бахархах, эх оронч, оюунлаг, баатарлаг, хөдөлмөрч, авьяаслаг, тусч,</p>	100%

		тохирсон хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.			<p>спортлог, найрсаг, эртэч, байгальд ээлтэй ард түмний үр сад гэдгийг ойлгуулах, залгамж халааг нэр төртэйгөөр өвлөн авч явах, түгээн дэлгэрүүлэх чин сэтгэлийг хоногшуулах зорилгоор 21 сургууль, 33 цэцэрлэгт “Орон нутгийн онцлогт тохирсон хүүхэд багачуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн.</p> <p>2022-2023онд Орон нутгийн онцлогтой сургалтын хөтөлбөрийг судлах хүрээнд Иххэт сумын сургуулийн сурагчид “Байгалиа шинжихүй” төслөөр нутгийн үзэсгэлэнт байгаль, түүхэн дурсгалт газрыг танин мэдэх, Эрдэнэ сум 163 хүүхдийг “Бүрдэний элс” байгалийн үзэсгэлэнт, түүх дурсгалыг таниулах, Даланжаргалан сумын сургууль “Их нартын байгалийн нөөц газар” үзэсгэлэнтэй байгалийн тогтоц, ховор ан амьтан, түүх соёлын баялаг өвийн өлгий болсон нутагтай танилцах, Мандахын сургуулийнхан Толийн булаг, Сүйхэнт уул, Хадны бичээс, Өлгий хийд, Улаанбадрах сумын багш сурагчид сумынхаа 9 гайхамшгийг үзэх аяллуудыг зохион байгуулсан.</p> <p>Мөн аймаг, сумын музейд түүхийн хичээлүүдийг зааж, “Ёс заншлын өргөө”-гөөр зочлуулан монгол ахуй соёлыг танилцуулах, аялал, уулзалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагаанд 5031 сурагч хамрагдан мэдлэг ойлголтоо нэмэгдүүлсэн.</p> <p>2023-2024онд 22 сургуульд “Орон нутгийн онцлогт” хөтөлбөрийн боловсруулан хэрэгжүүлж тайлагнан ажиллалаа.</p> <p>Нийт сургуулиудаас хөтөлбөрийг шинжлэх ухааны мэдлэг, орон нутгийн онцлог, сурагчдын төлөвшилд тохируулан бүрэн хэрэгжүүлж тайлагнасан 3 сургуулийг шалгаруулан сайн туршлагыг аймаг болон Улсад түгээн дэлгэрүүллээ. Үүнд: Хөвсгөл- “Адууны соёл”, Зүүнбаян –“Миний нутаг бидний бахархал” Замын-Үүд 2-р сургууль –“Шагайн наадгай” хөтөлбөрөө тайлагнасан ба 21 сургууль бүр орон нутгийн онцлогтой хөтөлбөр хэрэгжүүлсэн.</p>	
66	2.3.4. Цахим засаг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн -Цахим сургалтыг хөгжүүлэхэд багш нарын оролцоог дэмжиж, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан	80. Цахим сургалтыг хөгжүүлэх бүх талын арга хэмжээг авч багш, суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх	2021 - 2024	2/50	<p>Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээг батлах тухай” 372 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны “Цахим системд суурилсан англи хэлний хөтөлбөр хэрэгжүүлэх, төлөвлөгөө батлах тухай” А/353 дугаар тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны “Сургалтын цахим систем нэвтрүүлэх, зардал батлах тухай” А/312 дугаар тушаалаар 2023-2024 оны хичээлийн жилээс ЕБС-ийн 3-4 дүгээр ангид</p>	100%

	туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ.				<p>Эдүтэн цахим систем, 5-6 дугаар ангид олон улсын англи хэлний Пийрсон хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p>Иймд тус үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх сургалтын орчны бэлэн байдал, цахим системийн бүртгэл, ашиглалт, сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалт зэрэг хэрэгжилтийн гарааны нөхцөл байдалтай танилцаж, тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор 2023оны 10 ба 12-р сард БШУГ-ын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг Сайншандын 1,2,3,5,6-р сургууль болон Зүүнбаян, Өргөн сумдын сургуулиудад зөвлөн тусалж ажилласан.</p> <p>Eduten цахим системд Дорноговь аймгийн төрийн өмчийн 21 сургуулийн 104 бүлгийн 3200 суралцагч, Англи хэлний Pearson хөтөлбөрт 119 бүлгийн 3758 суралцагч хамрагдаж байна. Аймгийн төрийн өмчийн 21 сургуулийн 5,6-р ангид Pearson хөтөлбөр хэрэгжиж байгаа ба Сайншанд сумын ерөнхий боловсролын 1-р сургуулийн 5,6,7,8,9,10-р ангийн 1025 суралцагчид туршилтаар хэрэгжиж байна. 2024.09.01-с Eduten 1,2,3,4,5-р анги, Пийрсон 3,4,5,6,7-р анги тус тус хамрагдахаар бэлтгэл ажлаа хангаж байна.</p> <p>Иймд сургууль бүр дотоод сүлжээ, интернэт орчин бүхий цахим ангийг бий болгохоор зорин ажиллаж одоогоор төрийн өмчийн 8 сургууль цахим ангиа байгуулан кабинетаар хичээллэж байна.</p> <p>2023 онд орон нутгийн төсвийн 854.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 20 сургуулийн 254 багшийг шинээр зөөврийн компьютертой болгосон.</p>	
67		83. Зарим сургуулийг цахим сургууль болгох, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2021 - 2024	2/100%	<p>Орон нутгийн төсвийн 854.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 20 сургуулийн 254 багшийг шинээр зөөврийн компьютертэй болгосон.</p> <p>Цахим сургалтыг хөгжүүлэх ажлын хүрээнд "Mobicom" Корпорациас хэрэгжүүлж буй "Smart education 3" төсөлд Сайншанд сумын 1-р сургууль хамрагдан 121 сая төгрөгийн өртөг бүхий "Дижитал анги"-тай болсон.</p> <p>Дижитал ангитай болсноор "PEARSON ENGLISH", "EDUTEN MATHEMATICS" платформуудаар дамжуулан англи хэл, математикийн хичээлүүдийг үзэх, 8-р ангийн физикийн хичээлийг "VR" төхөөрөмжөөр виртуал орчинд үзэх, "VR" контентуудыг хичээлтэйгээ уялдуулан үзэх, "medle.mn" платформыг хичээл дээрээ ашиглах, мэдээлэл технологийн</p>	90%

					<p>хичээлийг 1-р ангиас заах, сургууль тус бүр дээр "IT" клуб байгуулах зэрэг олон талын үр дүнтэй ажил зохион байгуулсан.</p> <p>2024 оны эхний хагас жилд ерөнхий боловсролын 21 сургуульд боловсролын удирдлагын мэдээллийн систем "Амжилт", "Их нүүдэл" платформыг нэвтрүүлж, 570,0 сая төгрөгийн өртгөөр интернэтийн дэд бүтцийг сайжруулж, Wifi төхөөрөмжийг байршуулан, суурилуулах ажлыг "Mobi net" ХХК-тай хамтран хэрэгжүүллээ.</p> <p>Мөн орон нутгийн төсөв болон төгсөгчдийн нийт 205,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, хандиваар Мандах, Хатанбулаг Даланжаргалан, Зүүнбаянгийн ЕБ-ын сургуульд 28 ухаалаг дэлгэц, 20 телевизор, 15 зөөврийн компьютер, вэб, видео камераар хангасан.</p>	
68	2.3.5. Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, Үндэсний Монгол хэл, бичгээ чанартай эзэмшин, хэрэглэж хэвшинэ.	84. "Миний монгол хэл, бичиг- 2025" зорилтод төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2021 - 2024	15	<p>Аймгийн Засаг даргын 2023 оны А/733 дугаар захирамжаар Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн орон тооны бус орон нутгийн салбар зөвлөлийг мэргэжлийн байгууллагын 7 гишүүнтэй шинэчлэн байгуулсан.</p> <p>Төлөвлөгөөний дагуу аймгийн төрийн албан хаагчдаас монгол бичгийн түвшин тогтоох сорил авч, үндэсний бичгийн цахим бичвэр боловсруулах сургалтад 90 гаруй төрийн байгууллагын 380 албан хаагчийг танхимаар, 14 сумын төрийн байгууллагын 100 гаруй албан хаагчийг цахимаар тус тус хамруулсан.</p> <p>Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлөөс Сайншанд сумын төрийн 33 байгууллагын архив, бичиг хэргийн 34 ажилтанд монгол бичгийн цахим бичвэрийн давтан сургалт, "Хамтдаа судалъя, хөгжье" үйл ажиллагааг 22 сургууль, 33 цэцэрлэгийн 1500 гаруй багш, "Сүегэр" уран бичлэгийн уралдаанд 27 багш, 23 сурагчийн бүтээл, 6-12-р ангийн үндэсний бичгийн "Анги хамт олны олимпиад"-ыг 3 үе шаттайгаар зохион байгуулж 267 бүлгийн 7377 сурагч оролцсон.</p> <p>"Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг угтан сургууль бүр өөрийн онцлогтоо тохируулан багш, сурагч, эцэг эх, иргэдийг хамарсан 20 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Мөн ЕБС-ын 12-р ангийн 55 сурагч, 15 байгууллагын 75 төрийн албан хаагчийн дунд "Тунгаамал" тэмцээн, 50 гаруй төрийн албан хаагчдын дунд зөв бичих дүрмээр "Үсэглэлийн хаад" тэмцээнийг зохион байгуулсан.</p>	90%

						Нийтдээ 12 арга хэмжээ зохион байгуулж, 25000 орчим багш, сурагч, иргэд хамрагдсан. Төлөвлөгөөнд 4 чиглэлийн 10 үйл ажиллагаа тусгасан ба хэрэгжилт 90 хувийн гүйцэтгэлтэй байна.	
69		85. Монгол хэл, бичгийн улсын олимпиадыг орон нутагт зохион байгуулах	2022 - 2024		-	<p>Д.Равжаагийн мэндэлсний 220 жилийн ойг угтсан ажлын хүрээнд Монгол хэл, бичгийн улсын олимпиадыг 2023 онд орон нутагт зохион байгуулах талаарх саналыг Боловсрол шинжлэх ухааны яам, Монгол Улсын боловсролын их сургуулийн "Монгол хэлний олимпиад"-ыг зохион байгуулах дэд хороотой зөвлөлдөж, саналыг хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй.</p> <p>2023, 2024 онд Монгол хэл, бичгийн улсын олимпиадын хоёрын даваанд давхардсан тоогоор 121 багш, эхний даваанд шалгарсан 12-р ангийн 70 суралцагч оролцож, мэдлэг чадвараа сорьсон. Үүнээс Улсын олимпиадын гурвын даваанд Сайншанд сумын 2 дугаар сургуулийн монгол хэл, бичгийн багш Б.Мөнхчимэг, Замын-Үүд сумын 1 дүгээр сургуулийн сурагч О.Номинжин тусгай байр, 2024 оны Улсын олимпиадад Замын-Үүд сумын 2 дугаар сургуулийн монгол хэл, бичгийн багш Б.Мөнгөнцэцэг, Замын-Үүд сумын 1 дүгээр сургуулийн 12-р ангийн сурагч Э.Анударь нар тусгай байр эзэлсэн амжилт тус тус үзүүлсэн.</p>	30%
70		86. Иргэдэд зориулсан үндэсний бичгийн танхимыг сургуульд түшиглэн байгуулах	2021 - 2024		2	<p>Иргэдэд зориулсан үндэсний бичгийн танхимыг сургуульд түшиглэн байгуулах төслийг 2021-2022 онд хэрэгжүүлж, Сайншанд, Айраг, Хатанбулаг, Мандах сумын Насан туршийн суралцахуйн төв, нэгжид орон нутгийн төсвийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар үндэсний бичгийн танхимыг байгуулж, компьютер, техник хэрэгсэл, үндэсний бичгийн толь, сурах бичиг, ном бүтээл, хэрэглэгдэхүүн, гарын авлагаар хангаж тохижуулсан.</p> <p>2024 онд Сайншанд, Айраг, Хатанбулаг, Мандах, Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын сургуульд түшиглэсэн үндэсний бичгийн нийт 8 танхим сургалтын үйл ажиллагаагаа явуулж хэвшсэн.</p> <p>Насан туршийн суралцахуйн төв, сумдын насан туршийн боловсролын нэгжийн сургалтын танхимд үндэсний бичиг, үсгийн чиглэлээр иргэд болон төрийн албан хаагчдын дунд түргэн уншлага, хүмүүн бичиг сонины захиалга, уншлага, сургалт, тэмцээн, уралдаан, арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж, 34 төрлийн арга хэмжээнд давхардсан тоогоор 8000 гаруй иргэнийг хамруулсан.</p>	90%

					<p>Мөн иргэдийн монгол бичгийн мэдлэг чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 20 цуврал хичээл, нутгийн зохиолчдын бүтээл, онч мэргэн үгс, сургаалын зохиол, монголын сонгодог яруу найргийн 70 гаруй хөрвүүлэг бэлтгэж, "Босоо бичиг-Бидний бахархал" группэд байршуулан бүлгэмийн 4899 гишүүдэд түгээсэн.</p> <p>Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс аймгийн нийт төрийн албан хаагчдаас монгол бичгийн түвшин тогтоох сорил авч, үндэсний бичгийн цахим бичвэр боловсруулах сургалтад 90 гаруй төрийн байгууллагын 380 албан хаагчийг танхимаар, 14 сумын төрийн байгууллагын 100 гаруй албан хаагчийг цахимаар, 33 байгууллагын архив, бичиг хэргийн 34 ажилтанд монгол бичгийн цахим бичвэрийн давтан сургалтыг тус тус зохион байгуулсан.</p>	
71		70. Зарим сумдад сургуулийн барилгыг шинээр барьж, сургууль, цэцэрлэг, дотуур байрны засвар үйлчилгээг хийнэ.	2021 - 2024		<p>2020-2024 онд Боловсролын салбарт улс, орон нутгийн төсвийн 26,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж 3 сургуулийг шинээр ашиглалтад оруулан, 17 сургууль, 22 цэцэрлэг, 5 дотуур байранд засвар хийж, боловсролын салбарын давхардсан тоогоор 54 байгууллагад 311 нэр төрлийн 1753 ширхэг тоног төхөөрөмжөөр ханган ажиллалаа.</p> <p>Улсын төсвийн 17,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 1 дүгээр багт 320 хүүхдийн сургуулийн өргөтгөлийн барилгын ажлыг "Жинсийн орой" ХХК, Хатанбулаг суманд 320 хүүхдийн сургуулийн барилгыг "Ньюконстракшн" ХХК, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 7,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгөөр Сайншанд сумын 6 дугаар багт "640 хүүхдийн сургууль барих" ажлыг "Болор-Аграмба" ХХК тус тус барьж гүйцэтгэн, ашиглалтад хүлээлгэн өгсөн.</p> <p>Орон нутгийн төсвийн 2,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн гадна дулаан, цэвэр усны шугамын засвар, 3 дугаар сургуулийн спорт заалны гадна фасадны засвар, Айраг сумын ЕБС-ийн 1-р байрны их засвар, ын Даланжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр, спорт заалны сантехник, цахилгааны засвар, урлаг заалны засвар, Зүүнбаян багийн ЕБС-ийн дотор халаалтын системийн засварын ажлуудыг тус тус бүрэн гүйцэтгүүллээ.</p> <p>Орон нутгийн төсвийн 247.1 сая төгрөгийн төсөвт өртгөөр Дэлгэрэх сумын Хүүхдийн цэцэрлэгийн засвар, Өргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн гадна фасадны засвар, Хөвсгөл сумын цэцэрлэгийн дээврийн засварын ажлуудыг гүйцэтгүүллээ.</p>	100%

						<p>Орон нутгийн төсвийн 387,1 сая төгрөгийн төсөвт өртгөөр Хөвсгөл сумын ЕБС-ын дотуур байрны засвар, Өргөн сумын ЕБС-ийн дотуур байрны дээвэр, гадна фасадны засварын ажлыг тус тус гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн авсан.</p> <p>Энэ онд улсын төсвийн Даланжаргалан суманд 320 хүүхдийн сургууль барих, Сайншанд 150 хүүхдийн цэцэрлэг барих, Замын-Үүд сумын 1-р сургуулийн буулгаж шинээр барих, Сайншанд сумын 1 дүгээр сургууль, Айраг, Дэлгэрэх, Замын-Үүд, Хөвсгөл сумдын ЕБС-ийн барилгад засвар хийх, Сайншанд сумын 8, 9,10, 12 дугаар цэцэрлэг, Замын-Үүд сумын 2,4 Хөвсгөл сумдын цэцэрлэгийн барилгуудыг засварлахаар төлөвлөсөн.</p> <p>Тендер шалгаруулалтын ажлууд хийгдэж 30-50 хувийн гүйцэтгэлтэй ажлууд хэрэгжиж байна.</p>	
72		87. Политехникийн коллеж болгох асуудлыг судалж шийдвэрлэх	2021 - 2024	-		<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь 2020 онд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр байгууллагын магадлан итгэмжлэлд орж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/68 тоот тушаалаар Дорноговь Политехник коллеж болон өргөжиж, 2021-2024 онд 19 мэргэжлээр сургалтын үйл ажиллагаагаа явуулж, нийт 1606 мэргэжилтэй ажилтныг бэлтгэн гаргасан.</p>	100%
73	2.3.6. Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог өргөжүүлнэ.	88. Багшлах хүний нөөцийг нэмэгдүүлж чадавхжуулах	2021 - 2024	40		<p>"Алсын хараа-2050" Монгол улсын Засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлогын "Хөдөөгийн сэргэлт" зорилтын хүрээнд боловсролын үйлчилгээ, хүртээмжийг сайжруулах, шилдэг мэргэжилтнүүдийг Дорнын говь нутагтаа урин ажиллуулах, мэдлэг, чадвар, арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Ирээдүйн төлөө" хөтөлбөрийн сонгон шалгаруулалтын шаардлагыг ханган шалгарсан англи хэлний 3 багш, орос хэлний 1 багш, удирдах ажилтан 1, боловсролын салбарын нийт 5 багш, удирдах ажилтныг 5 жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах гэрээгээр орон сууцаар ханган ажиллуулж байна.</p> <p>Орон нутагт чадварлаг боловсон хүчнийг татах, багшлах боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор Түрээсийн орон сууц хөтөлбөрийн 1 дүгээр ээлжинд сургуулийн 16, цэцэрлэгийн 15 багшийг хамруулсан. Дуу хөгжмийн багш болон хөгжимчин мэргэжлээр суралцаж байгаа 9 оюутанд жил бүр сургалтын төлбөрийн 100%-ийн дэмжлэг үзүүлж, нийт 90.0 сая, 10 оюутанд нийт 25.0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Боловсролын ерөнхий газараас зохион байгуулсан мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад 1, 5, 10 дахь</p>	100%

					<p>жилдээ ажиллаж буй багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад гадаад хэл, мэдээллийн технологи, түүх, нийгмийн ухаан, биологийн судлагдахууны 5 багш хамрагдаж, батламж авч, 4 багш багшлах эрхийн сургалтад хамрагдаж, сургах зүйн чадамж эзэмшсэн.</p> <p>Политехникийн коллежийн багшийн тоо жил бүр нэмэгдэж, 2024 онд 43 үндсэн багш ажиллаж байгаа нь өмнөх оноос 10 багшаар нэмэгдсэн. Нийт багшлах боловсон хүчний хангалт 90,5 хувь байгаа нь өмнөх оноос 1,8 хувиар өссөн байна.</p>	
74	2.3.7. Орон нутагт мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, их, дээд сургуулиудын үйл ажиллагааг дэмжиж, оюутны сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлнэ.	89. Орон нутагт сургалтын үйл ажиллагаа явуулдаг их дээд сургуулиудад шаардлагатай мэргэжлээр сурах оюутнуудад төлбөрийн дэмжлэг үзүүлэх	2021 - 2024	30	<p>АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургуулийн эх баригчийн ангийн 11, их эмчийн ангийн 3, эм найруулагч 16 нийт 30 оюутныг төгсөөд орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах гэрээ байгуулан сургалтын төлбөр болох 23,0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас олгосон.</p> <p>Анагаах ухааны сургуульд 14 хүнийг “Эх барихуй” мэргэжлээр сургаж сургалтын төлбөрийг 100% шийдвэрлэж ажилласан.</p> <p>Даланжаргалан сумын ЗДТГ, уул уурхайн компаниудтай хамтран орон нутгийн харьяалалтай 51 оюутны 200.0 гаруй сая сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлэг олгосон. "Дезерет солар пауэр ван" ХХК нь ШУТИС-ийн дулааны эрчим хүчний чиглэлээр суралцаж буй 1 оюутанд 3 жилийн 100 хувийн сургалтын төлбөр олгосон. "Дашваанжил" ХХК-аас Энэтхэг улсад газрын тосны мэргэжлээр суралцах 5 оюутанд сургалтын төлбөрийг 100 хувь олгохоор батламжилсан.</p> <p>Гадаад харилцааг өргөжүүлэх “Гүүр” төслийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлж эхлэн Политехник коллеж, АШУУИС-иудад шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмжийн худалдан авахад аймгийн Засаг даргын захирамжаар 40,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгон дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Уг төслийн хүрээнд гадаадын их, дээд сургуульд эрэлттэй мэргэжлээр суралцах хүсэлтэй 132 суралцагчийн судалгааг гаргаж тэтгэлэгт хамруулах үйл ажиллагааг 2024-2025 оны хичээлийн жилээс зохион байгуулахаар төлөвлөсөн.</p> <p>Орон нутагт нэн шаардлагатай байгаа мэргэжлээр суралцаж буй 97 оюутанд нийт 176,6 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн.</p>	90%
75		90. Орон нутагт их, дээд сургуулийн салбар байгуулах	2023 - 2024	-	<p>Аймгийн ЗДТГ-аас “Дабльфиш” ХХК-ийн дэргэдэх Төмөр замын мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулан нийт 6 мэргэжлээр 265 оюутан суралцуулж байна. Үүнд: Вагон үзэгч засварчин 17,</p>	70%

		үйл ажиллагааг дэмжинэ.				Зүтгүүрийн туслах машинч 53, Төмөр замын замчин 60, Өртөөний жижүүр 65, Ачаа вагон хүлээлцэгч 66, Дохиолол төвлөрүүлэлт холбооны монтёр 4 байна.  Отгонтэнгэр их сургууль, Засагт хан дээд сургууль, Глобал удирдагч зэрэг их дээд сургуулиудтай хамтран багшийг ажлын байрандаа хөгжих боломжийг олгож, төлбөрийн уян хатан нөхцлөөр сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуульд шаардлагатай мэргэжлүүдээр бакалавр, магистрын эчнээ ангийн хөтөлбөрт 20 багш цахимаар хамрагдаж байна.	
76	2.5.1. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагыг бодитой төлөвлөх	92. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагыг бодитой төлөвлөх	2021 - 2024		100%	Нийгмийн даатгалын сангийн ирэх оны төсөв, дараа онуудын төсөөллийг боловсруулж 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн бөгөөд нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг тайлант онуудад бүрэн биелүүлсэн. Нийгмийн даатгалын орлогын төлөвлөгөөний биелэлт 2024 онд 23,6 тэрбум буюу 100.01% бөгөөд өнгөрсөн оноос 4.41%-иар өссөн. Нийгмийн даатгалын сангийн зарлага мөн оны байдлаар 91,2% бөгөөд 2021 оныхтой харьцуулахад 12.1%-иар буурсан нь нийгмийн даатгалын сангийн зардал хэтрээгүй, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт хангагдсан.	100%
77	2.5.1. Нийгмийн даатгалын шинэчлэлийг хэрэгжүүлж, хүрээг сангийн төлөвлөгөөг биелүүлнэ. хамрах өргөтгөж, орлогын	93. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогч болон даатгуулагчийн тоог нэмэгдүүлэх	2021 - 2024		971 21927	Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр 98 ААНБ-ийн 587 албан журмын даатгуулагчид, АШУҮИС-ийнн 65 оюутанд, 41 багийн 2320 малчинд нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомж болон нийгмийн даатгалд даатгуулахын ач тусын тухай сургалтыг зохион байгуулснаар хамралтыг дараах байдлаар нэмэгдүүлсэн. 1.Малчин, туслах малчны сайн дурын даатгалын тэтгэврийн даатгалын 50 хувийг төрөөс хөнгөлөх хуулийн талаар мэдээлэл хүргэж, 115 малчинг хамруулав. 2.Гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн сайн дурын даатгалд хамрагдсан эхийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын 50 хувийн хөнгөлөлтийн мэдээллийг хүргэж, 35 эхийг хамруулав. 3.Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцгийн сайн дурын даатгалын тэтгэврийн даатгалын 100 хувь төрөөс хөнгөлөх хуулийн талаар мэдээлэл хүргэж, 50 эцэг, эхийг нэмж хамруулав. Жилийн эхэнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн судалгааг гаргаж, түүний дагуу нийгмийн даатгалд	100%

					<p>хамруулан ажил олгогчоор бүртгэсэн. Үүний үр дүнд нийт шимтгэл төлөгч аж ахуйн нэгжийн тоо 843 болж нэмэгдсэн бөгөөд 2021 онд 711 ажил олгогчийн 19567 албан журмын даатгуулагч хамруулж, 3608 сайн дурын даатгуулагч хамруулсан.</p> <p>2022 онд 757 ажил олгогчийн 20529 албан журмын даатгуулагч хамруулж, 3593 сайн дурын даатгуулагч хамруулсан бол 2023 онд 837 ажил олгогчийн 22355 албан журмын даатгуулагч хамруулж, 3276 сайн дурын даатгуулагч хамруулсан.</p> <p>2024 онд нийгмийн даатгалын цахим систем шинэчлэгдэн "SICOS" шинэ програм хангамж нэвтэрсэнтэй холбоотойгоор даатгуулагчийн тоо нарийн гарах боломжгүй нөхцөл байдал үүссэн. Учир нь шинэ цахим системд бүрэн шилжээгүй мөн тус програм хангамжийн хөгжүүлэлтийн ажил дуусгавар болоогүй байна.</p> <p>2024 онд 843 ажил олгогчийг хамруулсан нь өмнөх оноос 0,7 хувиар, 2021 оноос 18,5-аар нэмэгдсэн байна. 2024 онд 3951 сайн дурын даатгуулагч хамруулсан нь өмнөх оноос 20,6 хувиар, 2020 оноос 9,5 хувиар нэмэгдсэн.</p>	
78		94. Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх бүх талын арга хэмжээ авах	2021 - 2024	100%	<p>Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, шимтгэл төлөгчийн бааз суурийг нэмэгдүүлэх, зорилгоор нийгмийн даатгалын үйчлилгээ, хууль тогтоомжийн мэдээ мэдээллийн талаар ААНБ, малчид, иргэдэд сургалт, суртчилгаа, явуулын үйлчилгээг тогтмол зохион байгуулж 45 удаагийн сургалтаар 3419 иргэнд мэдээлэл хүргэж ажилласан.</p> <p>Түүнчлэн нийгмийн даатгалын байгууллагын page, вэб хуудас болон Дорноговь телевиз DSB болон DTV-тай хамтран нийт 87 удаагийн мэдээллийг түгээж 189687 иргэнд мэдээлэл, сургалт сурталчилгаа хийж ажилласнаар 2024 оны хагас жилийн байдлаар орлогын төлөвлөгөөг 100,01%-иар биелүүлсэн.</p> <p>Орлогын биелэлт 2021 онд 711 ажил олгогчийн 19567 албан журмын даатгуулагч хамруулж 3608 сайн дурын даатгуулагчийг хамруулснаар орлогын төлөвлөгөө 117,1%-иар биелсэн бөгөөд 2022 онд 100,04%, 2023 онд 99,19%-иар тус тус биелүүлэн ажилласан.</p> <p>Өмнөх оны орлогын биелэлтээс хагас жилийн байдлаар 0,82%-иар ахисан. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн тоог нэмэгдүүлэх олон төрлийн арга хэмжээг авч даатгуулагчдын</p>	100%

						тоог нэмэгдүүлснээр орлогын төлөвлөгөөг жил бүр 100-117%-иар давуулан биелүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан.	
79	2.5.2. “Цахим нийгмийн даатгал” арга хэмжээний хүрээнд нийгмийн даатгалын үйл ажиллагааг үе шаттайгаар цахимжуулж иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай хүртээмжтэй болгоно.	95. Нийгмийн даатгалын үйл ажиллагааг цахимжуулан, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод шуурхай хүртээмжтэй болгох	2021 - 2024		Цахимжуулсан үйлчилгээний тоо	<p>ITZONE ХХК нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системийг 2019-2023 оны хугацаанд даатгуулагчдын хэрэгцээ шаардлага, ил тод байдал болон судалгаанд тулгуурлан хөгжүүлсэн. Уг системийг 2024 оны 01 дүгээр сараас эхлэн үе шаттайгаар нэвтрүүлж, цахим үйлчилгээний <a href="http://www.portal.ndaatgal.mn">www.portal.ndaatgal.mn</a> хаягаар даатгуулагч өөрийн хүссэн үйлчилгээг түргэн, шуурхай цаг алдалгүй, цахимаар авах боломжит нөхцөл үүссэн.</p> <p>Төрийн үйлчилгээний нэгдсэн системд хандах эрхээр нэвтрэн нийгмийн даатгалын тэтгэмжийн хүсэлт, ажил олгогчийн тайлан илгээх, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт авах, сайн дурын даатгалд даатгуулах, өндөр насны тэтгэврийн олголтыг харах зэрэг 11 нэр төрлийн үйлчилгээг авах бөгөөд цахим үйлчилгээний тухай 45 удаагийн сургалт, мэдээллийг 3419 иргэнд хүргэн ажилласнаар 2024 оны хагас жилийн байдлаар Нийгмийн даатгалын цахим дэвтэр 167 иргэнд, тэтгэврийн цахим дэвтэр 312 тэтгэвэр авагчид, ажилгүйдлийн тэтгэмжийн 190 хүсэлт, хөдөлмөрийн чадвар алдалтын эмнэлгийн хуудас 2376, жирэмсэн болон амаржсаны эмнэлгийн хуудас 499 хүсэлт, ажил олгогчийн тодорхойлолт, цахим нийгмийн даатгалын тайлан 843, сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сайн дурын даатгал төлөлтөө шалгах хүсэлтүүдийг цахимаар хүлээн авч, 4387 иргэний хүсэлтийг хуулийн хугацаанд цахимаар шийдвэрлэсэн.</p> <p>Цахимаар үйлчилгээг 2022 онд 2878 иргэнд, 2023 оны эхний 5 сарын байдлаар 3902 иргэнд хүргэсэн ба энэ оны эхний 5 сарын байдлаар 4387 байгаа нь өмнөх оны түвшингээс 485 үйлчилгээгээр илүү буюу 12.4%-иар нэмэгдсэн.</p> <p>Түүнчлэн аймгийн хэмжээнд нийт тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэргийг цахим системд оруулах ажлыг 2023 оны 10 дугаар сараас эхлүүлэн энэ оны хагас жилийн байдлаар нийт тэтгэвэр авагчдын 71.1%-ийн анхан шатны баримт бичгийн бүрдэл болох тэтгэврийн хувийн хэргийг цахим системд оруулаад байна.</p>	100%
80		96. Нийгмийн даатгалын архивын	2021 - 2024		100%	Нийгмийн даатгалын байгууллага 2000 оноос хойшхи нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг	100%

		баримтыг бүрэн цахимжуулах				<p>local.ndaatgal.mn программаас QR кодтойгоор иргэдийн хүсэлтийн дагуу гаргаж, 2006 оноос хойшхи нийгмийн даатгалын лавлагааг иргэд e-mongolia цахим системээс авах боломжтой бөгөөд 2024 онд 6878,1 мянган лавлагааг улсын хэмжээнд авсан.</p> <p>Нийгмийн даатгалын газрын архивт хадгалагдаж байсан 1995-2006 оны хоорондох 318 нэгжийг 2021 онд ITZONE ХХК-ийн цахим хөгжүүлэлтээр SICOS.ndaatgal.mn программд сканердаж бүрэн оруулсан нь цаасан баримт шүүх цаг хугацааг хэмнэж, ажлын цаг ашиглалтыг хэмнэж байна.</p> <p>Нийгмийн даатгалын лавлагаа цахимжсанаар 2024 онд 755 лавлагаа гаргасан. Үүнд: 1. www.SICOS.ndaatgal.mn сканердаж оруулсан лавлагаа 276 2. QR кодтой лавлагаа 383 3. Бусад аймаг дүүрэг рүү able цахим системээр 96 лавлагаа гаргаж, хүргүүлсэн. 4. Бусад аймаг дүүргээс манай аймгийн иргэдийн хүсэлтээр able цахим системээр дамжуулан 183 лавлагаа ирсэн 5. Дорноговь аймгийн сумд руу INBIT дотоод мессэнжерээр 132 лавлагаа хүргүүлж, иргэдийн цаг хугацааг хэмнэсэн.</p> <p>2024 оны хагас жилийн байдлаар 755 лавлагааг гаргаж, 431%-иар цахим лавлагаа олголт нэмэгдсэн.</p>	
81	2.5.3. Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан, цахим системд үе шаттай шилжүүлнэ.	97. Нийгмийн халамжийн үйлчилгээг цахим системд шилжүүлэх	2021 - 2024		100%	<p>Монгол улсын Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 194 дүгээр тогтоолоор “Нийгмийн халамжид хамрагдах иргэний хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, шийдвэрлэх журам” батлагдсан.</p> <p>Нийгмийн халамжийн үйлчилгээ нь 2020 оны 08 дугаар сараас эхлэн үе шаттайгаар цахим системд шилжсэн бөгөөд 2020 онд 5 төрлийн үйлчилгээ, 2021 онд 21, 2022 онд 38, 2023 онд 2 нэр төрлийн үйлчилгээ нэмэгдэж нийт нийгмийн халамжийн 66 үйлчилгээ, үүнээс гадна И-Монголиа системд 4 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг оруулсан ба нийт үйлчилгээний 91,6 хувийг цахимжуулсан. Дээрх үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ 2020 онд 1252 иргэн, 2023 онд 4043 иргэн, 2024 онд 6057 иргэн гаргасныг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн.</p> <p>Хүсэлт гаргасан иргэдийн тоо 2020 оноос 73.9%, 2023 оноос 33.2%-иар тус тус нэмэгдсэн.</p> <p>Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, тусламж хөнгөлөлтийг 2020 оны хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 24355 иргэнд олгож 4,138.3 сая төгрөг, 2023 онд 20064</p>	100%

						иргэнд 5,909.5 сая төгрөг олгож байсан бол 2024 оны эхний хагас жилийн байдлаар 20304 иргэнд 5,239.5 сая төгрөг олгосон. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 2020 оноос 19.9%-иар буурч, харин 2023 оны мөн үеэс 1.2%-иар нэмэгдсэн байна.	
82		98. Хөдөлмөр эрхлэгчдийн нутгийн бүртгэлийн мэдээллийн байгуулах орон цахим санг	2022 - 2024	-	-	Хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн цахим систем "EJOB" платформыг 2023 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа нэвтрүүлж "EJOB" платформыг танилцуулах, ашиглалтыг сайжруулах зорилгоор сумдын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан 13 мэргэжилтэн, ажил хайгч 366 иргэн, төр, хувийн хэвшлийн 172 байгууллагын 283 удирдлага, хүний нөөцийн ажилтанд сургалт зохион байгуулсан ejob платформд 71 ажил олгогч байгууллага, 159 ажлын байрны захиалга, 465 ажил хайгч иргэн бүртгүүлж, 168 иргэн ажилд зуучлагдсан. 2024 оны эхний хагас жилийн байдлаар "Алсын хараа-2050", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд Цахим хөгжил харилцаа холбооны сайдын баталсан "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд Цахимд хэвшье уриатай #Digital_First_D1 арга хэмжээнд, Хөгжлийн Шийдэл ТББ-н хэрэгжүүлж буй BEST хөтөлбөрөөс зохион байгуулсан энтрепренер эмэгтэйчүүд IV форумд оролцогч 100 гаруй эмэгтэйчүүдэд танилцуулж, гарын авлага арга зүйгээр хангаж ажилласан. "EJOB" платформд 376 ажил олгогч байгууллага, 466 ажлын байрны захиалга, 410 ажил хайгч иргэн бүртгэгдэж, 310 иргэнийг ажилд зуучилсан. Энэ нь өмнөх оны мөн үеэс ажлын байрны захиалга 65.8%, ажил зуучлал 48.5%-иар нэмэгдэж, бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 11.8%-иар буурсан үзүүлэлттэй байна.	100%
83		99. Өрхийн амжиргааны тогтоох чанарыг сайжруулж, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот эзэнд нь хүргэх түвшин судалгааны судалгааны чанарыг сайжруулж, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот эзэнд нь хүргэх	2021 - 2024	-	Нийгмийн халамжийн үйлчилгээ зорилтот иргэнд хүрсэн	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа зохион байгуулах тухай" А/36 тоот тушаалаар судалгааны удирдамж батлагдсан. Тус судалгаа нь улсын хэмжээнд 4 дэх удаагаа зохион байгуулагдсан бөгөөд судалгааны онцлог нь хосолмол аргачлалыг ашиглан нэлэнхүй бус өргөдлийн аргад суурилан, ядуу зорилтот өрхийг хамруулахаар зорьж улсын хэмжээнд 26,9 мянган өрх сонгогдсон бол манай аймгийн хувьд 478	100%

						<p>өрхөөс судалгаа авах жагсаалт гарч, өрхийг 100 хувь хамруулсан.</p> <p>Судалгааны хариу улсын хэмжээнд гараагүй . Харин 2017 оны судалгааны мэдээллийн санд бүртгэлтэй 15350 өрхөөс доод түвшний 1429 өрх, харьцангуй бага хэрэглээтэй 3236 өрх, дундаж түвшний 7356 өрх, дунджаас дээгүүр 2725 өрх, дээд түвшний 604 өрх бүртгэлтэй байна. Үүнээс доод түвшний 1429 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж, сумдын амьжиргаа дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлэн хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх үйлчилгээг 2020 оны хагас жилийн байдлаар 639 өрхөд 355,0 сая төгрөг, 2021 онд 303 өрхөд 227,3 сая төгрөг, 2022 онд 157 өрхөд 88,3 сая төгрөг, 2023 онд 146 өрхөд 47,6 сая төгрөг, 2024 оны эхний хагас жилийн байдлаар 138 өрхийн 276 том хүн, 352 хүүхдэд үйлчилгээг үзүүлж нийгмийн халамжийн сангаас 35,9 сая төгрөгийг тус тус зарцуулсан.</p> <p>Дээрх өрхүүдэд сумдын амьжиргаа дэмжих зөвлөлтэй хамтран нөхцөл байдлын үнэлгээ хийж журмын дагуу шалгуур үзүүлэлтээр дүгнэн ажлын байранд зуучилж амьдралын нөхцөл сайжирсан болон бусад шалтгаанаар 2020 оноос хойш 551 өрхийн үйлчилгээг зогсоож 50 өрхийг шинээр хамруулсан. Тус үйлчилгээнд хамрагдаж буй өрхийг 2020 онтой харьцуулахад 501 өрх буюу 434%, 2023 оноос 6%-иар тус тус буурсан байна.</p>	
84		100. Орлого багатай болон эмзэг бүлгийн өрхийн гишүүдийг чадавхжуулах замаар ажлын байранд зуучилж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх	2021 - 2024		1500 130	<p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа зөвлөгөө өгөх үйлчилгээ болон суурь ур чадварын сургалтад өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн 409-өөс доош оноотой буюу нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн 53 иргэнийг хамруулж чадавхжуулсан.</p> <p>2024 оны хагас жилийн байдлаар 52 иргэнийг байнгын ажлын байранд, 16 иргэнийг улирлын ажлын байранд, 1 иргэнийг түр ажлын байранд нийт 69 иргэнийг зуучилж 2020 оны мөн үеэс 23%-аар, 2023 оны мөн үеэс 15%-аар тус тус нэмэгдсэн.</p>	100%
85	2.5.4. Орон нутгийн бүтээн байгуулалтын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэ ажлын байр бий болгох, ажилгүйдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж,	101. Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх	2021 - 2024		300 /гүйцэтгэлээр/	<p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа”-ны танхимын сургалтыг “Нярав” мэргэжлээр Баян нэгүл ХХК-ийн дэргэдэх сургалтын төвтэй хамтран зохион байгуулж, ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй 22 иргэнийг хамруулсан.</p> <p>Танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалтад хамрагдах хүсэлтэй иргэдийн бүртгэлийг цахимаар авч байгаа бөгөөд</p>	100%

	хөдөлмөр эрхлэлтийн түвшинг тогтмол нэмэгдүүлнэ					бүртгүүлсэн 36 иргэний болон зах зээлийн эрэлтэд тулгуурлан 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. 2020, 2023 оны мөн үед танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалтууд зохион байгуулагдаагүй бэлтгэл ажлыг хангаж байсан бөгөөд тайлант хугацаанд 22 иргэнийг хамруулж сертификат олгосон.	
86	102. Цагийн болон өдрөөр ажиллах хөдөлмөрийн уян хатан тогтолцоо, нөхцөлийг бүрдүүлэх	2021 - 2024			3 540	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд ажил олгогч байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч, иргэдийн ажлын байрны захиалгыг тухай бүрд авч орон нутгийн DTV болон цахим пэйж хуудсаар дамжуулан иргэдэд ажлын байрны зар мэдээллийг тухай бүрд шинэчлэн хүргэж түр болон цагийн ажилд 2020 оны 965, 2021 онд 361 иргэн, 2022 онд 572 иргэн, 2023 онд 443 иргэн, 2024 оны хагас жилийн байдлаар 50 иргэн нийт 2391 иргэнийг түр болон цагийн ажилд зуучлан ажилласан. Тайлант оны хагас жилийн байдлаар 50 иргэний түр болон цагийн ажлын байранд зуучилсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2 иргэнээр өссөн.	100%
87	103. Орон нутгийн бүтээн байгуулалтын хүрээнд шинээр бий болсон үйлдвэр, үйлчилгээний салбарын шинэ ажлын байранд ажиллагсдыг зуучилж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх	2021 - 2024			1500, 1600,	Хөдөлмөр эрхлэлтийн цахим бүртгэлийн систем ejob платформд 149 шинэ ажлын байрыг бүртгэж, 310 иргэн ажилд зуучлагдсанаас орон нутгийн бүтээн байгуулалтын хүрээнд шинээр бий болсон үйлдвэр, үйлчилгээний салбарын байнгын ажлын байранд 96 иргэнийг зуучилж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүллээ. Шинээр бий болсон ажлыг байрны бүртгэл 2020 оны мөн үетэй харьцуулахад 14.6%, 2023 оны мөн үетэй харьцуулахад 29,5%-иар, зуучлагдсан иргэн 1-ээр нэмэгдсэн үзүүлэлттэй.	100%
88	104. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хууль тогтоомжийг хэрэгжүүлж, сумдын ХАБЭА-н зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	2021 - 2024			100%	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг шинэчлэн баталж, 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн ажлын төлөвлөгөөг 3 зорилт 17 арга хэмжээг тусган төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Түүнчлэн Аймгийн салбар зөвлөлөөс сумдын Засаг дарга, агентлаг аж ахуйн нэгж байгууллагын дарга нарт ХАБЭА-н сарын аяны хүрээнд хэрэгжүүлж ажиллах 7 чиглэлийг өгч үүрэгжүүлэн хэрэгжилтийг бүрэн хангуулсан.	100%

					<p>ХАБЭА-н сарын аяныг “Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл аюулгүй хөдөлмөр эрхэлцгээе” уриан дор нийт 14 зорилтын хүрээнд төлөвлөгөө гарган баталж, хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>ХАБЭА-н тухай хууль тогтоомжийг суртачлан таниулах зорилгоор 2021 онд 5 зорилт 19 арга хэмжээ, 2022 онд 9 зорилт 24 арга хэмжээ, 2023 онд 3 зорилт 25 арга хэмжээтэйгээр жилийн болон сарын аяныг 100% гүйцэтгэлтэй зохион байгуулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд 2024 онд ХАБЭА-н тухай хуулийг хангуулах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 6 удаагийн сургалтаар 306 төрийн албан хаагч, 48 аж ахуй нэгж байгууллагын 66 ажилтныг чадавхжуулсан мөн "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг зохион байгуулж барилгын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 28 ААНБ-ын төлөөллүүд, 73 төрийн албан хаагчийг хамруулсан. ХАБЭА-н зөвлөл 2021-2024 онуудад “Хөдөлмөрийн харилцаанд хамтын гэрээ, хэлэлцээрийн гүйцэтгэх үүрэг, хэрэгжилт, Хөдөлмөрийн аюулгүй байдлын зохицуулалт”, “ХАБЭА-н удирдлагын тогтолцоо, MNS ISO 45001:2018 стандартын талаарх ойлголт, чадамжийг гүнзгийрүүлэх, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад тус стандартыг нэвтрүүлж эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх”, “ХАБЭА-н тухай хууль, салбар зөвлөлийн чиг үүрэг, тулгарч буй асуудал” зэрэг нийт 100 гаруй сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж давхардсан тоогоор 8000 гаруй иргэнийг хамруулсан.</p> <p>ХАБЭА-н зөвлөлийн 2024 оны жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсанаар аймгийн хэмжээнд уул уурхай, барилга, зам тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-т хяналт шалтгалт хийхээр төлөвлөсөн.</p>	
89	105. Хувийн хөдөлмөрийн бирж байгуулах иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих	2021 - 2024	-	<p>“Дорнын говь тур” ХХК нь цагийн ажилд иргэдийг зуучлах зорилгоор 2024 оны 04 сараас эхлэн хөдөлмөрийн биржийг туршилтаар үйл ажиллагаа явуулж, "Төгс-Өнөд" ХХК, "Хангайн бигэр" ХХК, Равжаа музей, "Дэлгэр баясах" зам зэрэг аж ахуй нэгж байгууллага болон засвар, барилгын ажил хийж буй хувь хүмүүст давхардсан тоогоор 150-200 иргэдийг 4-12 цагийн ажилд зуучилсан.</p>	100%	

					<p>Хөдөлмөрийн хувийн бирж байгуулан ажиллах хүсэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласнаар “Хутагт мөрөн” ХХК-ийн дэргэдэх Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн агент нь 2024 оны 03 дугаар 01-ний өдрөөс эхлэн “Залуучуудын хөдөлмөр зуучлалын төв” хөдөлмөрийн хувийн бирж байгуулан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.</p> <p>Тус төвд ажил хайгчаар 200 иргэн бүртгүүлсэн бөгөөд ажлын байрны захиалга ирээгүй байна.</p> <p>Өмнөх онуудтай харьцуулахад шинээр 1 Хөдөлмөрийн бирж бий болсон.</p>	
90		106. Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын барилга барих	2022 - 2023		<p>Гүйцэтгэл 100%</p> <p>Улсын төсвийн 2.5 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр "Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын барилга барих" ажлыг 2022 оноос "Тогоруутай нуур" ХХК гүйцэтгэж байна. Барилгын үндсэн хийц бүтээцийн угсралт болон гадна инженерийн шугам сүлжээ, гадна цахилгаан хангамжийн ажил бүрэн хийгдсэн.</p> <p>Дотор заслын ажил, дотор халаалт, бохир усны шугамын ажил, дотор цахилгаан, салхивчийн ажлууд хийгдэж байна. Ажлын явц 90 хувьтай.</p> <p>Барилга угсралтын ажлыг гэрээнд заасан хугацаанд буюу 12 дугаар сарын 20-ны дотор хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p>	90%
91	2.5.5. Хөгжлийн бэрхшээл тэй иргэд, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.	107. Сайншанд суманд Ахмадын сувиллын барилга барих	2021 - 2024		<p>Сайншанд сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт 60 ортой ахмадын сувиллыг барих ажлыг 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр “Элит конкрет” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан улсын төсвийн 5,5 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр хэрэгжүүлэн гүйцэтгэж дуусгасан бөгөөд 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр улсын комисс ажиллаж, 2023 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр тус сувиллын нээлтийг хийж ашиглалтад оруулсан.</p> <p>Тус сувиллын газарт ашиглагдах тоног төхөөрөмж тавилга, эд хогшлыг орон нутгийн төсвийн 687,3 сая төгрөгөөр худалдан авч тохижуулсан.</p> <p>Үйл ажиллагааг явуулах аж ахуйн нэгжийг менежментийн гэрээгээр сонгон шалгаруулахаар нээлттэй тендерийг 2023.11.28-ны өдрөөс нэг сарын хугацаатай зарлаж, 1 материал ирүүлсэн гэвч шаардлага хангаагүй улмаас Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дэргэд "Төвшин сайхан" амралт нэртэйгээр 2024.05.01-ний өдрөөс үйл ажиллагааг тогтмол явуулж эхэлсэн.</p>	100%

					Уг амралтын газрын 7 хоногийн төлбөр иргэнээс 56,0 мянган төгрөг, нийгмийн халамжийн сангаас 245.0 мянган төгрөгийн хөнгөлөлт үзүүлж нийт 301,0 мянган төгрөгийн зардлаар 1 иргэнийг амрааж байгаа бөгөөд үйл ажиллагаагаа тогтмол явуулж эхэлснээс хойш нийт 120 ахмадыг хүлээн авч үйлчилгээ үзүүлсэн.	
92		108. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “Эрүүлжин хөгжих төв”-ийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах	2021 - 2024	50	<p>Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, Тайваний “Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн сан”-гийн хөрөнгө оруулалт 43,0 сая төгрөгөөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өдөр өнжүүлэх “Эрүүлжин хөгжих төв”-ийг 2020 онд байгуулсан.</p> <p>Уг төвийн үйл ажиллагаа "Ковид-19" цар тахлын цаг үетэй холбоотойгоор эхлүүлэх боломжгүй байсан бөгөөд 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс одоог хүртэл үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байна.</p> <p>Аймгийн хэмжээнд 2022 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 255 байгаагаас 157 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж, харин үлдсэн 98 хүүхэд нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдах насанд хүрээгүй болон суралцахад хүндрэлтэй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байсан.Үүнээс 9 хүүхэд тус төвд хамрагдан сэргээн засах, бариа заслын үйлчилгээнд хамрагдсан.</p> <p>Тухайн онд төвийн үйл ажиллагааны зардалд орон нутгийн төсвөөс 18,8 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд олон улсын "Holtinternational" сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, ажилчид болон тусгай хэрэгцээт цэцэрлэг сургуулийн бүлгийн багш нар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өдөр өнжүүлэх “Эрүүлжин хөгжих төв”-ийн ажилтнууд, байнгын асаргаатай хүүхдүүдийн эцэг, эх нийт 50 иргэнд хүүхдийн асаргаа сувилагааны талаар сургалт зохион байгуулсан.</p> <p>Өнгөрсөн онд 9 хүүхэд хамрагдаж, өдөр тутам сэргээн засах, бариа заслын үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлж , 4 хүүхдэд бие бялдар, үйл хөдлөл, сэтгэхүйн онцлогт бүрэн өөрчлөлт гарч, 5 асран хамгаалагч ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй байсан бол 3 асран хамгаалагч байнгын ажилтай болсон.</p> <p>Харин 2024 оны эхний хагас жилийн байдлаар төвийн үйл ажиллагааны зардалд орон нутгийн төсвөөс 41,3 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд 9 хүүхэд тогтмол хамрагдаж байгаагаас 5 хүүхдэд бие бялдар, үйл хөдлөл, сэтгэхүйн онцлогт эерэг өөрчлөлт гарсан.</p>	100%

					<p>Түүнчлэн ажил хөдөлмөр эрхлээгүй байсан 7 асран хамгаалагчаас 4 асран хамгаалагч байнгын ажлын байртай болсон давуу талтай байна.</p>	
93		<p>93. Ахмад настны хөгжил, хамгаалал, оролцоог дэмжих цогц бодлогыг хэрэгжүүлнэ.</p>	<p>2021 - 2024</p>		<p>Ахмад настны хөгжил, хамгааллын хүрээнд Говийн бүсийн төрөлжсөн асрамжийн газарт 2020 онд Дундговь аймгаас 1, 2021 онд Дорноговь аймгийн 1 ахмад, 2022 онд Өмнөговь, Дорноговь аймгаас тус бүр 1 ахмад, 2023 онд 3 ахмад нийт 15 ахмад настан асруулж байна.</p> <p>Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын шинэ барилгын ажлыг улсын төсвийн 2,5 тэрбум төгрөгийн өртгөөр "Уртын уул" ХХК гүйцэтгэж барилгын ажлын явц 90 хувьтай байна. Асрамжийн газрын барилгад шаардагдах "багц 1", "багц 2"-ын тоног төхөөрөмжийг орон нутгийн төсвийн 103,6 сая төгрөгөөр худалдан авсан. Энэхүү барилга ашиглалтад орсноор ахмадуудын бүх талын оролцоог нэмэгдүүлэн хөгжүүлэх, үйлчилгээ үзүүлэх, амьдрах таатай орчин бүрдэнэ.</p> <p>Түрээсийн орон сууц хөтөлбөрийн 1 дүгээр ээлжинд 105 айлын орон сууцнаас 11 ахмад настан байртай болсон.</p> <p>Мөн улсын төсвийн 5,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд суманд 60 ортой "Ахмадын сувиллын барилга барих" ажлыг "Элит Конкрет" ХХК гүйцэтгэж дуусган хүлээлгэн өгсөн.</p> <p>Ахмад настануудад үзүүлэх тусламж үйлчилгээний хувьд өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй байнгын асаргаа шаардлагатай ахмад настануудад орон нутгийн төсвөөс 21,5 сая төгрөгөөр санхүүжүүлэн, аймгийн Улаан загалмайн хороотой гэрээлэн 2020 онд 18 ахмад, 2021 онд 28 ахмад, 2022 онд 20 ахмад, 2023 онд 11 ахмадад гэрийн асрамж халамжийн үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>Ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, тусламж, дэмжлэг үзүүлэх зорилгоор 84 байгууллага ахмадын сан байгуулсан байгаа нь 2020 оны мөн үетэй харьцуулахад 34-өөр нэмэгдсэн.</p> <p>Мөн Ахмад настны эрхийг хангах, нийгмийн дунд эрүүл идэвхтэй амьдрах, хөгжил оролцоог дэмжих зорилгоор Монголын ахмадын холбоо, аймгийн Ахмадын хорооноос санаачлан хэрэгжүүлсэн "Говийн бүсийн ахмадуудад сургалт, урлаг, спорт"-ын арга хэмжээг 5,9 сая төгрөгөөр дэмжлэг үзүүлж Говийн 4 аймгийн 108 ахмад хамрагдсан ба 1350 гаруй ахмад үзсэн байна, Билгийн тооллын хаврын тэргүүн сар, Цагаан сарын баярыг тохиолдуулан 2020-2024 онд 90, түүнээс дээш настай давхардсан тоогоор 235 гаруй ахмадуудад 14,397,800 төгрөгөөр аймгийн Засаг дарга хүндэтгэл үзүүлсэн.</p>	<p>100%</p>

					<p>Аймгийн Ахмадын хороо нь үйл ажиллагааны үзүүлэлтээр улсад 2022 онд улсын шилдэг Ахмадын хороогоор шалгарсан. Нийт 14 суманд ахмадын өргөө, 1 аймгийн ахмадын хорооны төв байр, аймгийн Нэгдсэн эмнэлэг, ОБГ тус тус ахмадын өргөөтэй үйл ажиллагааг эрхлэн явуулж байна.</p> <p>Аймгийн хэмжээнд 6803 ахмад байгаа ба 2020 оны мөн үетэй харьцуулхад 653 ахмадаар нэмэгдсэн. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зорилгоор аймгийн Ахмадын хорооны 2020-2024 оны үйл ажиллагаанд жил бүр 70,4 сая төгрөг, нийт 281,6 сая төгрөгийн санхүүжилтийг олгож 344 багц арга хэмээний хүрээнд давхардсан тоогоор 60000 гаруй ахмадын хөгжил, оролцоог дэмжиж ажилласан.</p>	
94	2.5.6. Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай дэмжлэг, тусалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.	109. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх	2021 - 2024	550/5	<p>Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төв нь 2020 оны 06 сарын 17-ны өдөр нээлтээ хийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 2024 оны хагас жилийн байдлаар тус төвөөр дамжуулан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг Сайншанд, Улаанбадрах сумын ЕБС-н 12 дугаар ангийн 3 бүлгийн 83, 9 дүгээр ангийн 23 сурагчид зохион байгуулсан. Мөн "Таймон Флоуртек" ХХК, Болд төмөр ерөө гол ХХК-ний 2 удаагийн ажлын ярилцлагад 42 иргэн оролцоноос 5 иргэн байнгын ажлын байранд зуучлагдсан.</p> <p>Тус хоёр арга хэмжээг амжилттай зохион байгуулан 458 иргэнд үйлчилгээ үзүүлэн ажилласан түүнчлэн ажлын байрны мэдээллийг 227 иргэнд хүргэн, ажилгүйдлийн тодорхойлолтыг 83 иргэд олгосон.</p> <p>Загвар төвөөр үйлчлүүлсэн иргэдийн тоог 2020 оны жилийн эцсийн байдалтай харьцуулбал 2.2%-аар, 2023 оны мөн үетэй харьцуулбал 1.3%-иар нэмэгдсэн</p>	90%
95		110. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжих	2021 - 2024	24 /гүйцэтгэлээр/	<p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, Залуучуудын гарааны бизнесийн талаарх мэдээллийг 1-3 дугаар сарын "Халамжаас-Хөдөлмөрт 222" арга хэмжээнд хамрагдсан 681 иргэн, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)-ны нээлт "Та хөдөлмөрлө, бид дэмжье" арга хэмжээгээр 568 иргэнд өгч ажиллалаа. Старт-Ап арга хэмжээг бусад санхүүгийн үйл ажиллагааны төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж дууссаны дараа 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн.</p>	90%

					<p>Өргөн сумын Старт ап хөтөлбөрт 1 иргэн хамрагдан 10,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан. Залуу малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих малжуулах арга хэмжээнд 2021-2024 онуудад нийт 5 малчин өрх хамрагдсан.</p> <p>Эрдэнэ сум 2021 онд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих "Оролцоо" хөтөлбөрийн хүрээнд 18-34 насны залуучуудыг шалгаруулж 1000000 төгрөгний тэтгэлэгтэй 2 үе шаттай сургалтад 5 иргэнийг хамруулж, 1 иргэнийг ажлын байранд зуучилсан. 2022 онд Залуучуудын хөдөрмөр эрхлэлтийг дэмжих "Оролцоо" хөтөлбөрийн хүрээнд 18-34 насны залуучуудыг шалгаруулж 1000000 төгрөгийн тэтгэлэгтэй 2 үе шаттай сургалтад 5 иргэнийг хамруулж, 1 иргэнийг ажлын байранд зуучилсан. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих "Оролцоо" хөтөлбөрийн хүрээнд 18-34 насны залуучуудыг шалгаруулж 1000000 төгрөгийн тэтгэлэгтэй 2 үе шаттай сургалтанд 5 иргэнийг хамруулж, 1 иргэнийг ажлын байранд зуучилсан. Улаанбадрах суманд дутагдалтай мэргэжлээр сурч буй 11 оюутныг сургуулиа төгсөөд сумандаа ажиллах гэрээтэйгээр сургалтын төлбөрийн тэтгэлэгт хамруулан суралцуулж байна.</p> <p>Тайлант онуудад 6 төсөл хөтөлбөрийн хүрээнд 48 залуучуудыг ажлын байранд зуучилсан байна. ЕБС-ийн 9-11-р ангийн сурагчдад "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх" сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан.</p>	
96	2.5.7. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн тогтолцоог бэхжүүлж, байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ	111. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг бүх түвшинд сурталчлан, хамтын ажиллагааг дэмжиж, жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2021 - 2024	6	<p>НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ХГБХХГ-аас зохион байгуулсан жендерийн хэвшмэл ойлголтын талаар "Тэгш хүртээмжтэй байдал залуусын манлайлал" сургалтад аймгийн ХГБХХГ -ын Залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн сургагч багшаар бэлтгэгдэн "Жендерт хүйс хамаатай юу?", "Охид хөвгүүдийнхээ талаар ярилцъя", "Аз жаргалтай гэр бүлийг бүтээцгээе", "Эрүүл мэндээ хамтдаа хамгаалцгаая" зэрэг 10 сэдвээр 480 иргэнд сургалт мэдээлэл өгсөн. Дорноговь аймгийн ХГБХХГ-ын даргын 2023 оны А/39 дугаар тушаалын төлөвлөгөөний дагуу Жендэрийн тэгш байдлын сургалтыг 5 дугаар сарын 4-20-ны өдрийн хооронд Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд, Өргөн, Хатанбулаг, Хөвсгөл, Алтанширээ, Их хэт сум болон аймгийн Цагдаагийн газар, ШШГГ, АШУҮИС-ын оюутан, залуучууд, албан хаагч 312 иргэнд жендерийн хэвшмэл ойлголтын хор уршгийн талаарх мэдлэг, мэдээллийг түгээж ажилласан.</p>	100%

					<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал” үндэсний чуулганы хүрээнд 30 эрэгтэйчүүдийн төлөөлөл оролцож аймгийн дэд хэлэлцүүлгийг зохион байгуулснаар тус хэлэлцүүлгээс гарсан санал, тулгамдсан асуудлыг нэгтгэн үндэсний чуулганд хүргүүлж, аймгаа төлөөлж 5 эрэгтэй оролцсон.</p> <p>Жендерийн хэвшмэл ойлголтыг халах зорилгоор 8 төрлийн арга хэмжээг зохион байгуулж 1510 иргэн хамрагдан жендерийн хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголттой болсон. “Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан” ТББ-ын Замын-Үүд дэх салбараас сургууль, цэцэрлэгийн 100 гаруй залуу эмэгтэй багш ажилчдад “Өөрийгөө хайрлая”, “Жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний суурь шалтгаан” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Мөн Дорноговь, Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр аймгуудын 600 гаруй эмэгтэйчүүдийг хамруулж нийгэмд тулгамдаж буй асуудал, оролцох оролцоо, хандлага төлөвшлийг сайжруулах чиглэлээр “Дулаахан” говийн бүсийн эмэгтэйчүүдийн чуулганыг зохион байгуулсан мөн сумдад Харилцан хүндэтгэе аян зохион байгуулсан.</p>	
97		112. Төрийн үйлчилгээ болон хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд иргэдийг бүх талаар тэгш хамруулах бодлогыг хэрэгжүүлэх	2021 - 2024	100%	<p>Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрүүдийн төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэгт 2021 онд 9, 2022 онд 13, 2023 онд 12 төрийн бус байгууллага болон иргэдийн төлөөллийг оролцуулан шийдвэр гаргах түвшинд тэдний оролцоог ханган ажиллаж байгаа бөгөөд төсөл хөтөлбөрүүдийн сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн нийт гишүүдийн 2021 онд 36 хувь, 2022 онд 43.3 хувь, 2023 онд 40 хувьд нь төрийн бус байгууллага, иргэний төлөөллийг оролцуулж байна. Харин 2024 онд хэрэгжүүлэх "Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа", "Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа"-ны төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн 30% буюу 9 нь төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулан шийдвэр гаргах түвшинд тэдний оролцоог ханган ажилласан.</p> <p>Төсөл сонгон шалгаруулах 5 ажлын хэсэгт Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн төлөөлөл-5, төрийн бус байгууллагын төлөөлөл -2, иргэдийн төлөөлөл-1, бусад төрийн</p>	90%

					байгууллагын төлөөлөл-1, нийт 9 иргэн ажиллаж байна. Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгүүдэд 2020 онд 6, 2023 онд 12 төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулан шийдвэр гаргах түвшинд тэдний оролцоог ханган ажилласан.	
98	2.5.8. Гэр бүлийн үнэ цэнэ, тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлнэ.	113. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах бүх талын бодлого, нөлөөллийн үйл ажиллагааг явуулах	2021 - 2024	29/40000	<p>Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Олон улсын гэр бүлийн өдөр, Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр, Олон улсын аавуудын өдөр, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Олон улсын охидын өдөр зэрэг тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд нэгдүгээрт хүүхэд, гэр бүлийн дундах эерэг харилцааг нэмэгдүүлэх, хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэхийн ач тус, өсвөр насны хүүхдийн төлөвшил зэрэг уриалгын хүрээнд сум, байгууллагуудад хүргүүлсэн албан чиглэлийн хүрээнд нийт 43 нөлөөллийг ажлыг зохион байгуулан давхардсан тоогоор 1500 иргэнд, Хүүхэд хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн хосуудын харилцан ойлголцол, бат бэх байдлыг дэмжих, амьдрах ухааны, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлүүдээр төрийн байгууллагын албан хаагч болон иргэд рүү чиглэсэн 78 удаагийн сургалтуудыг нийт 2900 иргэнд, Ээж охидын хэлэлцүүлэг, Хамтдаа гэр бүлийн чин сэтгэлийн ярилцлага, Хосын цаг агаар, Гэр бүлдээ цаг гаргая чөлленж зэрэг гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих 4 төрлийн арга хэмжээнд 2400 иргэнийг хамруулан ажилласан.</p> <p>Хүүхдийн эрх, хамгааллын тухай хуулиар хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг, хариуцлага, гэр бүлийн үнэ цэнэ зэрэг 44 төрлийн гарын авлагыг бэлтгэж хөдөөгийн багийн 3305 өрхөд хүргэсэн.</p> <p>Байгууллагын албан ёсны пэйж хуудсанд 46 цуврал хүүхэд хүмүүжлийн эерэг аргын зөвлөмж постер, 6 төрлийн подкаст, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хялбаршуулсан 15 төрлийн танилцуулгыг бэлтгэн байршуулж, иргэд олон нийтэд тогтмол хүргэсэн. Нийт 17 төрлийн сургалт, арга хэмжээнд 4923 иргэнийг хамруулсан.</p> <p>42 төрлийн гарын авлагыг 3305 иргэнд хүргэсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд 2020 оноос 2024 оны эхний хагас жилийн байдлаар Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 230 гаруй нэр төрлийн хэсэгчилсэн арга хэмжээ, сургалт, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж давхардсан тоогоор 64,024 гаруй иргэдийн хамруулсан.</p>	90%

99		114. Гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах	2022 - 2024		-	<p>Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх танхимыг 2023 онд 1,2 сая төгрөгөөр өрөөг тохижуулан, иргэд олон нийт, хүүхэд ганцаарчилсан зөвлөгөөг өгөхийн зэрэгцээ мэргэжилтнүүд болон Хамтарсан багийн нийгмийн ажилтнуудын зүгээс насанд хүрээгүй 31, насанд хүрсэн 1, 3 гэр бүлд тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэх, сэтгэл зүйн анхан шатны үйлчилгээг үзүүлсэн.</p> <p>Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Татварын хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, эрүүл мэндийн газар, Дорноговь Политехник коллеж зэрэг нийт 12 байгууллагын 178 албан хаагчид гэр бүлийн боловсрол, хүүхэд хүмүүжлийн эерэг арга, ажлын байрны стрессээс урьдчилан сэргийлэх сэдвээр 8 удаа, сургуулийн өмнөх боловсролын 14 байгууллагын 340 асран хамгаалагч, 60 багш сурган хүмүүжүүлэгчид “Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг оролцоо, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон арга зүй” сэдвээр 14 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Үүний үр дүнд гэр бүл, боловсролын орчинд учирч болзошгүй эрсдэлээс үр хүүхдээ хамгаалах, анхаарал халамж тавих, хараа хяналтаа сайжруулахад ойлголт, мэдлэгээ дээшлүүлсэн.</p>	90%
100		115. Иргэдийг гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ойлголт, хандлагыг сайжруулж, гэр бүлийн харилцаа болон хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх	2021 - 2024		23/19000	<p>Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр, ХТУ-108 утасны өдөр, Олон улсын гэр бүлийн өдөр зэрэг тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд "Хамтдаа" гэр бүлийн уулзалт, "Гэр бүлдээ цаг гаргаарай" цахим челленж зэрэг асран хамгаалагч хүүхдийн харилцаа хандлагад эерэг нөлөө үзүүлэх 2 төрлийн арга хэмжээнд нийт 70 гэр бүлийн гишүүдийг оролцуулсан.</p> <p>Олон улсын гэр бүлийн өдрийг “Монгол гэр бүл” сэдвийн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэх тухай албан чиглэлийг сумдад хүргүүлсний үр дүнд “Гэр бүл-хүүхэд” арга хэмжээг ерөнхий боловсролын 3 сургуулиудад зохион байгуулж, эцэг эхчүүдэд “Гэр бүлийн орчин дахь хүүхэд хамгааллын тухай”, “Хүүхдийн хүмүүжил дэх эцэг эхийн оролцоо” “Эцэг, эх сургуулийн хамтын ажиллагааг өргөжүүлэх нь” зэрэг сэдвийн хүрээнд Эрдэнэ, Хатанбулаг сумд 57 эцэг, эх, асран хамгаалагч нарт сургалт зохион байгуулсан.</p> <p>Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг аймгийн Гэр бүлийн талбайд зохион байгуулж эцэг, эх, асран хамгаалагч, хүүхэд багачуудад хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн</p>	90%

					<p>найруулга, хүүхдийн тусламжийн 108 утасны мэдээллийг өгч ажилласан.</p> <p>“Монгол гэр бүл” өдрийн хүрээнд Сайншанд, Эрдэнэ, Хатанбулаг сумдад “Алтан ургийн хэлхээ-3” спортын арга хэмжээ, гар бөмбөгийн тэмцээ, цахим арга хэмжээг тус тус зохион байгуулж гэр бүлүүд авхаалж самбаагаа дайчлан өрсөлдөж 1,2,3 дугаар байруудыг шагнаж урамшуулсан.</p> <p>“Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ийн хүүхдэд тохиромжтой хялбаршуулсан хувилбар, “Өөрийгөө хайрлахуй”, “Өөрийгөө хамгаалах аюулгүйн 10 дүрэм”, “Иргэн та үүнийг мэдэх үү”, “Хүүхдийн бэлэг сахаргүй хэрэглээ” зэрэг Олон улсын гэрээ конвенц, хүүхдийн эрх, хамгааллын тухай хуулиар хамгаалагдсан хүүхдийн эсэн мэнд амьдрах, хамгаалуулах эрхтэй холбоотой 15 төрлийн постер зөвлөмжийг байгууллагын цахим хуудсанд байршуулж 6250 хүн хандалт авч хүүхэд гэж хэнийг хэлэх, тэд ямар эрх эдлэх, эрхийг нь хэрэгжүүлэхэд төр, иргэн ямар үүрэгтэй байдаг талаар олон нийтийн хандлагад эерэг нөлөө үзүүлсэн.</p>	
101	2.5.9. Хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ.	116. “Хүүхдэд ээлтэй орон нутаг” зорилтод хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2021 - 2024	Төлөвлгөөний хэрэгжилт 100%	<p>Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдэд ээлтэй орон нутаг” зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд 3 зорилтын 20 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.</p> <p>Тус хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн хөгжил оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан “Майхант чуулган”, “Хүүхдийн зөвлөлийн хэлэлцүүлэг”, “Өсвөрийн парламент-2023”, Дорноговь аймаг дахь Скаутын холбооны цугларалт уулзалт нийт 218 хүүхдийг оролцуулж, аймгийн хэмжээнд Хүүхдийн нэгдсэн чуулган, “Нэгдүгээрт хүүхэд” хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээ, зууны манлай бүжиг дэглээч Ц.Сэвжидийн нэрэмжит “Өсвөрийн бүжигчдийн улсын XVI наадам”, “Яргуй-2024” хүүхдийн урлагийн наадам, “Дорноговь цом-2022” олон хотын нээлттэй боксын тэмцээн зэрэг уралдааныг зохион байгуулж 12,216 хүүхдийг хамруулсан.</p> <p>Мөн гэр бүлийн боловсролыг дэмжих чиглэлээр Сайншанд, Алтанширээ, Өргөн зэрэг 5 сумдад гэр бүлийн зөвлөгөөн, Алтанширээ, Мандах сумын хамтарсан баг “Дэвжээ” тэмцээн, 28 аж ахуй нэгж байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс 45 төрлийн нөлөөллийн арга хэмжээнд 6738 гэр бүл, иргэд олон нийтийг</p>	90%

					<p>хамруулж, айл гэр цуврал подкаст, 27 төрлийн зөвлөмжийг хүргэсэн.</p> <p>Юнител группийн нийгмийн хариуцлагын хүрээнд НҮБ-ын Хүн амын сантай хамтран “Unitel Hub” электроникийн суурь ойлголтуудыг олгох сургалтын танхимыг тохижуулсан. Мөн 31 байгууллага “Хүүхэд хамгааллын бодлого”-ын баримт бичгийг батлан мөрдөж, 11 байгууллага хүүхдийн өрөөг тохижуулж хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлсэн.</p> <p>“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” аймгийн Засаг даргын захирамж, “Хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай” аймгийн Засаг даргын 05 дугаар албан даалгавар зэрэг хүүхдийн эрх, хамгааллын үйл ажиллагааг төрийн байгууллага, иргэд, олон нийт, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор бодлогын хэрэгжилтийг хангаж ажилласан.</p>	
102		117. Хүүхдийн зуслан барьж ашиглалтад оруулах	2021 - 2024	-	<p>Улсын төсвийн 1589.7 сая төгрөг, орон нутгийн төсвийн 698.8 сая төгрөг, нийт 2288.5 сая төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд суманд Хүүхдийн зуслан байгуулах ажлыг "Энержи парагон" ХХК, "Дэлгэр баясах зам" ХХК-ууд гүйцэтгэж 2022 оны 06 дугаар ашиглалтад оруулсан.</p> <p>Хүүхдийн зуслан нь амрагч хүүхдийн нийт 28 байр, ажилчдын байр-4ш, хооллох танхим, нийтийн ариун цэврийн байр, нийтийн халуун ус, анхны тусламжийн барилгуудаас бүрдсэн.</p> <p>"Хүүхдэд ээлтэй орон нутаг" зорилтот жилийн хүрээнд орон нутагт барилга угсралт, материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран Сайншанд сумын 2-р багийн нутаг дэвсгэрт шинээр баригдсан "Жаргалан" хүүхдийн зусланд 80.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий усан оргилуур, усан бассейн, цахилгааны утас, шугам босгох, дэд станц угсрах ажлын гүйцэтгэл 100 хувьтай хэрэгжсэн.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн “Тэрбум мод” санаачилгын хүрээнд тус аймаг “10 сая мод” тарих ажлыг эхлүүлж зуслангийн гадна талбайд 800 суулгац суулгасан. Хүүхдийн зусланд 2022, 2023 онуудад амрагч хүүхдүүдийг хүлээн авч "Жаргалан" зуслангийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд 400 хүүхдийг хамруулсан.</p>	100%

						"Жаргалан зуслангийн зуны ээлжийг 2024 оны 06 дугаар сараас эхлүүлж нийт 850 хүүхдийг амраагаад байна.	
103		118. Хүүхдийн ордны дэргэд "Хүүхдийн урлан бүтээх төв" байгуулах	2022 - 2024		-	Хүүхэд бүхний хөгжил оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Аймгийн Засаг даргын 2022 оны А/95 дугаар захирамжаар батлагдсан "Хүүхэд хөгжил-2022" зорилтот жилийн хүрээнд хүүхдийн ордныг "Хүүхэд хөгжлийн төв" болгох шийдвэр гаргаж тайлант хугацаанд уран нугаралт, шатар, хөгжим, охидын клуб, илтгэх урлаг, уран зураг, мэтгэлцээн зэрэг 7 төрлийн дугуйланд давхардсан тоогоор 1500 гаруй хүүхэд, багачууд Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1,2,3,5,6 дугаар сургуулиудаас эрсдэлт бүлгийн 29 хүүхдүүд үнэ төлбөргүй хичээллэж байна. 2023 онд 198,0 сая төгрөгийн байрны урсгал засвар, 2024 онд 17,2 сая төгрөгөөр хөгжим тоног төхөөрөмжийн засвар хийсэн.	90%
104		119. Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийн тоог нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх	2021 - 2024		100/100 /өссөн дүнгээр/	Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоол, ХНХС-ын "Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар батлах тухай" 2022 оны А/110 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж байна. 2024 онд байгууллага аж ахуйн нэгжийн "Эцэг эхийн зөвлөл"-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд оролцогч талуудын идэвхийг нэмэгдүүлэх нь сэдэвт хэлэлцүүлэг, "Олон улсын гэр бүлийн өдөр"-ийг тохиолдуулан "Гэр бүлдээ цаг гаргах "ЦАГ ГАРГАЯ" чөлөөнийг байгууллага, аж ахуйн нэгжүүдэд уриалж 14 байгууллага нэгдсэн. 16 байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс албан хаагчид болон гэр бүлийн гишүүдийг хамруулсан хөгжөөнт тэмцээн уралдаан, "Гэр бүлдээ зарцуулах цаг хугацаа үнэ цэнэ", "Хүүхдийн эрх үүрэг", "Давсаа хасъя" зэрэг сургалт нөлөөллийн арга хэмжээнд 807 иргэнийг хамруулсан. Сайншанд сумын 32 төрийн байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн 66 гишүүдийг оролцуулан Өсвөр насны охид, хөвгүүдэд тулгарч буй асуудал, цахим орчны зөв зохистой хэрэглээ, байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн үүргийн талаарх мэдээллээр хангах, нийгмийн оролцоог нь нэмэгдүүлэх зорилгоор уулзалт арга зохион байгуулсан. Аймгийн Эрүүл мэндийн газар, Нийтлэг үйлчилгээний газар, Алтанширээ сумын төсвийн 5 байгууллага зэрэг 11 байгууллага нөөц боломжоо ашиглан хүүхдийн өрөөтэй болсон. Сайншанд сумын ЗДТГ нь байгууллагын дотоод журамд "0-18 насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхдийн төрсөн өдрөөр цалинтай чөлөөг олгоно" гэсэн заалтыг нэмж, нийт 84 албан хаагч хүүхдийнхээ төрсөн өдрөөр цалинтай чөлөөг авсан.	90%

					<p>Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, хүүхдээ болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Миний гэр аюулгүй орчин” гэрийн аюулгүй байдлыг үнэлэх үнэлгээг 56 албан хаагчдаас авч, эрсдэлийг засах арга хэмжээг авч ажилласан.</p> <p>Аймгийн хэмжээнд 56 байгууллага Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгээ стандартын дагуу боловсруулж, хянуулан мөрдөж ажиллаж байгаа. 120 байгууллага эцэг эхийн зөвлөл ажиллаж байна.</p>	
105	<p>2.5.10. Залуучуудын хөгжил, оролцооны талаарх төрийн бодлого шийдвэр, дүрэм журмын хэрэгжүүлж залуучуудын санаачилгыг дэмжинэ.</p>	<p>120. Залуучуудын хөгжил, оролцоог сайжруулж, санал санаачлагыг дэмжих</p>	<p>2021 - 2024</p>	<p>8</p>	<p>“Говийн хөх салхи” НҮТББ-ын дэргэдэх Дорноговийн сайн дурынхны төвийн санаачлан зохион байгуулсан “Гайхамшигт бямба гараг” алхалт, аяллыг 6 дахь жилдээ зохион байгуулан, эх дэлхийгээ хайрлах, энэрэх, хамтач үзэл, сайн дурын ажлыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж хэвшсэн.</p> <p>Энэ жил НҮБ-ийн нийгэмлэгийн “Эх дэлхийн сургууль” хөтөлбөрийн хүрээнд Сайншандаас “Шамбала-2056”-г зорин очиж, 4500 модыг Эрдэнэ сумын багш нартай хамтран 6 цагийн дотор бортогolon тариалалтад бэлэн болгосон.</p> <p>Сайншанд сумын Засаг даргын Тамгын газар, Музей сургалт судалгааны төв, Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа “Иргэдийн оролцоо-Хотын хөгжил” зорилтот жил, “Музейтэй Дорноговь” сарын аяны хүрээнд Сайншанд сумын Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад нутаг орны түүх, соёлыг сурталчлах, тусгай хамгаалалттай газар нутагтай танилцуулж, эх нутгаараа бахархах, байгаль орчныг хайрлан хамгаалах хүмүүжил төлөвшүүлэх зорилгоор 2024 оны 05 дугаар сарын 13-14-ний 10-12 дугаар ангийн 80 сурагч хамруулсан “CITY TOUR” түүх соёлоо сурталчлах хотын аяллыг зохион байгуулсан нь хүүхдүүдэд түүх соёлоороо бахархсан, мэдлэг мэдээлэл олгосон арга хэмжээ болсон.</p> <p>Залуучуудын хөгжил оролцоог сайжруулах зорилгоор мал маллах арга ухаанд суралцах, амьжиргаагаа дээшлүүлэх хүсэлтэй 23 залуучуудын саналыг дэмжин холбогдох байгууллагад уламжлан 5 иргэнийг малжуулах төсөлд хамруулсан.</p> <p>Өсвөр үе, залуучуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх архи, тамхины хор хөнөөлийг сурталчлах, хорт зуршлаас</p>	<p>90%</p>

					урьдчилан сэргийлэх зорилгоор “Тамхидалтыг зогсооё, амны хаалтаа зүүе” арга хэмжээг санаачлан зохион байгуулсан.	
106		122. Залуу гэр бүлийг орон сууцтай болгох төсөл, хөтөлбөрийг дэмжих	2023 - 2024	25%	<p>Дорноговь аймгийн ИТХ-ын 2021 оны 04/04 дугаар тогтоолоор "Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам", 2023 оны 07-р сарын 04-ны өдрийн 12/02 дугаартай тогтоолоор "Дорноговь аймгийн зорилтот бүлгийн иргэдийг түрээслээд өмчлөх орон сууцанд хамруулах журам" - ыг тус тус батлан, журмын хүрээнд хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй Сайншанд сумын 35 хүртэлх насны 25 залуу гэр бүлийн материалыг ажлын хэсэг хүлээн авч, шалгаруулалтыг зохион байгуулснаар 8 багийн 10 залуу гэр бүлийг түрээслээд өмчлөх орон сууцны хөтөлбөрт хамруулсан.</p> <p>Мөн Даланжаргалан сумын нутагт "Мак цемент" ХХК-ний 100 хувийн хөрөнгө оруулалтаар Төрийн албан хаагчдын 8 айлын орон сууц ашиглалтад орж тус сумын 3 залуу гэр бүл, Сайхандулаан суманд 6 айлын орон сууцанд 3 байгууллагаас 6 залуу гэр бүл, Эрдэнэ суманд 27 айлын орон сууц ашиглалтад орж 10 орон сууцыг төрийн албан хаагчийн орон сууцын зориулалтаар худалдан авч, төсвийн 5 байгууллагын 10 албан хаагч залуу гэр бүлүүдийг дэмжиж орон сууцаар ханган 27 айлын орон сууцанд 17 залуу гэр бүл хамруулсан. Нийт 4 сумаас 36 залуу гэр бүлийг орон сууцанд хамруулан ажилласан нь урьд оны мөн үеэс 20-оор нэмэгдсэн.</p>	90%
107		125. Залуучуудын хөгжил, оролцоо, эрх хамгааллын талаарх төрийн бодлого шийдвэр, дүрэм журмын хэрэгжилтийг хангах	2021 - 2024		<p>“Залуучуудын оролцоо, манлайлал” МУ дахь “НҮБ-ын нийгэмлэг”-ийн туршлага хуваалцах уулзалт, “Оролцоно, төлөөлнө” 2 удаагийн сургалт, “Эмэгтэйчүүдийн манлайлал” сургалт уулзалт, “Охидын өдөр”, “Залуусын дуу хоолой” хэлэлцүүлэг, “Иргэний мэдэх эрх” сургалт, “Иргэний төсөв”, “Цаг хэд бол байна вэ?” Чила лекторын лекц, Хорихоос суллагдсан иргэдэд "Харилцаа хандлагын сургалт" зэрэг 20 сургалт, арга хэмжээний хүрээнд 2717 хүнд хүрч үйлчилсэн.</p> <p>Мөн Бүгд Залуусын Төлөө, Залуус Бүгдийн Төлөө төсөл Дорноговь аймгийн удирдлага, ТББ болон иргэдийн төлөөлөлтэй хамтран, бодлогын хэлэлцүүлэг зохион байгууллаа. Цаашид иргэдийн амьдралд нөлөөлдөг шийдвэрийг гаргах үйл явцад тэдний оролцоог үр дүнтэй нэмэх аргыг хамт хэрэгжүүлэхээр болсон. Уг сургалт, хэлэлцүүлэгт аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, аймаг, сумын Иргэдийн хурлын төлөөлөгчид, 14 сумын Залуучуудын салбар</p>	90%

					<p>зөвлөл, хөгжлийн зөвлөлийн гишүүд, иргэний нийгмийн байгууллагын төлөөл 60 залуу оролцсон.</p> <p>Тогтвортой хөгжлийн 13 дахь зорилт болох Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах Цаг уурын өөрчлөлт, түүний үр дагавартай тэмцэх талаар арга хэмжээ авах зорилтын хүрээнд Дорноговь, Төв, Говьсүмбэр аймгийн сурагчдын төлөөллүүдэд байгаль орчин, тогтвортой хөгжлийн мэдлэг мэдээлэл олгох, бүх түвшний шийдвэр гаргах явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн оролцоотойгоор аливаа шийдвэр тогтоолуудыг байгальд ээлтэй байх шаардлагыг хангахад хувь нэмэр оруулах зорилгоор "YOUTH POWER GTD" Байгальд ээлтэй залуусын чуулган зохион байгуулсан.</p>	
108	2.6.1. "Алсын хараа - 2050" урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, стандарт шаардлагад нийцсэн соёл урлагийн байгууллагын барилга байгууламжийн тоог нэмэгдүүлнэ	123. Хамарын хийдэд ноён хутагт Д.Данзанравжаагийн нэрэмжит соёл аялал жуулчлалын цогцолбор байгуулах төслийг эхлүүлэх	2022 - 2024	-	<p>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 15/09 дугаар тогтоолоор баталсан 2024 оны аймгийн Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд "Хамарын хийдэд Ноён хутагт Д.Данзанравжаагийн нэрэмжит соёл-аялал жуулчлалын төв" гэр театрын барилга барих арга хэмжээг тусгасан.</p> <p>Соёлын аялал жуулчлалын цогцолбор төв байгуулах бэлтгэл ажлыг ханган Говийн ноён хутагт Д.Данзанравжаагийн нэрэмжит "Хутагтын өргөө, гэр театрын барилга" барих зураг төсвийн ажлыг "Сант номун" ХХК-иар гүйцэтгүүлж үзэгчдийн танхим, тайз, тайзны арын өрөө, хурлын өрөө гэх мэт 232.58 м2 талбай бүхий барилга байгууламж, 0,3 га ногоон байгууламж байгуулах төлөвлөлт хийсэн.</p> <p>Ханбаянзүрх хайрханы гэрэлтүүлэг зам талбайг өргөтгөж, засварлах, Шамбалын орон, Ханбаянзүрх хайрхан орчимд нийтийн бие засах газрууд, Хамарын хийдийн Шамбалын орныг 108 агуйтай холбосон автозам, зогсоол хийх ажил, Хунгийн хөшөө шинээр барих, Сайншанд-Хамарын хийд чиглэлийн автозамын засвар шинэчлэлтийн ажлуудыг хийж аялагчдын ая тухтай аялах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд анхаарч орон нутгийн төсвөөс 2 тэрбум орчим төгрөгийг зарцуулсан.</p>	90%
109		124. Сайншандад 700 хүний суудалтай "Саран Хөхөө" шинэ театрын барилга барих	2021 - 2024	-	<p>Улсын төсвийн 18.5 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд суманд 700 хүний суудалтай Саран Хөхөө театрын барилга барих ажлыг "Болор-Аграмба" ХХК гүйцэтгэж байна.</p> <p>Тус театрын барилга нь 69.0м х 53.4м хэмжээтэй, зоорьтой, 3 давхар, төмөр бетон каркасан хийцтэй барилга бөгөөд 2021-2023 онд улсын төсвөөс батлагдсан 10.2 сая төгрөгийн санхүүжилтээр барилгын газар шороо, суурь, зоорьны давхрын каркасан хийцийн угсралт, тайзны хэсгийн багана, дамнуруу</p>	90%

					<p>болон хөгжимчдийн хэсгийн дамнурууны угсралт, 1, 2-р давхрын багана дамнуруу, хучилтын ажил, зоорийн давхрын хамар ханын тоосгон өрөг, 1, 2-р давхрын блок ханын дүүргэлтийн ажлууд хийгдсэн.</p> <p>2024 онд улсын төсөвт 7.0 тэрбум төгрөг батлагдаж барилгын +10.35м түвшин дэх хучилтын хэв хашмал арматурчлалын ажил, цонх угсралтын ажил, гадна ханын 15см эрдэс хөвөн дулаалга болон металл фасадны рам угсрах ажил, гадна болон дотор ханын өрөг угсралтын ажил, дотор халаалт, салхивч, цэвэр бохир усны шугам хоолойн угсралтын ажлууд нь хийгдэж байна.</p> <p>700 хүний суудалтай шинээр баригдаж буй Саран хөхөө театр ашиглалтад орсноор шинээр 120 ажлыг байр бий болж , ажилчдын ажиллах таатай орчин бүрдэх, үйл ажиллагааны хүчин чадал нэмэгдэж, шинэ техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаж, иргэдэд соёл урлагийн үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэх юм.</p>	
110		125. Замын-Үүд суманд 500 хүний суудалтай соёлын ордон барих	2021 - 2024	-	<p>Улсын төсвийн 8.3 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр Замын-Үүд суманд 500 хүний суудалтай соёл, урлагийн ордны барилга барих ажлыг "РСТ" ХХК гүйцэтгэж байна.</p> <p>Тус театрын барилга нь тэнхлэгээрээ 46.0х45.0м хэмжээтэй, хагас зоорьтой, 2 давхар, төмөр бетон каркасан хийцтэй барилгын үндсэн хийц бүтээц, дээврийн дулаалга, гадна шугам сүлжээ, цонх угсрах ажлууд хийгдсэн.</p> <p>Гадна дотор шавардлага заслал, халаалт, салхивч, гэрэлтүүлэг, гадна үүдний шат довжоо, дээврийн ажлууд үргэлжлэн хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 85%-тай</p>	90%
111	2.6.2. Соёл, урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангаж, "Цахим соёл" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	127. Номын санд "Үүлэн сервэр" электрон каталогийг нэвтрүүлж, номын фондыг нэмэгдүүлж, интернэтэд суурилсан үйлчилгээг хүргэх	2021 - 2024	Номын сангийн үйлчилгээг орон зай харгалзахгүй 100% авдаг болсон байна.	<p>Аймгийн Засаг даргын 2022 оны А/663 дугаар захирамжаар Төв номын санд "Үүлэн сервер" электрон каталогийг нэвтрүүлж, уншигчдад хэрэгцээт ном хэвлэлийг түргэн шуурхай эрэн хайх боломжийг бүрдүүлэн, цахим лавлагаа мэдээллийг өгч, интернэтэд суурилсан үйлчилгээг хүргэж эхэлсэн. 2021 онд цар тахлын улмаас электрон каталогийн үйлчилгээг хүргээгүй.</p> <p>2022 онд электрон каталогит шинээр 569 ном, Зава Дамдингийн 17 судрыг цахим санд бүртгэж, уншигчдын хэрэгцээ шаардлагыг хангасан.</p> <p>2023 онд шинээр авсан 320 ширхэг номыг цахим санд бүртгэн электрон каталогт байршуулсан. Үйлчлүүлсэн иргэдийн</p>	100%

					<p>тоо- 1654. Өмнөх 2022 онтой харьцуулахад 13,7 хувиар цахим үйлчилгээний тоо өссөн.</p> <p>Электрон каталогт 1265 ширхэг ном оруулсан. 2020-2024 онд Цахим соёл түгээх зорилгоор Аман зохиол, ардын зан үйл, ёс заншил, шинжлэх ухаан танин мэдэхүйн, үлгэр туульс, хэлц үг сургалт өгүүллэг, цахим үлгэр, гэх мэт 120 гаруй нэр төрлийн 6300 гаруй пост мэдээ мэдээллийг 64940 хүнд хүргэлээ.</p> <p>Тайлант хугацаанд цахимаар доорх уралдаан тэмцээнийг зохиож уншигчдын идэвхийг өрнүүллээ. "Нутгийн Уул усны шинэ домог яриулах" уралдааныг анх удаа ахмадын дунд амжилттай зохиож 20 гаруй ахмад оролцлоо.</p> <p>Хүүхдийн хөгжилтэй яриа видео бичлэгийн уралдаанд 24 бичлэг ирж нийтэд 13500 хүнд танилцуулсан байна. • Ном миний амьдралд видео бичлэгийн уралдаан – 9 бичлэг 3 байр шалгаруулж 7300 хүнд үйлчилсэн. Дэлхийн номын өдрөөр *Хөгжилтэй зурган зүйр үг таах* уралдаан зэрэг цахим орчны уралдааныг тогтмол дөрвөн жил зохион байгуулан ажиллаж дээрх уралдаан тэмцээнийг нийт 48000 гаруй хүн дэмжин үзэж сонирхсон байна.</p> <p>2024 оны эхний хагас жилд 1300 үйлчлүүлэгчээр өссөн нь өмнө оны жилийн эцсийн байдлаас 78%-аар өссөн.</p>	
112	128. Соёлын байгууллагуудын үйлчилгээнд цахим технологийг нэвтрүүлэх	2021 - 2024	3	<p>Соёл, урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангаж, “Цахим соёл” арга хэмжээг хэрэгжилтий хүрээнд 2021-2024 оны хооронд 12 цахим технологи, үйлчилгээг 13 байгууллагад нэвтрүүлэн ажилласан.</p> <p>Алслагдсан сумдын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад музей үзэх боломжийг бүрдүүлж “Цахим музей” арга хэмжээг явуулж Замын-Үүд, Алтанширээ, Айраг, Дэлгэрэх, Улаанбадрах зэрэг сумдын дунд ангийн болон ахлах ангийн 400 сурагчийг хамруулсан. Үндэсний онцлогийг агуулсан Ноён хутагтын 130 гаруй төрлийн эд өлгийн зүйлсийг дэлгэн AR технологиор дамжуулан үзмэрийн мэдээллийг хүлээн авах боломжийг бүрдүүлснээс гадна “Danzanravjaa museum” аппликейшнийг бүтээж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Хатанбулаг сумын Соёл, спортын төв 54 үзмэрээ 3D хэлбэрт шилжүүлэн 300 гаруй иргэнд үйлчилсэн.</p> <p>Саран хөхөө театр цахим тасалбарын "Ticket.mn"-тэй гэрээ байгуулж тоглолт болон жүжгийн тасалбаруудаа цахимаар худалдаалж эхэлсэн.</p>	90%	

					<p>Аймгийн төв номын сан “Үүлэн сервер” программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн 1265 номыг бүртгэж 2954 иргэн үйлчлүүлсэн. Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумд шинээр лед дэлгэц байршуулан соёлын үйлчилгээг технологийн шинэлэг, дэвшилтэт шийдэл ашиглан хүргэж эхэлсэн. Соёлын салбарт цахим шилжилтийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд Монгол Улсын өв соёлын дижитал шилжилтийг идэвхжүүлэх зорилгоор Соёлын яамнаас соёлын салбарын байгууллагуудад GLAM систем, чөлөөт уран бүтээлчдийн оюуны өмчийг хамгаалах CREATIVEHUB зэрэг цахим мэдээллийн сангуудын хөгжүүлэлтийг хийж хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болгосон.</p> <p>Мөн соёлын салбарын статистик мэдээний cis.mn программийг албан хэрэгцээнд ашиглах талаар арга зүйн цахим сургалтыг салбарын 18 албан хаагчдын дунд зохион байгуулсан.</p> <p>2024 оны аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 15/09 дугаар тогтоолоор аймгийн Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд Музей сургалт судалгааны төвд VR төхөөрөмж нэвтрүүлэн хэрэгжилтийг хангах тухай заалтыг тусгасан.</p>	
113	129. Соёл урлагийн байгууллага, сургууль цэцэрлэгийн дуу хөгжмийн багш, мэргэжлийн уран бүтээлчдийг сургаж бэлтгэх	2021 - 2024	5	<p>Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, мэргэшсэн байдлын үнэлгээг нэмэгдүүлэх, зорилгоор СУИС-ын мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран сумдын дуу хөгжмийн багш нарын ур чадварыг дээшлүүлж, чадавхжуулах 5 хоногийн сертификат олгох, кредит тооцох сургалтад Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Замын-Үүд, Иххэт, Өргөн, Хөвсгөл, Эрдэнэ зэрэг 8 сумын 9 хөгжмийн багш, бүжгийн багшийг бүжиг заах арга зүйн 40 цагийн 6 хоногийн сургалтад Улаанбаатар хотод оролцууллаа.</p> <p>Аймгийн хэмжээнд нэн шаардлагатай хөгжмийн багш, хөгжимчний мэргэжлээр 9 оюутныг суралцуулж аймгаас сургалтын төлбөрийн тэтгэлэг олгон гэрээ байгуулан дэмжлэг үзүүлсэн.</p> <p>2022 онд аймгийн Засаг даргын 2022 оны А/280 дугаар захирамжаар Саран хөхөө театрын хөгжимчин, бүжигчин 3 уран бүтээлчийн сургалтын хөтөлбөрийн төлбөрт нийт 5,0 сая, А/575 дугаар захирамжаар МУ-ын СУИС-д Дуу хөгжмийн багш мэргэжлээр суралцаж буй 5 оюутны сургалтын төлбөрт орон нутагтаа эргэн ажиллах нөхцөлтэй гэрээний дагуу нийт 20,0 сая, Даланжаргалан сумаас хөгжмийн багш мэргэжлээр сурч буй 1 оюутны сургалтын төлбөрт 4,0 сая, бусад мэргэжлээр</p>	90%	

					суралцаж буй 6 оюутанд 16 сая, орон нутагт нэн шаардлагатай багшийг бэлтгэхэд нийт 15 оюутанд 45,0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн.		
114		130. Соёлын байгууллагуудын үйлчилгээнд шинэлэг арга барилыг нэвтрүүлж хүртээмжийг сайжруулах.	2021 - 2024		2/8000	<p>2020-2024 онд AR технологиор "Адистэд хурсан гайхамшиг" тусгай үзэсгэлэнг Чингис хаан музейд, Олон Улсын Равжаа судлалын "Ноён хутагтын өв: өнгөрсөн, одоо, ирээдүй" эрдэм шинжилгээний VI хурал, Улсын хэмжээнд зураач, барималч, урчуудын дунд "Ноён хутагт данзанравжаа" уран бүтээлийн уралдаан, орчин цагийн музей үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд Соёлын яамнаас зохион байгуулсан "Монгол гэр" үзэсгэлэн, "Монгол гэр-Соёлын орон зай" соёлын арга хэмжээ, яруу найргийн OPEN MIC, Ардын дууны "Аясгалан хөг" арга хэмжээ, "Эгшиглэнт говь" 14 сумын соёлын өдрүүд, "Соёлын сэргэлт-2023" аян, "Тэнгэрийн хутагт" бүжгэн жүжиг зэрэг 10 гаруй шинэлэг арга хэмжээг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж танхим болон цахимаар 130000 гаруй иргэдийг хүргэлээ.</p> <p>Аймгийн мэргэжлийн урлагийн байгууллага Саран хөхөө театр 2020 оноос 2024 оны хагас жилийн байдлаар шинээр "Гэтэлгэх мөр" туульсын драмын жүжиг, "Эвт Мэргэн Өвгөн Эх Чоно хоёрын домог", "Чандмань эрдэнэ" хүүхдийн жүжиг, "Одонтой аав" кино контент, "Хайрынхаа төлөө" дуун контентыг бүтээж танхимаар 5000 гаруй, цахимаар 30000 гаруй хүүхэд багачууд, иргэд олон нийт үзэж сонирхлоо.</p>	90%
115	2.6.3. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, орон нутгийн онцлог шингэсэн соёлын үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ	131. Төрийн шагналт, "Болор цом"-ын эзэн яруу найрагчдын "Эх орон-Өв уламжлал" яруу найргийн чуулган зохион байгуулах	2021 - 2024		-	<p>Дорноговь аймгийн түүхт 90 жилийн ойг тохиолдуулан Монголын Зохиолчдын эвлэл болон Дорноговь аймгийн ЗДТГ, Дорноговийн зохиолч яруу найрагчдын "Хурмаст тэнгэр" төвийн хамтарсан санаачилгаар Болор цомын эзэд болон Монголын Зохиолчдын эвлэлийн гишүүд 25 хүнээс бүрдсэн яруу найрагчдыг Сайншандад урьж орчин цагийн номын сан үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан аймгийн Төв номын сангаас "Эх орон-Өв уламжлал" яруу найргийн чуулганыг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын захирамжаар 15,0 сая төгрөгийг шийдвэрлэж ажлын хэсгийн бүрэлдэхүүн гарган ажиллалаа.</p> <p>МУСГЗ, Нацагдоржийн шагналт, Болор цомын эзэн нийт 25 яруу найрагчид эх орон, өв соёл, уламжлалт ёс заншил, монгол бахархал, шударга ёс, цэрэг эх орны сэдэвтэй шүлэг яруу найргаар сонсогч үзэгчдийн сонорыг мялааж 328 уншигч үзэгчдийг хамруулсан.</p>	100%

116		132. Баяр наадам, тэмдэглэлт ой, томоохон арга хэмжээнд зориулсан уран бүтээлийг дэмжиж ажиллах	2021 - 2024		3	<p>Нэрт соён гэгээрүүлэгч V дугаар Ноён хутагт Д.Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойн хүрээнд "Тэнгэрийн хутагт" бүжгэн жүжиг, "Ноён хутагтын өв: өнгөрсөн, одоо, ирээдүй" ОУ эрдэм шинжилгээний хурал, "Ноён хутагтын өв: өнгөрсөн, одоо, ирээдүй" улсын уралдаан, "Гэтэлгэх мөр" хөгжимт драмын жүжиг, "Адистэд хурсан гайхамшиг" тусгай үзэсгэлэн, "Эгшиглэнт говь" сумдын соёлын өдрүүд зэрэг арга хэмжээг 1 тэр бум 90 сая төгрөгөөр орон нутгийн дэмжлэгээр зохион байгуулсан.</p> <p>2020 оноос 2024 оны хагас жилд Зууны манлай бүжиг дэглээч Ц.Сэвжидийн нэрэмжит "Өсвөрийн бүжигчдийн Улсын XVI уралдаан", Ерөөлч магтаалч, туульчдын наадам, "ИХ ГОВИЙН ТЭМЭЭ-2023", МУСГЗ Л.Эрдэнэбатын "Дөрвөн цагийн тал" арга хэмжээ, "Язгуур алтан өв" СББӨ-ийн наадам, "Нүүдэлчин-2022,2023" фестиваль, "Номын баяр" арга хэмжээ, "Соёлын сэргэлт-2023", "Яргуй-2024" хүүхдийн урлагийн их наадам зэрэг томоохон арга хэмжээнд аймаг орон нутгаас 150 сая төгрөгөөр дэмжин ажиллаж, соёлын үйлчилгээг 60000 гаруй иргэдэд хүргэлээ.</p>	90%
117		133. Хүүхдэд зориулсан шинэ уран бүтээл тогтмол туурвих.	2021 - 2024		1	<p>2024 оны хагас жилд Саранхөхөө театр Э.Нямдуламын зохиол "Эвт Мэргэн Өвгөн -Эх Чоно хоёрын домог" хүүхдийн жүжгийг сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдүүдэд, мөн Э.Нямдуламын зохиол "Чандмань Эрдэнэ" хүүхдийн жүжгийг Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулан толилууллаа.</p> <p>2023 онд Замын-Үүд сумын Соёл, спортын ордноос "Зөв ирээдүйн төлөө хамтдаа" зорилтот хөтөлбөрийн хүрээнд "Дүрсгүй отголдой" мини театрын хэрэгжүүлсэн Н.Төрбадрахын зохиол "Нэг ангийнхан" сургамжит хүүхдийн драмын жүжгийг Замын -Үүд, Хөвсгөл, Улаанбадрах,Өргөн, Эрдэнэ сумдаар ЕБС-ийн 6-12-р ангийн 1200 хүүхдэд хүргэсэн.Улсын хүүхэлдэйн театрт хамтран ажиллах гэрээний дагуу Сайншанд, Замын -Үүд сумдад СӨБ-ын болон 1-5-р ангийн 2300 хүүхдийг хамруулан хүүхэлдэйн жүжиг толилуулсан.</p> <p>"Морин хуур-35" наадмуудад хүүхдэд зориулсан шинэ уран бүтээл "Хүүхдийн дууны цоморлог" бүтээлээр хөгжмийн зохиолч Ж.Нямсүрэн оролцож, дууны төрөлд тэргүүн байр эзэлсэн.</p> <p>"Нэгдүгээрт хүүхэд" уриан дор Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр "Саран хөхөө" театрын "Шидэт бэлгийн эрэлд"</p>	100%

						зохиомжит үлгэрийн баатруудын тоглолтыг 300 гаруй хүүхэд багачуудад үзүүлсэн.	
118		134. Нутгийн яруу найрагч, хөгжмийн зохиолчдын дууг нутагшуулах, ардын авьяастнуудын дунд уралдаан зохион байгуулах, тоглолт хийх, шилдэг уран бүтээл, уран бүтээлчдийг сурталчлах	2021 - 2024		2	<p>2020 оноос 2024 оны хагас жил хүртлэх хугацаанд байдлаар Нутгийн яруу найрагч, хөгжмийн зохиолчдын дууг нутагшуулах, ардын авьяастнуудын дунд уралдаан зохион байгуулах, тоглолт хийх, шилдэг уран бүтээл, уран бүтээлчдийг сурталчлах 20 гаруй арга хэмжээг зохион байгуулж түгээн дэлгэрүүлсэн. Тухайлбал: "Намсрайн Батнасан сан"-гийн нэрэмжит "Шинэ зууны наран" найрал дууны анхдугаар уралдаан, Монгол Улсын Төрийн өргөмжлөлт ерөөлч, магтаалч, туульч З.Чулуунбаатарын нэрэмжит наадам, Төрийн соёрхолт Ардын уран зохиолч Б.Догмидын "Санаж сарвайх нутаг, ус мину" уншигч, зохиолчийн уулзалт, СГЗ Л.Эрдэнэбатын цомнол "Тэнгэрийн хутагт" бүжгэн жүжиг, Монголын зохиолчдын "Хурмаст тэнгэр" төв, "Арлааны Эрдэнэ-Очир сан" хамтран хайрын шүлгийн "Оюу ай" наадам, А.Эрдэнэ-Очирын нэрэмжит "Нөмрөг тэнгэрийн дор" уншлага, "Борхойн цом" яруу найргийн наадам, "Алтан говийн унага" 60 жилийн ойд зориулсан Ч.Банзрагчийн нэрэмжит уртын дуу дуулаачдын улсын уралдаан, МУСГЗ Л.Эрдэнэбатын "Дөрвөн цагийн тал" арга хэмжээ, "Говийн уянга" бүжгийн хамтлагийн "ҮЗЭСГЭЛЭНТ ГОВЬ" бүжгийн тоглолтыг зохион байгуулж 5000 гаруй иргэдэд хүргэж нутгийн уран бүтээлчдээ алдаршуулан, бүтээл туурвилыг сурталчлан ажиллалаа.</p> <p>Соён гэгээрүүлэгч Д.Данзанравжаагийн нэрэмжит "Саран хөхөө" театрын тайзнаа 2024/03/09нд тоглогдож Дорноговь аймгийн бүжиг дэглээч багш МУСТА Ө.Эрдэнээ, "Саран хөхөө" театрын бүжигчин МҮЭСТА Н.Өсөхбаяр нарын дэглэлт бүжгийг Сайншанд ЕБС 2 р сургуулийн Говийн Уянга бүжгийн хамтлагийн сурагчид бүжиглэн 350 гаруй иргэд 600 гаруй хүүхэд багачуудад хүргэлээ. Дэлгэрэх сумын Соёлын төвийн хөгжмийн багш Х.Болдбаатарын "Хуурч" номын нээлтийн арга хэмжээ, Өргөн сумын Соёлын төвийн хөгжмийн багш Э.Ган-Эрдэнийн "Үзэсгэлэн" анхны бие даасан тоглолт, Дорноговь аймгийн "Мөнгөн харш" хамтлагийн 4р үеийн анхны бие даасан "Мөнгөн харш" хамтлагийн тоглолтууд зохион байгуулагдлаа.</p>	100%
119	2.6.4. Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг	135. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын видео бичлэг, дуу	2021 - 2024		3/25	Говь нутгийн байгаль цаг уур, хүн зоны аж байдлын онцлогийг харгалзан Соёлын биет бус өвийн мал маллах арга ухаанд суралцуулах, мэдлэг ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, зорилгоор Хөвсгөл сумын соёлын төв нь ямаа самнах, хөрзөн гишгэх, ишиг амлуулах зэрэг малчдын өдөр тутмын ажлыг	100%

	<p>сайжруулан, судлан сэргээх, өвлөн уламжлуулах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>дүрсийг хадгалж, цахим сан үүсгэн, өвлүүлэн үлдээхэд урамшуулах</p>			<p>дүрсжүүлэн контент бэлтгэж Ерөнхий боловсролын 2-7-р ангийн 120 сурагчдад хүргэж цахимд байршууллаа.</p> <p>Иххэт сумаас зохион байгуулсан “Таван эрдэнэ-2024” малчдын зөвлөгөөний үеэр язгуур урлагийн 15 өвлөн уламжлагчдын тоглолтыг цахимаар шууд дамжуулан 100 гаруй үзэгчдэд хүргэж тус тоглолтын дүрс бичлэгийг хадгалан цахим сан үүсгэлээ.</p> <p>Хатанбулаг сумын соёл, спортын төв нь 2020 онд Шинжлэх ухааны академитай хамтран хийсэн угсаатан зүйн судалгаандаа үндэслэн аман хууч яриа, үлгэр домгийг өвлүүлэн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Цагаан арслан хийгээд цагаан зандан мод”-ны үлгэрийг дүрсжүүлэн контент бэлтгэж цахим сан үүсгэсэн бөгөөд тус үлгэрийн контент нь нутаг орны хууч домог яриа, угсаатны онцлогийг хойч үедээ өвлүүлэн үлдээхэд өндөр ач холбогдолтой юм. 2024 оны хагас жилийн байдлаар соёлын биет бус өвийн язгуур урлаг, мал маллах арга ухаан, эх хэл аман уламжлал илэрхийлэл ай савын тус тус 1 бүтээлийг дүрс бичлэг болгон контент бэлтгэн цахимд байршуулж нийт 3 бүтээлээр цахим сан үүсгэлээ.</p> <p>Ингэснээр 2020-2024 онуудад орон нутгийн төсвийн 25 сая төгрөгөөр "Язгуур алтан өв" соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын наадмыг телевизийн бичлэгээр баримтжуулан 350ш ном, 250ш DVD хэвлүүлэн нутгийн онцлог бүхий биет бус өвийг хадгалах, сурталчлан түгээн дэлгэрүүлэх өндөр ач холбогдолтой сан хөмрөг бүрдүүлснээс гадна "Нүүдэлчин-2022, 2023", "Эгшиглэнт говь", "Ерөөлч магтаалчдын анхдугаар наадам" зэрэг улс, аймгийн чанартай томоохон 11 арга хэмжээг бичлэг болон гэрэл зургаар баримтжуулан 60 сая төгрөгөөр цахим сан үүсгэж орон нутгийн төсвийн 20,0 сая төгрөгөөр 100 гаруй өвлөн уламжлагчдыг урамшууллаа.</p>	
120		<p>136. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг алдаршуулах, тоглолт арга хэмжээ зохион байгуулах</p>	2021 - 2024		<p>1</p> <p>Музей, сургалт судалгааны төвийн дэргэдэх "Эвийн эгшиг" уртын дууны дугуйлангийн 10 жилийн хугацаанд 300 гаруй шавь төрүүлж 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр өвлөн уламжлагчдыг алдаршуулах, тоглолт арга хэмжээг зохион байгууллаа.</p> <p>Өвлөн уламжлагчид нь уртын дуу болон ховордож мартагдсан аман зохиол, ерөөл магтаал, бусад хөгжмийн зэмсгийг хөгжимдөж дуулахаас гадна тухайн дууны түүх, онцлог шинж, өвийг өвлөж авах, дуулахдаа өмсөх монгол хувцсыг иж бүрэн, цэвэр цэмцгэр өмсөхөөс эхлэн олон зан заншлыг эзэмшдэг тусгай өв юм.</p> <p>2023 онд орон нутгийн онцлог шингэсэн, нутгийн яруу найрагч, уран бүтээлчдийг алдаршуулах, соёл урлагаар</p>	100%

					<p>дамжуулан соён гэгээрүүлэх зорилготой "Эгшиглэнт говь" сумдын соёлын өдрүүдийг 14 сумын 140 гаруй өвлөн уламжлагчдыг оролцуулан зохион байгуулсан.</p> <p>"Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалд аймаг орон нутгаа төлөөлөн жил бүр оролцож гадаад болон дотоодын зочид, төлөөлөгчдөд говь нутгийн соёлын биет болон биет бус өв соёлоо түгээн сурталчилан ажилласан.</p> <p>Монгол Улсын Төрийн өргөмжлөлт 3.Чулуунбаатар агсны нэрэмжит ерөөлч, магтаалчдын наадам, хойд бүсийн өсвөрийн уртын дууч, морин хуурчдын "Өв алтан эрдэнэ" уралдаан, "Язгуур алтан өв" аймгийн соёлын биет бус өвийн анхдугаар их наадам, Зууны манлай бүжиг дэглээч Ц. Сэвжидийн нэрэмжит "Өсвөрийн бүжигчдийн Улсын XVI уралдаан", "Болор эгшиглэн" үндэсний хөгжмийн хамтлагийн 10 жилийн ойн тоглолт зэрэг томоохон арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг алдаршуулан, урамшуулж цахим сан үүсгэн бүртгэлжүүлж ажиллалаа.</p> <p>Тус арга хэмжээнүүдийг 120000 гаруй иргэд, олон нийт үзэж сонирхлоо.</p>	
121		137. Музейн сан хөмрөгийг баяжуулж, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэлжүүлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах	2021 - 2024	2/10	<p>2021-2023 онд музейн сан хөмрөгийг 14 дэсийн 14 ширхэг үзмэрээр баяжуулсан. Үзмэр баяжуулалтад 3,5 сая төгрөгийг музейн үндсэн үйл ажиллагааны Эрдэм шинжилгээ судалгааны ажлын зардлаас гарган зарцуулсан байна.</p> <p>2024 онд Замын-Үүд сумын гаальд хураагдсан түүх соёлын дурсгалт зүйлсийг Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн шийтгэврээр манай музейн сан хөмрөгт шилжүүлсэн 35 судар номыг баримтат өвд бүртгэн авсан.</p> <p>Монгол Улсын Их Сургуулийн Археологийн судалгааны төвтэй хамтран 2022 онд Мандах сумын Өехий багийн нутаг дахь Дэнгийн овоо орчимд археологийн малтлага, судалгааны ажил, 2023 онд ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнтэй хамтран Хатанбулаг сумын Сүж уулын орчим дахь 2 булш оршуулганд авран хамгаалах археологийн малтлага судалгааг зохион байгуулсан.</p> <p>Дээрх археологийн малтлага судалгааны ажлуудад 7,5 төгрөгийг зарцуулсан. Аймгийн Засаг даргын 2022 оны А/566 дугаар захирамжаар Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогыг 13 сумын нутаг дэвсгэрийн 415 дурсгалт газар орших 2500 гаруй дурсгалт газруудыг бүрэн хамруулан, гэрэл зургаар</p>	100%

						баримтжуулан, газар зүйн байршлыг тогтоон rich.mongol.uv.mn программд мэдээллийг оруулсан.	
122		138. Хүн бүр удмаа мэдэж, угийн бичгийг хөтлөх үндэсний уламжпалыг хэвшүүлэх зан үйлийг сургах, сургалт нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлэх	2021 - 2024		25/1500	<p>Иргэд олон нийтэд угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг таниулах зорилгоор Үндэсний сургагч багш , өв соёл ураг удам судлаач Д.Цогбадрах, хүний их эмч н.Александр нартай хамтран "Угийн бичиг-Улсын үндэс" хөтлөх номын жишиг танилцуулах, мэдээлэл өгөх сургалт арга хэмжээг "Монгол гэр-Соёлын орон зай" хөтөлбөрт тусган хэрэгжүүллээ.</p> <p>Тус сургалтыг 2 удаагийн давтамжтайгаар зохион байгуулж 50 гаруй иргэнийг хамрууллаа.</p> <p>Иххэт, Сайхандулаан, Хөвсгөл сумдын соёл болон соёл, спортын төвөөс угийн бичиг хөтлөх арга зүйн 4 удаагийн танхимын сургалт зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулийн 111 сурагч 6 залуу гэр бүлийг хамрууллаа.</p> <p>2022-2024 онуудад угийн бичиг хөтлөх 117 удаагийн сургалт арга хэмжээ зохион байгуулж угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо 2056 болсон.</p> <p>Иргэд олон нийтэд угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг таниулах зорилгоор Үндэсний сургагч багш , өв соёл ураг удам судлаач Цогбадрах, хүний их эмч Александр нар "Угийн бичиг-Улсын үндэс" хөтлөх номын жишиг танилцуулах, мэдээлэл өгөх сургалт арга хэмжээг Соёл, урлагийн газраас зохион байгуулсан "Монгол гэр-Соёлын орон зай" хөтөлбөрт тусган хэрэгжүүллээ.</p> <p>Иххэт, Сайхандулаан, Хөвсгөл сумдын соёл болон соёл, спортын төвөөс угийн бичиг хөтлөх арга зүйн 4 удаагийн танхимын сургалт зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулийн 111 сурагч 6 залуу гэр бүлийг хамрууллаа.</p> <p>Аймгийн хэмжээнд угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо 2020 онд 1804 байсан бол 2024 онд 2056 болж угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо 14,1%-иар өссөн үзүүлэлттэй байна.</p>	90%
<b>3. Эдийн засгийн бодлого</b>							
123	3.1.1. Банк санхүүгийн зах зээлийн эрсдэл даах, найдвартай байдлыг сайжруулна.	139. Банкны үйлчилгээг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх замаар аж ахуйн нэгж, иргэдийн хуримтлал үүсгэхэд анхаарч	2021 - 2024		180 тэрбум төгрөг	<p>Аймгийн хэмжээнд 2024 оны 06 сарын байдлаар нийт хадгаламжийн үлдэгдэл 242,6 тэрбум төгрөг болж 2023 оны мөн үетэй харьцуулахад 67,4 тэрбум төгрөгөөр, харилцах дансны үлдэгдэл 115,3 тэрбум болж 22,3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн.</p> <p>Хадгаламж эзэмшигчийн тоо 75.5 мянга болж өмнөх оны мөн үеэс 5.0 мянгаар, харилцах данс эзэмшигч 177.6 мянга болж 9.1 мянгаар нэмэгдсэн байна.</p>	100%

		бэлэн бус төлбөр тооцоог дэмжих				<p>Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Цагдаагийн газар, арилжааны 6 банк болон Насан туршийн боловсролын төвтэй хамтран "Global money week" аяныг зохион байгуулж 1766 оюутан сурагчид, 37 иргэнд хуримтлалын ач холбогдол болон санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг хүргэсэн.</p> <p>Мөн санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар 24.8 мянган иргэдэд масс мессежээр, хүүхдүүдийн дунд REELS уралдаан зарлаж цахимаар 3099 иргэнд мэдээлэл хүргэсэн.</p>	
124		140. Иргэдийн санхүүгийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэн санхүүгийн эрсдэл, дарамтад өртөхөөс сэргийлэх	2021 - 2024		1000	<p>Орон нутгийн DTV телевиз, "Өнөөдрийн Дорноговь" сониноор банкны сар бүрийн мэдээ тайлан, мэдээллийг иргэд хүргэж байна.</p> <p>Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Цагдаагийн газар, арилжааны 6 банк болон Насан туршийн боловсролын төвтэй хамтран "Global money week" аяныг зохион байгуулж 1.766 оюутан сурагчид, 37 иргэнд хуримтлалын ач холбогдол болон санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг хүргэсэн.</p> <p>Мөн санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар 24.8 мянган иргэдэд масс мессежээр, хүүхдүүдийн дунд REELS уралдаан зарлаж цахимаар 3099 иргэнд мэдээлэл хүргэсэн.</p>	100%
125		141. Иргэдийн санхүүгийн сахилга батыг дээшлүүлэхэд анхаарч хугацаа хэтэрсэн зээлийг бууруулж зээлжих чадварыг нэмэгдүүлэх	2021 - 2024		5,0%	<p>Банкнуудын зээлийн багц 444.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 111.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, чанаргүй зээл 16.5-11.4 тэрбум болж багцын 2.6 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.4 функтээр буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Чанаргүй зээл буурсан шалтгаан нь Замын-Үүд хилийн боомтын үйл ажиллагаа сэргэсэнтэй холбоотой ба Замын-Үүд дэх арилжааны банкнуудын чанаргүй зээл 10.8-5.8 тэрбум төгрөг болж багцад эзлэх чанаргүй зээл 10.3-3.9% хүрч буурсантай холбоотой байна.</p>	100%
126	3.1.2. Төсвийн хөрөнгийг орон нутгийн хөгжилд чиглүүлэн үр ашигтай, хариуцлагатай зарцуулах зарцуулах бодлого баримтална.	142. Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, татвар төлөгчдийг татварт хамруулах хүрээг нэмэгдүүлэх	2021 - 2024		96,6% 23073	<p>"Цахимаар татвараа төлж цагаа хэмнэе" уриан дор татвар төлөгчдөд чиглэсэн 29 төрлийн татварын үйлчилгээг 100 хувь цахимаар хүргэж, НӨАТ-ын хуулийн хэрэгжилтийг сайжруулахаар "Баримтаа аваарай" сошиал аяныг зохион байгуулсан.</p> <p>"Нэхэмжлэлд суурилсан" татвар ногдуулалт, төлөлтийн цахим систем бий болсноор татвар төлөгч татварын алба болон банканд очих шаардлагагүй болж цахим банкаар татвараа төлж, тайлагнах бүрэн боломж бүрдсэн. 2024 оны 05 сарын байдлаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан-1895, НӨАТ-ын тайлан-4881, Суутган-8 тайлан-6784</p>	100%

					татвар төлөгч цахимаар тайлангаа илгээж, хамрагдалт өнгөрсөн оны мөн үеэс 4.3 хувиар өссөн. Мөн Замын-Үүд, Сайншанд, Даланжаргалан, Алтанширээ, Өргөн, Улаанбадрах, Хатанбулаг сумдад татвар төлөгчийн ажлын байранд очиж явуулын посоор татвар хураах үйлчилгээг үзүүлж, давхардсан тоогоор 8519 татвар төлөгчийн 5,681.4 сая төгрөгийн татварыг хураан төсөвт төвлөрүүлсэн.		
127		144. Төсвийг зардлыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, төсвийн сахилга батыг сайжруулах	2021 - 2024		3,5	Оны эхний 6 сарын байдлаар орон нутгийн төсөвт 56,7 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 84,8 хувьтай байна. Орон нутгийн төсвийн орлогын биелэлттэй уялдуулан зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэн төрийн албан хаагчдын цалин, хөдөлмөрийн хөлс, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой зардал, төсвийн байгууллагуудын халаалтын зардлыг эхний ээлжид санхүүжүүлэх эрэмбэ тогтоож 80,8 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийсэн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 64,6 хувь буюу 44,3 тэрбум төгрөгийн хэмнэлттэй байна. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний дагуу 11 байгууллагад төлөвлөгөөт, удирдах дээд шатны байгууллагын шийдвэрээр 3, нийт 14 байгууллагад санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар 2024 оны 06 сарын байдлаар 112,9 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрч, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 1 албан шаардлага бичиж, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 132 төлбөрийн акт тогтоон 37,7 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулсан.	100%
128		145.Төсвийн хөрөнгийн зарцуулалтад хийх хяналт шалгалтын үр өгөөжийг дээшлүүлэх	2021 - 2024		99,8	2024 онд төсвийн 66 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, 57 байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийгдэхээс 18 байгууллагад төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт, 14 байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит тус тус хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар 213,2 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрч, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 131 акт тогтоон, 3 албан шаардлага бичиж, 161,2 сая төгрөгийн төлбөрийг барагдуулсан.	100%
129		146. Улсын секторын нягтлан бодох бүртгэлийг	2021 - 2024		100%	Төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг төсвийн байгууллагад мөрдүүлэх, төсвийн гүйцэтгэлийг	100%

		онлайн системд бүрэн шилжүүлэх				тайлагнах үйл ажиллагааг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвийн багцад хамаарах байгууллага (117 байгууллага)-ын санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн "ctsystem" программд бүрэн шилжүүлсэн.	
130		147. Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож "Шилэн тендер шалгаруулалт"-ын бодлого хэрэгжүүлэх	2021 - 2024		100%	Аймгийн худалдан авах ажиллагааны 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан 73 төсөл арга хэмжээг 100 хувь, 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан 84 төсөл арга хэмжээг 100 хувь төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn сайтын дэлгэрэнгүй төлөвлөгөө цэсэд байршуулан Сангийн яамаар батлуулсан. Тендер шалгаруулах урилгыг tender.gov.mn болон "Зууны мэдээ" өдөр тутмын сонинд байршуулж олон нийтэд нээлттэй зарласан.	100%
131	3.1.3. Төрийн худалдан авах ажиллагааг хариуцгаажуулан орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагуудыг бодлогоор дэмжинэ.	148. Тендер шалгаруулалтад хуулийн дагуу давуу эрх нь тооцогдох боломж бүхий аж ахуйн нэгжүүдийн чадавхыг нэмэгдүүлж, орон нутгийн хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх бодлого баримтлах	2021 - 2024		Давуу эрхийн 80 хувь	Аймагт зарлагдсан төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх олгохоор тусгагдсаны дагуу 2022 онд 9 аж ахуйн нэгж, 2023 онд 1 аж ахуйн нэгжээс орон нутгаас ажиллах хүч авч ажиллуулах, дотоодод үйлдвэрлэсэн бараа материал худалдан авах хүсэлт ирж, нотлох баримтуудыг үндэслэн дотоодын давуу эрхийн зөрүүг 2022-2023 онд нийт 1410.6 сая төгрөгөөр хийсвэрлэн тооцсон. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн дагуу тендерт оролцогч давуу эрх тооцуулах нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Давуу эрх олгох бол санал болгож буй үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцох тухай тендер шалгаруулалтын зааварчилгаанд тусгасан. Худалдан авах ажиллагааны төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх олгохоор тусгагдсаны дагуу 2023 онд нийт тендерт шалгарсан ХХК-ын 44% нь орон нутгийг ХХК байна. Энэ нь 2020 онтой харьцуулахад 10%-иар өссөн үзүүлэлэлттэй байна.	100%
132	3.1.4. Даатгалын хариуцлагын тогтолцоог сайжруулан, хамрах хүрээг нэмэгдүүлнэ	149. Албан журмын даатгалын холбоо, даатгал, хөрөнгийн үнэлгээний компаниудын хохирол барагдуулах ажиллагааны	2021 - 2024		3	Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хуулийн хэрэгжилт, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, даатгалын хохирол, нөхөн төлбөрийг барагдуулах, иргэд жолооч нарын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх, хөрөнгийн үнэлгээг бодитой хийх талаар аймагт үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа тусгай зөвшөөрөл бүхий 8 даатгалын компани, хөрөнгө үнэлгээний 2 компани болон Цагдаагийн газрын замын цагдаагийн тасаг, АЖДХолбооны салбарын уялдаа холбоог хангаж.	100%

		уялдаа холбоог сайжруулах				2024 онд 3 удаа уулзалт арга хэмжээг зохион байгуулсан. Авто тээврийн хэрэгслийн техникийн үзлэг оношилгоог зохион байгуулахад 04-р сард даатгалын компани, авто тээврийн төвтэй хамтран сумдад ажиллаж, жолоочийн даатгалын гэрээ байгуулах, даатгалын нөхөн төлбөрийн талаарх мэдээллийг иргэдэд хүргэж ажилласан.	
133		150. Даатгалын байгууллагын нөхөн төлбөр олголтыг сайжруулах	2021 - 2024		98,0	Аймаг дахь даатгалын компаниуд 300.0-500.0 мянган төгрөгийн жолоочийн хариуцлагын даатгалын нөхөн төлбөрийг орон нутагтаа шийдвэрлэн шуурхай олгож байгаа бөгөөд дээрх мөнгөн дүнгээс давсан хохирлыг Цагдаагийн газрын зам тээврийн осол аваар гаргасан тухай тодорхойлолтын төв салбаруудад илгээн 24 цагийн дотор шийдвэрлэж ажилласан. 2024 онд 74 даатгалын тохиолдолд 45,225.5 мянган төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь олговол зохих даатгалын нөхөн төлбөрийг 96 хувь байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 3,0 функтээр өссөн үзүүлэлттэй байна..	100%
134		151. Иргэдийг даатгалд хамруулах нөлөөллийн ажлыг дэмжих	2021 - 2024		1 2000	Аймагт үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа даатгалын компаниуд тайлант хугацаанд нийт 8212 иргэн, аж ахуйн нэгжтэй даатгалын гэрээ байгуулсан нь 2021 онтой харьцуулахад 3618 иргэн аж ахуйн нэгжээр өссөн үзүүлэлттэй байна. 2024 онд даатгалын хугацаа дуусаагүй 13200 гэрээ байна. Жолоочийн хариуцлагын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Өнөөгийн Ялалт" сонинд 4 удаа, аймаг дахь ДТВ, DSB телевизүүдэд 3 удаа нийтлэл, мэдээлэл нэвтрүүлэн, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.	100%
135	3.1.5. Хөрөнгийн зах зээлийг иргэндээ ээлтэй, эдийн засагт өгөөжтэй байдлаар хөгжүүлнэ.	152. Хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасны компаниудыг орон нутагт үйл ажиллагаа явуулахад бодлогоор дэмжиж ажиллах	2021 - 2024		3	Хөрөнгийн биржид болон аймагт бүртгэлтэй үнэт цаасны "Бидисек", "Санар", "Гүүдсек" 3 компаниас "Гүүдсек ҮЦК" ХХК тогтмол үйл ажиллагаа явуулж байна. "Гүүдсек ҮЦК" ХХК-тай хамтран 2024 онд 980 иргэн, аж ахуйн нэгжид хувьцаа, үнэт цаасны талаар холбогдох мэдээ мэдээллийг тогтмол өгч, 7560 хувьцааны дансыг нээж ажилласан.	100%
136		153. Үнэт цаас, хувьцааны талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх	2021 - 2024		2 640	"Гүүдсек ҮЦК" ХХК-тай хамтран "Амьдралын санхүү", "Хамтаараа баяжихтун", арилжааны 5 банкны гаргасан IPO танилцуулгыг цахим хуудсаар болон салбар нэгжүүд дээрээ сурталчлан, тус компанийн брокерууд цаг тухай бүрд нь иргэдэд данс нээн хувьцаатай холбоотой мэдээллээр ханган,	100%

						давхардсан тоогоор 980 бизнес эрхлэгч, иргэдэд үнэт цаас, хувьцааны талаарх мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.	
137		154. Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилтыг төрийн бусад мэдээллийн сантай уялдуулан сайжруулж, хүн ам зүйн нарийвчилсан мэдээллийг гаргахад ашиглах	2021 - 2024		5 100%	<p>Засаг захиргааны анхан шатны нэгжид хөтлөгдөж буй хүн ам, өрхийн мэдээллийн сангийн шинэчилсэн мэдээллийг үнэн зөв, бодитой хөтлөх, баяжилтыг цаг хугацаанд нь хийх зорилгоор сар бүр алдааны протоколыг татан авч, сумдад хүргүүлэн холбогдох заавар, зөвлөмжийг өгч 2024 онд 465 алдаа засварласан нь 2021 онтой харьцуулахад алдааны тоо 345-аар буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>"Хүн ам өрхийн мэдээллийн сан"-ийн чанарыг сайжруулах сарын аяны үйл ажиллагааг эрчимтэй зохион байгуулснаар өрх, хүн амын тоо, тэдгээрийн шилжилт хөдөлгөөн, амьдарч буй орчин, орон сууцны нөхцөл зэрэг судалгааны мэдээллийн чанарыг сайжруулж ажилласан.</p> <p>УБЕГ-ын төрөлт, нас баралтын мэдээллийг тогтмол бүртгэх, алдааг засварлуулах, үр дүнгийн үзүүлэлтээр танилцуулга бэлтгэн тогтмол тараах ажлыг хийсэн.</p>	100%
138	3.1.6. Нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлогыг тодорхойлоход шаардлагатай мэдээллийн үүсвэртэй болно.	155. Мал, тэжээвэр амьтдын тооллогыг зохион байгуулж, хөдөө аж ахуйн салбарын түүвэр судалгаанд хамрагдах өрхийн жагсаалт болон сэдэвчилсэн судалгааг гаргахад ашиглах	2021 - 2024		100%	<p>Мал тооллогын 2021-2023 оны үр дүнгээр "Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга"-ыг жил бүр бэлтгэн гаргаж байна. Судалгаанд аймгийн эдийн засагт хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь, мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, малын тооны өөрчлөлт, малчдын тоо, тэдний соёл, ахуйн нөхцөлийн үзүүлэлтүүдээр судалгааг боловсруулж, 600 гаруй цахим хэрэглэгчдэд хүргэж, вэб хуудсанд байршуулсан.</p>	100%
139		156. Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээ, тайланг боловсруулах, тархаах, шуурхай, хүртээмжтэй байдлыг сайжруулах, тооллого судалгааны мэдээллийн үр өгөөжийг нэмэгдүүлэх	2021 - 2024		100%	<p>Албан ёсны статистикийн 37 нэр төрлийн мэдээ, тайлан, 1 төрлийн тооллого, 4 төрлийн түүвэр судалгаанд хамрагдвал зохих сум, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг бүрэн хамруулж долоо хоног, сар, улирал, жилийн давтамжтайгаар мэдээллийг цуглуулж, 2872 нэгж мэдээг графикт хугацаанд нь ҮСХ-нд дамжуулсан.</p> <p>Энэ оны 6 сарын байдлаар хэлтсийн фэйсбүүк, цахим хуудасны мэдээллийн санд үнийн мэдээ 21 удаа, жилийн эцсийн танилцуулга 1 удаа, сарын нийгэм, эдийн засгийн танилцуулга 5 удаа, улирлын болон салбарын инфографик 4 удаа, тэмдэглэлт баярын өдрүүдтэй холбоотой инфографик 3 удаа, сар бүрийн нийгэм эдийн засгийн байдлын тухай танилцуулгыг 5 удаа, статистик динамикийг 23 удаа, "Хөдөө аж</p>	100%

						ахуйн салбарын судалгаа-2023", "Хүн ам өрхийн үндсэн үзүүлэлт-2023", "Амьдарч буй орчин, нийгмийн үзүүлэлтийн судалгаа-2023", "Худалдаа үйлчилгээний салбарын танилцуулга-2023", "Аж үйлдвэр, барилгын салбарын 2023" танилцуулгыг тус бүр 1 удаа байршуулж, иргэд, байгууллагуудыг татан авч үйл ажиллагаандаа ашиглах нөхцөлийг хангаж ажилласан.	
140	3.2.1. Эдийн засгийн өсөлтийг хангахуйц нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ	157. Цагаан суваргын зэс молибдений үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэхэд орон нутгаас ус ашиглуулах гэрээ байгуулах, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох, замын трасс батлах зэрэг дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах,	2021 - 2024		1	Мандах сумын нутаг дахь Цагаан суваргын зэс молибдений үйлдвэрийг 2025 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн хөвүүлэн баяжуулах үйлдвэр, бутлуурын хэсэг, тээрмийн барилгын суурийн цутгалт 70 хувь, краказ угсралтын ажлууд 20 хувийн гүйцэтгэлтэй, нийт төслийн ажил 55 хувийн гүйцэтгэлтэйгээр "Мак аранжин зэс" ХХК, "ЭЙЧБАЯ" ХХК-иуд нийт 321 гадаад, 95 монгол ажилтантайгаар ажлаа үргэлжлүүлж байна.	90%
141	3.2.1. Эдийн засгийн өсөлтийг хангахуйц нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ	158. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайн дэд бүтцийн ажлыг гүйцэтгэхэд орон нутгаас ус ашиглуулах гэрээ байгуулах, газар ашиглах эрх олгох, замын трасс батлах зэрэг дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах	2021 - 2024		1	Зүүн цагаан дэлийн далд уурхай нь 2021 оны III улиралд үйл ажиллагаагаа эхлүүлж тээвэрлэлтийн налуу ам №1 болон №2-ыг ашиглалтад оруулж 2024 оны I улирлын байдлаар нийт 2,342.0 тууш метр уулын малталтаар 20,220.8 м3 уулын цулд нэвтрэлтийн ажил хийж гүйцэтгээд байна. Үүнээс уулын үндсэн малталт – 1,809.5 тууш метр, 16,093.3 м3, Уулын бэлтгэл малталт – 532.5 тууш метр, 4,127.5 м3-тай ажил үргэлжилж байна. Дээрх ажлын хүрээнд 1150 м-ийн түвшнээс дээш 7-р хүдрийн биетэд 249,731.0 тонн хайлуур жоншны хүдэр, 1-р хүдрийн биетэд 1,194,000.0 тонн хайлуур жоншны хүдэр 1,443,731.0 тонн хүдрийг нээгээд байна. Уурхайн дэд бүтэц байгуулах ажлын хүрээнд Иххэт сумын Засаг даргын 2022 оны А/13 тоот захирамжаар 5 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын доорх 16.27 га газрыг "Монголросцветмет" ТӨХК-д эзэмшүүлэх шийдвэрийг, талбайн зориулалтыг хэсэгчилж өөрчлүүлэх шийдвэрийг Иххэт сумын Засаг даргын 2023 оны А/83 дугаар захирамжаар тус тус шийдвэрлэн газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгосон.	100%

					<p>Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаанаас ус ашиглах гэрээг байгуулсан. “Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, тэсэлгээний ажил явуулах” 595 дугаар тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад орон нутгаас дэмжсэн саналыг Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яаманд тус тус хүргүүлж үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлж ажилласан. Дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх, соёлын өвийг хамгаалах, бүтээн байгуулалт нийгмийн хариуцлага, хог хаягдлын чиглэлээр “Хамтран ажиллах гэрээ” -ний дагуу нийт 50,0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хамтран амжилттай хэрэгжүүллээ.</p>	
142		159. Уул уурхайн баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлэх.	2021 - 2024	Хамтран ажилласан арга хэмжээний тоо 5	<p>Алтанширээ сумын нутаг дэвсгэрт баригдаж буй Газрын тос боловсруулах үйлдвэрийн Технологийн бус барилга байгууламжийн ажлыг “JMC projects India” компани гүйцэтгэж ажлын явц 98 хувийн гүйцэтгэлтэй, Улсын комисс ажиллуулах бэлтгэл ажил хангагдаж байна.</p> <p>Анхдагч процессын болон дагалдах байгууламж болон үйлдвэрийн цахилгаан станцын суурийн ажлууд хийгдэж байна.</p> <p>"Монголиан транс ложистик" ХХК-ийн "Алтанширээт" үйлдвэр технологийн паркийн барилгын ажил 45 хувийн гүйцэтгэлтэй, Айраг сумын нутаг дэвсгэрт "Алтраг ахас" ХХК-ийн манган боловсруулах үйлдвэрийн барилгын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй, Цагаан суваргын зэс молбидены үйлдвэрийн хөвүүлэн баяжуулах үйлдвэр, бутлуурын хэсэг, тээрмийн барилгын суурийн цутгалт 70 хувь, краказ угсралтын ажлууд 20 хувийн гүйцэтгэлтэй, нийт төслийн ажил 55 хувьтай, Хөвсгөл сумын нутагт баригдаж буй "Гэрэлт говь" аж үйлдвэрийн угаах үйлдвэрийн барилгын ажил 90 хувьтай, коксын үйлдвэрийн барилгын ажил 15 хувьтай, төмөр замын далан, гүүрэн байгууламжийн ажил 97 хувьтай нийт төслийн ажил 35 хувийн гүйцэтгэлтэйгээр ажлаа үргэлжлүүлж байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газраас үйлдвэрлэл технологийн паркаар зарлагдсан Алтанширээ сумын нутаг дэвсгэрт байрлах "Алтанширээт" үйлдвэрлэл технологийн паркийн 674.44 га, Хөвсгөл сумын нутаг дэвсгэрт байрлах "Гэрэлт говь" үйлдвэрлэл технологийн паркийн 264.38 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэсэн.</p>	100%

					Орон нутагт уул уурхайн нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийн бодлогыг дэмжих ажлын хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2022-2024 онд Айраг, Даланжаргалан, Мандах, Хатанбулаг, Хөвсгөл сумдын нутаг дэвсгэрт 10 байршилд 3337.38 га газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, газар олголтын үйл ажиллагааг зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн.	
143	3.2.2. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.	160. Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахад орон нутгаас дэмжлэг үзүүлэх.	2021 - 2024	2/80%	<p>Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн Технологийн бус байгууламжийн Инженерчлэл-худалдан авалт-барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр “Жэй Эм Си Прожектс Индиа” компани шалгарч үйлдвэрийн иргэний барилга байгууламж (Захиргааны байр, агуулах, засварын цех, гал командын байр, анхны тусламжийн төв, лаборатори, угтах байр), Ус хангамжийн систем, талбайн дэд бүтэц зэрэг барилга байгууламжуудыг барих ажлыг гүйцэтгэх ажилд туслан гүйцэтгэгч 8 компани ажиллаж, үйлдвэрийн гадна хашаажуулалт, усны нөөцийн савны арматурчлалын ажил, ус цуглуулах савны ажил, авто замын ажил, гал командын байр, ажилчдын байр , Захиргааны байр, агуулах, засварын цех, анхны тусламжийн төв, лаборатори, угтах байрны барилгын ажлууд дууссан.</p> <p>Төслийн эхний багцад хамаарах түргэн тусламжийн байр, хоолны заал, нэвтрэх заал зэрэг барилга , байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт ирүүлсний дагуу 2024 оны 05 дугаар сарын 27 ны өдөр ашиглалтад хүлээн авах улсын комисс ажиллах холбогдох үүрэг чиглэлийг өгч бүрэн биелүүлсний дараа биелэлт Барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг шуурхай олгож, Замын-Үүдийн боомтоор барилгын материалуудыг нэвтрүүлэх, түгээмэл тархацтай ашигт малтмал буюу 55,3 мянган куб элсийг ашиглуулах гэрээг байгуулж дэмжлэг үзүүлэн ажилласан. Сайншанд суманд баригдаж буй Ажилчдын хотхон ашиглалтад орохтой холбогдуулан улсын төсвийн 4,9 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 640 хүүхдийн сургууль, орон нутгийн төсвийн 910.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 6 дугаар баг, Шинэ зууны гудамжны автозамд нийт 1860 м2 талбайд нөхөөс хийх, 2,2 км явган хүний зам, дугуйн зам шинээр ашиглалтад оруулсан бол 7 дугаар багт байрлах "Тэс петролиум" ХХК-ийн ШТС-ын тойргоос 1, 6 дугаар багийн</p>	100%

					офицерын төв зам хүртэлх 3.6 км хатуу хучилттай авто замыг орон нутгийн төсвийн 4,9 тэрбум төгрөгийн хөрөнгөөр барих ажил 95 хувийн гүйцэтгэлтэй байна.	
144		161. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих, бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлэх.	2021 - 2024	Бүтээн байгуулалтын ажил-100% Дэмжлэгийн тоо-2	<p>Монгол газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн эхний багцад багтсан технологийн бус барилга байгууламжууд Нэвтрэх хаалга, Эмнэлгийн анхны тусламжийн барилга, Ажилчдын хооллох газрын барилга угсралтын ажлуудад 2024.05.27-ны өдөр улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэсэн.</p> <p>2024 оны эхний хагас жилд газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийн 15 барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийн хугацааг сунгасан.Тус суманд баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн усны шугам хоолой барих ажилд 2021 онд дүүргэлт хийх зориулалттай 80,350м.куб цагаан элс, 2022 онд 55,350 м.куб цагаан элс ашиглуулах гэрээ хийж хамтран ажилласан.</p> <p>Сум орон нутгийн зүгээс 2022 онд Газрын тос боловсруулах үйлдвэрийн газрын тос татах хоолойн төслийн түр кемпийн зориулалтаар байгуулах барилгын ашиглах 4,2542 га газрыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэж, газар олголтыг хийсэн.</p> <p>Харин 2023 онд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар газрын тос дамжуулах хоолойн газрыг хамгаалалтын зурвас байгуулах саналыг хэлэлцүүлэн холбогдох газарт нь хүргүүлж шийдвэрлэсэн. Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын гадаад ажилчид болох 200 гаруй Энэтхэг улсын иргэн, 20 гаруй Хятад улсын иргэдийг Гадаадын иргэн харьяат газарт тодорхойлолт хүргүүлж ажиллах зөвшөөрлийг гаргуулаад байна.</p>	100%
145	3.2.3. Байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг дэмжинэ.	162. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа уул уурхайн компанийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах хүртэл арга хэмжээг хэрэгжүүлэх.	2021 - 2024	90%/80%/3	<p>Аймгийн хэмжээнд 2024 оны 04 дүгээр сарын байдлаар ашиглалтын тусгай зөвшөөрөл 215, хайгуулын тусгай зөвшөөрөл нийт газар нутгийн 9.2 хувийг эзэлж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын 2019 оны А/938 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2021 онд 13 аж ахуйн нэгж, 2022 онд 25 аж ахуйн нэгж, 2023 онд 29 аж ахуйн нэгжийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгч нийт дундаж 91 хувийн хэрэгжилттэй ажилласан.</p> <p>Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор "Хариуцлагатай уул уурхайн</p>	90%

					<p>зөвлөгөөн"-ийг 2021, 2023 онд зохион байгуулж зөвлөгөөний үеэр уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, биологийн төрөл зүйлийг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлэн хамтран ажиллах “Хамтран ажиллах гэрээ”-г давхардсан тоогоор хамтран ажиллах гэрээг 20 аж ахуйн нэгж байгууллагатай байгуулж, 80 хувийн дундаж биелэлттэйгээр хэрэгжүүлж ажилласан.</p> <p>Мөн хог хаягдал, ус ашиглах гэрээг давхардсан тоогоор 60 гаруй аж ахуйн нэгж байгууллагатай байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж дүгнэсэн.</p> <p>2023,2024 онд Байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй 7 иргэн, 10 аж ахуйн нэгжийг 15,2 сая төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж, Байгалийн нөөцийг зөвшөөрөлгүй ашигласан 9 аж ахуйн нэгжийг нийт 45 сая төгрөгөөр торгож, 750, 9 сая төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж барагдуулсан.</p> <p>2024 оны хагас жилийн байдлаар төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 5 удаа зохион байгуулж 20 объектыг хамруулан 26 зөрчил дутагдал илрүүлж, илэрсэн зөрчил дутагдалд 17 заалт бүхий 3 албан шаардлага хүргүүлж байгаль орчны эсрэг зөрчил үйлдсэн 7 иргэн, 4 ААН-д 13.0 сая төгрөгийн нөхөн төлбөр, 12.2 сая төгрөгийн торгууль оногдуулсан.</p>	
146		163. Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллах.	2021 - 2024	4	<p>“Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн 414,6 км төмөр зам, “Тавантолгой-Манлай-Ханги” чиглэлийн хүнд даацын хатуу хучилттай авто зам, “Зүүнбаян-Ханги” чиглэлийн 226,9 км төмөр зам, Даланжаргалан-Бор өндөр чиглэлийн 50 км хатуу хучилттай авто зам ашиглалтад оруулсан.</p> <p>Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Өргөн, Хатанбулаг, Мандах, Иххэт, Сайхандулаан сумдад үйл ажиллагаа явуулж буй 15 аж ахуйн нэгжийн 1600 км тусгай зориулалтын авто замын трассыг аймгийн Засаг даргын захирамжаар батлан, хатуу хучилттай, сайжруулсан авто зам барьж тээвэрлэлт хийх үүрэг чиглэлийг өгч хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Авто тээврийн газар болон сумдын Засаг дарга нар хамтран ажиллах гэрээ байгуулсан.</p>	70%

					Байгаль орчны салбарын чиглэлээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг тус бүр 4 удаа гүйцэтгэж 61 объектыг хамруулан шалгаж, шалгалтын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 42 аж ахуйн нэгжид хугацаатай албан шаардлага өгч, 18 иргэн, аж ахуйн нэгжид 59 сая төгрөгийн торгууль, 1,02 тэрбум төгрөгийн хохирол нөхөн төлбөрийг барагдуулсан.	
147	3.3.1. Атрын IV аяныг хэрэгжүүлжорон нутгийн онцлог тохирсон газар тариалангийн үйлдвэрлэл ийг нэмэгдүүлэх замаар хүн амын төмс, хүнсний ногооны хангамжийг тогтвортой өсгөнө.	164. Газар тариалан эрхлэгчдийг сургаж дадлагажуулах мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бэхжүүлэх арга хэмжээг зохион байгуулах;	2021 - 2024	6 200 15	Тариалан эрхлэгчдийг чадавхжуулах, мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлын хүрээнд Хөгжлийн шийдэл ТББ-ын "Best" хөтөлбөр, "Дэлхийн зөн Монгол" Олон улсын байгууллагын "Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг" төсөл, Монголын Хүлэмжийн аж ахуйн холбоо, Булган голын алим ХХК, "Монгол ногоо" төсөл, Дорнын говийн тариаланчид ТББ, Ургамал хамгаалал, сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн, Атрын шим ХХК, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран 2020 оноос 2024 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд 25 удаагийн танхимын сургалт, 2 удаагийн талбайн сургалт, 2 удаагийн туршлага солилцох аялал, 4 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 1730 тариаланчийг хамруулсан. АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн санхүүжилттэй Best хөтөлбөртэй хамтран Дорноговь аймгийн газар тариалан эрхлэгчдийг хамтын тариалалт, борлуулалт бизнес төлөвлөлт хийхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох, сайн дурын бизнес ментор, ментийг тодорхойлох, техникийн тусламж үзүүлэх зорилготой дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэллээ. Аймгийн "Политехникийн коллеж"-ийн хүлэмжийн аж ахуй, жимс жимсгэнэ, фермерийн аж ахуйн мэргэжилтэй ажилтан бэлтгэх ангийг 87 суралцагч амжилттай төгсөж аж ахуй эрхлэн, шинээр 41 суралцагч элсүүлж хүний нөөцийг бэхжүүлсэн.	90%
148		165. Тариалангийн талбайн хөрсийг хамгаалах, үржил шимийг сайжруулан, бордоо, ургамал хамгааллын зохистой байдалд хяналт тавих;	2021 - 2024	0/га/ 2	Тариалангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7-д "Агрхими, агрофизикийн шинжилгээг таван жил тутамд тариалангийн газрын эзэмшигч, ашиглагч өөрийн хөрөнгөөр хийлгэнэ" гэж заасны дагуу "Дорнын говийн тариаланчид" төрийн бус байгууллага, Дархан-Уул аймгийн ургамал газар тариалан сургалт эрдэм шинжилгээний хүрээлэнгийн хөрс судлалын лабораторитой хамтран аймгийн тариалангийн 97,6 га талбайд хөрсний чанар, төлөв байдалд агрохимийн	90%

					<p>шинжилгээ хийж, сорилын дүн, зөвлөмжийг тариаланчдад хүргүүлсэн.</p> <p>Тариалангийн зориулалтаар ашиглагдаж буй 14 сумын 232 тариаланчийн 223 га талбайн хөрсний төлөв байдалд газар дээр нь очиж 14 удаа заавар зөвлөмж өгсөн. Баталгаатай эрүүл аюулгүй хүнс үйлдвэрлэлийг бий болгох ажлын хүрээнд “Эс эф си эс” баталгаажуулалтын байгууллагатай хамтран ажиллаж Даланжаргалан, Сайншанд сумын 12 тариаланч Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлд Хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлж гэрчилгээгээ гардан авсан. АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн санхүүжилттэй Best хөтөлбөртэй хамтран 2024 оны 03 сарын 27-нд “Агро ойжуулалтаар ашгаа нэмэгдүүлэх боломж” сэдэвт сургалтыг зохион байгуулж говийн бүс нутагт хамгаалалтын ойн зурвас байгуулах ач холбогдол, тохиромжтой мод бутыг тариалах, арчлах талаар мэдлэг мэдээллийг өгч аймгийн 30 газар тариалан эрхлэгчийг хамруулсан.</p> <p>Мөн хөрс боловсруулалтыг сайжруулах ажлын хүрээнд аймгийн 15 тариалан эрхлэгчдийг “GREEN GORWTH” хөтөлбөрт хамруулан Монгол улсын аварга тариаланч Л.Лувсанпүрэвийг газар дээр авч ирж хөрс боловсруулалтын дадлага сургалт, зөвлөх үйлчилгээг үзүүлж төмсний эрчимжсэн технологийн туршилтыг хийж эхлүүлсэн.</p> <p>Тариаланчдын талбайгаар явж хөрс боловсруулалт, тариалалтын явцтай танилцаж, мэдээлэл зөвлөмж өгөх ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэж байна.</p>	
149		166. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох шинэ сортын үрийг үржүүлэн хангамжийг нэмэгдүүлэх;	2021 - 2024	13	<p>Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд тагар сонгины 200 кг төл, амтат гуаны 12.4 кг үр, тарвасын 10 кг үр тус тус гарган авч ХХААХҮЯ-ны дэргэдэх “Монгол ногоо” төсөлд нийлүүлсэн.</p> <p>Сорт сорилтын ажлын хүрээнд Мөнх ашиг хоршоо эртийн байцайны 1, сонгино 1, тарвасын 1, саримс 1, бууцай 1, гүзээлзгэнэ 1, чавганы 40 ширхэг суулгац, нийт 7 төрлийн сортыг үр шинэчлэлд, амтат гуаны 2 сортыг ирээдүйтэй сортоор батлуулахаар туршилтын ажлыг 3 дахь жилдээ үргэлжлүүлж байна.</p> <p>Мөн хөдөө аж ахуйг дэмжих сангаас нийлүүлсэн Солонгосын бууцай, байцаа, салат навчны 3-н төрлийн сортыг тариалан туршсан.</p>	100%

					<p>Төмсний эрчимжсэн технологийг Сайншанд сумын 15 газар тариалан эрхлэгчдэд нэвтрүүлж 5 га-д тариалалт хийгээд байна.</p> <p>Жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор Монгол улсын гавьяат агрономч Т.Баярхүүгээс шинэ сортын амтатгуа, гүзээлзгэнэ, улаан лоолийн үр, үрслэг татан авч туршихаар тариаланчдад олгосон.</p> <p>Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 2021-2024 онд 80 хувийн хөнгөлөлттэй олгосон давхардсан тоогоор 45 нэр төрлийн хүнсний ногооны үрийг 14 сумын газар тариалан эрхлэгчдэд хуваарилан олгосон.</p> <p>Мөн үр үржүүлэх чиглэлээр 80 хувийн хөнгөлөлттэй үнээр 2 тн төмсний үрийг “Мөнх-Ашиг” хоршоо, “Оюун шанд” ХХК-д нийлүүлж, үрийн шинэчлэл хийхээр 80 хувийн хөнгөлөлттэй үнээр 3 тн төмсний элит үрийг Сайншанд, Эрдэнэ, Сайхандулаан, Даланжаргалан сумдын 20 гаруй тариаланчдад тус тус нийлүүлснээр үрийн хангамжийг 2020 оноос 30,2%-р нэмэгдүүлсэн.</p>	
150		167. Өрхийн тариалангийн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх замаар техник технологийг шинэчлэн, хамгаалагдсан хөрсний тариалалт, зоорийн хангамжийг нэмэгдүүлэх	2021 - 2024	10% 300 /м2/ 1	<p>Газар тариалангийн чиглэлээр 338 өрх, 30 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулан, иргэн, аж ахуйн нэгжүүд нь төмс 22,31 га, хүнсний ногоо 85,6 га, малын тэжээл 57,6 га, жимс, жимсгэнэ 9,6 га, нийт 175,1 га талбай, бага оврын трактор 63, үрлэгч 25, ухагч 4, 38,9 га-ын дуслын усалгааны систем, 900 м2 өвлийн хүлэмж 2ш, 29520 м2 зуны хүлэмж 415 ширхэг, 984 тонны багтаамж бүхий 31 зоорийг үйл ажиллагаандаа ашигласан.</p> <p>“Гамшигт тэсвэртэй ХАА” төслийн хүрээнд 3 суманд 4 га талбайд малын тэжээлийн ургамлыг туршилтаар тариалж, бороожуулах усалгааны систем, бага оврын хадлангийн трактор, анжис, хадуур, тармуур, хаман боогч зэрэг 70,2 сая төгрөгийн техникийн шинэчлэл, “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг төслийн хүрээнд Иххэт суманд малын тэжээлийн ургамал тариалах “Өнгөт” малчдын бүлэгт 79,0 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг нийлүүлж дэмжлэг үзүүлсэн.</p> <p>“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг орон нутагт эрчимжүүлэх, хүнсний ногооны хангалтыг нэмэгдүүлэх, өрхийн тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор УТ-ийн 2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр “ШИНЭ ХӨДӨӨ” төслийг хэрэгжүүлж 952,5 сая төгрөгийн үнэ</p>	90%

					<p>бүхий 4 төрлийн хэмжээст хүлэмж 350 ш, 899,2 сая төгрөгийн үнэ бүхий 40 морины хүчтэй дугуйт трактор 20 ширхэг, анжис 20 ширхэг, роторт сийрүүлүүр 20 ширхэг, сийрүүлэгч манагч 20 ширхэг, төмс суулгагч 20 ширхэг, хүнсний ногооны үрлүүр 20 ширхэг, 38,0 сая.төгрөгийн үнэ бүхий 1,5 тн-ы багтаамжтай 40 ш усны нөөцийн савыг шинээр нэмэгдүүлэн 14 сумын газар тариалан эрхлэгчдэд олгосон.</p> <p>Мөн аймгийн ИТХ-аас хөрс халаагч, ургамал хамгааллын автомасыг 21 иргэнд гардуулав.Тариалангийн талбайн хэмжээ 37,1 га-аар, зоорины хангамж 34 тн-оор, техникийн хангамж-63,4%, хамгаалагдсан хөрсний тариалалт 19200 м2-аар тус тус нэмэгдсэн.</p> <p>Энэ онд “Шинэ хөдөө” төслийн 1,7 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хүнсний ногооны орчин үеийн механикжсан зоорь барихаар тендер зарлах ажлын бэлтгэлийг хангаж байна.</p> <p>Газар тариалан эрхлэгчдийг дэмжиж ажилласнаар 2020 онтой харьцуулахад тариалан эрхлэгчдийн тоо 3 дахин, тариалсан талбайн хэмжээ 127,6 га-аар, хамгаалагдсан хөрсний тариалалт 17091 м2-аар, хураан авсан нийт ургацын хэмжээ 29%-р тус тус нэмэгджээ.</p>	
151		168. Газар тариалан эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрт хамруулан үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	2021 - 2024	4 /га/, 5 30.0 /саятөг/ 3%	<p>ХХААХҮЯ-наас 2021-2024 онд 80%-н хөнгөлөлттэй олгосон давхардсан тоогоор 45 нэр төрлийн хүнсний ногооны үрийг 14 суманд, үрийн шинэчлэл хийхээр 5 тн элит төмсний үрийг “Мөнх-Ашиг” хоршоо, “Оюун шанд” ХХК, Сайншанд, Эрдэнэ, Сайхандулаан, Даланжаргалан сумын тариаланчдад 80 % хөнгөлөлттэй үнээр нийлүүлж, үрийн хангамжийг 2020 оноос 30,2 хувиар, урьд оноос 10 хувиар, тариалалтыг 29,7 хувиар нэмэгдүүлсэн.</p> <p>Засгийн газрын 3%-н хүүтэй 24 сарын хугацаатай зээлд хүнсний ногооны чиглэлээр 1 хоршоонд 26,8 сая.төг, 4 иргэнд 42,8 сая.төг, Хүнсний хангамж-аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих 5-6 %-н хүүтэй зээлд нийт 27 иргэн, ААН-д 566,0 сая төгрөг, мөн Замын-Үүд, Сайншанд, Айраг, Мандах, Сайхандулаан, Хатанбулаг сум "Хоршоо хөгжүүлэх сан"-гаас 8 иргэнд 157,0 сая төгрөг, 3 ААН, 2 хоршоонд 226,0 сая төгрөг, хүлэмж, мод үржүүлгийн чиглэлээр Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 1 ААН-д 90,0 сая төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 1 иргэнд 5,0 сая,төгрөг нийт 47 иргэн, ААН, хоршоонд 1,113.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож дэмжлэг үзүүлсэн.</p>	90%

					<p>Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжин 5 сумд 15 иргэн, 5 аж ахуйн нэгж, 1 хоршоонд нийт 169,5 га газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлсэн.</p> <p>Газар тариалан эрхлэгчдийг дэмжиж ажилласнаар 2020 онтой харьцуулахад тариалан эрхлэгчийн тоо 3 дахин, тариалсан талбайн хэмжээ 127,6 га-аар тус тус нэмэгдэж, хүн амын төмс, хүнсний ногооны хангамж 23.29% болж 2020 оноос 12,59 хувиар өссөн.</p> <p>“Мөрөөдлийн говь” ХХК нь 2024 онд 180,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд суманд 0,7 га-д хүлэмжийн аж ахуйн цогцолбор байгуулах ажил 50%-н гүйцэтгэлтэй байна.</p>	
152	<p>3.3.2. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих замаар малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ</p>	<p>169. Гол нэрийн зарим хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх</p>	<p>2021 - 2024</p>	<p>11 10 42 5 150.0 /сая.төг/ 1.2%</p>	<p>Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Мандах, Сайхандулаан, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ, Өргөн, Санйшанд, Замын-Үүд сумдын “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас 2021-2024 онд сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэх 8 иргэнд 130,5 сая, хагас боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх, мах нөөцлөх хөргүүртэй агуулах барих 3 аж ахуйн нэгж, 7 иргэнд 620,0 сая, талх, нарийн боов, хэрчсэн гурилын үйлдвэрлэл эрхлэх 7 иргэнд 111,3 сая, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бусад чиглэлээр 6 иргэнд 191,1 сая, хүнсний ногоо тариалах 1 аж ахуйн нэгж, 5 иргэнд 142,0 сая, нийт 11 сумын 4 аж ахуйн нэгж, 33 иргэнд 1194,9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон.</p> <p>Мөн Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолд тусгасан “Хүнсний болон Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” жилийн 5-6 хувийн хүүтэй зээлд 2023-2024 онд газар тариалан, мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 27 иргэн, аж ахуйн нэгжид 885,0 сая төгрөгийг олгосноор 2021-2024 онд нийт 1959,9 сая төгрөгийг хүнсний үйлдвэрлэлийг дэмжихэд зарцуулсан. Гурилан бүтээгдэхүүний цех 37, мах, махан бүтээгдэхүүний 3 үйлдвэр цех, сүү, сүүн бүтээгдэхүүний 5 цех савласан усны 13 цех, байгалийн болон ургамлын гаралтай жижиглэн савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл-1, бялууны төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл-8, өндөгний 1 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулан, хүн амын махны хэрэгцээг 100%, сүүний хэрэгцээний 76,3%, гурилан бүтээгдэхүүний хэрэгцээний 5,4%, төмс, хүнсний ногооны 23,29 %, өндөгний 73,6%-ийг орон нутгаас хангаж байна.</p> <p>Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хангалтын хувь өмнөх оны мөн үеэс мах 20,8%-иар, сүүн сүүн бүтээгдэхүүн 7,9%-иар, гурил гурилан бүтээгдэхүүн 2% -иар тус тус өссөн.</p>	90%

153		170. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, хадгалалт, тээвэрлэлт, түгээлтийн үйл ажиллагааг өргөжүүлж, тавих хяналтыг сайжруулах;	2021 - 2024		0 70 79	<p>Аймгийн Засаг даргын 2020 оны А/825 захирамжаар "Хүнсний хангамжийн шуурхай штаб"-ыг байгуулан, хүн амын стратегийн хүнс-мах, сүү, гурилаар орон нутгийг тогтвортой хангах, улирлын нөөц бүрдүүлэх гэрээг 14 сумын 2 хоршоо, 4 иргэн, 49 аж ахуйн нэгжтэй байгуулсан.</p> <p>Аж ахуйн нэгж, иргэдийн нөөц бүрдүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн явцад хүнсний худалдаа, хоол, үйлдвэр үйлчилгээний чиглэлээр 5 удирдамжийн хүрээнд нийт 194 объектн хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 850 зөрчил дутагдлыг илрүүлж 296 буюу 34,82%-ыг арилгуулан, зөрчил ихээр илэрсэн 16 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 493 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, 43 иргэн, аж ахуй нэгжид улсын байцаагчийн зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>2024 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгөөр махны нөөц бэлтгэх тендерт Сайншанд сумын 5 дугаарт багт үйл ажиллагаа явуулдаг "Үзүүрт зараа" ХХК шалгарч дотоодын хэрэгцээнд үхэр-30тн, хонь-50тн, ямаа-20тн, нийт 100 тн махны нөөцийг бүрдүүлэн 4 дүгээр сарын 15-наас зах зээлийн үнээс кг тутмыг 2000-3000 төгрөгийн хямд үнээр худалдаанд гаргасан.</p> <p>Нөөцийн махны борлуулалт, түгээлтийг өргөжүүлж Замын-Үүд сумын 2, Сайншанд сумын 11, нийт 13 хүнсний дэлгүүрт худалдан борлуулж байна.</p> <p>Нөөцийн мах худалдаж эхэлсэн хугацаанаас эхлэн 14 хоног тутам мэдээллэх зарцуулалтын явцын мэдээг гаргаж, махны нийлүүлэлт, худалдаалах үйл ажиллагаанд тухай бүр хяналт тавьж, арга зүйгээр ханган ажиллаж байна.</p> <p>"Хүнсний аюулгүй байдал" аяны хүрээнд 14 сумын хүнсний худалдааны 65 объект, хоол үйлдвэрлэл үйлчилгээний 34, ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийн 41, үйлдвэрийн 14 нийт 154 объектыг төлөвлөгөөт бус шалгалтад хамруулж, 16 удаагийн сургалт мэдээллийг зохион байгуулан 521 иргэн аж, ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулан мэдээлэл өгч 8 төрлийн зөвлөмж боршур тараасан.</p>	90%
154		171. Сумдад мал нядлах эрүүл ахуйн шаардлага хангасан	2022 - 2024		2 31.5/тн/	<p>Аймгийн хэмжээнд мах хадгалах стандартын шаардлага хангасан зоорьтой 2 аж ахуйн нэгж /Суман зурхай ХХК, Үзүүрт зараа ХХК/, 15 иргэн, "Хайрхан" малын гаралтай түүхий эд,</p>	90%

		төвлөрсөн цэг байгуулах, малын гаралтай экологийн цэвэр бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх			<p>бүтээгдэхүүний зах, мал төхөөрөх 1 үйлдвэр, мах боловсруулах /хиам/ 2 үйлдвэр, дайвар бүтээгдэхүүний 1 үйлдвэр, мал нядалгааны 7 цэг үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Тайлант хугацаанд мал нядалгааны цэгийг шинэчлэн болон сэргээн засварлах, мах боловсруулах, мах хадгалах зориулалтай хөргүүртэй агуулах барихаар Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Сайншанд, Замын-Үүд, Хатанбулаг, Иххэт сумд хоршоо хөгжүүлэх сангаас 2 ААН, 2 хоршоо, 4 иргэнд нийт 610.0 сая төгрөг, “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл”-ийн хүрээнд махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэх 1 аж ахуйн нэгжид 270,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлснээр 7 ажлын байрыг хадгалж 15 ажлын байрыг шинээр бий болгож, Айраг, Даланжаргалан, Хатанбулаг суманд нийт 220 тонны багтаамжтай махны гүн хөлдөөх зоорийг шинээр барьж ашиглалтад оруулсан.</p> <p>Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд сумдад сургагч багш нар ажиллаж, сумын төв болон малчны хотонд ажиллаж Шинэ хоршоо хөдөлгөөний талаар мэдээ мэдээлэл хүргэж, анхан шатны хоршоо байгуулахад дэмжлэг хүргэн ажиллаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд 20 хоршоо байгуулагдаад байна. Үүний 10 гаруй хоршоо нь мах махан бүтээгдэхүүн, мал нядалгааны цэг байгуулах чиглэлээр төслөө бичиж боловсруулаад байна.</p> <p>“Шинэ хөдөө” төслийг 2024 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж улсын төсвийн 1.8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр мах болон хүнсний ногооны орчин үеийн механикжсан зоорь барихаар тендер зарлах ажлын бэлтгэлийг хангаж байна.</p>	
155		172. Ноос, ноолуур, арьс шир боловсруулах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хувийн хэвшлийн санал санаачлагыг дэмжих;	2021 - 2024	23 4 80.0 /сая.төг/	<p>Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 6 иргэн, 1 ААН, 4 хоршоо, арьс, ширний анхан шатны боловсруулалтын чиглэлээр 4 иргэн үйл ажиллагаа явуулж, иргэдийн захиалгын дагуу бэлэн хувцас, бэлэг дурсгалын зүйл, хонины элдсэн нэхий, хурганы арьс, үстэй дээл, монгол гэрийн эсгий дээвэр, гудас зэргийг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж байна.</p> <p>"Шинэ хөдөө" төслийн хүрээнд Айраг, Даланжаргалан, Иххэт, Алтанширээ, Мандах, Сайхандулаан, Өргөн, Эрдэнэ сумдад олгосон "Нэхий элдэгч", "Арьстай мах хуулах" машиныг иргэдэд гэрээгээр ашиглуулан, үйл ажиллагааг жигдрүүлсэн.</p>	70%

					<p>Алтанширээ сумын "Олон ширээ" хоршоо 107 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж, ХХС-аас 80,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг авч, ноос, ноолуурын холбооны гэрчилгээ аван хоршооны гишүүдийн бэлтгэсэн 40 тн ноолуурыг ангилан ялгаж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг "ГОЁЛ" үндэсний үйлдвэрт нийлүүлсэн.</p> <p>"Дэвжих эсгий" ХХК нь ХХС-аас 20.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч 2м*5м харьцаатай эсгий өдөрт 40-50 ширхгийг үйлдвэрлэх хүчин чадалтайгаар байнгын 3, түр ажлын байр 2-ыг бий болгосон. Өргөн сумын хувиараа аж ахуй эрхлэгч иргэн малчидтай гэрээ байгуулан бүтээгдэхүүн болон бэлэн мөнгөөр түүхий эдээ худалдан авч 145 ширхэг эсгий үйлдвэрлэн борлуулсан.</p> <p>"Дорнын Үжин гоо" ХХК нь "Цагаан алт" ХХК-аас угааж, самнасан хонины ноосыг захиалгаар авч эцсийн бүтээгдэхүүн болгон МҮХАҮТ-тай гэрээ байгуулан 100% гар аргаар хийсэн 500 ширхэг чихмэл тэмээг, мөн Улаанбаатар хотын бэлэг дурсгалын дэлгүүрүүдэд 450 ширхэг чихмэл тэмээг захиалгаар тус тус нийлүүлсэн.</p> <p>Тайлант хугацаанд Засгийн газраас хэрэгжүүлсэн "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хүрээнд нийт 213 иргэн 3,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг хөдөө аж ахуй, түүхий эд бэлтгэх чиглэлээр авсан.</p> <p>Мөн 5 сум ХХС-аас 100 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 5 иргэнд арьс ширэн бүтээгдэхүүн, суран эдлэл үйлдвэрлэлийн чиглэлээр олгож 4 ажлын байрыг хадгалж, шинээр 2 ажлын байрыг нэмэгдүүлсэн.</p>	
156		173. Үндэсний үйлдвэрүүдэд чанар, стандартын шаардлага хангасан түүхий эд нийлүүлсэн малчдыг урамшуулалд хамруулах ажлыг зохион байгуулах;	2021 - 2024	5%	<p>Үндэсний үйлдвэрүүдэд чанар, стандартын шаардлага хангасан түүхий эд нийлүүлсэн малчдад тухайн компани нь Татварын е-баримт үүсгэн цахимаар илгээн баталгаажуулж байгаа учир төрийн оролцоогүй болсон.</p>	100%
157	3.3.3. Малын чанар, ашиг шимийг сайжруулах,	174. "Дэлгэрэхийн улаан" омгийн ямааны тархалтыг	2021 - 2024	250 70	<p>Дэлгэрэх, Иххэт, Улаанбадрах сумдын нийт 9800 малд улсын төсвийн 19,5 сая төгрөгийн санхүүжилтээр үзлэг, ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэн, мэдээллийн нэгдсэн санд</p>	90%

	<p>биотехнологийн ололтыг нэвтрүүлэн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлнэ</p>	<p>нийт хээлтүүлэгчийн 30 хувьд хүргэх, үрийг генийн санд хадгалуулах;</p>				<p>бүртгүүлэх ажлыг технологит хугацаанд зохион байгуулсан. Нутгийн шилмэл ноолуурын чиглэлийн “Дэлгэрэхийн улаан омог”-ийн 5000 ямаанд үзлэг, ангилалт хийж стандартын шаардлага хангасан 90 хээлтэгчийг ялган мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид төвлөрүүлсэн.</p> <p>Нутгийн шилмэл омгийн ямааны тархалт, ямаан сүргийн чанар, ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Дэлгэрэхийн улаан омог”-ийн 707 толгой өсвөр хээлтүүлэгч бэлтгэн Улаанбадрах, Мандах, Алтанширээ, Өргөн, Даланжаргалан, Айраг Замын-Үүд сумдын 127 малчин өрхөд нийлүүлж 35350 толгой малыг хээлтүүлэх боломж бүрдсэн ба 2024 онд 30 толгой өсвөр хээлтүүлэгч нэмж бэлтгэснээр 1500 толгой малыг хээлтүүлэх боломжтой болсон.</p> <p>Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран “Дэлгэрэхийн улаан омог”-ийн ямааны 3000 үрийг генийн санд хадгалуулсан ба хээлтүүлэгч ямааны тоо 1847 толгой хүрч, орон нутгийн нийт хээлтүүлэгчийн 30 хувьд тархсан.</p> <p>2024 оны эхний хагас жилд Дэлгэрэх, Өргөн, Алтанширээ сумдын нийт 8800 малд улсын төсвийн 15,8 сая төгрөгийн санхүүжилтээр үзлэг, ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэн, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх ажлыг технологит хугацаанд зохион байгуулахаар ажиллаж байна.</p> <p>Сумын хэмжээнд нийт 633 хээлтүүлэгч байгаагийн 9,7%-ийг Дэлгэрэхийн улаан омгийн ямааны хээлтэгч эзэлдэг. Нутгийн шилмэл ноолуурын чиглэлийн “Дэлгэрэхийн улаан омог”-ийн 5000 ямаанд үзлэг, ангилалт хийж стандартын шаардлага хангасан 62 хээлтэгчийг ялган мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид төвлөрүүлсэн</p>	
158		<p>175. Мал сүрэгт эзлэх өндөр ашиг шимт малын тоог өсгөх замаар малын чанар, ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэх;</p>	2021 - 2024		0,5%	<p>Малын чанар, ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэхээр “Дэлгэрэхийн улаан омог”-ийн ишгэн ухна 655, барга, үзэмчин үүлдрийн 302 хурган хуц, нийт 957 толгой өсвөр хээлтүүлэгч бэлтгэн бойжуулсан.</p> <p>Биотехнологийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн зохиомол хээлтүүлгийг орон нутагт зохион байгуулах ажлын хүрээнд Алатау, Хар тарлан үүлдрийн 426 толгой үхэр , 3008 нутгийн монгол хонь, дэлгэрэхийн улаан омгийн ямааны нийт 3384 толгой малд шингэлсэн үр болон гардан хээлтүүлэг хийж нутгийн малын ашиг шимийг сайжруулсан.</p> <p>Алтанширээ, Сайншанд, Замын-Үүд сумд “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас мал чанаржуулах, махыг үйлдвэрийн</p>	70%

					<p>аргаар бэлтгэх, эрчимжсэн аж ахуйн эрхлэх 2 иргэн, 1 аж ахуйн нэгжид 143,0 сая, “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд 5-6 хувийн хүүтэй зээлийг арилжааны банкаар дамжуулан эрчимжсэн мал аж ахуй эрхлэх 2 иргэн, аж ахуйн нэгжид 415,0 сая төгрөг, “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-гаас “Цагаан сүүний буян” ХХК, “Өлзийт баян мод” ХХК-д 360,0 сая төгрөг, нийт 918,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.</p> <p>Өндөр ашиг шимт малын тоо 79506 толгойд хүрч, 5 төрөл дээрээ 1,4%-иар өссөн нь нийт мал сүргийн 2,7 хувийг эзэлж байна.</p> <p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн урт хугацаатай хөнгөлөлттэй зээлд эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр “Очир баян хүү” ХХК нь 175,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл хүсэж төсөл нь урьдчилсан шатны шалгаруулалтад тэнцэн нарийвчилсан судалгааны шатанд явж байна.</p>	
159	176. Сумдад эрчимжсэн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулах хувийн хэвшлийн санал санаачлагыг дэмжих;	2021 - 2024	72 4 100.0 /сая төг/	<p>Аймгийн хэмжээнд махны чиглэлийн фермер 10, сүүний чиглэлийн 72, гахай 7, тахианы аж ахуй эрхлэгч 12 иргэн аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>“Мөрөөдлийн говь” ХХК нь Сайншанд сумын 6 дугаар багт хувийн 650,0 сая төгрөгийн хөрөнгөөр 60000 тахианы механикжсан ферм байгуулж, эхний ээлжид 38000 өндөглөгч тахиатайгаар орон нутгийн иргэдэд өндөг нийлүүлэн үйл ажиллагаа нь тогтмолжсон.</p> <p>“Солид Партнерс групп” ХХК нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Дорноговь аймагтай хамтран “Монгол тэмээ Дорноговь” төслийг хэрэгжүүлэн ингэний сүүг боловсруулан хуурай сүү, молоко зэрэг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох үйлдвэрийг Замын-Үүд суманд, үйлдвэрт шаардагдах ингэний сүүг цуглуулах эрчимжсэн фермерийг Мандах, Хатанбулаг, Улаанбадрах, Хөвсгөл, Сайншанд сумдад байгуулахаар малчид, иргэдэд танилцуулга мэдээллийг хүргэж эхэлсэн.</p> <p>Мандах, Замын-Үүд сумын сум хөгжүүлэх сангаас эрчимжсэн мал аж ахуйн 2 төсөлд 47 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл, Айраг, Алтанширээ, Иххэт, Сайншанд, Замын-Үүд сумд хоршоо хөгжүүлэх сангаас мал чанаржуулах махыг үйлдвэрийн аргаар бэлтгэх, эрчимжсэн аж ахуйн эрхлэх 6 иргэн, аж ахуйн нэгжид 433,0 сая, жижиг, дунд үйлдвэрийг</p>	90%	

					<p>хөгжүүлэх сангаас сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, махны чиглэлийн хонины аж ахуйн чиглэлээр 3 төсөлд 460,0 сая, “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд үйлдвэрлэл эрхлэгчдэд 5-6 хувийн хүүтэй, таван жилийн хугацаатай 2 иргэн, аж ахуйн нэгжид арилжааны банкаар дамжуулан 415 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл, нийт 13 иргэн, аж ахуйн нэгжид 1 тэрүм 355 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэн, хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжин ажилласан.</p> <p>2024 оны эхний хагас жилд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн урт хугацаатай хөнгөлөлттэй зээлд эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр “Очир баян хүү” ХХК нь 175,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл хүсэж төсөл нь урьдчилсан шатны шалгаруулалтад тэнцэн нарийвчилсан судалгааны шатанд явж байна.</p> <p>МУ-ын Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж буй “Шинэ хоршоо” хөдөлгөөн Дорноговь аймагт эрчимтэй өрнөж 98 хоршоо шинээр байгуулагдаж, 3,2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг шийдвэрлүүлэн үйл ажиллагаа эхлүүлж, хөдөлмөрөө хоршоод байна.</p>	
160		177. Малчид, иргэдийн захиалгын дагуу бод, бог малын зохиомол хээлтүүлэг хийх;	2021 - 2024	484 2%	<p>Биотехнологийн дэвшилтэт технологийг орон нутагт нэвтрүүлэх ажлын хүрээнд иргэн аж ахуй нэгж болон малчдаас бод, бог малд зохиомол хээлтүүлэг хийлгэх захиалга авч 2021-2024 оны байдлаар Алатау, Хар тарлан үүлдрийн 282 толгой үхэрт, 2848 толгой Дэлгэрэхийн улаан омгийн ямаа, нутгийн монгол хонь, ямаа нийт 3130 толгой малд шингэлсэн үр болон гардан хээлтүүлэг хийж 2020 оноос 23,7 хувиар нэмэгдүүлсэн.</p> <p>Сайн Ус багийн 1 малчин өрх ХАА-н мэргэжилтнүүдтэй хамтран 2020 онд Суффольк үүлдрийн хуцны үрээр зохиомол хээлтүүлэг хийж 100 гаруй төл авч байсан. Тухайн малчин нь жил бүр суффольк үүлдрийн хуцыг хээлтүүлгэндээ ашиглаж жилдээ 45-50 төл хүлээн авч 2022 оны жилийн эцсийн тооллогоор суффолкийн эрлийз 81 хонь тоологдсон.</p> <p>Мөн мал эмнэлгийн 1 мэргэжилтэн аймгийн хэмжээнд шинээр "эхо" аппаратаар адууны үрчил хийн жилд 15-20 эрлийз буюу F1 төрлийн адууг гарган авч байна.</p> <p>Малын чанар, ашиг шимийг сайжруулах зорилгоор "Казакын цагаан толгойт" 10 хээлтүүлэгч үхрийг 19.9 сая төгрөгөөр худалдан авч 10 малчин өрхөд 2 жилийн хугацаатайгаар гэрээг байгуулан олгосон.</p>	90%

161	3.3.4. Бэлчээрийн төлөв байдал, даацад тулгуурлан нөхөн сэргээлт ийг хийж, бэлчээрийн хангамжийг хангамжийг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулна.	178. Бэлчээр ашиглалтын нөлөөллийг фотомониторингийн аргаар тодорхойлж, сум бүр орон нутгийн онцлогт тохирсон бэлчээр ашиглах журам, менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх;	2021 - 2024		14 3	<p>Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу жил бүрийн 8 дугаар сард бэлчээрийн төлөв байдлын, ургац тодорхойлох ажлыг 14 сумын 54 багийн 72 бэлчээрийн төлөв байдлын ажиглалтын цэгт гүйцэтгэж бэлчээрийн даацыг тодорхойлсон.</p> <p>Бэлчээрийн даацын мэдээнд үндэслэн 2023-2024 оны өвөлжилт хаваржилт, отор нүүдлийн зураглалыг гарган холбогдох газруудыг мэдээллээр хангаж ажилласан.</p> <p>Орон нутгийн онцлогтоо тохирсон бэлчээр хамгаалах журам, менежментийн төлөвлөгөө боловсруулах талаар заавар, зөвлөмж өгч ажилласнаар Айраг, Даланжаргалан, Иххэт, Өргөн, Мандах, Улаанбадрах, Сайхандулаан, Хөвсгөл, Эрдэнэ, Сайншанд, Алтанширээ, Замын-үүд сумд бэлчээр ашиглах, отор нүүдэл зохицуулах журам, менежментийн төлөвлөгөөг сумын ИТХ-аар батлуулж, эрх зүйн нэгдсэн системд бүртгүүлэн 2023 оноос ашиглаж эхлээд байна.</p> <p>Энэ онд Дэлгэрэх, Хатанбулаг сумд бэлчээр ашиглах журам, менежментийн төлөвлөгөөг батлуулахаар иргэд, малчдадаа танилцуулж журмын төсөлд санал авах ажил хийгдэж байна.</p> <p>2024-2025 оны Бэлчээрийн төлөв байдал, даац тодорхойлох ажлыг 8-р сард холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.</p>	90%
162		179. Зарим сумдын бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготонтой тэмцэх, доройтлыг бууруулах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах;	2022 - 2024		15000/га/	<p>Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран “Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй хөнөөлт мэрэгчдийн хаврын тодотгох судалгаа”-ны ажлыг 2022 онд Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх сумдын нутагт гүйцэтгэсэн. Дээрх 5 сумын бэлчээрийн 153000 га талбайд буюу бэлчээрийн газрын 26.5 хувьд хөнөөлт мэрэгч болох “Үлийн цагаан оготно”-ы тархалт, нягтшил нь хэсэгчилсэн болон үргэлжилсэн тархалттай, 74 мянган га бэлчээрт тэмцэх ажил зохион байгуулах шаардлагатай гэсэн зөвлөмж, дүгнэлт гарсан.</p> <p>Мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, дүгнэлтийг орон нутгийн малчид, иргэдэд танилцуулах, бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй хөнөөлт мэрэгчтэй энгийн механик, биологийн аргаар тэмцэх арга, аргачлалыг гарын авлага хэлбэрээр давхардсан тоогоор 690 гаруй иргэдэд хүргэсэн ба малчид хувиараа болон хоршоо, нөхөрлөлийн хэмжээнд 5 мянга орчим га бэлчээрт үлийн цагаан оготно устгах ажлыг энгийн механик аргаар зохион байгуулсан.</p>	70%

					<p>МУ-ын Засгийн газрын 2019 оны 185 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/143 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны А/679 тоот захирамжийн хүрээнд 2023 онд Улсын төсвийн 48 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт сумдын нийт 30 мянган/га бэлчээрийн талбайд бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготнотой байгаль орчинд халгүй энгийн механик, биологийн аргаар тэмцэх ажлыг тухайн сум орон нутгийн 133 малчин, мал бүхий иргэдийг хамруулан зохион байгуулсан.</p> <p>Тус ажлыг зохион байгуулснаар бэлчээрийн талхагдлыг багасган, бэлчээрийн ургамлын нөхөн ургах боломжийг бүрдүүлж хонин толгойд шилжүүлснээр 6,9 мянган толгой малыг бэлчээрлүүлэх боломж бүрдсэн.</p> <p>Ургамал хамгаалал, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс 2023 онд намрын хортон мэрэгчийн тодотгох судалгааг Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт сумдад хийж тэмцэх хэмжээний биш гэсэн дүгнэлт гарсан тул 2024 онд Үлийн цагаан оготнотой тэмцэх ажил хийгдэхгүй.</p>	
163		180. Төр, хувийн хэвшлийн хөрөнгөөр бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх	2021 - 2024	10 15	<p>Бэлчээрт инженерийн хийцтэй 488, богино яндант 29, бетон хашлагат 534, энгийн уурхай 2177 нийт 3228 худаг ашиглагддаг судалгаа гарсан. Улсын төсвийн 269.5 сая төгрөгийн хөрөнгөөр 5 суманд 8 инженерийн хийцтэй худгийг шинээр, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 342 сая төгрөгийн хөрөнгөөр 2 суманд 7 инженерийн хийцтэй худаг шинээр, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн 910.5 сая төгрөгийн хөрөнгөөр 59 инженерийн хийцтэй худаг шинээр болон сэргээн засварлан, уул уурхайн болон томоохон хөрөнгө оруулагчид, гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, малчдын хөрөнгөөр 9 суманд 56 инженерийн хийцтэй худаг шинээр болон сэргээн засварлан тус тус ашиглалтад оруулсан.</p> <p>Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021-2023 онд 14 суманд нийт 130 инженерийн хийцтэй худаг ашиглалтад оруулж, 195 мянган га бэлчээрийг усжуулан, бэлчээр ашиглалт, талхдалтыг бууруулж, 273 мянган толгой малыг услах боломжийг бүрдүүлсэн.</p>	90%
164	3.3.5. Мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, байгаль цаг уурын эрсдэлээс хамгаалах,	181. Хөдөө аж ахуйн салбарын цаг үеийн мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх	2021 - 2024	100000	<p>Мал аж ахуйн салбарын цаг үеийн мэдээ, мэдээллийг малчдад шуурхай хүргэх зорилгоор аймгийн Засаг даргын А/33, А/241, А/263 дугаар захирамжаар нийт 16,0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн, Мобиком, Скайтел компаниудтай</p>	100%

	бэлэн байдлыг хангах нөхцлийг бүрдүүлнэ.	"Масс мессеж" үйлчилгээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;				тус тус гэрээ байгуулан "Масс мессеж" үйлчилгээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, цаг агаарын болон цаг үеийн мэдээллийг давхардсан тоогоор нийт 504870 иргэн, малчинд хүргэсэн.	
165		182. Хадлан тэжээл бэлтгэх менежментийг сайжруулж, малын тэжээлийн ургамал тариалах ажилд иргэд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх	2021 - 2024		5 7.5 /га/ 700 17/тн/	<p>Бэлчээрийн даац, төлөв байдлаас шалтгаалан аймаг, сум, малчдын түвшинд бэлтгэвэл зохих нөөцийн хэмжээг ЗГ 2023 оны 279 тогтоолын дагуу аймгийн нөөцөд 600 тн өвс, 209 тн тэжээл, сумдын нөөцөд 648.9 тн өвс 268.9 тн тэжээл бэлтгэн, 97.8 хувьтай хангасан.</p> <p>Сумдын газар тариалан эрхлэгч, малчдын 45 төлөөллийг малын тэжээл тариалах чиглэлээр талбай бэлтгэх, тариалалт хийх явцтай газар дээр нь танилцуулж туршлага судлуулсан. Мөн Дэлхийн зөн ОУБ-ын "Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг" төсөлтэй хамтран аймгийн Газар тариалан эрхлэгчдийн сургалт зөвлөгөөнийг зохион байгуулж "Говийн бүсэд ногоон тэжээл тариалсан туршлага, ногоон тэжээл тариалах арга технологи" сэдвээр 97 тариаланчдад мэдээлэл хүргэсэн.</p> <p>"Гамшигт тэсвэртэй хөдөө аж ахуй" төслийн хүрээнд 3 суманд 4 га талбайд малын тэжээлийн ургамлыг туршилтаар тариалж, бороожуулах усалгааны систем, бага оврын хадлангийн трактор, анжис, хадуур, тармуур, хаман боогч зэрэг 70,2 сая төгрөгийн техникийн шинэчлэл, "Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг төслийн хүрээнд Иххэт суманд малын тэжээлийн ургамал тариалах "Өнгөт" малчдын бүлэгт 79,0 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг нийлүүлж дэмжлэг үзүүлснээс гадна 3 сум Хоршоо хөгжүүлэх сангаас Малын тэжээлийн ургамал тариалах 2 хоршоо, 1 аж ахуйн нэгжид нийт 170,0 сая.төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон.</p> <p>Замын-Үүд суманд 2, Даланжаргалан, Иххэт сумдад тус бүр 1 хадлангийн салаа үйл ажиллагаа явуулан, хадлан тэжээл бэлтгэж хэвшсэн.</p> <p>Сайншанд суманд ногоон тэжээлийг гидропоник нөхцөлд тариалах туршилтын ажил амжилттай болсон. Тайлант онд 9 сум нийт 56.1 га талбайд малын тэжээлийн ургамал тариалж өмнөх оноос 65 тоноор илүү буюу 83 тонн ургац хураан авсан.Малын тэжээлийн ургамал тариалах төлөвлөлтийн дагуу сумдын Засаг дарга нарт чиглэл өгч, ногоон тэжээл тариалах болон соёолж бэлтгэх зөвлөмжийг 14 суманд хүргүүлсэн.</p>	90%

						Аймгийн хэмжээнд 2024 онд 113 га талбайд малын тэжээлийн ургамал тариалсан нь 2020 онтой харьцуулахад тариалсан талбайн хэмжээ 11,07 дахин буюу 102,8 га-аар нэмэгджээ.	
166		183. Малын тооноос хамааруулан өвс, тэжээлийн шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, стандартын дагуу хадгалах	2021 - 2024	-	70%	<p>Тус аймгийн 14 сум мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангахад сумын аюулгүйн нөөцөд өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэн хадгалах агуулахтай.</p> <p>2021-2023 онд Дэлгэрэх, Иххэт, Эрдэнэ сум орон нутгийн хөгжлийн сангийн 313,7 сая төгрөгийн хөрөнгөөр өвс, тэжээлийн агуулахыг шинээр барьж ашиглалтад оруулсан.</p> <p>Засгийн газрын 2023 оны 279 дүгээр тогтоолоор тус Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 80 тн тэжээл, Сумдын нөөцөд 560 тн өвс, 420 тн тэжээл нийт аймгийн хэмжээнд 660 тн өвс, 500 тн тэжээл бэлтгэх даалгавартайгаас аймгийн аюулгүйн нөөцөд 600 тн өвс, 209 тн тэжээл, сумдын аюулгүйн нөөцөд 648.9 тн өвс 268.9 тн тэжээл бэлтгэж аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт 97.8 хувьтай хангагдсан.</p> <p>2024 онд аймаг, сумдын аюулгүйн нөөцөд 648,9 тн өвс, 269.0 тн тэжээл бэлтгэсэн. Өвс, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж 1782 тн өвс, 1398 тн тэжээлийг нэмж бэлтгэн, үүнээс 2144,1 тн өвс, 1551 тн тэжээлийг зарцуулсан.</p>	100%
167		184. Бэлчээрийн даацад тулгуурлан отор, нүүдлийг эртнээс төлөвлөн оновчтой зохион байгуулах;	2021 - 2024		3	<p>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/11 дүгээр тогтоолоор 6 сумын нийт 108,9 га бэлчээрийн газрыг “Сум дундын отрын нөөц нутаг”-аар тогтоож, 5 жилийн хугацаатайгаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан.</p> <p>Дээрх отрын нөөц нутгуудад бэлчээрийн ургац 0.4-3.1 ц/га хэмжээтэй байх үед хонин толгойд шилжүүлснээр 64263 толгой мал өвөлжиж, хаваржих боломжтой.</p> <p>Аймгийн хэмжээнд гадны аймагт отроор өвөлжих 6 сумын 148 өрхийн 150,0 мян толгой мал байгаа бөгөөд бэлчээрийн даацын мэдээнд үндэслэн 2023-2024 оны өвөлжилт хаваржилт, отор нүүдлийн зураглалыг гарган холбогдох газруудыг мэдээллээр хангаж ажилласан.</p> <p>Отор нүүдлийг оновчтой зохион байгуулах ажлын хүрээнд хил хамгаалах ерөнхий газар, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр аймгийн удирдлагуудад отор нүүдэл хийх санал хүргүүлж, Мандах, Хатанбулаг, Хөвсгөл, Сайншанд сумд хил залгаа сумдтайгаа отор нүүдэл хийх гэрээ байгуулсан.. Мөн Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын “Хэрлэнбаян-Улаан” отрын бүс нутгийн бэлчээр ашиглалтыг зохицуулах үүрэг бүхий</p>	100%

					орон тооны бус зөвлөлийн хуралд оролцож уг отрын бүс нутагт Дорноговь аймгаас 10 мянган толгой малыг отроор өвөлжүүлэх зохицуулалтыг хийсэн.	
168		185. Мал сүргээ тогтвортой өсгөн үржүүлж, нүүдлийн соёл, уламжлалыг хадгалан малчдын залуу халааг бэлтгэхэд хувь нэмрээ оруулж байгаа тэргүүний малчдыг урамшуулах, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах	2021 - 2024		1 45	90%
169	3.3.6. Орон нутгийн худалдаа, үйлчилгээ, өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжин хөгжүүлж, хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна.	186. Сайншанд, Замын-Үүд сумдад ахуйн үйлчилгээ, худалдааны нэгдсэн төв байгуулах хувийн хэвшлийн санал, санаачлагыг дэмжих	2021 - 2024		1 2 2 200.0 /сая.төг/	90%

					<p>Аймгийн Засаг даргын 2021 оны А/327 дугаар захирамжаар Сайншанд сумын 3 дугаар багийн нутагт 750 м2, 2 дугаар багт 5500 м2, Замын-Үүд сумын 4 дүгээр багийн нутагт 20000 м2 газрыг худалдаа, үйлчилгээний зориулалтаар олгосон.</p> <p>Сайншанд суманд орон нутгийн худалдаа үйлчилгээ болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор аймгийн Засаг даргын А/47 дугаар захирамжаар 4 дүгээр багт ONE MART худалдаа үйлчилгээний төв байгуулахаар 15.5 га газрыг төсөл сонгон шалгаруулалтаар олгосон.</p> <p>Замын-Үүд сумын 1 дүгээр багийн нутагт "Өлгий эргэл" ХХК хувийн хөрөнгөөр худалдаа, үйлчилгээний зориулалт бүхий 1600 мкв талбай бүхий 3 давхар барилгыг ашиглалтад оруулж, 12 ажлын байр шинээр бий болгосон.</p>	
170		<p>187. Орон нутгийн хүнс, газар тариалан, өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэр- лэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах “Нутгийн брэнд” төвийг байгуулах хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжих</p>	2021 - 2024		<p>Монгол, Япон 2 улсын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн 5 жилийн ойг тохиолдуулан Япон улсын зах зээлд "Монголын үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ"-г танилцуулах цахим форумд аялал жуулчлалын бүс нутаг "Хамарын хийд", үндэсний тохирлын тэмдэгтэй “Загсгал цай”-г, “Жижиг, дунд үйлдвэрийн газар”-аас зохион байгуулсан</p> <p>"Орон нутгийн-Онцлох бүтээгдэхүүн"-ийг цувралаар танилцуулах арга хэмжээнд “Тарвас”, “Загсгал цай”, “Тансаг цагаан” ингэний хоормогийг танилцуулан сурталчилсан.</p> <p>Мөн Монгол-Хятадын эдийн засгийн түншлэлийн хүрээнд Зүүн баян багт зохион байгуулсан “Талын түнш” арга хэмжээнд жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 12 иргэн, ААН-ийг хамруулж 5,8 сая төгрөгийн борлуулалт хийсэн.</p> <p>Улаанбаатар хотод босон “Шинэ-Хоршоо” хөдөлгөөний нээлтийн арга хэмжээнд “Өөлий урлан”, “Мондо урлан”, “Chimivie fashion”, “Эсгий урлал” зэрэг бичил бизнес эрхлэгчид бараа бүтээгдэхүүнээ сурталчлан оролцсон.</p> <p>Орон нутгийн газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, харилцан туршлага судлуулах зорилгоор “Цагаан сар”, “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг 14 сумын хэмжээнд жил бүр зохион байгуулж давхардсан тоогоор 523 иргэн, аж ахуйн нэгж, хоршоо нөхөрлөл, малчид оролцож 453.7 сая төгрөгийн борлуулалт хийсэн.</p>	100%

					<p>МҮХАҮТ, "Монгол брэнд" ХХК-тай хамтран өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн, мэдээллийн нэгдсэн бааз (онлайн платформ)-ыг үүсгэж гадаад, дотоодын зах зээлд таниулан сурталчлах ажлыг эхлүүлсэн.</p> <p>Орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих ХАА-н үйлдвэрлэлийн цогцолборыг байгуулахаар Сайншанд сумын 2-р багийн нутаг дэвсгэрт 849 м2 газрыг аймгийн Засаг даргын 2023 оны А/589 дүгээр захирамжаар шийдвэрлэж ажлын явц 95 %-тай үргэлжилж байна.</p>	
171		<p>188. Орон нутагт хэрэгжиж буй томоохон төсөл, хөтөлбөр, боловсруулах, баяжуулах үйлдвэрийн захиалгат ажлыг өрхийн болон жижиг, дунд бизнес эрхлэгчид гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх;</p>	2021 - 2024	20 50 43 7	<p>Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн болон томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч нартай ЖДҮ, бизнес эрхлэгчдийн холбох, борлуулалтыг нэмэгдүүлэх бодлого барин, Алтанширээ сумын нутагт баригдаж буй "Газрын тос боловсруулах үйлдвэр"-ийн төсөл хэрэгжүүлэгч талтай орон нутгаас хамтран ажиллах "Говь консалтинг менежмент" ОНӨААТҮГ-ыг аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр тогтоолоор байгуулан, "Газрын тос боловсруулах үйлдвэр"-ийн төсөл хэрэгжүүлэгч "JMC Projects Mongolia" ХХК-тай орон нутгийн худалдааны 3, цэвэр усны 1, мах, махан бүтээгдэхүүн 1 аж ахуйн нэгж гэрээ байгуулан захиалгын дагуу нийлүүлэлт хийсэн.</p> <p>Үйлдвэрийн бүтээн байгуулалтад оролцож буй туслан гүйцэтгэгч 8 компани нь цэвэр усны 4, мах 1, сүү, сүүн бүтээгдэхүүний 1, хүнсний ногооны 1 ААН-тэй гэрээгээр, бусад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг Сайншанд сумын зах худалдааны төв, худалдаа, үйлчилгээний газруудаас сонгон авч байна. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 21 уурхай, боловсруулах болон баяжуулах 13 үйлдвэр, тээврийн 35 компани нь 14 сумын худалдааны 38, цэвэр усны 12, мах 1, махан бүтээгдэхүүний 1, сүү, сүүн бүтээгдэхүүний цех 1, фермер 6, өндөгний аж ахуй эрхлэгч 1, оёдлын үйлдвэр 1, цех 18, ногооны 4 а.а.н, иргэнтэй гэрээгээр, бусад өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, сэлбэг, шатах, тослох материалыг тухай бүрд орон нутгийн бизнес эрхлэгчдээс худалдан авсан.</p> <p>Оёдлын салбарын нөхцөл байдлын судалгааг NRCC судалгааны байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн ба Дорноговь аймагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг</p>	100%

					компаниуд их боловч оёдлын салбартай тогтвортой хамтын ажиллагаа бүрдээгүй байна гэсэн дүгнэлттэй. Үүнээс үндэслэн 2024 оны 1 дүгээр сард “Хөгжлийн шийдэл” ТББ болон Таван Богд Финанс ББСБ-тай хамтран оёдлын бизнес эрхлэхэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, хамтын ажиллагаа ба кластерын ойлголтыг өгөхөөр “Оёдлын салбарын хамтын ажиллагаа ба кластер” уулзалтыг оёдолчдын холбооны 50 гаруй төлөөллийг оролцуулан зохион байгуулсан.	
172	189. Орон нутагт хэмжлийн нэгдмэл байдлыг хангаж, стандартыг сурталчлан цар хүрээг өрөгжүүлэх	2021 - 2024		3000 96% 0	<p>Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт, хэмжил зүй, стандарт, сорьцын баталгаажуулалт зэрэг үндсэн 4 чиглэлээр орон нутгийн иргэн, аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээ үзүүлж хэмжлийн нэгдмэл байдлыг ханган 380 худалдааны, 293 үйлдвэр, 142 үйлчилгээний цэг, цахилгааны 22470, массын 400 гаруй, эзлэхүүний 4628 хэмжих хэрэгсэл тус тус ашиглагдаж байна.</p> <p>Худалдаа, үйлчилгээний 1246 газрыг тохирлын үнэлгээнд хамруулан заавар, зөвлөгөө өгч, стандартуудыг тухай бүрд тайлбарлан таниулж, 76 бүтээгдэхүүн, 739 үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгосон.</p> <p>Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтад 4110 цахилгааны, 1388 массын, 1418 эзлэхүүний хэмжих хэрэгслийг хамруулсан. Худалдаа, хүнс, нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох стандартыг мөрдүүлэх, стандартыг сурталчлах чиглэлээр 17 удаагийн танхимын болон цахим сургалтад нийт 538 иргэн, 63 аж ахуйн нэгж, төрийн байгууллагын 103 төлөөллийг хамруулж, 313 стандартыг үнэ төлбөргүй олгосон.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 79 дүгээр тогтоолын хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалтад 25 объектыг хамруулж, их эрсдэлтэй 1, дунд эрсдэлтэй 5, бага эрсдэлтэй 19 үнэлэгдэж, 156 зөрчил, дутагдал илрүүлэн, зөрчлийг арилгуулахаар 92 заалт бүхий 15 албан шаардлага, 23 заалттай 14 зөвлөмж, дүгнэлт 1, хяналт шалгалтын танилцуулга 19 тус тус боловсруулан гаргасан.</p>	100%
173	3.3.6.4. Худалдаа, хүнс, нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл	2021 - 2024			2021-2024 оны хөтөлбөрийн хугацаанд нийт Худалдаа, үйлчилгээний 790 газрыг тохирлын үнэлгээнд хамруулан заавар, зөвлөгөө өгч, стандартуудыг тухай бүрд тайлбарлан таниулж, 42 дотоодын бүтээгдэхүүн, 540 үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгосон.	100%

		ажиллагаанд холбогдох стандартыг мөрдүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхжуулан мэргэжилтэй ажилтан бэлтгэх				<p>Худалдаа, хүнс, нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох стандартын талаар, бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалтын болон хэмжил зүйн чиглэлээр нийт 32 удаагийн сургалт зохион байгуулж сургалтад 1125 аж ахуй нэгж, иргэн хамрагдаж мэдээлэл авсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газраас зохион байгуулж буй “Хүнсний аюулгүй байдал” арга хэмжээний хүрээнд Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд, Сайхандулаан, Мандах, Сайншанд сумдад хяналт шалгалтыг хийж, хүнсний худалдааны 29 объект /5ААНБ, 24иргэн/, хоол үйлдвэрлэлийн 13 объект /10 ААНБ, Зиргэн/, нийт 42 объектод хяналт шалгалт хийж 539 зөрчил дутагдлыг илрүүлж, 293 буюу 54,35%-ыг газар дээр нь арилгуулан, зөрчил ихээр илэрсэн 3 иргэнд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 31 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага, 7 аж ахуйн нэгж, 10 иргэнд 156 заалт бүхий улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлж, чанар аюулгүй байдлын шаардлага хангаагүй 17 нэр төрлийн 491 ширхэг 445 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг татан авхуулж, 68 нэр төрлийн 777 ширхэг 0,8 гр 2,308,300 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хураан авч Замын-Үүд, Эрдэнэ, Мандах, Сайхандулаан сумдын Засаг даргын дэргэдэх захиргааны журмаар хураагдсан эд зүйлийг улсын орлого болгох, устгах орон тооны бус зөвлөлд шилжүүлж, 9 иргэнд 2,7 сая төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулж ажилласан.</p> <p>Худалдаа эрхлэгчдийн чадавхжуулах зөвлөмж төвтэй хамтран худалдагчийн чадамжийн гэрчилгээ олгох сургалтыг зохион байгуулан орон нутгийн 35 иргэнийг мэргэжилтэй боловсон хүчнээр бэлтгэсэн.</p>	
174	3.3.7. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулж, экспортыг нэмэгүүлнэ	190. Малын эмч, мэргэжилтний хүний нөөцийг бүрдүүлэн, чадавхжуулах;	2021 - 2024	200 5%	<p>Малын эмч, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх 11 удаагийн цахим, 15 удаагийн танхимын сургалтанд давхардсан тоогоор 285 эмч, мэргэжилтэнийг хамруулан, 16 төрлийн гарын авлага материал 2100 ширхэгийг тараан олгосон.</p> <p>Мал эмнэлгийн салбарын ажилтны зөвлөгөөнийг 2 өдөр зохион байгуулж, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарыг сургалтад хамруулсан.</p> <p>Малчдын нэгдсэн зөвлөгөөнд оролцсон 450 малчинд 3 төрлийн мэдээллийг хийж, 5 төрлийн 330 ш гарын авлага олгож, мэдлэгийг дээшлүүлсэн нь мөн оны өмнөх онтой харьцуулахад сургалт, мэдээлэлд хамрагдсан эмч мэргэжилтэн, иргэдийн тоо</p>	90%	

					<p>2.5 хувиар өссөн. Байгууллагын 2 төрлийн цахим хаягт давхардсан тоогоор 21 постер,4 төрлийн богино хэмжээний видео мэдээллийг байршуулж, үйл ажиллагааг сурталчилан 897 иргэний хандалт авсан.</p> <p>Даланжаргалан сумын Малын эмч, мал эмнэлгийн тасгийн мэргэжилтний хүний нөөцийг нэмэгдүүлэхээр 2021-2023 оны хичээлийн жилд Хөдөө Аж Ахуйн Их Сургуульд малын их эмч мэргэжилээр суралцдаг тус сумын 1 оюутны сургалтын төлбөрийг 3 жил сум орон нутгаас төлж дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Мөн Айраг сумын Тус сумын Сайн ус багийн нутагт үйл ажиллагаа эрхэлдэг “БИТИ ДЕВОЛМЕНТ” ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу суманд тулгамдаж байгаа мэргэжил болох малын эмчээр 1 хүнийг сургаж байна.</p>	
175	191. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулах;	2021 - 2024		иргэн-150, ААН-75	<p>Мал эмнэлгийн нэгдсэн системээр малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний хяналтыг тавьж ажилласан.</p> <p>2024 оны эхний хагас жилийн байдлаар малын гаралтай бүтээгдэхүүний 2813 ширхэг гэрчилгээ бичигдсэн. Адууны дэл, сүүл-1180кг, мах-235374кг, умс, цувдай 1220кг, Гахайн мах-750кг, Тахианы өндөг-1346640 ширхэг, Тэмээний арьс-411 ширхэг, ингэний хоормог- 30 литр, мах-107483кг, ноос 1100кг, Үхрийн мах- 149651кг, арьс 1590 ширхэг, сүү, тараг 193 литр, цувдаа 4565кг, Хонины мах- 555066кг, ноос -2000, цувдаа-5868кг, Ямааны арьс-36124 ширхэг, мах-275196кг, ноолуур 275196кг, арьс 36124 ширхэг, сүү, тараг 167 литр, цувдай 800кг бичигдсэн.</p> <p>Мал эмнэлгийн нэгдсэн системийн сургалтад 9 сумын мал эмнэлгийн тасгийн байцаагч, тархвар зүйч, мал амьтны эрүүл мэндийн албаны мэргэжилтнүүд цахимаар хянан баталгаажуулж ажилласан.</p>	100%
176	192. Малын гоц халдвар, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын ажлыг зохион байгуулахад мал эмнэлгийн нэгж, малчдын хамтын ажиллагаа, ур нөлөөг дээшлүүлэн	2021 - 2024		13 16 96%	<p>Тайлант хугацаанд мал, амьтны гоц халдварт 1 төрлийн өвчнөөр давхардсан тоогоор 8 суманд оношлогдож, нийт 278 толгой мал өвчлөн 10 толгой мал хорогдож, 78 лгой малын шинж тэмдэг арилж, 190 толгой малыг зориудын аргаар устгасан. Малын гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад Айраг, Замын-Үүд, Даланжаргалан сумын голомт, сэжигтэй бүсийн 10000 толгой хонийг дархлаажуулалтад хамруулан тайланг нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн.</p> <p>Өвчний гаралт, тархалт буурахгүй байгаатай холбогдуулан Мал эмнэлгийн Ерөнхий газраас 100,000 мянган</p>	100%

		малын өвчлөлийг бууруулах			<p>тун вакциныг дахин хуваарилан Айраг, Даланжаргалан, Иххэт, Сайхандулаан сумын голомт, сэжигтэй бүс болон халдварын эрсдэлийг бууруулах зорилгоор хамгаалалтын бүс үүсгэн 96600 толгой малыг дархлаажуулалтад хамруулах ажил явагдаж байна.</p> <p>Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтад 3889 өрхийн 75996 толгой мал, амьтныг хамруулахаар төлөвлөн 76800 вакциныг сумдад олгож эхлүүлсэн.</p> <p>Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт арга хэмжээг хэрэгжүүлэхэд 14 сумын 30 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн 42 малын их эмч, 1 малын бага эмчид арга зүйн зөвлөгөөг 2 удаа, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, холбогдох заавар зөвлөмжийн хүрээнд 790 малчинд өгч, хамтран ажилласан.</p> <p>Мал, амьтны гоц халдварт өвчний 9 тохиолдол 4 суманд оношлогдож өвчилсөн мал өмнөх оноос 53,3 хувиар, өвчлөл оношлогдсон сум 57,1 хувиар тус тус буурсан.</p>	
177		193. Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлж, халдварт бус өвчний шалтгаан нөхцөлийг тодорхойлж эрүүлжүүлэн, малын зүй бус хорогдлыг бууруулах	2021 - 2024	3 70% 1.5 /сая. тол/ 44.6 /мянга/ 2.5	<p>Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 2024 оны угаалга 767.9 толгой мал, туулгалт 265.5 толгой мал, боловсруулалт 288.5 толгой мал, гуурын боловсруулалт 21.6 толгой мал, нийт 1343.5 толгой мал хамруулах төлөвлөсөн.</p> <p>Цаг үеийн нөхцөл байдал хүнд байсны улмаас түр арга хэмжээ хойшлогдсон. Үхрийн арьс гууртах 828 толгой малыг хамруулсан байна.</p> <p>Аймгийн хэмжээнд зудын улмаас зүй бусаар хорогдсон 2652 өрхийн нийт 501796 толгой малын сэг зэмийг цуглуулан орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийн ажлын зохион байгуулан ажилласан. Малын халдварт өвчин хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор 119 устгалын цэг, 148 хашаа хороо, 44 өтөг бууц, 43 худаг ус, 29,1 мянган м2 бэлчээрт халдваргүйтгэл хийсэн.</p> <p>Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх идэвхтэй үзлэг тандалтыг 15 удаа хийж 1279,3, идэвхгүй үзлэг тандалтыг 32 удаа хийж 1845.1 толгой мал нийт давхардсан тоогоор 3,1 сая толгой малыг хамруулсан нь өмнөх онтой харьцуулахад 67,7 хувиар өссөн.</p> <p>Мал эмнэлгийн лабораторийн төлөвлөгөөт 5 төрлийн тандалт шинжилгээнд 28965 толгой мал, шинээр болон дахин сэргэж байгаа 4 төрлийн өвчний шинжилгээнд давхардсан тоогоор 129 малчин өрхийн 1590 толгой малыг хамруулсан.</p>	100%

178		194. Мал амьтны зооноз, шинээр болон дахин сэргэж байгаа өвчний тандалт, шинжилгээг тогтмолжуулж, зарим төрлийн өвчингүй тайван бүсийг баталгаажуулах;	2021 - 2024		10000 44.6 0	<p>Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 2024 оны угаалга 767.9 толгой мал, туулгалт 265.5 толгой мал, боловсруулалт 288.5 толгой мал, гуурын боловсруулалт 21.6 толгой мал, нийт 1343.5 толгой мал хамруулах төлөвлөсөн.</p> <p>Цаг үеийн нөхцөл байдал хүнд байсны улмаас түр арга хэмжээ хойшлогдсон. Үхрийн арьс гууртах 828 толгой малыг хамруулсан байна.</p> <p>Адууны ям, үхрийн сүрьеэ, бусад төрлийн өвчнүүдийн шинжилгээг хийхэд сөрөг дүнтэй гарч, эрүүл тайван бүсийг баталгаажуулсан.</p> <p>Монгол улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд аймгуудыг "Зоонозын төв"-тэй болгох зорилгоор Монгол Улсын Шадар Сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын 2023 оны А/18 дугаар тушаалаар 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын 2-р багт "Зоонозын төв" байгуулах чиглэл ирж, Сайншанд сумын Засаг даргын 2023 оны А/317 дугаар захирамжаар Зоонозын төв байгуулах барилгын 50000м<sup>2</sup> газрыг шийдвэрлэсэн.</p> <p>Сайншанд суманд "Зоонозын төв"-ийг байгуулснаар Замын-Үүд, Ханги хилийн боомтуудад "Зоонозын тандалтын нэгж"-үүдийг салбарлан байгуулахаар төлөвлөж, ЭМГ-т Зооноз хариуцсан нарийн мэргэжлийн эмчийг сургаж, хүний нөөцийг бэлтгэн ажиллуулж байна.</p>	100%
179	3.4.1. Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлнэ.	195. Аймгийн аялал жуулчлалын төлөвлөгөөг хэрэгжүүлж, жуулчдын тоог нэмэгдүүлэх;	2021 - 2024		100%/67000	<p>Говийн догшин ноён Хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойг угтан Ханбаянзүрх хайрханы гэрэлтүүлэг зам талбайг өргөтгөж, засварлах, Шамбалын орон, Ханбаянзүрх хайрхан орчимд нийтийн бие засах газрууд, Хамарын хийдийн Шамбалын орныг 108 агуйтай холбосон автозам, зогсоол хийх ажил, Сайншанд-Хамарын хийд чиглэлийн автозамын засвар шинэчлэл зэрэг ажлуудыг хийж орон нутгийн төсвөөс 2 тэрбум төгрөгийг зарцуулан жуулчдыг татах, аялал жуулчлалын бүсэд аялагчдын ая тухтай аялах нөхцөл боломжийг бүрдүүллээ.</p> <p>Аймгийн аялал жуулчлалын холбооны үйл ажиллагааг эрчимжүүлэх, шинэчлэн зохион байгуулалтад оруулах зорилгоор орон нутгийн аялал жуулчлалын бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл, Хамарын хийдийн хамгаалалтын захиргаа ОНААТҮГ нийт 23 иргэний уулзалтыг зохион байгуулж аймгийн аялал жуулчлалын холбооны удирдах зөвлөлийн 9 гишүүнийг шинээр сонгосон.</p>	90%

					<p>Аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Зочлох, үйлчлэх салбарын сургалт хөгжлийн төв” ТББ, “Монголын зочлох үйлчилгээний гэр холбоо” ТББ-ууд хамтран зочид буудал, зоогийн газар, дэн буудал, жуулчны баазын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад зориулж “Ковидийн дараах борлуулалтын хэв маяг” сэдэвт сургалтыг 2021 онд, 2022-2023 онд аялал жуулчлалын бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад 2 удаагийн хэлэлцүүлэг, 3 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 120 гаруй хүн хамрагдаж, сургалтын үр дүнд үйлчилгээгээ сайжруулсан.</p> <p>Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны төлөөлөгчид хилийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх уулзалт зөвлөгөөнийг 05 дугаар сарын 28-ны өдөр Замын-үүд суманд аялал жуулчлалын бизнес эрхлэгч, Дорноговь аймгийн аялал жуулчлалын холбооны гишүүдтэй уулзалт хийж, аялал жуулчлалын мэргэжлийн салбар холбоог байгуулах ажлыг зохион байгуулж, хилийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, хоёр улсын жуулчдыг аялуулах хүлээн авах талаарх хэлэлцүүлгийг мөн зохион байгуулсан.</p> <p>БНХАУ-ын жуулчдыг хүлээн авах талаар 2 тал нэгдсэн шийдвэрт хүрсэн нь Дорноговь аймгийг зорин ирэх гадаадын жуулчдын тоо, түүнийг дагасан эдийн засаг нэмэгдэх боломжтой юм.</p> <p>Энэ оны эхний хагас жилийн байдлаар "Хамарын хийд", "Ханбаян зүрх хайрхан уул"-ын орон нутгийн тусгай хамгаалалттай газарт нэвтэрсэн тасалбарын мэдээгээр дотоод 50300 гадаадын 225 нийт 50525 аялагч аялсан нь 2020 оны мөн үетэй харьцуулахад 58 хувиар өссөн байна.</p>	
180		196. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг шинэлэг байдлаар сурталчилах,	2021 - 2024	35%	<p>“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд Сайншанд 7, Замын-Үүд 2 нийт 9 жуулчны бааз, Сайншанд 8, Замын-үүд 11, Айраг 3, Алтанширээ1, Дэлгэрэх 1, Даланжаргалан 5, Хөвсгөл 2, Улаанбадрах 2, Мандах 1 нийт 34 зочид буудал, 16 гэр буудал, 9 хоолны газар, 2 сувиллын газрын мэдээллийг цахимд оруулснаас 6 буудал, 2 сувилал мэдээллийг QR кодоор оруулж, орон нутгийн аялал жуулчлалын 5 минутын видео танилцуулга бэлтгэж тус газрын <a href="https://do.mne.gov.mn/">https://do.mne.gov.mn/</a>, <a href="https://www.dornogovi.gov.mn/intro/">https://www.dornogovi.gov.mn/intro/</a> сайтад байршуулж олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан. Мөн <a href="http://www.touristinfocenter.mn">http://www.touristinfocenter.mn</a>, <a href="https://joinme.mn/">https://joinme.mn/</a> цахим сайтуудад орон нутгийн аялал, жуулчлалын гол бүс нутгуудын</p>	90%

					<p>танилцуулгыг оруулж 120000 гаруй хандалт авсан нь өмнөх оноос 8.2 хувиар өссөн.</p> <p>Монголын Үндэсний олон нийтийн Телевиз болон бусад IPTV-гээр 4 удаагийн 2 цуврал нэвтрүүлэг, 2 ярилцлага болон музейн сан хөмрөгийн хосгүй үнэт үзмэрийн талаарх мэдээллийг хүргэж ажилласан.</p> <p>Аймгийн DTV, Саран хөхөө театртай хамтран “Амттай аялал” нэртэй 3 цуврал нэвтрүүлгийг бэлтгэн телевизээр үзэгчдэд хүргэсэн. МҮОНРадиоогоор Дорноговь аймгийн Түүх соёлын хосгүй үнэт үзмэрийн талаар 2 удаагийн ярилцлагыг бэлтгэн аймаг орон нутгийн онцлогийг сурталчилсан.</p> <p>Монголын үндэсний олон нийтийн телевиз, Монголын мэдээ сонин, Post media цахим мэдээллийн сүлжээнд "13-р зуун" үзэсгэлэн болон түүх соёлын хосгүй үнэт үзмэрийн тухай баримтат киног 10 телевизийн сувгаар цацаж цахим сургалчилгааг хэрэгжүүлж ажиллалаа.</p>	
181	197. Үндэсний зан заншил, уламжлал, түүх соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг дэмжиж, хөгжүүлэх	2021 - 2024	4	<p>Соёлын аялал жуулчлал хөгжүүлэх чиглэлээр Алтанширээ сумын Соёлын төвтэй хамтран сумын төвд ойрхон дурсгалт газрыг түшиглэж аялал жуулчлалын маршрут гарган анхны аяллыг зохион байгуулсан.</p> <p>Музейн дэргэд "Эвийн эгшиг" уртын дууны дугуйлан, "Увдист ятга" ятга хөгжмийн дугуйлан хичээллэж байна. Үндэсний зан заншил, түүх, соёлыг хүүхэд залуучуудад түгээн дэлгэрүүлэх зорилгоор Музейн боловсролын хөтөлбөрүүдийг шинэчлэн "Зэр зэвсэг", "Монгол гэр", "Би зураач", "Миний монгол хувцас", "Мандала" зэрэг хөтөлбөрүүдийг Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхэд сурагчдад зохион байгуулж 2021-2023 онд 1516 хүүхэд, 2024 оны эхний хагас жилд 905 хүүхэд хамруулсан.</p> <p>2020 оноос эхлэн Сайншанд суман дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрууд, хөшөө дурсгалуудыг түшиглэн "Сити тур" хотын аяллын хөтөлбөрийг Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад зохион байгуулж хэвшсэн.</p> <p>Говийн догшин ноён Хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойн арга хэмжээг угтан Ханбаянзүрх хайрханы гэрэлтүүлэг зам талбайг өргөтгөж, засварлах, Шамбалын орон, Ханбаянзүрх хайрхан орчимд нийтийн бие засах газрууд, Хамарын хийдийн Шамбалын орныг 108 агуйтай холбосон автозам, зогсоол хийх, Сайншанд-Хамарын хийд</p>	90%	

					<p>чиглэлийн автозамын засвар шинэчлэлийн ажлуудыг хийж аялагчдын ая тухтай аялах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд анхаарч 2,0 тэрбум төгрөгийг зарцуулсан.</p> <p>“Лусын тамга”, “Талын салхи” мото фестиваль, “Сайншанд авто кросс-2023” уралдаан, “KHAMAR MONASTERY-2023” засмал замын болон уулын замын дугуйн уралдаан, “Их говийн тэмээ”-ний уралдааныг зохион байгуулсан.</p> <p>Хамарын тусгай хамгаалалттай газарт олгох тасалбарын мэдээгээр 2021 оноос 2024 оны хагас жилийн байдлаар нийт 225330 дотоод, 3015 гадаад аялагчдыг хүлээн авч үйлчилгээ үзүүлсэн нь 2020 оны мөн үетэй харьцуулахад дотоодын аялагч 44569-өөр нэмэгдсэн байна.</p>	
182	3.5.1. Эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлнэ	198. Сайншанд сумын дулааны станцын барилгын ажлыг эхлүүлэх	2021 - 2024	Барилгын ажил 10%	<p>Сайншанд сумын 7 дугаар багт Дулааны эх үүсвэр барих ажлыг орон нутгийн төсвийн 3,8 тэрбум төгрөгийн хөрөнгөөр “Чандмань-Илч” ХХК гүйцэтгэж, ашиглалтад оруулсан.</p> <p>Дулааны станц ашиглалтад орсноор 1000 айл өрхийг төвлөрсөн дулаан хангамжид холбох нөхцөл бүрдсэн.</p> <p>2023-2024 оны халаалтын улиралд хэвийн ажилласан. 2024 онд улсын төсвийн 5,9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр аймгийн төвийн дулааны станцын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэх тендер шалгаруулалтыг зарлаад байна.</p> <p>2024 онд орон нутгийн төсвийн 150,0 сая төгрөгийн санхүүжилтээр Айраг сумын дулааны 3 дугаар зуух, 178,0 сая төгрөгийн санхүүжилтээр Өргөн сумын уурын зууханд өргөтгөл шинэчлэлтийн ажлыг “Бэсүжин констракшн” ХХК тус тус гүйцэтгэж хүчин чадлыг нэмэгдүүлэн хэвийн ажиллагааг хангасан.</p>	100%
183		199. Чойр-Сайншандын 230 км урттай 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барихад дэмжлэг үзүүлж хамтран ажиллах	2021 - 2024	1	<p>Чойр-Сайншанд чиглэлд цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих зориулалтаар 2021 онд 7.8 га газрыг орон нутгаас шийдвэрлэж газрын гэрчилгээг олгосон.</p> <p>2022 онд ЦДАШ-ын холбогдох трассыг хянаж батлуулсан. Европын сэргээн босголтын банк, хөгжлийн банк хооронд байгуулсан “Чойр-Сайншандын 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих төсөл”-ийг 62,8 сая ам.долларын зээл болон 12,0 сая еврогийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p>2024 оны 05 дугаар сард төслийн нэгж орон нутгийн удирдлага, мэргэжлийн байгууллагуудын төлөөлөлтэй албан уулзалт хийж, трассын дагуу газар дээр нь ажилласан. Төслийг хэрэгжүүлэхэд орон нутгаас шаардлагатай бүхий л талын</p>	90%

					дэмжлэгийг холбогдох хууль, журмын хүрээнд үзүүлж, хамтран ажиллаж байна.	
184		200. Сайншанд сумын дулаан хангамжийг хоёрдогч хэлхээнд шилжүүлэх.	2022 - 2024	-	<p>Сайншанд сумын дулаан хангамжийг хоёрдогч хэлхээнд шилжүүлэх ажлын хүрээнд төв садны хашаанд 1, 4-р 58 байрны урд талд-1, 9 дүгээр цэцэрлэгийн баруун талд-1, 5-р 58 байрны хойно-1 ус дулаан дамжуулах төвийн нийт 4 барилгыг Эрчим хүчний яамны төслийн санхүүжилтээр "Одкон холдинг" ХХК, гадна шугам холболтыг Чандмань-Илч ОНӨХХК тус тус хийж гүйцэтгэн, 100% ашиглалтад оруулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд ус, дулаан дамжуулах 7 төвийг халаалтын улиралд ашиглаж дулааны станцын ачааллыг бууруулах, халаалтыг хэрэглэгчдэд жигд хүргэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.</p>	100%
185		201. Зарим сумын цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх судалгааны ажлыг хийж, үе шаттайгаар хэрэгжүүлж эхлэх.	2021 - 2024	Эрдэнэ сумыг Өргөн сумаас цахилгаан эрчим хүчээр хангах 42,1 км 35 кВ-ын ЦДАШ, дэд станцын барилгын ажлын гүйцэтгэл 100%	<p>Хөвсгөл сумын төвлөрсөн шугам сүлжээний гадна цахилгаан хангамжийн ажил, Улаанбадрах сумын ЦДАШ солих, дэд станц барих ажлын судалгааны дагуу зураг төслийг "Электро" ХХК боловсруулж, орон нутгийн төсвийн 295.1 сая төгрөгийн төсөвт өртөгөөр "Смарт Крафт" компани гүйцэтгэж ашиглалтад оруулсан.</p> <p>Хатанбулаг -Ханги чиглэлийн 100 км ЦДАШ барих ажлын зураг төсвийг орон нутгийн төсвийн 50,0 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгүүлж, цаашид ЦДАШ барих ажилд шаардагдах 17,9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2024 оны улсын төсөвт тусгуулах саналыг хүргүүлсэн.</p> <p>Тухайн бүс нутгийг төвийн цахилгаан эрчим хүчний сүлжээнд холбосноор хувийн хэвшил, бизнесийн үйл ажиллагаа өргөжих, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бий болох юм.</p> <p>Сайншанд сумын 7 дугаар багийн нутагт орон нутгийн төсвийн 1,4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр "Мандах наран-5" орон сууцны хорооллын гадна цахилгааны ажлыг орон нутгийн төсвийн 622,4 сая төгрөгийн хөрөнгөөр "Уртын уул" ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн.</p> <p>2024 онд орон нутгийн төсвийн 94,0 сая төгрөгийн санхүүжилтээр Иххэт сумын шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн угсралтын ажлыг "Эрчим" ХХК гүйцэтгэсэн.</p> <p>Улсын төсвийн 821,9 сая төгрөгийн хөрөнгөөр Сайншанд сумын шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчинд холбох ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендер зарлагдаад байна.</p>	100%

					<p>Хатанбулаг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 115,4 сая төгрөгийн санхүүжилтээр өмчлөлийн газарт цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажлын гүйцэтгэчийг шалгаруулах тендер зарласан.</p> <p>Тус аймгийн 14 сум нь төвийн цахилгаан эрчим хүчний нэгдсэн системд бүрэн холбогдсон ба 2020-2023 онд 60.52 км ЦДАШ, 37 дэд станц байгуулж, хүчин чадлыг 20 хувиар нэмэгдүүлж ажилласан.</p>	
186		202. Мандах, Сайхандулаан сумдад халаалтын зуух, нэгдсэн инженерийн шугам барих судалгааны ажлыг хийх.	2022 - 2024	Зураг төсвийн гүйцэтгэл 100%	<p>2023 онд орон нутгийн төсвийн 199,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мандах, Сайхандулаан сумдын төвд төвлөрсөн халаалт, цэвэр, бохир усны шугам барих ажлын зураг төсвийг боловсруулах ажлыг "Хайдро дизайн прожект" ХХК гүйцэтгүүлсэн.</p> <p>Мандах сумын төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ байгуулах ажлыг эхлүүлж тендер шалгаруулалтаар "Одконхолдинг" ХХК шалгарч ажлаа эхлээд байна.</p> <p>2020-2024 онд сумын төвийн нэгдсэн халаалтын зуух, нэгдсэн шугам сүлжээний зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, улсын төсвөөс 100,0 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Сумын Засаг Даргын А/89 дугаар захирамж, А/90 дугаар захирамжаар Халаалтын зуух болон цэвэрлэх байгууламжийг тус тус олгосон.</p>	70%
187	3.6.1. Зам, тээврийн сүлжээг байгуулж, дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ	204. Сайншанд-Баруун-Урт- Хөөт, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах.	2021 - 2024	-	<p>Боомтын сэргэлт төслийн хүрээнд хийгдэж буй Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашиг малтмал ашиглах зөвшөөрлийг нийт 232 байршилд аймгийн Засаг даргын 2022 оны А/204, А/369, А/624 тоот захирамжаар, харин Замын-Үүд хилийн боомтыг өргөтгөн шинэчлэхтэй холбогдсон автозам, төмөрзам, барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашиг малтмал ашиглах зөвшөөрлийг нийт 7 байршилд аймгийн Засаг даргын 2022 оны А/512, А/551, А/593 тоот захирамжаар олгож орон нутгаас бүхий л талаар дэмжин ажилласан.</p>	100%
188		205. Сайншанд, Замын-Үүд сумдын авто замыг өргөтгөх судалгааны ажлыг хийж, авто зам, замын	2021 - 2024	Төлөвлөгөөний хувь 100	<p>2021 онд замын сангийн 692,1 сая төгрөг, ОНХС-ийн 648,0 сая төгрөг, ОНТ-ийн 2,210.0 сая төгрөг, СОНХС-ийн 116,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын хэмжээнд 88 авто машины хүчин чадал бүхий авто зогсоол, 0.26 км хатуу хучилттай авто зам, 0.4 км явган хүний замыг шинэчилсэн.</p>	90%

		байгууламжид засвар шинэчлэлт хийх, шинээр барих.			<p>2022 онд орон нутгийн төсөв, замын сангийн 3717.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 7 байршилд шинээр автозам, авто зогсоол барих ажлыг хийж гүйцэтгүүлсэн.</p> <p>2023 онд орон нутгийн төсөв, замын сангийн 6,862,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 11 байршилд 270 машины автозогсоол, 4,3 км явган хүний болон дугуйн зам, 30,9 км авто замыг шинээр болон сэргээн засварлах , Замын-Үүд сумын 2 байршилд нийт 0,4 км хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтад оруулж авто замын сүлжээг өргөжүүлэн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулсан.</p> <p>2024 онд улсын төсвийн 4,7 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Замын-Үүд сумын төвд 2,15 км автозам, 12,4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Сайншанд сумын 2 баг Хамарын хийдийн 3 замын уулзвараас Зүүнбаян баг хүртэлх 20 км автозам барих ажлын гүйцэтгэгчээр "Борхойн зам" ХХК шалгарч, ажлыг эхлүүлээд байна.</p> <p>Орон нутгийн замын сангийн 1,4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 5 байршилд 2,35 км, орон нутгийн төсвийн 5,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 3 байршилд 2,9 км, нийт 5,25 км автозамыг шинээр барих, 3 байршилд 989,6 сая төгрөгийн санхүүжилтээр 3 байршилд авто зогсоол барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлагдаад байна.</p>	
189		206. Сум, суурин газрыг хатуу хучилттай авто замаар холбох судалгааны ажлыг хийж, барилгын ажлыг эхлүүлэх арга хэмжээг авч ажиллах.	2021 - 2024	-	<p>Сайншанд-Замын-Үүд чиглэлийн олон улсын чанартай хатуу хучилттай А0103 авто замаас Өргөн сум хүртэлх нийт 18,2 км хатуу хучилттай авто замын санхүүжилт шийдвэрлэгдээгүйн улмаас үлдээд байсан 9,3 км авто замыг улсын төсвийн 3,4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр "Дорноговь- АЗЗА" ТӨХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан орон нутгийн чанартай авто замын сүлжээг өргөжүүлэн иргэдийн аюулгүй, шуурхай зорчих нөхцөлийг бүрдүүлсэн.</p> <p>Улсын төсвийн 16,0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Сайншанд сумын 2-р баг, Хамарын хийдийн 3 замын уулзвараас Зүүнбаян баг хүртэлх 20 км хатуу хучилттай автозам барих ажлын гүйцэтгэгчээр "Борхойн зам" ХХК шалгарч, ажлыг эхлүүлээд байна.</p>	90%
190		207. Хот доторх нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг технологи	2023 - 2024	-	<p>Сайншанд хотын хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээг батлагдсан 3 чиглэлийн дагуу 25 хүний суудалтай, 3 автобус өдөр бүр 07:00-18:30 цагийн хооронд өвөл, хавар, намрын улиралд том хүн 400 төгрөг, хүүхэд 200 төгрөгөөр үйлчилгээ</p>	100%

		нэвтрүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх.				үзүүлж хэвшсэн бөгөөд жилд давхардсан тоогоор 15,000 гаруй зорчигчийг аюулгүй тээвэрлэсэн байна. Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж буй 3 автобусанд GPS, түлш хэмжигч төхөөрөмж суурилуулах ажлыг "Гайхам" ХХК гүйцэтгэж, орон нутгийн төсвийн 3,2 сая төгрөгийг зарцуулсан. 2020 онд Замын-Үүд сумын ОНТ-ийн 68,0 сая төгрөгийн хөрөнгөөр 25 хүний суудалтай автобусыг худалдан авч ЕБ-ын 1, 2, 3, "Үлэмж тэнгэр" сургуулийн сурагчдыг ажлын таван өдөр, өглөө 07:00-08:30, орой 17:30-18:30 цагуудад үнэ төлбөргүй гэр, сургуульд хооронд тээвэрлэн үйлчилгээ үзүүлж, давхардсан тоогоор өдөрт 250 гаруй зорчигч үйлчилгээ авч байна.	
191		208. Замын-Үүд суманд автотээврийн үйлчилгээний төв барих.	2023 - 2024		Барилга угсралтын гүйцэтгэл 50%	Замын-Үүд суманд байрлах улс хоорондын зорчигч тээврийн төвийг барих барилгын ажлыг 2023 онд суурийн блок болон ханын зутгуур, хучилтын хэсгийн битон болон армотурын ажлыг эхлүүлж, 2023 оны 10 сард хийгдсэн шинжилгээгээр дээрх ажлыг үргэлжлүүлэн барьж болох шийдвэрийг гаргасан. Барилгыг 2024 онд барьж дуусгахаар төлөвлөсөн төсөв батлагдаагүй. Уг ажлыг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүсээд байгаа тухай албан хүсэлтийг МУЗГ, Зам тээврийн хөгжлийн сайдад 2 удаа уламжлан хүргүүлсэн.	30%
192	3.7.1. "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтэц, хаягжилтын нэгдсэн системийг аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж, тэдгээрийн тоон мэдээллийг түгээх тогтолцоог үе шаттайгаар бий болгоно.	210. Хаягийн тэмдгийн суурилуулалтын ажлыг зохион байгуулж, хаягийн мэдээллийн нэгдсэн системд оруулан, олон нийтэд сурталчилах	2022 - 2024		4	Аймгийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн 208,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд, Улаанбадрах сумаас бусад сумдад 9021 хаягийн тэмдгийн суурилуулалтын ажил хийж, хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд оруулсан. "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглэнд нэвтрүүлэх тухай", "Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягжуулах журамд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2022 оны 180, 181 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталгаажуулаагүй гудамжийг баталгаажуулж, хаягийн мэдээллийн санд оруулах үүрэг, чиглэлийг өгснөөр гудамж зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмын дагуу шинээр 601 нэгж талбар, барилгыг дугаарлан хаягийн мэдээллийн системд бүртгээ аймгийн хэмжээнд 12 сумын төвд хаягжуулалт бүрэн хийгдээд байна. Энэ онд орон нутгийн төсвийн 30,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Улаанбадрах сумын төвийн хаягжуулалт хийх ажилд "Талст газар" ХХК шалгарч тус ажилд шаардлага тэмдэгийн захиалгыг БНХАУ-руу хүргүүлсэн.	100%

						<p>Замын-Үүд сумын хувьд шинээр хаягжуулах шаардлагатай гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах байр зүйн зураг боловсруулж дуссан.</p> <p>Мөн газрын хаягийн мэдээллийн сан үүсгэх ажлыг зохион байгуулж сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2024 оны 4-р улирлын хурлаар батлуулахад бэлэн болсон байна.</p>	
193		212. Газарзүйн нэрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан байгуулах	2022 - 2024		-	<p>Газарзүйн нэрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан байгуулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 14 сумын газар зүйн нэрийн зөвлөлийг сумдын Засаг даргын захирамжаар шинэчлэн байгуулж газар зүйн нэрийн тодруулалт хийх, мэдээллийн бүрдүүлэх ажлын даалгавар, төсөв, төслийг боловсруулж ГЗБГЗЗГ-т хүргүүлж батлуулсан.</p> <p>Сумдад газар зүйн нэрийн тодруулалт хийхээр орон нутгийн төсвийн 237.0 сая төгрөгөөр "Зарим сумдын газар зүйн нэрийн тодруулалт хийх" ажлын тендерт "Тэгш хэм групп" ХХК шалгарч 219,1 сая төгрөгөөр гэрээ байгуулан хийж гүйцэтгэж байна.</p> <p>2023 онд орон нутгийн төсвийн 219.08 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалт хийх, мэдээллийн бүрдүүлэх ажлыг "Тэгш хэм групп" ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн ба аймгийн 14 сумын хэмжээнд 1056 газарзүйн шинэ нэрийг тодруулан, нийт 11096 газарзүйн нэрийн мэдээллийн санг үүсгэн, үр дүнг сумдын газарзүйн нэрийн зөвлөл болон аймаг, сумын ИТХурлаар хэлэлцүүлэн, санал авч, тогтоолыг холбогдох байгууллагад хүргүүлээд байна.</p>	70%
194		213. Устсан геодезийн цэг тэмдэгтийг сэргээн засварлах ажлыг зохион байгуулж, геодезийн хэмжилт, зураглалыг хийж гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлэх	2022 - 2024		263	<p>Аймгийн Засаг даргын 2022 оны А/262 дугаар захирамжийн дагуу төрийн өмчийн үзлэг, тооллогын ажлын хүрээнд аймгийн хэмжээнд байрлаж буй геодезийн цэг, тэмдэгтийг нүдээр үзэж, тоолон бүртгэж, геопортал цахим системд оруулж, тооллогын бүртгэлийн үр дүнг тус газрыг 2022 оны 409 албан тоотоор ГЗБГЗЗГазарт хүргүүлсэн.</p> <p>Эзэн холбогдогч нь тодорхойгүй Айраг-53, Алтанширээ-5, Даланжаргалан-9, Дэлгэрэх-8, Замын-Үүд-9, Иххэт-13, Мандах-30, Өргөн-15, Сайхандулаан-20, Сайншанд-25, Улаанбадрах-18, Хатанбулаг-30, Эрдэнэ-11, Хөвсгөл-15 ширхэг нийт 261 ширхэг геодезийн цэг тэмдэгт устсан байна.</p> <p>Үүнтэй холбогдуулан пээрхустсан геодезийн цэг тэмдэгтийг сэргээн засварлахтай холбогдсон шаардагдах төсөв, ажлын даалгаврыг боловсруулан жил бүр сумдад хүргүүлэн ажилласан ба 2021-2024 онд Сайншанд суманд-2, Замын-Үүд суманд-1, Айраг суманд-3, Дэлгэрэх суманд-6, Сайхандулаан суман-10 нийт 22 цэг тэмдэгтийг сэргээн завсарлаж, геодезийн</p>	90%

					хэмжилт, зураглалыг хийж гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлэн ажилласан байна.	
195	3.7.2. Иргэд, олон нийтийн оролцоотой газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлтийн болон газрын кадастрын нэгдсэн ухаалаг системүүдийг орон нутагт нэвтрүүлнэ	214. Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийг газрын үнэлгээний системд оруулан, дүн шинжилгээ хийх	2021 - 2024		1345	90%
196		215. Газрын бүртгэлийн нэгдсэн системд эзэмшил, ашиглалт, өмчлөлд олгогдсон газруудыг бүрэн хамруулж, нөхөн бүрдүүлэлт хийх	2021 - 2024		100%	100%
197		216. Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг нэвтрүүлэх, боловсронгуй болгоход хамтран ажиллах	2021 - 2024		2 100%	100%

					Газрын зах зээлийн үнийн мэдээ цуглуулах үйл ажиллагааг газрын цахим биржээр олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлсэн.	
198		217. Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газрын кадастрын нэгдсэн ухаалаг системүүдийг бүрэн нэвтрүүлэх.	2022 - 2024	10000	<p>Монгол Улсын Засгийн газраас 2021-2024 онд “Цахим үндэстэн” болох зорилт дэвшүүлсний хүрээнд ГЗБГЗЗГазраас газар зохион байгуулалтын болон газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийн иргэд, олон нийтэд зориулсан цахим систем /www.egazar.gov.mn/-ийг 2021 оны 10 дугаар сарын 01-ээс албан ёсоор хэрэглээнд нэвтрүүлж, www.egazar.gov.mn веб хандалтат цахим хуудаснаас иргэд, олон нийт цаг хугацаа, орон зайнаас үл хамааран 72 төрлийн үйлчилгээг цахимаар авах боломжтой болсон.</p> <p>2024 оны байдлаар дээрх газрын удирдлагын нэгдсэн системд газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой нийт 52626 өргөдөл хүсэлт, тэдгээрийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг оруулсан бол газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан газар зохион байгуулалт, хот төлөвлөлттэй холбоотой 241 баримт бичгийн мэдээллийг оруулж, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэж ажилласан.</p> <p>Аймгийн хэмжээнд сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлыг газар зохион байгуулалт, төлөвлөлтийн системээр дамжуулан бүрэн цахимжаад байна.</p>	100%
199	3.7.3. Өрх гэр бүлийн худалдан авах чадварт нийцүүлэн орон сууцжуулах бодлого хэрэгжүүлнэ.	218. "Мандах наран" орон сууцны хорооллын төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2022 - 2024	2060	<p>Өрх гэр бүлийн худалдан авах чадварт нийцүүлэн орон сууцжуулах бодлогын хүрээнд Сайншанд сумын 7-р багт "Мандах наран-5" хорооллын 1152 айлын орон сууц барих төслийг "Гантулга трейд" ХХК хэрэгжүүлж нийт 384 айлын 6 блок орон сууцны барилгыг барьж 2023 оны 4-р улирал, 2024 оны 1-р улиралд бүрэн ашиглалтад оруулсан ба 48 айлын үйлчилгээтэй о/с*-2 блок/-ны барилгын ажлын гүйцэтгэл 95%-тай хувь хэрэгжиж байна.</p> <p>Сайншанд сумын 7 дугаар багийн нутагт баригдсан “Мандах наран-5” орон сууцны хорооллын 502В, 502Д блок 144 айлын орон сууц нь “Түрээсийн орон сууц”-ны ангиллаар төлөвлөгдөж орон нутгийн хөгжлийн сангийн 13,5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр "Гантулга трейд" ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан.</p> <p>Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 12/02, 12/03 дугаар тогтоолоор "Дорноговь аймгийн зорилтот бүлгийн иргэдийг түрээслээд өмчлөх орон сууцанд хамруулах журам", "Түрээсийн орон сууцны сум, баг, байгууллагад олгох хувь хэмжээ"-г тогтоон, түрээсийн орон сууцанд хамрагдах иргэдийн хүмэлтийг хүлээн авч, зохион байгуулах, удирдлага</p>	100%

					<p>зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллав.</p> <p>Замын-Үүд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт "Мандах наран-6" хорооллын 384 айлын орон сууц барих төслийг "Гантулга трейд" ХХК 2023 оны 10-р сараас эхлүүлээд байна.</p>	
200	219. Инженерийн шугам сүлжээнд холбогдсон сумдад орон сууц барина. /Айраг, Даланжар галан, Алтанширээ, Иххэт, Өргөн, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг,	2021 - 2024		262 /айл/	<p>Хатанбулаг суманд ОНТ-ийн 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 айлын орон сууц барих ажлыг "Аяа" ХХК гүйцэтгэж дуусан ашиглалтад оруулахад бэлэн болсон.</p> <p>Даланжаргалан суманд 36 айлын орон сууцны барилга барих ажлыг Жапан стандарт ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 90%-тай 2024 оны 06-р сард багтаан ашиглалтад оруулах төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байна.</p> <p>Улаанбадрах суманд Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны 296.5 сая төгрөгийн хөрөнгөөр "Гаднаа тоглоомын талбайтай төрийн албан хаагчийн 8 айлын орон сууц"-ны барилга угсралын ажлыг "Эко повер лайн инженеринг" ХХК гүйцэтгэж, ашиглалтад оруулан 8 төрийн албан хаагчийг орон сууцанд хамруулж, нийгмийн баталгааг хангасан.</p> <p>2023 оны орон нутгийн хөгжлийн сангийн 215,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хуучин хөгжлийн төвийн байрыг засвар хийж төрийн албан хаагчийн төвлөрсөн шугам сүлжээнд бүрэн холбогдсон 8-н айлын орон сууцыг бүрэн ашиглалтад оруулаж төрийн албан хаагчийг орон сууцаар хангаад байна.</p> <p>Мөн 2024 онд Улаанбадрах суманд төрийн албан хаагчийн 6 айлын орон сууц, Дэлгэрэх сумын Төвийн албан хаагчийн 6 айлын орон сууц барихаар шийдвэрлэж гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зарлахаар бэлтгэл ажлыг хангаж байна.</p>	100%
201	220. Сайншанд суманд "Тохилог хотхон" орон сууц барих хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжих	2021 - 2024		-	<p>Өрх гэр бүлийн худалдан авах чадварт нийцүүлэн орон сууцжуулах бодлогын хүрээнд Сайншанд сумын 7-р багт "Мандах наран-5" хорооллын 1152 айлын орон сууц барих төслийг "Гантулга трейд" ХХК хэрэгжүүлж нийт 384 айлын 6 блок орон сууцны барилгыг барьж 2023 оны 4-р улирал, 2024 оны 1-р улиралд бүрэн ашиглалтад оруулсан.</p> <p>Замын-Үүд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт "Мандах наран-6" хорооллын 384 айлын орон сууц барих төслийг 2023 оны 10-р сараас эхлүүлсэн. Сайншанд сумын 3 дугаар багт "Саруул талын өргөө" ХХК нь 9 давхар 90 айлын 2 блок орон сууцны барилгын төслийг хэрэгжүүлж эхний ээлжийн 45 айлын орон сууцыг 2023 оны 10-р сард ашиглалтад оруулсан. 2-р ээлжийн 45 айлын орон сууцны барилга угсралтын ажил 40%-тай үргэлжилж байна.</p>	90%

					<p>Мөн Сайншанд сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт "Нандин эрхэм" ХХК-аас 60 айлын орон сууцны барилга барих ажлыг эхлүүлэх хүсэлт ирүүлсний дагуу ажил эхлүүлэх зөвшөөрлийг олгоод байна.</p> <p>УБТЗ-ХНН-ээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Сайншанд зангилааны төмөр замчдыг орон сууцжуулах төслийг хамтран хэрэгжүүлэхээр санамж бичгийг байгуулан төсөл хэрэгжүүлэх газрыг ашиглуулах, гэрээнд зааснаар тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх эрхийг төсөл хэрэгжүүлэгч талд олгох баримт бичгийн ажлууд хийгдэж байна.</p>	
202	221. Засгийн газраас хэрэгжүүлж буй түрээсийн орон сууц хөтөлбөрт орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байуулах	2022 - 2024	-	<p>Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023.07.04-ний өдрийн 12/02 дугаартай тогтоолоор "Дорноговь аймгийн зорилтот бүлгийн иргэдийг түрээслээд өмчлөх орон сууцанд хамруулах журам"-ыг баталсан.</p> <p>2023 онд ОНӨГ-аас зарласан Түрээсийн орон сууц худалдан авах Багц-1 ажлын тендерт 13.5 тэрбум төгрөгийн өртөгөөр "Гантулга трейд" ХХК шалгарч, Сайншанд сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт Мандах наран-5 хороололд 72 айлын 2 блок, нийт 144 айлын орон сууцыг орон нутагт хүлээлгэн өгсөн.</p> <p>Тус ажлын 2-р багцад "Энержи парагон" ХХК шалгарч Сайншанд сумын 3-р багт 30 айлын орон сууц барих ажлыг 3.3 тэрбум төгрөгийн өртгөөр гүйцэтгэж байна. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад Замын-Үүд суманд Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэхээр 16.0 тэрбум төгрөг батлагдсан.</p> <p>Мөн Хатанбулаг сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд түрээсийн орон сууц засварлах ажилд 169.9 сая төгрөг батлагдсан бөгөөд аймаг орон нутгийн зүгээс Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж буй түрээсийн орон сууц хөтөлбөрийн хүрээнд зорилтод бүлгийн 144 өрхийг түрээслээд өмчлүүлэх орон сууцанд хамруулаад байна.</p>	100%	
203	222. Суурьшлын бүсэд дэд бүтэц бий болгох ажлыг судалгаанд тулгуурлан төлөвлөж үе шаттай хэрэгжүүлэх	2021 - 2024	100%	<p>Тус аймгийн 12 сум нь төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдсон ба 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар орон сууцны 5104, гэр хорооллын 284 өрх цэвэр ус, орон сууцны 4720, гэр хорооллын 210 өрх бохир усны, орон сууцны 4788, гэр хорооллын 231 өрх төвлөрсөн дулааны шугамд холбогдож аймгийн нийт айл өрхий 20 орчим хувийг эзэлж байна.</p>	90%	

					<p>Аймгийн хэмжээнд 2021-2023 онд нийт 26217 метр инженерийн шугам сүлжээг шинэчлэн засварлаж хэвийн үйл ажиллагааг хангасан. 2021 онд Алтанширээ, Дэлгэрэх сумд төвлөрсөн инженерийн хангамжид холбогдсон. 2022 онд Сайншанд сумын 7-р багийн нутаг дэвсгэрт шинээр суурьшлын бүсэд ОНТөсвийн нийт 12022.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар дулаан станц, цэвэр, бохир усны шугам, 1.59 км автозам, Өлзийт хорооллын айл өрхийг цахилгаанд холбох ажлыг хийж гүйцэтгэсэн. Хөвсгөл, Хатанбулаг сумд төвлөрсөн инженерийн хангамжид холбогдсон. 2023 онд орон нутгийн иргэдийг тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Иххэт сумын шинэ суурьшлын бүс болох "Барга" хороололд 04 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг орон нутгийн төсвийн 344,8 сая төгрөгийн хөрөнгөөр "ЭРЧИМ" ХХК гүйцэтгэж, 254 өрх цахилгааны эх үүсвэрт холбогдох нөхцөлийг бүрдүүлсэн.</p> <p>Сайншанд сумын 7 дугаар багт Дулааны эх үүсвэр барих ажлыг орон нутгийн төсвийн 3,8 тэрбум төгрөгийн хөрөнгөөр "Чандмань-Илч" ХХК гүйцэтгэж, 1000 айл өрхийг төвлөрсөн дулаан хангамжид холбох нөхцөлийг бүрдсэн. Хатанбулаг-Ханги чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажлын 2022 онд боловсруулсан зураг ТЭЗҮ боловсруулахад шаардагдах судалгаа, мэдээллийг холбогдох газарт хүргүүлсэн. Уг ажлыг гүйцэтгэхэд шаардагдах 17,9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2024 оны улсын төсөвт тусгуулахаар Сангийн яам, Эрчим хүчний яаманд тус тус хүргүүлсэн.</p> <p>2024 оны эхний хагас жилд нийт 116 техникийн нөхцөлийг олгосон.</p>	
204	3.7.4. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттай гаар нэмэгдүүлж, ашиглалтын дэвшилтэт технологи нэвтрүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.	223. Хуучны орон сууцнуудын инженерийн шугам сүлжээг шинэчлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх.	2021 - 2024	Төлөвлөгөөний биелэлтийн хувь 100 Иххэт сумын 6, Өргөн сумын 6 орон сууцны шугам сүлжээний шинэчлэлт 100%	<p>Аймгийн орон нутгийн төсвийн 147,512,000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 2 дугаар багийн Алтанговийн гудамж 100-1 дүгээр байр, Эрх чөлөөний гудамж 125 дугаар байрны зоорины давхрын сантехникийн засварын ажлыг "Ханбаянбуурал Чандмань" ХХК хийж гүйцэтгэн, 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээж авсан.</p> <p>2023 оны аймгийн орон нутгийн төсвийн 17,193,000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 108-р байр /мэргэжилтний 12 айл/-ны бохир усны шугам шинэчлэх ажлыг "Ханбаянбуурал чандмань" ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн.</p>	90%

					<p>Сайншанд сумын Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 3,903,000 төгрөгөөр Сайншанд сумын 7 дугаар багийн 136 дугаар байр буюу 40 айлын орон сууцны зоорины давхрын бохир усны шугам засварлах ажлыг иргэн Т.Батсайхан шууд гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн.</p> <p>Мөн тус нөөц хөрөнгөнөөс 19,140,000 төгрөгөөр Сайншанд сумын 8 дугаар багийн нутаг дэвсгэрт Залуус хорооллын чиглэлд дулаан худаг-102 худгаас дулаан худаг-99 худаг хооронд гадна дулааны шугам шинэчлэх ажил, 9,950,000 төгрөгөөр орон сууц, гэр хорооллын бохирын шугамд угаалга цэвэрлэгээ хийх ажил, 19,949,020 төгрөгөөр ДХ-214 худгаас ДХ-217 худаг хооронд гадна дулаан, цэвэр усны шугам шинэчлэх /Эрчмийн байрны 44 айл чиглэл/, 19,949,020 төгрөгөөр ДХ-217 худгаас ДХ-221 худаг хооронд гадна дулаан цэвэр усны шугам шинэчлэх /Эрчмийн байр 44 айл чиглэл/ ажлуудыг тус тус Чандмань илч ОНӨ ХХК -тай гэрээ байгуулсан.</p> <p>Ажлын гүйцэтгэл 100 хувьтай. Өргөн сумын төв дулааны шугамыг 2021 онд 145 сая төгрөгийн хөрөнгөөр 133 тай болгож өргөж шинэчилсэн.</p>	
205	224. Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, цэвэрлэх байгууламжаас гарсан саарал усыг дахин ашиглах боломжийг судалж хэрэгжүүлэх.	2021 - 2024	-	<p>Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН3388/3713 төсөл”-ийн хүрээнд хоногт 3000м3 бохир ус хүлээн авах хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн угсралтын ажлыг улсын төсвийн 6350.8 сая төгрөгийн төсөвт өртгөөр “Компорт импекс” ХХК гүйцэтгэж, 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдөр барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан. Тус цэвэрлэх байгууламж нь механик, биологи, гүйцэд цэвэрлэгээний технологитой ба цэвэрлэгдсэн усыг цэцэрлэг, зүлэгжүүлэлт, зам талбай, хөрсний усалгаанд ашиглахад зориулагдсан цооногтой. Мөн цэвэрлэгээний явцад гарсан лагийг боловсруулан бордоо, түлш гаргах тоног төхөөрөмжтэй жишиг байгууламж болсон.</p> <p>Тус цэвэрлэх байгууламж нь механик, биологи, гүйцэд цэвэрлэгээний технологитой ба цэвэрлэгдсэн усыг цэцэрлэг, зүлэгжүүлэлт, зам талбай, хөрсний усалгаанд ашиглахад зориулагдсан цооногтой ба эргэн тойрон хэсэгт эрүүл ахуйн аюулгүй бүсийг үүсгэсэн.</p> <p>Мөн цэвэрлэгээний явцад гарсан лагийг боловсруулж бордоо, түлш гаргах тоног төхөөрөмжтэй жишиг байгууламжтай болсон. Үүний дүнд хөрсний бохирдол үүсэх</p>	90%	

					<p>эрсдэл буурч, цэвэрлэх байгууламжаас гарсан хаягдал усыг дахин ашиглах боломж бүрдээд байна.</p> <p>Орон нутгаас цэвэрлэх байгууламжийн эрүүл ахуйн бүсийг тогтоон мөрдүүлэх, ойр орчмын газрын хөрснөөс дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэхээр бэлтгэл хангагдаж байна.</p> <p>Дорноговь аймаг, Япон улсын Шизоүка муж хоорондын хамтын ажиллагааны хүрээнд саарал усыг дахин ашиглах боломж, инженер техникийн ажилчдыг бэлтгэх, сургаж дадлагажуулах, туршлага судлуулах арга хэмжээг зохион байгуулж байна.</p>	
206	225. Зарим сумдын ус хангамжийн нөөцийн санг өргөтгөж, нөөцийг нэмэгдүүлэх.	2021 - 2024	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 50%	<p>Сумдын ус хангамжийн нөөцийн санг өргөтгөж, нөөцийг нэмэгдүүлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлж Айраг, Мандах, Сайхандулаан сумдаас бусад 11 сумыг 100-3000 м3 хүчин чадал бүхий цэвэр усны нөөцийн сан байгуулсан.</p> <p>2020-2024 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр Хөвсгөл, Хатанбулаг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх сумдад тус бүр 100 м3 хүчин чадалтай цэвэр усны нөөцийн сан шинээр байгуулсан.</p> <p>Улсын төсвийн 1983.5 сая төгрөгийн төсөвт төгрөгөөр Сайншанд суманд хоногт 3000 м3 ус нөөцлөх хүчин чадалтай цэвэр усны нөөцийн сан байгуулах ажлыг "Энержи парагон" ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.</p> <p>Замын-Үүд сумын хүн амын ундны усны нөөцийн 3000 м3 хүчин чадалтай усан сан байгуулах ажлыг улсын төсвийн 2,0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэхээр батлагдсан.</p>	100%	
207	226. Зарим сумдын цэвэрлэх байгууламж барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.	2021 - 2024	Айраг суманд шинээр барих цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын гүйцэтгэл 100%	<p>Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Сайншанд сумын Зүүнбаян баг, Өргөн, Айраг, Иххэт сумдад бага оврын цэвэрлэх байгууламж барих зураг төслийн ажлыг "Алтайн газрын хүч" ХХК гүйцэтгүүлэн 2021 онд хүлээн авсан.</p> <p>Даланжаргалан сумын ОНХС-гийн 294.0 сая төгрөгийн хөрөнгөөр цэвэрлэх байгууламж барих ажлыг "Аббадон констракшн" ХХК гүйцэтгэж, ашиглалтад оруулсан.</p> <p>Тус аймгийн Сайншанд, Замын-Үүд, Дэлгэрэх, Хатанбулаг, Хөвсгөл сумд нь хүчин чадлын хувьд харилцан адилгүй боловч цэвэрлэх байгууламжтай.</p> <p>Дорноговь аймаг, Японы Судуака муж хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Япон улсад зохион байгуулагдсан цэвэршүүлэх байгууламжийн ашиглалтын талаарх туршлага судлах, дадлага сургалтад орон нутгаас 2 төлөөлөл</p>	100%	

						хамрагдсан. Үүний үр дүнд Япон улсын "Жайка" ОУБ-ын төслийн хүрээнд зарим сумдад бага оврын цэвэрлэх байгууламж байгуулах боломжийг судлуулахаар холбогдох судалгаа мэдээллийг хүсэлтийн хамт хүргүүлээд байна.	
4. Засаглалын бодлого							
208		227. Төрийн байгууллагуудад цахим хэрэглээг үе шаттай нэвтрүүлж, мэдээллийг шуурхай солилцох нөхцөлийг сайжруулна.	2021 - 2024		28	<p>Аймгийн хэмжээнд 172 байгууллагыг төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системд нэвтрүүлсэн нь 98 хувьтай байна. Системийн ашиглалтыг нэмэгдүүлэхээр төрийн болон төрийн өмчит байгууллагуудын бичиг хэргийн ажилтан, мэдээлэл технологийн ажилтан, хүний нөөцийн ажилтнуудад Цахим хөгжил харилцаа холбооны яам, И-Монгол академи УТҮГ-тай хамтран ERP системийн ашиглалтыг сайжруулж ДОСХ дундын системд холбох, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 7 удаагийн сургалтыг зохион байгуулан нийт 540 албан хаагчийг хамруулсан.</p> <p>Мөн системд гарсан алдааг засварлах, ашиглалтын заавар зөвлөмжийг утсаар болон цахимаар дамжуулан давхацсан тоогоор 330 удаа өгч, нийт 320 албан хаагчдад мэдээлэл өгч ажилласан.</p>	100%
209	4.1.1. Төрийн үйлчилгээг шуурхай хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, төрийн цахим үйлчилгээг хөгжүүлнэ.	228. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг төрийн үйлчилгээнд нэвтрүүлж иргэд, байгууллагад үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулан хүртээмжийг нэмэгдүүлэх.	2021 - 2024		129, 1890,	<p>Аймгийн 15 төрийн байгууллагын 85 үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн (e-mongolia.mn) системд нэвтрүүлэн нийт 1800 үйлчилгээг 12461 иргэнд үзүүлсэн. Төрийн үйлчилгээний нэгдсэн "E-Mongolia", "E-business" системийг ашиглах, цахим ур чадварыг дээшлүүлэх, төрийн цахим үйлчилгээг сурталчлан таниулах сургалтыг 25 удаа зохион байгуулж нийт 1502 иргэн, 15 байгууллагын 208 албан хаагч хамруулсан.</p> <p>Нийт 458 төрлийн лавлагаа, мэдээллийг 51000 удаа гаргаж үйлчилсэн. "ХурДан" төв, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, татварын хэлтэс, газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, нийгмийн даатгалын газар, улсын бүртгэлийн газрууд цахимаар дамжуулан төрийн үйлчилгээг "e-mongolia.mn", "e-halamj.mn", "etax.mn", "e-gazar.gov.mn," "nd-daatgal.mn", "burtgel.gov.mn", "e-job.gov.mn" системүүдээр 6793 үйлчилгээг давхардсан тоогоор нийт 56120 иргэн, аж ахуй нэгжид үзүүлж, заавар зөвлөмжийг өгч ажилласан.</p> <p>Мөн төрийн үйлчилгээний лавлах "call center" үйлчилгээгээр дамжуулан төрийн болон төрийн өмчит 18 байгууллагын 45 төрийн үйлчилгээний талаарх мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлж нийт 1143 дуудлагад хариу өгч ажилласан. Тоон</p>	90%

					<p>бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, мэдлэг ур чадварыг дээшлүүлэхээр “И-Монгол академи”-ийн УТҮГ-ын газар, Улсын бүртгэлийн газартай хамтран “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийг сурталчлах ажлыг төрийн 900 албан хаагч, 52 аж ахуйн нэгж, байгууллага болон нийт 9540 иргэнийг хамруулан зохион байгуулсан.</p> <p>Улсын бүртгэлийн хэлтсээс иргэдэд тоон гарын үсгийг иргэний үнэмлэхэд суулгах ажлыг зохион байгуулж нийт 3988 иргэнийг тоон гарын үсэгтэй болгосон.</p>	
210		<p>229. Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг сайжруулж, иргэд, олон нийтийн оролцоог хангах.</p>	2021 - 2024	<p>Цахим хаягтай сум, байгууллагын тоо 14 сум, 28 агентлаг</p>	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн хэрэгжилтийн хүрээнд аймгийн хэмжээнд 60 байгууллага, 14 цэцэрлэг, 14 Сумын ЗДТГ, 6 сургуулиудад Shilen.gov.mn сайтын админ эрх нээж мэдээлэл байршуулах эрхийг нээж өгсөн.</p> <p>Төрийн байгууллагын ил тод байдлыг шалгах удирдамжийн дагуу 40 байгууллагыг хамруулан “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хэрэгжилт, иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн талаарх мэдээллийг албаны цахим хуудсанд тогтмол байршуулсан талаарх хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж ажилласан.</p> <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж нээлттэй мэдээллүүдийг нэг дороос авах нөхцөлийг бүрдүүлж dornogovi.gov.mn аймгийн цахим хуудсанд нээлттэй байхаар заасан 5 төрлийн 98 заалтын мэдээллийг байршуулж ажилласан.</p> <p>Аймгийн талаарх мэдээ мэдээлэл, аймгийн онцлог, бүтээн байгуулалт, амьдрах таатай орчин, аялал жуулчлал, бизнес эрхлэх боломж, газар зохион байгуулалт, ажлын байрны зар мэдээг авах боломжийг бүрдүүлсэн гар утасны "Нээлттэй Дорноговь" аппликейшныг бүтээж 2000 гаруй татагдан ашиглагдаж байна. Цаашид хөгжүүлэлт хийж төлбөр тооцоо, аймгийн төрийн цахим үйлчилгээ авах, аялал жуулчлалын чиглэлийн мэдээллийг авах, санал хүсэлт, санал асуулга гэх мэт нэг дороос аймгийн талаарх үйлчилгээ, мэдээллийг авах боломжийг бүрдүүлэхээр "Цахим Дорноговь" хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Мөн төрийн үйлчилгээний лавлах “Call center” үйлчилгээгээр дамжуулан төрийн болон төрийн өмчит 18 байгууллагын 45 төрийн үйлчилгээний талаарх мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлж нийт 1143 дуудлагад хариу өгч ажилласан.</p> <p>Төрийн өмчит 62 байгууллагыг албаны цахим хуудастай болгосон нь өмнөх оноос 4 байгууллагаар нэмэгдсэн бөгөөд аймгийн хэмжээнд 72 хувьтай байна.</p>	90%

					<p>Төрийн болон төрийн өмчит 46 байгууллага 2020 онд албан цахим хаяг ажиллуулж байсан нь аймгийн хэмжээнд 54 хувьтай байсан. 2024 онд 8 байгууллага албан цахим хаягтай болсон.</p>	
211		<p>211. Төрийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, ажиллах таатай нөхцөл боломжийг бүрдүүлнэ.</p>	2021 - 2024		<p>Дэлгэрэх сумын цаг уурын станцын барилга шинээр барих ажлыг 2022 онд 240.4 сая төгрөгөөр “Алъянстрейд ХХК” хийж, Замын-Үүд сумын 1-р багийн Иргэдийн хөгжлийн төвийн барилга барих ажлыг 796.5 сая төгрөгөөр “Мандах наран сүлжээ” ХХК хийж гүйцэтгэсэн. Сайншанд сумын 3-р багт Иргэдийн хөгжлийн төвийн барилга барих ажлыг 393.8 сая төгрөгөөр “Жи Ти Кей Эс” ХХК хийж гүйцэтгэсэн.</p> <p>ОНТ-ийн 596,4 сая төгрөгөөр 14 сум, агентлаг, төрийн байгууллагуудад ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах, ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тавилга, техник хэрэгслээр хангах, стандартын шаардлага хангасан өрөө тасалгааны хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл аюулгүй орчинд ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлсэн. Хатанбулаг 51.2 сая төгрөг, Эрдэнэ 57.7 сая төгрөг, Хөвсгөл 63.0 сая төгрөг, Улаанбадрах суманд 56.7 сая төгрөгөөр тус тус техник хэрэгсэл, лед дэлгэцийг худалдан авч, нийт 4 сумын Соёлын төвийн техник хэрэгслийг сайжруулахаар ОНТ-ийн 228.7 сая төгрөгөөр тохижуулсан.</p> <p>Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж цахим шилжилтийг эрчимжүүлэхээр сумдын ЗДТГ болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарт хэрэгцээ шаардлагад нь нийцсэн хүчин чадал сайтай 326 компьютер, техник хэрэгслийг ОНТ-ийн 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан. Сайхандулаан суманд 6 айлын орон сууцанд 3 байгууллагаас 6 залуу гэр бүл, Эрдэнэ суманд 27 айлын орон сууцанд төсвийн 5 байгууллагын 10 албан хаагчийг дэмжиж орон сууцаар хангасан.</p> <p>Ханги боомтод Төрийн албан хаагчийн 8 айлын орон сууц барих ажлыг 850.0 сая төгрөг, Улаанбадрах суманд Төрийн албан хаагчийн 6 айлын орон сууцны барилга барих ажлыг 480.0 сая төгрөг, Дэлгэрэх суманд Төрийн албан хаагчийн 6 айлын орон сууцны барилга барих ажлыг 480.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр 2024 оны төсөвт тусгасан. Төрийн байгууллагын ажиллах нөхцөлийг сайжруулж Онцгой байдлын газрын автомашины граш, Дэлгэрэх сумын цаг уурын станцын барилга шинээр барьж, аймгийн Цагдаагийн газрын өргөтгөл, Айраг, Сайхандулаан, Мандах, Иххэт, Сайншанд сумдын Засаг даргын Тамгын газрын барилгад шаардлагатай засварыг хийж нийт 12 төрийн байгууллагын ажиллах нөхцөлийг сайжруулан 942,0 сая төгрөгийг зарцуулсан. Мөн 6 суманд нийт 659,8 сая төгрөгийн автомашин, 227,5 сая төгрөгийн мотоцикл авсан байна.</p>	100%

212	4.1.2. Төрийн бодлогын залгамж чанарыг ханган, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлнэ.	230. Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, ажил үүргийн давхцал, хийдлийг арилгах бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлэх	2021 - 2024		39	<p>Сайншанд, Замын-Үүд сумдын Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Хот тохижилтын байгууллагын үйл ажиллагаанд чиг үүргийн шинжилгээ хийх үүрэг хүргүүлж, чиг үүргийн шинжилгээг асуулга, ажлын байрны зураг авалтын аргаар хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан ирүүлснийг үндэслэн, сумын Захирагчийн ажлын алба, Хот тохижилтын байгууллагыг нэгтгэх замаар чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах арга хэмжээ авч ажилласан.</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог чиг үүргийн оновчтой хуваарилж зарчмаар шинэчилж аймгийн Засаг даргын 2024 оны А/02 дугаар захирамжаар баталсан.</p> <p>Аймгийн Засаг даргын 2024 оны А/09 захирамжаар аймгийн Худалдан авах ажиллагааны газрын, мөн А/10 захирамжаар аймгийн Орон нутгийн өмчийн газрын бүтэц орон тоог тус тус шинэчлэн баталж, байгууллагуудын удирдлагын сонгон шалгаруулалтыг явуулж, томилон ажиллаж байна.</p> <p>Худалдан авах ажиллагааны газрыг 2023 онд багтаан шинээр байгуулан ажиллагсдын цалин хөлсний зардалд 11.2 сая төгрөгийг ОНӨГ-аас төсвөөс шилжүүлэн орон нутгийн 2023 оны төсвийн зохицуулалтаар шийдвэрлэсэн.</p>	90%
213		231. Орон нутагт дутагдалтай байгаа салбарын мэргэжлээр төрийн албанд шаардлагатай байгаа хүний нөөцийг бэлтгэх	2021 - 2024		70	<p>Орон нутагт боловсон хүчин бэлтгэх, эрэлттэй мэргэжлээр суралцагч оюутнуудыг дэмжих зорилгоор 2020-2024 онд инженер, боловсрол, соёл, урлаг, мэдээллийн технологи, мал эмнэлзүй, газрын тосны салбар, сувилагч зэрэг орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа 350 оюутанд 500,0 сая гаруй төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэгийг аймгийн Засаг дарга, Дорноговь аймгийн нутгийн зөвлөл, УИХ-ын гишүүдээс санхүүжүүлэн ажилласан.</p> <p>Сургалтын төлбөрийн дэмжлэгт хамрагдсан оюутнуудыг төгсмөгц орон нутгийн төрийн байгууллагад 90 хувийг нь ажлын байраар хангасан. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд хүний нөөцийн хангалт 82,6% байна.</p> <p>Орон нутгаас суралцах элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, нэн шаардлагатай мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх, төгсөгчдийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах үр дүнтэй хөшүүргийг бий болгох, нийгэм эдийн засгийн баталгааг хангах зэрэг асуудлуудыг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг дарга, АШУҮИС-ийн захиралтай хамтран ажиллах гэрээ байгууллаа.</p>	100%

					<p>МУБИС-д багш мэргэжлээр орон нутгаас суралцаж байгаа 1-4 дүгээр курсийн оюутнуудын судалгааг гаргаж, дутагдалтай байгаа дуу хөгжмийн багш мэргэжлээр суралцаж буй 9 оюутны сургалтын төлбөрийн тэтгэлгийг олгосон.</p> <p>Аймгийн хэмжээнд нийт 248 оюутныг төрийн байгууллагад дутагдалтай байгаа мэргэжлээр суралцах нөхцөл бололцоог хангаж, гэрээ байгуулан, төлбөрийг төлж, хөнгөлөлт үзүүлэн нийт 395.6 сая төгрөгийг зарцуулсан.</p>	
214		232. Төрийн байгууллагын сургалтын орчныг сайжруулж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах бодлого баримтлах	2021 - 2024		<p>Хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх ажлын байрны шаардлага, шалгуур хангасан боловсон хүчин бэлтгэх, төрийн албаны залгамж чанарыг бий болгох зорилгоор аймгийн төрийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг боловсруулсан.</p> <p>Хүний нөөцийн төлөвлөгөөний хүрээнд төрийн байгууллагын сургалтын орчинг сайжруулах чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: Удирдлагын академын богино, дунд болон урт хугацааны суралтуудад төрийн болон төрийн өмчит 52 байгууллагын 1200 гаруй албан хаагчдад танхимаар болон цахимаар суралцах боломжийг олгосон.</p> <p>2024 онд Удирдлагын академитай хамтран 14 сумын 65 багийн Засаг дарга нарыг чадавхжуулах зорилтот сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Мөн сумдын багийн хэсгийн ахлагч нарыг чадавхжуулах, мэдлэгийг дээшлүүлэх, тулгамдаж буй асуудлын талаарх хэлэлцүүлэг зохион байгуулан ажилласан.</p> <p>12 байгууллагын сургалтын танхимыг сургалт зохион байгуулахад тохиромжтой байдлаар тохижуулж техник хэрэгсэл, цахим сургалт зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд байгууллага бүр сургалт, сурталчилгааны төлөвлөгөөний дагуу 7 хоног бүр тогтмол албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж байна.</p>	100%
215		233. Төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлж, шинэ соёлыг төлөвшүүлэх	2021 - 2024		<p>Засаг даргын эрхлэх хүрээний 25 агентлагийн хяналт шинжилгээ үнэлгээ, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн 14 сумын хуулийн асуудал эрхэлсэн албан тушаалтнууд, боловсролын салбарын 21 багш, тусгай чиг үүргийн 36 ахлах болон дунд шатны офицер, байцаагч нарт мэргэжлийн болон хувийн зан төлөв, зарчимч, тууштай, ёс зүйтэй, ажил хэрэгч чанараараа манлайлах, бусдыг дэмжих,</p>	90%

					<p>чиглүүлэх хандлагыг телевизүүлэх сургалтыг 4 удаа зохион байгуулсан.</p> <p>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон төрийн албаны тухай хуулийн хүрээнд 24 байгууллагын 250 албан хаагчдад ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд төрийн болон төрийн өмчит 46 байгууллага ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулж үйл ажиллагаагаа явуулж байна. Тус хороодод шинэчлэгдсэн ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг хэрэгжүүлэх мэдлэг олгох сургалтыг танхимаар болон цахимаар 328 албан хаагчдыг хамруулсан.</p>	
216	234. Төрийн албанд жендэрийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлэх	2021 - 2024		100%	<p>"Жендерт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл "Дэвжээ" танин мэдэхүйн тэмцээн, "Хайраа хайрлая", "Хандлагаа өөрчилье", "Хамтдаа үлгэрлэе" зэрэг нөлөөллийн олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.</p> <p>Орон нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа "Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан", "Өнгө нэмье-дундын оффис", "Нийгмийн дархлаа холбоо" нийт 3 төрийн бус байгууллагуудтай хамтран 6 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээгээр 4300 гаруй иргэд, албан хаагчдад жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг сурталчлан, хамтын ажиллагааг өргөжүүлсэн.</p> <p>Сайншанд, Замын-Үүд, Өргөн, Хатанбулаг, Хөвсгөл, Алтанширээ, Иххэт сум болон аймгийн Цагдаагийн газар, ШШГГ, АШУҮИС-ийн оюутан, төрийн албан хаагч нийт 312 иргэнд жендерийн хэвшмэл ойлголтын хор уршгийн талаарх мэдлэг, мэдээллийг түгээж ажилласан.</p> <p>"Жендерт суурилсан хүчирхийлэл, түүний суурь шалтгаан", "Залуусын оролцоо-хотын хөгжил 2023" залуучуудын чуулганыг зохион байгуулж "Жендерийн хэвшмэл ойлголт" зэрэг сэдвээр сургалт хийж нийт 8 удаагийн сургалтаар 600 гаруй иргэн, албан хаагчдад мэдээлэл хийж, хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан.</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцэд "Жендэрийн тэгш байдал, салбар дундын бодлого хариуцсан мэргэжилтэн"-ний албан тушаалыг шинээр аймгийн Засаг даргын 2024 оны А/02 дугаар захирамжаар баталсан.</p>	100%
217	235. Орон нутгийн өмчийн бүртгэл,	2021 - 2024		143	Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн эд хөрөнгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 онд 49, 2021	100%

		ашиглалт, хамгаалалтыг сайжруулах				<p>онд 97, 2022 онд 149, 2024 онд 47 төсөвт байгууллагуудад эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалттай танилцан, анхан шатны бичиг баримтын бүрдлийг үзэж шалган илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд нь холбогдох хүмүүст танилцуулан цаашид гарсан зөрчил дутагдлыг арилгуулах талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.</p> <p>2021 онд 19 байгууллагын 900,7 сая төгрөгийн хөрөнгийг актлах, 14 байгууллагын 3,479,7 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, 5 байгууллагын 89.0 сая төгрөгийн хөрөнгийг худалдан борлуулах санал, 2022 онд 7 байгууллагын 501.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хэрэгцээтэй байгууллага руу нь балансаас балансад шилжүүлсэн.</p> <p>Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журмын дагуу 2020 онд 14 сумын 192 гэрээ, 2021 онд 126, 2023 онд 190, 2024 онд 126 гэрээг хянан баталгаажуулсан.</p> <p>Мөн 2020 онд орон нутгийн өмч эзэмшүүлэх гэрээг 146, 2021 онд 145, 2024 118 байгууллагатай байгуулсан байна.</p>	
218		4.1.2.5. Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, чадварлаг төрийн албыг бэхжүүлж иргэн төвтэй төрийн үйлчилгээг төлөвшүүлэх	2021 - 2024			<p>Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг байгууллага, 14 суманд чадахуйн зарчимд суурилсан төрийн албыг бэхжүүлж, иргэн төвтэй төрийн үйлчилгээг үзүүлж байна.</p> <p>“ХурДан” төв, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, татварын хэлтэс, газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, нийгмийн даатгалын газар, улсын бүртгэлийн газрууд цахимаар дамжуулан төрийн үйлчилгээг “e-mongolia.mn”, “e-halamj.mn”, “etax.mn”, “e-gazar.gov.mn,” “nd-daatgal.mn”, “burtgel.gov.mn”, “e-job.gov.mn” системүүдээр 6793 үйлчилгээг давхардсан тоогоор нийт 56120 иргэн, аж ахуй нэгжид үзүүлж, заавар зөвлөмжийг өгч ажилласан.</p> <p>Мөн төрийн үйлчилгээний лавлах “call center” үйлчилгээгээр дамжуулан төрийн болон төрийн өмчит 18 байгууллагын 45 төрийн үйлчилгээний талаарх мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлж нийт 1143 дуудлагад хариу өгч ажилласан.</p>	100%
219		4.2.4.4.Мэргэжлийн салбарын хяналт хяналт, шалгалтын хараат бус, шударга, ил тод байдлыг ханган үр нөлөөг нэмэгдүүлж,	2021 - 2024			<p>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны аравдугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрыг татан буулгах шийдвэр гарсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 469 дүгээр тогтоолоор салбарын хяналтын байцаагчдыг холбогдох яамд руу шилжүүлсэн. Тайлант хугацаанд 13 салбарын хяналтын</p>	100%

		хяналтыг сайжруулна.				<p>чиглэлээр 512 объектод төлөвлөгөөт шалгалт, аймгийн Засаг даргын захирамж болон иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас гомдол мэдээллийн дагуу 85 объектод төлөвлөгөөт бус шалгалт хийж гүйцэтгэсэн.</p> <p>Салбарын хяналтын газрын даргын баталсан урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийн дагуу 19 удаа 456 объектыг хамруулан нийт 948 объектыг хяналт шалгалт зохион байгуулсан.</p>	
220	4.2.1. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.	236. Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн ангиудад орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, хилийн торон саадыг шинэчлэх, хилчдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	2021 - 2024		100%	<p>Жил бүр "Хил хамгаалатад туслах хүчний зөвлөлийн төлөвлөгөөг батлан 2021-2023 онд тодорхой үр дүнд хүрсэн буюу 81-86 хувиар тус тус үнэлэгдсэн.</p> <p>Мөн Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн нэгдсэн зөвлөгөөнийг жил бүр онцлогтойгоор зохион байгуулж 2023 онд Замын-үүд суманд 0168 дугаар ангитай хамтран хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, эх орон үзэл, хандлагыг төлөвшүүлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>Түүнчлэн хилийн анги байгууллагуудад орон сууцны барилгын засвар, гадна, дотор сантехникийн засвар, байгуулагад шаардлагатай тоног төхөөрөмж, торон саадын засварлах зэрэг ажилд 2021 онд 240,0 сая төгрөг, 2022 онд 560,0 сая, 2023 онд 162,0 сая, 2024 онд 340,0 сая төгрөг нийт 1 тэрбум 302,0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. Үүний үр дүнд Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хилийн ангиудад орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, хилийн торон саадыг шинэчлэх, хилчдийн ажиллах орчин нөхцөл тодорхой хэмжээнд сайжирсан.</p>	90%
221	4.2.2. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	238. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгож, нутаг дэвсгэрийн онцлог, хүн ам, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал болон судалгаанд суурилсан ажил, арга хэмжээг	2021 - 2024		100%	<p>Орон нутгийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчилд жил, улирлаар дүн шинжилгээ хийж түүнд чиглэсэн хэсэгчилсэн ажил арга хэмжээг авч ажилласан бөгөөд дараах гэмт хэргүүд сүүлийн 4 жилийн байдлаар өссөн үзүүлэлттэй байна. Үүнд:</p> <p>1.Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2021 онд-243 буюу нийт гэмт хэргийн 49,5 хувийг, 2022 онд-335 нийт гэмт хэргийн 53,9 хувь, 2023 онд -340 буюу нийт гэмт хэргийн 51,8 хувийг, 2024 оны хагас жилийн байдлаар 213 буюу нийт гэмт хэргийн 50,5 хувийг тус тус эзэлж байна.</p> <p>2.Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2021 онд -19, 2022 онд-32, 2023 онд -42, 2024 оны хагас жилийн байдлаар -63 тус тус бүртгэгдсэн байна.</p>	100%

		төлөвлөн хэрэгжүүлэх			<p>3 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2021 онд 154, 2022 онд -186, 2023 онд 179, 2024 оны хагас жилийн байдлаар -90 тус тус бүртгэгдсэн. 4.Хүний бэлгийн эрх, эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2021 онд-12, 2022 онд -18, 2023 онд -32, 2024 оны хагас жилийн байдлаар-20 тус тус бүртгэгдсэн. Энэ хүрээнд Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбарын зөвлөл болон холбогдох чиг үүргийн байгууллагуудын зүгээс 40 гаруй төрлийн арга хэмжээгээр давхардсан тоогоор 62,0 гаруй иргэнийг хамруулсан. 2021 онд Хайр нэмье, Хүчирхийллийг хасъя” “ “Бүү март” “Тэвчье цэглэе арга хэмжээ, 2022 онд “Хүүхэд бүр хайрлагдах эрхтэй”, “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” ,”Соёлтой жолооч, соёлтой зорчигч”, “Намайг алгас”, “Зөвийг зөвлөө”арга хэмжээ, 2023 онд Та татгалз”, “Анзаар”, “Нэг зам нэг соёл”, “Хүүхэд хамгаалал”, “Уусан бол бүү жолоод”, “Аз жаргалтай гэр бүл зэрэг нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлж гэмт хэргийн тоон судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан ажилласан.</p> <p>Мөн хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, авлигын эсрэг гэмт хэрэг сүүлийн 4 жилд тогтмол буурсан үзүүлэлтэй байна.</p>	
222		239. Хяналтын камерийн нэгдсэн төвийг Сайншанд, Замын-Үүд сумдад байгуулах, бусад сумдад дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх.	2021 - 2024	100%	<p>Нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх зорилгоор камержуулалтыг нэмэгдүүлэх талаар жил бүр тодорхой төсвийг шийдвэрлэн ажилласан.</p> <p>2024 онд 2,2 тэр бум төгрөгийн санхүүжилтээр Сайншанд, Замын-Үүд суманд теле хяналтын төвийг шинэчлэх, өргөжүүлэх ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд Сайншанд суманд тодорхой 38 цэг байршилд 100 гаруй камер хэвийн ажиллаж байна.</p> <p>Мөн Сайншанд суманд 1,3 тэрбум төгрөгөөр 63 цэг байршилд 163 камер, сувагчлалын ажлыг /“Прожект девелопмент тотал солюшн” ХХК-/ гүйцэтгэхээр шалгарч 2024 оны 05 дугаар сард нээлтийн арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>Камержуулалтыг нэмэгдүүлснээр нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой бөгөөд аливаа гэмт хэрэг зөрчлийг илрүүлж, шуурхай арга хэмжээ авах нөхцөл боломж бүрдээд байна. Түүнчлэн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх камержуулалтаас гадна хувийн хэвшил, иргэн аж ахуйн нэгж байгууллагууд камержуулалтыг өөрсдийн нөөц боломжид тулгуурлан нэмэгдүүлж Гэмт хэрэг, зөрчлөөс</p>	90%

					<p>урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн хангахад санаачилга гаргаж байгаа нь сайн талтай байна.</p> <p>2021 онд бүх сумдын хяналтын камерын нэгдсэн судалгааг гарган 2024 оныг хүртэл шат дараатайгаар чанарын шаардлага хангасан камерыг нэмэгдүүлэхээр төлөвлөн ажилласан. Энэ хүрээнд: 2021 онд 169.799.000 сая, 2022 онд 620 сая, 2023 онд 135,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж нийт 924,799,000 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар камержуулалтын болон гэрэлтүүлэг шинээр нэмэгдүүлэх засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.</p>	
223		<p>240. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинэ түвшинд гаргаж, түр хамгаалах байрыг зарим суманд байгуулж, урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлэх</p>	2021 - 2024		<p>2021-2023 онуудад Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан 94.8 хувьтай хэрэгжилтийг үнэлүүлсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд түр хамгаалах байрны орчин нөхцөлийг сайжруулах тохижилт, засвар үйлчилгээ болон хууль, эрх зүйн зөвлөгөө, өмгөөлөл, эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэхэд 2021 онд -8,0 сая, 2022 онд -19,0 сая, 2023 онд 53,0 сая, 2024 онд 90 сая төгрөг нийт 170,0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлж санхүүжилтийг жил бүр нэмэгдүүлэн түр хамгаалах байрны үйл ажиллагааг хэвийн явуулж байна.</p> <p>"Түр хамгаалах байр"-нд 2021 онд 18 иргэн, 2022 онд 23 иргэн, 2023 онд 24 иргэн 2024 оны эхний 05 сарын байдлаар 11 иргэн, нийт 76 иргэнд тусгай хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хамгааллын үйлчилгээг үзүүлсэн.</p> <p>Түүнчлэн хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг шинэ түвшинд гаргах үүднээс Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийн зүгээс хүүхдээ үл хайхрах хүчирхийлэл үйлдсэн иргэдтэй биечлэн уулзаж, хууль тогтоомжоор хүлээсэн эх, эцэг байх үүргээ биелүүлэх талаар шаардлага тавьж, холбогдох хариуцлагыг хүлээлгэх, хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор багийн засаг даргатай хамтран гэрийн эргэлт, хамгааллын үйлчилгээг үзүүлсэн.</p> <p>Энэхүү ажил арга хэмжээ өмнөх онуудаас онцлогтой бөгөөд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийг таслан зогсоох, хүүхдийг хамгаалахад шуурхай удирдлага, арга зүйгээр хангаж, хариу арга хэмжээг цаг алдалгүй хүргэхэд шинэ алхам, арга барил болсон.</p>	90%

224		241. Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар замын хөдөлгөөнд оролцогчдын хандлага, соёл, дадал, хариуцлагыг дээшлүүлж, зам тээврийн ослыг бууруулах	2021 - 2024		100%	<p>"Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлж 2021-2023 онд төлөвлөгөөний хэрэгжилт 96.7 хувьтай үнэлэгдсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд авто зам шинээр барих, цэгт авто зогсоол шинээр барих, шинээр баригдсан автозамуудад хурд сааруулагч, замын тэмдэг тэмдэглэлээ, анхааруулах самбар байршуулах, такси үйлчилгээ эрхлэгчид, авто жолооны курс, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөлөл, жолооч иргэдийг хамруулсан уулзалт арга хэмжээг зохион байгуулах зэрэг ажилд 2021-2022 онд 52 сая, 2023 онд 33 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Түр хяналтын цэгүүдэд хэсгийн төлөөлөгч, сумын цагдаа нарыг цагийн менежментээр ажиллуулж, шалгалтаар 2021-2024 онд нийт давхардсан тоогоор 815.350 тээврийн хэрэгсэл шалгаж, 2021 онд- 22212, 2022 онд -22146, 2023 онд- 29767, 2024 оны -1 улиралд 7349 нийт зөрчил 81.474 илрүүлж зөрчил илрүүлж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шалгаж шийдвэрлэсэн.</p> <p>Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг /эрүүгийн хуулийн 27.1-27.11/ 2021 онд -19, 2022 оны- 32, 2023 оны- 42, 2024 оны эхний 4 сарын байдлаар 10 нийт 103 гэмт хэрэг бүртгэгдэж жил бүр өссөн үзүүлэлтэй байна.</p> <p>Энэ хүрээнд "Анхаар, хурдаа тохируул, Согтуугаар бүү жолоод, Хамгаалах бүсээ хэрэглэ, Жолооны ард утсаар бүү оролд, Хүүхдийн суудлыг хэрэглэж хэвшээрэй, "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ", "Соёлтой жолооч, соёлтой зорчигч гэх зэрэг улсын болон орон нутгийн хэмжээнд замын хөдөлгөөний соёл, дадал, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээг жил бүр зохион байгуулж нийт хүн амын 80 орчим хувьд хүрч ажилласан.</p>	90%
225		242. Цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг эрчимжүүлж, олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоог нэмэгдүүлж, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэн, гэмт	2021 - 2024		100%	<p>Цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг эрчимжүүлж, олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоог нэмэгдүүлж, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэн, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг дэмжин жил бүр шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмж, хувцас хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулсан.</p> <p>Мөн Монгол Улсын хэмжээнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өөрчлөлт орсонтой холбоотойгоор олон нийтийн цагдаагийн урамшуулал 1.150.000 төгрөг болгож нэмэгдүүлсэн.</p>	100%

		хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сурталчлах, соён гэгээрүүлэх ажлуудыг зохион байгуулах			<p>Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор олон нийтийн цагдаагийн орон тоог 33 болгон нэмэгдүүлэн баталсан.</p> <p>2021 оны жилийн эцсийн байдлаар 13 олон нийтийн цагдаа алба хааж байсан бол 2024 оны хагас жилийн байдлаар 20 олон нийтийн цагдаагийн алба хаагч ажиллаж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр явган, хөдөлгөөнт эргүүл, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нэгдсэн эргүүл, хяналтын цэгүүдэд цагдаагийн алба хаагчийн хамт үүрэг гүйцэтгэж согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 850, гудамж талбай, олон нийтийн газарт хэрүүл маргаан үүсгэж танхайрсан 215 нийт 1065 зөрчлийг илрүүлж эрх бүхий албан тушаалтан шилжүүлж, Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явсан архи согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн 240 иргэнийг ар гэр асран хамгаалагчид хүлээлгэн өгч ажилласан.</p> <p>Аймгийн цагдаагийн газрын олон нийтийн цагдаа нар нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр явган, хөдөлгөөнт эргүүл, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нэгдсэн эргүүл, хяналтын цэгүүдэд цагдаагийн алба хаагчийн хамт үүрэг гүйцэтгэж согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 175, гудамж талбай, олон нийтийн газарт хэрүүл маргаан үүсгэж танхайрсан 25 нийт 200 зөрчлийг илрүүлж эрх бүхий албан тушаалтан шилжүүлсэн</p>	
226		243. Соёл урлагаар дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэн, бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, зөв хэрэглээг төлөвшүүлэх сургалт сурталчилгааны ажлыг хийж, салбар дундын хамтын	2021 - 2024	100%	<p>Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2021-2024 оны хагас жил хүртэл 300 гаруй удаагийн үйл ажиллагааг зохион байгуулж 300000 хүүхэд багачууд, иргэд, олон нийтэд соёлын боловсролыг хүргэн ажиллалаа.</p> <p>Соёл урлагаар дамжуулан 2021 онд 15 гаруй ажлыг зохион байгуулж 51800 гаруй иргэдийг хамруулсан.</p> <p>2022 онд 24 удаагийн арга хэмжээг салбар дундын 20 гаруй төрийн болон хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулж 82000 гаруй иргэдийг хамруулсан.</p> <p>2023 онд 27 сургалт хүмүүжил, сурталчилгааны аянуудыг өрнүүлэн 100000 гаруй 26 арга хэмжээг зохион байгуулан 152 удаагийн сургалт, уулзалт хэлэлцүүлэг, 20 видео контент, 44 зурагт хуудас байршуулж 70000 гаруй иргэнд соёлын боловсрол олгож, 90 гаруй төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллалаа. 2024 онд Соёл,</p>	90%

		ажиллагааг бэхжүүлэх.				<p>урлагийн газар, БШУГ-тай хамтран соёл урлагаар дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх зорилгоор "Соёлын өдөр" арга хэмжээг батлан соёлын салбарын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж ажиллалаа.</p> <p>Арга хэмжээний хүрээнд ЕБС, СӨХ-ын байгууллагууд сар бүрийн сүүлийн өдөр соёлын боловсрол олгох угийн бичиг, уртын дуу, морин хуур, бий биелгээ, " Дээлтэй Монгол" "Би зураач" "Гэр" боловсролын хөтөлбөр, "Олуулаа уншъя" аян, зөөврийн номын сангийн үйлчилгээг үзүүлж хүүхэд, залууст зөв хандлагыг төлөвшүүлэн ажлуудыг хэрэгжүүллээ.</p> <p>Төв номын сан хүүхэд залуусын гар утасны хэрэглээг багасгах, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх 98 удаагийн соёл, олон нийтийн ажлыг цахимаар болон танхимаар зохион байгуулж 3315 хүүхэд залуус хамрагдлаа. "Монгол гэр-соёлын орон зай" арга хэмжээг 10 хоногийн турш аймгийн төв талбайд зохион байгуулж 1000 гаруй иргэдэд соёлын боловсрол олгосон. 2024 оны хагас жилийн байдлаар 30 гаруй соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж 40 гаруй аж ахуй нэгж, төрийн болон хувийн байгууллагуудтай хамтран ажиллаж 20000 гаруй иргэдийг соён гэгээрүүллээ.</p>	
227	4.2.3. Хууль сахиулах салбарын материаллаг баазыг бэхжүүлэх, албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.	244. Барилга байгууламжийг шинээр барих, засвар шинэчлэлт хийх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх	2021 - 2024		100%	<p>2021-2023 онд аймгийн Цагдаагийн газар болон Айраг сумын цагдаагийн газар, Тагнуулын Ерөнхий газрын Замын-Үүд дэх салбар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Улсын бүртгэлийн хэлтэст, аймгийн Тагнуулын хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт материаллаг баазыг бэхжүүлэх, хүүхдэд таатай орчин бүрдүүлэх зорилгоор хүүхдийн өрөөг тохижуулах зэрэг ажлуудад 2021 онд 387,6 сая, 2022 онд 201,4 сая, 2023 онд 1,1 тэрбум, 2024 оны хагас жилийн байдлаар 41,3 сая төгрөг нийт 1,7 тэрбум төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн байна.</p> <p>Үүний үр дүнд сум болон байгууллагуудад туулах чадвар сайтай 14 жийп машин, туулах чадвар сайтай мотоцикл 10 , хууль сахиулах салбарын материаллаг бааз нэмэгдэж, албан хаагчдын ажиллах орчин нөхцөл сайжирч эерэг үзүүлэлттэй байгааг харуулж байна.</p>	100%
228		245. Төрийн архивыг үндэсний санах ой архивын баримтын хадгалалт, хамгаалалтын	2021 - 2024		100%	<p>2021-2023 онуудад төрийн архивын үйл ажиллагаанд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тоо хэмжээг 12 ширхэг зориулалтын нягтруулсан шүүгээ, 2 ширхэг агааржуулалтын систем, 4 иж бүрэн суурин компьютер, 3 үйлдэлт принтер, нөөтбүүк тус бүр нэг ширхэг, 200 ширхгээр</p>	100%

		нөхцөл, аюулгүй байдлыг хангах			<p>нэмэгдүүлж, архивын аюулгүй байдлыг хангаж ажиллах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлсэн.</p> <p>Архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд мэдээлэл лавлагаанд өргөн ашигладаг баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажил үе шаттай хийгдэж байна.</p> <p>2021 онд Төрийн архивын программд 10 хөмрөгийн 15 дансны 347 хадгаламжийн нэгжийн 51752 хуудас баримтыг тодорхойлон бичиж, 18225 заалт, 48720 хүний нэр шивж, мэдээллийн сан үүсгэсэн. 2022 онд 11 хөмрөгийн 9 дансны хадгаламжийн нэгжийн 40405 хуудас баримтыг скайнердаж, хамгаалалтын хувь үйлдэв. Хамгаалалтын хувиас 148 хадгаламжийн нэгжийн 19761 хуудас баримтыг фотошоп программаар засварлаж, ашиглалтын хувь үйлдэж, төрийн архивын програмд 10 хөмрөгийн 10 дансны 205 хадгаламжийн нэгжийн 28692 хуудас баримтыг тодорхойлон бичсэн.</p> <p>Программд 13377 заалт, 24888 хүний нэр, 1406 байгууллага, 702 газар зүйн нэр шивэгдэж, мэдээллийн сан үүссэн.Төрийн архивын 2023 оны цахимжуулалтын ажлын төлөвлөгөөний дагуу 30 хөмрөгийн 40 дансны 532 хадгаламжийн нэгжийн 40246 хуудас баримтыг скайнердан, фотошоп программаар засварлаж хамгаалалтын хувь үйлдэв. Хамгаалалтын хувь үйлдсэн 29 хөмрөгийн 39 дансны 511 хадгаламжийн нэгжийн 38529 хуудас баримтыг программд тодорхойлон бичиж, цахим мэдээллийн сан үүсгэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад программд оруулсан баримтын тоо 9837 хуудас буюу 1,3 хувиар өссөн үзүүлэлттэй байв.</p> <p>2024 оны эхний хагас жилийн байдлаар 8 хөмрөгийн 9 дансны 153 нэгжийн 16300 хуудас баримтыг скайнердаж, хамгаалалтын хувь үйлдэн,төрийн архивын програмд 8 хөмрөгийн 9 дансны 150 хадгаламжийн нэгжийн 16020 хуудас баримтыг тодорхойлон бичсэн.</p>	
229	4.2.4. Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний	246. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн, бэлэн байдлыг хангаж, гамшгийн эрсдэлийг бууруулах	2021 - 2024	Гамшгийн эрсдэлийг бууруулах үнэлгээ хийлгэсэн сумын тоо 2	<p>Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль, Монгол улсын Шадар сайд аймгийн Засаг даргатай байгуулсан төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, аймгийн Засаг даргын захирамжийн дагуу гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургуулийг 7 суманд, Команд штабын сургуулийг 4 суманд, Бэлэн байдлын үзлэгийг 6 суманд зохион байгуулж, сумдын Онцгой комисс, Засаг даргын Тамгын газар, аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулан олон нийтийн</p>	100%

	нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.				<p>оролцоонд суурилсан гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж, тухайн орон нутгийн эрсдэл, эмзэг байдалд суурилан орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг сайжруулах, эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.</p> <p>“Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагаас орон нутгийн гамшгийн эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх, иргэдийн амьжиргааг хамгаалах, тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих, уур амьсгалаас үүдэлтэй гамшгийн эрсдэлийг даван туулах чадвар бүхий орон нутаг болоход дэмжлэг үзүүлэх зорилгоор “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг” төслийг 2022-2025 он хүртэл 3 жилийн хугацаатай Иххэт, Хатанбулаг, Сайншанд сумдад хэрэгжүүлж байна.</p> <p>Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, "Нийслэлийн Засаг даргын тамгын газар хамтран Газар хөдлөлтийн гамшиг тохиолдож, онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа” сэдэвт стратегийн команд штабын сургуулийг 2023 оны 06 дугаар сард зохион байгуулахад аймгийн Засаг даргын 2023 оны "Ажиллагааны удирдлагын төв байгуулж, бүрэлдэхүүнийг батлах тухай" А/351 дүгээр захирамжаар байгуулагдсан 103 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнээр оролцож, өгөгдсөн цагийн байдалд хариу арга хэмжээ авч ажилласан.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 336 дугаар тогтоолоор Алтанширээ, Хөвсгөл, Хатанбулаг сумдад гал унтраах зориулалттай 2 тээврийн хэрэгсэл, 1 төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн.</p>	
230		247. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн гамшгаас хамгаалах арга хэмжээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	2021 - 2024	2	<p>Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340, 2017 оны 67 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу “Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”, “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургууль”-ийг жил бүрийн 03 дугаар сард нийт 4 удаа зохион байгуулахад 14 сумын 96 аж ахуй нэгж, давхардсан тоогоор 29332 ажилтан, алба хаагч, иргэн оролцож, гамшгаас хамгаалах мэдлэг чадвараа дээшлүүлсэн.</p> <p>Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, "Нийслэлийн Засаг</p>	100%

					<p>даргын тамгын газар хамтран Газар хөдлөлтийн гамшиг тохиолдож, онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа” сэдэвт стратегийн команд штабын сургуулийг 2023 оны 06 дугаар сард зохион байгуулахад аймгийн Засаг даргын 2023 оны "Ажиллагааны удирдлагын төв байгуулж, бүрэлдэхүүнийг батлах тухай" А/351 дүгээр захирамжаар байгуулагдсан 103 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнээр оролцож, өгөгдсөн цагийн байдалд хариу арга хэмжээ авч ажилласан.</p> <p>Аймгийн Засаг даргын орлогчийн баталсан удирдамжийн дагуу 2023 онд Онцгой байдлын газар, “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагын “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг” төсөл хамтран Сайншанд, Хатанбулаг, Иххэт сумдад олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж, үнэлгээнд тулгуурлан, нийт 151,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, мөнгөн дэмжлэгийг олгосон.</p> <p>Гамшгаас хамгаалах тухай болон Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх хэрэгцээ шаардлага, Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, Аврагч мазаалай сэдвээр 37 цагийн хугацаатай танхимын сургалтыг боловсролын 17 байгууллагад зохион байгуулж, багш, ажилчид, хүүхэд, багачуудын төлөөлөл бүхий 285 хүнийг хамруулсан.</p>	
231		248. Цаг агаарын аюулт үзэгдэл, гамшгийн үеийн мэдээллийг амжиж анхааруулах системээр дамжуулан малчид, иргэдэд шуурхай хүргэх ажиллагааг сайжруулах	2021 - 2024	60000	<p>Онцгой байдлын ерөнхий газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөс ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг тухай бүр хүлээн авч, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга болон холбогдох албан тушаалтанд цахимаар шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж, иргэд, малчдыг болзошгүй цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангах талаар заавар, зөвлөмж өгч ажиллаж байна.</p> <p>Байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийг эрт мэдээллэж, сэрэмжлүүлэх, амжиж анхааруулах “Масс мессеж” үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар үүрэн холбооны Мобиком, Скайтел компаниудтай гэрээ байгуулан, сэрэмжлүүлэх мэдээллийг давхардсан тоогоор нийт 256985 иргэн, малчинд хүргэсэн.</p>	100%

					Мөн тайлант хугацаанд Онцгой байдлын газрын пэйж болон фэйсбүүк хуудаст давхардсан тоогоор 201 удаагийн сэрэмжлүүлэг, анхааруулах мэдээллийг байршуулж, олон нийтэд хүргэж ажиллалаа.	
232	4.3.1. Хөрш болон өндөр хөгжилтэй орнууд, олон улсын байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, гадаад харилцааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	250. Хөрш болон өндөр хөгжилтэй орнуудтай уламжлалт харилцаагаа үргэлжлүүлж, шинээр бусад улсуудын муж, хотуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх.	2021 - 2024	15	<p>2024 онд Дорноговь аймаг БНХАУ-ын Ляонин мужтай, тус аймгийн Сайншанд сум/хот БНХАУ-ын Ляонин мужийн Жинжоу, Пенжоу хотуудтай, Замын-Үүд сум БНХАУ-ын Хөбэй мужийн Жанжякоу хоттой тус тус Харилцан ойлголцлын “Санамж бичиг” байгуулан хамтран ажиллахаар зөвшилцөж байгаа бөгөөд санамж бичигт зөвшөөрөл авах, хамтын ажиллагаа, айлчлалын санал хүргүүлэх тухай албан бичгүүдийг тухай бүр Гадаад харилцааны яамны холбогдох газруудад хүргүүлэн “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Оросын Холбооны Улсын Эрхүү мужтай эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, боловсрол, аялал жуулчлал, соёл урлаг болон бусад салбарт найрсаг, түншлэлийн харилцааг хөгжүүлэх, өөрийн аймгийн онцлогт тулгуурлан хамтран ажиллах тухай санамж бичгийг байгуулсны дагуу ойрын хугацаанд хамтран хэрэгжүүлэх боломжтой ажлын саналыг аймгийн Засаг даргын 2024 оны 01/215 дугаар албан бичгээр хүргүүлсэн бөгөөд энэ хүрээнд тус онд багтаан багш, сурагчдын солилцооны хөтөлбөрийг дахин сэргээхээр бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p>Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хүрээнд уул уурхай, дэд бүтэц, хөдөө аж ахуйн салбарт бүс нутгийн түвшинд хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх зорилгоор Дорноговь аймаг нь АНУ-ын Миннеаполис хоттой эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг эрчимжүүлэх, ардчилал хүний эрхийг хөгжүүлэх, бизнесийн салбарын түншлэлээ өргөжүүлэх түүнчлэн боловсрол соёлын холбоогоо бэхжүүлэх зэрэг олон чиглэлээр хамтран ажиллах саналыг Монгол Улсын Гадаад харилцааны яам болон Америкийн Нэгдсэн Улсын Чикаго хотод суугаа Консулд аймгийн Засаг даргын 01/641, 01/642 албан бичгээр тус тус хүргүүлээд байна.</p>	100%
233		251. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг гадаад орнуудын	2021 - 2024	20	Монгол Улсын Зэвсэгт хүчин, БНХАУ-ын Ардын чөлөөлөх армийн Хуурай замын цэргийн хамтарсан “Талын түнш-2024” хээрийн сургуулийг тус аймгийн нутаг дэвсгэрт зохион байгуулсан ба хоёр орны найрамдал харилцааг хөгжүүлж,	90%

		<p>ижил төстэй байгууллагуудтай холбож, үр ашигтай хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд бодлогоор дэмжих</p>			<p>цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, харилцан туршлага солилцох, суралцах, бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хангахад хоёр орны хүчин чармайлтыг нэмэгдүүлэх зорилготой тус сургуульд 2 улсын 500 гаруй алба хаагчид оролцож, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж 400 гаруй нарс модноос бүрдсэн “Найрамдлын төгөл”-ийг байгуулсан.</p> <p>БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хот, Дархан Муу Мянган Холбоот хошуутай эртнээс найрамдалт харилцаа, хамтын ажиллагаагаа амжилттай үргэлжлүүлж ирсний зэрэгцээ сүүлийн жилүүдэд эрүүл мэнд, асран сувилахуйн салбарт үр дүнтэй гадаад хамтын ажиллагааг явуулахаар зорин ажиллаж байгаагийн хүрээнд тус салбарын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, эмч мэргэжилтэн, туршлага солилцох, хүнд өвчтөний асуудлыг хамтран шийдэх чиглэлээр хот, хошууны Монгол эмнэлгийн 20 гаруй эмч, эмнэлгийн ажилтны төлөөллийг энэ оны 08-р сард хүлээн авахаар урилга хүргүүлэн, бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p>Аймгийн БОАЖГ, Япон улсын Жайка түншлэлийн хөтөлбөрийн хүрээнд Сайншанд суманд “Гүн суулган тарих аргаар Дорнын говийн цөлөрхөг бүсийн хуурай газар нутгийг ургамалжуулах ажлыг дэмжих техникийн хамтын ажиллагааны төсөл” 3 жилийн хугацаатай хэрэгжиж байгаа ба говийн хэт хуурай бүс нутагт орших Сайншанд орчмын газар нутгийг ургамалжуулахад тохирсон технологийг сайжруулах, гүн суулган тарих арга ашиглан говийн унаган мод, ургамлын суулгац бэлтгэх, мэдлэг олж авах онол, дадлага хосолсон сургалтуудыг улирал тутам зохион байгуулж, одоогийн байдлаар нутгийн унаган ургамал болох Заг, Хайлаас, Сухай, Бүйлс, Харгана, Шээрэнгэ зэргийг хүлэмжид үржүүлж, 1 м 50 см-ийн гүн нүхэнд гүнээс услах технологиор тарилтыг хийж буй бөгөөд ургалт 100%-тай байна.</p>	
234		<p>252. Хүний хөгжил, нийгэм, эдийн засгийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэх.</p>	2021 - 2024	4	<p>“Гүүр” төсөл, хөтөлбөрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлж эхлээд байна.</p> <p>Төсөл, хөтөлбөрийн хүрээнд сум, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор Иххэт суманд “Оролцоонд суурилсан орон нутгийн стратеги төлөвлөгөө” боловсруулах ажил, сургалтын байгууллагын орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургууль, Политехник коллежийн лаборатори, практик сургалтын</p>	90%

					<p>танхимыг сайжруулах төсөл болон гадаадын их, дээд сургуулиудын тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.</p> <p>Төлөвлөгөөний дагуу орон нутагт эрэлттэй мэргэжлээр гадаадын их, дээд сургуульд суралцах хүсэлтэй 132 суралцагчийн судалгааг гаргасан. Судалгаан дээр үндэслэн хөтөлбөрийн хүрээнд тэтгэлэгт хамруулах үйл ажиллагааг 2024 оны 09 дүгээр сараас зохион байгуулахаар төлөвлөсөн.</p>	
235	4.4.1. Батлан хамгаалах тогтоомжийн хэрэгжилтийг байгуулах.	Батлан хууль зохион	4.4.1.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах аймгийн бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлэх	2021 - 2024	<p>"Үндэсний аюулгүй байдлыг орон нутгийн түвшинд хангах бодлого"-ыг Оршин тогтнохын аюулгүй байдал, Эдийн засгийн аюулгүй байдал, Дотоодын аюулгүй байдал, Хүний аюулгүй байдал, Хүрээлэн буй орчны аюулгүй байдал, Мэдээллийн аюулгүй байдал гэсэн тэргүүлэх чиглэлтэйгээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 52 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд жил бүр төлөвлөгөө боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд 11 зорилт, 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар 85,3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн ба холбогдох агентлаг, сумдаас мэдээлэл авч жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг тайлагнаж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 14 дүгээр хуралдаанд танилцуулж мэдээлэл хүргэсэн.</p> <p>2023 оны 05 дугаар сард Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээллээр хангах орон тооны бус зөвлөлийн хурлыг зохион байгуулж 2 удаагийн сургалтыг зохион байгуулснаар хуулиар хүлээсэн чиг үүргийн байгууллагуудын мэдээ, мэдээллийг цаг тухайд нь хүргэж хагас, бүтэн жилээр мэдээллийн сан үүсгэсэн.</p> <p>Хөтөлбөрийг хэрэгжилтийн үр дүнд Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийн байгууллагуудын уялдаа холбоо сайжирч, ажил үүргийн давхардал арилсан. Мөн Монгол Улсын хууль тогтоомж, эх орон ч үзэл төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээгээр дамжуулж иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн.</p>	90%
236			4.4.1.2. Батлан хамгаалах салбарын бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ.	2021 - 2024	<p>Батлан хамгаалах бодлого Зэвсэгт хүчний үйл ажиллагааг орон нутагт сурталчлах зорилгоор орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны ой, Ардын хувьсгалын ой, Улс тунхагласны ой, олон улсын Энхийг сахиулагчдын баяр, зэрэг томоохон ойн баяр тэмдэглэлт өдрүүдээр Дорноговь аймгийн Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагуудын дунд</p>	100%

					<p>болон хүүхэд залуус, ард иргэдийн дунд тэмцээн уралдаан, уулзалт өдөрлөг, танилцуулга зэргийг тогтмол зохион байгуулж хэвшсэн.</p> <p>Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулан баталгаажуулсан.</p> <p>Засгийн газрын тогтоол батлан хамгаалахын сайдын тушаалаар "Оюутан цэрэг" сургалтад Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны салбар сургуулийн нэгдүгээр курсийн 5, Политехникийн коллежийн 9 нийт 14 оюутныг сонгон шалгаруулж сургалтын "Цэргийн ерөнхий бэлтгэл" шатны сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Хүүхэд залуучуудад цэрэг эх-оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээний нэгдүгээр шатыг ерөнхий боловсролын сургуулиуд 2023 оны 05 дугаар сарын 10-ны дотор сургууль тус бүр дээрээ, хоёрдугаар шат буюу аймгийг аварга шалгаруулах тэмцээнийг аймгийн Засаг даргын 2023 оны А/237 дугаар захирамжаар 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр аймгийн төв талбайд тус тус зохион байгуулсан бөгөөд тэмцээнд аймгийн ерөнхий боловсролын 12 жилийн 11 сургуулийн 200 гаруй сурагчийг хамруулсан.</p>	
237		4.4.1.3. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэх	2021 - 2024		<p>Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалтуудын хүрээнд аймаг сумдын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг жил бүр тодотгон ажиллаж хэвшсэн.</p> <p>Сумдын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүн, ангийн буу, авто техник, агт морь, атан тэмээ, ердийн хөсгийг тус тус томилгоожуулан төлөвлөгөөнд хавсаргаж хэвшсэн бөгөөд томилгоо тодотгох ажлын гүйцэтгэл жил бүр өсөж 2023 оны байдлаар бүрэн хийгдсэн.</p> <p>Төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж заавар чиглэл өгч, хадгалалт хамгаалалтын байдалд жилд 2 удаа үзлэг шалгалт зохион байгуулан ажилласан.</p> <p>Орон нутгийн хамгаалалтын материаллаг баазыг бэхжүүлэх зорилгоор 174,6 сая төгрөгийн санхүүжилтийг төсөвлөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцүүлж, батлуулан ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар 80 гаруй хувийг нь зарцуулаад байна.</p> <p>Томилгоо тодотгох үйл ажиллагаа 14 сумын байдлаар 100 хувь хангагдсан.</p> <p>Дээрх төлөвлөгөөнүүдийг дайчилгааны бэлтгэл үүрэгтэн, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүн,</p>	100%

						техник хэрэгсэл, агт морь атан тэмээ үхэр, галт хэрэглэл зэргийг томилгоожуулан чанар байдалд нь дүн шинжилгээ хийж сэлгэн томилгоожуулж ажилласан.	
238		4.4.1.4. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлж, "Оюутан-цэрэг" сургалт, хугацаат цэргийн алба хаагчдын тоог нэмэгдүүлэх	2021 - 2024			<p>Цэргийн насны залуус болон Ерөнхий боловсролын ахлах ангийн хүүхдүүдэд цэрэг Эх-оронч үзэл төлөвшүүлэх тэдэнд сэтгэл зүйн болон бие бялдрын хүмүүжил олгох зорилгоор жил бүр 3-5 үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулсан бөгөөд тайлант хугацаанд 6000 гаруй хүүхэд залуучууд дээрх үйл ажиллагаанд хамрагдсан.</p> <p>2022, 2023 онд Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээний нэгдүгээр шатыг сургууль бүр дээр, хоёрдугаар шатыг аймгийн төвд аймгийн аварга шалгаруулах байдлаар зохион байгуулж, 2022 онд гуравдугаар шат буюу улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон. Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг энэхүү тэмцээнд нийт 3500 гаруй ахлах ангийн сурагчид хамрагдаж сэтгэлзүйн болон бие бялдрын бэлтгэлжилтээ сайжруулан эх орноо хайрлан хамгаалах үзэлд суралцсан. Монгол улсын Засгийн газрын тогтоол Батлан хамгаалахын сайдын тушаалаар "Оюутан-цэрэг" сургалтад 2023 онд 14 оюутан, 2024 онд 20 оюутан хамрагдсан.</p> <p>Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар сургууль, Политехникийн коллежийн оюутнуудыг дүрмийн дагуу сонгон шалгаруулж "Цэргийн ерөнхий бэлтгэл" шатны сургалтад 2 сарын хугацаатай хамруулан "Мэргэжлийн бэлтгэл" шатны сургалтад зохион байгуулагддаг зэвсэгт хүчний 167 дугаар анги руу тээвэрлэх, хүлээн авах, халах ажиллагаануудыг хөдөлмөрийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг мөрдлөг болгон зохион байгуулсан. Энэхүү сургалтад хамрагдах сонирхолтой оюутнуудын тоо жил бүр өсөх хандлагатай байна.</p>	100%
239	4.5.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангийн ашиглалтыг сайжруулж, баяжуулалт, шинэчлэлтийн ажлыг зохион байгуулна.	270. Төрийн албан хаагчдыг хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээрх арга зүйгээр хангаж, мэдлэг ур чадварыг сайжруулна.	2021 - 2024		100%	<p>Хяналт шинжилгээ үнэлгээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх төрийн болон нутгийн бодлогын баримт бичгийг хяналтад авах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, тайлагнах болон үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ хийх арга зүйд сургах зорилгоор сум, агентлагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулан "Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ" сэдэвт сургалтыг жил бүр зохион байгуулж давхардсан тоогоор 250 албан хаагчийг хамруулсан.</p> <p>Сургалтаар "Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндсэн ойлголт, анхаарах асуудал", "Бодлогын баримт бичгийн</p>	100%

					<p>хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүй", "Тайлан бичих арга зүй, анхаарах асуудал" зэрэг 7 сэдвээр мэдээлэл хүргэж, дадлага ажил зохион байгуулан үр дүнг тооцон ажиллалаа.</p> <p>Мөн давхардсан тоогоор 25 байгууллагын 100 гаруй албан хаагчид хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлангийн талаар болон ХШҮ-ний цахим сангийн хэрэглээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p>	
240		271. Төрийн байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлыг тогтмолжуулж, үр дүнг дээшлүүлнэ.	2021 - 2024	100%	<p>Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангийн баяжуулалт шинэчлэлтийн хүрээнд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлагдсан 2 зорилтот хөтөлбөрийг тухай бүр 100% байршуулсан. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Ерөнхий сайдын болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын шуурхай үүрэг даалгаврын системийн шинэчлэлт хийгдэн, хэрэгжилтийг бүр илгээн хэвшсэн.</p> <p>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг хагас жилээр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө, дэд болон зорилтот 11 хөтөлбөрийн тайланг бүтэн жилээр аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 28 агентлаг, 4 төсөвт байгууллага, 14 сумын ЗДТГ-аас тайланг хүлээн авч хэвшсэн.</p>	100%
241		272. Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангийн ашиглалтыг сайжруулж, баяжуулалт, шинэчлэлтийн ажлыг зохион байгуулна.	2021 - 2024	100%	<p>Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан /www.dornogovi.unelgee.gov.mn/-ийн ашиглалтыг сайжруулахаар нэвтрэх эрхгүй агентлаг, сум, төрийн үйлчилгээний байгууллагын 72 ажилчдын судалгааг авч Дорноговь аймгийн ХШҮ-ний мэдээллийн цахим санд нэвтрэх болон тайлагнах эрх үүсгүүлсэн.</p> <p>Бүртгүүлсэн албан хаагчид цахим санд хэвийн нэвтэрч, холбогдох тайланг цахим сан ашиглан илгээснээр тус сангийн бүртгэл, мэдээллийн баяжуулалт нэмэгдэж цаасан суурьтай баримт бичгийн эргэлт 80 хувиар буурсан.</p> <p>Мөн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймгийн дэд болон зорилтот хөтөлбөр, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргаас сайд нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийн тайланг цахимаар авахаар нийт сум, агентлагт холбогдох заалт, арга хэмжээг хуваарилж, 42 байгууллагын тайланг цахимаар авч, хяналтад аван нэгтгэх ажиллагаа бүрэн хийгдсэн.</p>	100%

**5. Ногоон хөгжлийн бодлого**

242	5.1.1. Агаарын бохирдлыг арга хэрэгжүүлнэ. Агаарын бууруулах хэмжээг	274. Агаарын бохирдлыг бууруулах өрхийн ухаалаг хэрэглээг бий болгох, цахилгаан халаалтыг дэмжих, дулааны станцын зуухыг утаа баригчтай болгох зэрэг арга хэмжээг судалж хэрэгжүүлэх	2021 - 2024		3 1	<p>Орон нутгийн төсвийн 647,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд Сайншанд сумын 4, 6, 8 дугаар багт цэвэр усны шугам татах, Алтанширээ сумын төвийн нийтийн орон сууцыг гадна дулаан цэвэр усны шугамд холбох ажлуудыг "Ингүүмэл-Оргил" ХХК, "Чандмань-Илч" ХХК, "Ивээлт баян буурал" ХХК-ууд гүйцэтгэж ашиглалтад оруулсан.</p> <p>Шинээр баригдсан инженерийн шугам сүлжээнд 162 айл өрх холбогдох боломж бүрдсэн ба одоогоор 64 айл холбогдоод байна. ОНТ-ийн 816.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Улаанбадрах сумын нэгдсэн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээний ажлыг "Түүрүү гарав" ХХК гүйцэтгэн 8 орон сууцны 31 айл төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон. 2024 онд төсвийн хөрөнгө оруулалтаар инженерийн шугам сүлжээний 31 төсөл арга хэмжээг 16,4 тэрбум төгрөгийн өртөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд үүнд Мандах сумын төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ байгуулах ажил, Хөвсгөл сумын ЕБС-ийн багш ажилчдын байрны 4 айлын орон сууцны барилгад халаалт, цэвэр, бохир усны шугам шинээр хийх ажил, Айраг сумын Уурхайчин байранд сангийн шугам шинэчлэх, Өргөн суманд гэр хороололд дулаан цэвэр усны шугам татах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхээр тендер шалгаруулалт зарлагдсан.</p> <p>2024 оны эхний хагас жилийн байдлаар Сайншанд сумын гэр хорооллын 31 өрх, Замын-Үүд сумын 45 айл дулаанд, цэвэр бохир усны шугам сүлжээнд холбох техникийн нөхцлийг олгосон. Сайншанд, Замын-Үүд сумын "Агаарын чанарыг сайжруулах, бүс тогтоох, бүсэд мөрдөх журам"-ыг батлаж, журмын хэрэгжилтийг хангаж "Пассив барилга" барих аргачлал, цахилгаан дулааны хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх боломжийн талаарх 2 удаагийн сургалтад давхардсан тоогоор 100 гаруй иргэн хамруулан мэдээллээр хангасан. Орон нутгийн төсвийн 55,0 сая төгрөгийн санхүүжилтээр Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн лабораторид (PM-2.5) нарийн ширхэгт тоосонцор хэмжих "Dust Truck" багажтай болгосон.</p> <p>Сайншанд, Замын-үүд сумын 1398 өрх шөнийн цагт хэрэглэсэн 1122944 квт цахилгааны 125209925.6 төгрөгийн тарифын хөнгөлөлт эдэлсэн байна.</p>	100%
243		275. Орон нутгийн нүүрсний уурхайг	2021 - 2024		10%	Орон нутгийн нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах ТЭЗҮ боловсруулах	90%

		түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах ажлыг дэмжих замаар агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.			тендерийг Эрчим хүчний яамнаас удаа дараа зарлаж гүйцэтгэгч оролцоогүй байна. Аймгийн нутаг дэвсгэрт 14 аж ахуйн нэгж нүүрс олборлолт баяжуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж Даланжаргалан суманд "Ачир" ХХК, "Говийн шандаст" хүлэг ХХК жилд 1.9 сая тн нүүрс угааж баяжуулах хүчин чадалтай 2 үйлдвэр ажиллаж нүүрсийг баяжуулан экспортлож байна. Алтанширээ, Дэлгэрэх, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл сумдууд дулааны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдож дээрх сумд болон Даланжаргалан, Сайншанд, Замын-Үүд сумын 378 айл, өрх 48 аж ахуйн нэгж байгууллага төвлөрсөн дулааны сүлжээнд холбогдсон. Мөн 2024 онд 25 өрх цахилгаан халаалт нэвтрүүлж нийт аймгийн хэмжээнд 294 өрх цахилгаан халаалт ашиглаж байна. PM10.0 тоосонцорын MNS 4885:2016 зөвшөөрөгдөх хэмжээ 0.044 байгаа зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй байна.	
244	5.1.2. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх, хүн амыг баталгаат ундны усаар хангах нэгдсэн менежментийг сайжруулна.	276. Газрын доорх усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх	2021 - 2024	2	Газрын доорх усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээний ажлыг "Усны мэдээллийн өнө мөнхийн ундарга төв" ХХК -иар гүйцэтгүүлсэн. Дээрх ажлын үр дүнг төрийн байгууллага, Сайншанд, Улаанбадрах сумдын иргэдэд танилцуулсан. Дэлгэрэх, Алтанширээ, Даланжаргалан, Хатанбулаг сумдын ундны усны эрүүл ахуйн хамгааллалтын бүс тогтоож хашаажуулсан. Өргөн, Эрдэнэ, Сайншанд сумдын эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хашааг засуулж шаардлагад нийцүүлсэн. 13 сумын төвийн унд ахуйн усны эх үүсвэр 23 худгаас дээж авч "Ханлаб" ХХК-ийн лабораторид, Зээгийн хөтөлийн газрын доорх усны орд, Эрдэнэ сумын унд ахуйн усны эх үүсвэр 18-ын худгийн газрын доорх усны орд дээр газар тариалан эрхэлж буй иргэн, ААН-ийн талбайгаас хөрс, усны дээж авч, Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн лабораторид тус тус шинжлүүлж шинжилгээний үр дүнд үндэслэн сумдад усны сан бүхий газар ус хангамжийн эх үүсвэрүүдийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, түүний ойр орчмын газрын хог хаягдлыг цэвэрлэх ажил хийгдсэн.	100%
245		277. Сумын төвүүдийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг	2021 - 2024	100%	Аймгийн Засаг даргын 2012 оны А/411 тоот захирамжийн дагуу аймгийн хэмжээнд нийт 95 худаг уст цэгт эрүүл ахуйн бүс тогтоож дэглэмийг мөрдүүлэн ажилладаг. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуй бүс, ус хангамжийн эх үүсвэрүүдийн тэжээгдлийн мужийн зааг, зураглал, холбогдох	100%

		нарийвчлан тогтоож мөрдүүлж хэвшүүлэх			<p>мэдээлэл, судалгааг шинэчлэн тогтоож хамгаалалтад авах газрын мэдээллийг Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаа, Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргаанаас гаргасан.</p> <p>Дээрх судалгаагаар Өргөн, Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайншанд, Замын-Үүд, Сайхандулаан сумдын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн худгийн хамгаалалтын бүстэй 239 газар давхцалтай байгааг тогтоож, талбайгаас бүсийн дэглэмийг мөрдүүлэх ажлыг сумдын Засаг дарга нар гүйцэтгэн ажиллаж байна.</p> <p>Эрүүл ахуйн бүсийг тогтоосон. Эрүүл мэндийн яамны санаачилгаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр аймгийн "Ус, ариун цэврийн аюулгүй байдлыг ханган ажиллах нэгдсэн төлөвлөгөө" боловсруулсан. 2021 онд 4, 2022 онд 4, 2023 онд 10 худаг, 2024 онд Хөвсгөл сумын хүн амын ус хангамжийн Гэрлийн шанд-1, Гэрлийн шанд-2, Гэрлийн шанд-3 худаг, Айраг, Даланжаргалан, үйл ажиллагаа явуулдаг "Би Ти Девелопмент" ХХК 1 худаг, "Ачир" ХХК 1 худаг, "Сармай дээлт" ХХК 1 худаг нийт 6 сум болон компаниудын эзэмшлийн шинээр гаргасан худгуудад эрүүл ахуйн бүс тогтоож хашаажуулж, тэмдэгжүүлэх ажил хийгдсэн.</p>	
246		278. Булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалж, тохижуулах ажлыг үргэлжлүүлэх	2021 - 2024	3	<p>Аймгийн хэмжээнд 370 булаг, шандын эхийг хашиж хамгаалахаас 2008-2020 онд 67, 2021 онд 7, 2022 онд 6, 2023 онд 9 нийт 89 булаг шанд хамгаалж тохижуулах ажил хийгдэж нийт булгийн 24 хувийг хамгаалан тохижуулсан.</p> <p>Айраг сумын Нарт багийн "Эзэгийт булаг", Иххэт сумын Баян багийн "Өлзийт булаг", Өргөн сумын 3 дугаар багийн "Живчид булаг", Улаанбадрах сумын 1 дүгээр багийн "Хоньч булаг", Эрдэнэ сумын 2 дугаар багийн "Бүлээн булаг" зэрэг нийт 5 булгийн аймгийн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 25.0 сая төгрөгийн хөрөнгөөр хашаажуулж гадаргын усан хангамжийг нэмэгдүүлсэн.</p> <p>Мөн Даланжаргалан сумын "Элдэвийн булаг", Мандах сумын "Шавартайн булаг", Сайхандулаан сумын "Дэврэхийн булаг", Иххэт сумын "Хөгцөт булаг"-ийг уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 3 компанийн 7,0 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр тохижуулснаар нийт 32,0 сая төгрөгөөр 8 сумын нутагт 9 булгийг тохижуулж, усны сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулсан нь өмнөх онтой харьцуулахад 66,6 хувиар өссөн.</p>	100%

					2024 онд Гадаргын усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 21.0 сая төгрөгийн хөрөнгөөр Сайхандулаан сумын Жаргалант багийн Арын булаг, Хатанбулаг сумын Сулинхээр багийн Хангийн булаг, Эрдэнэ сумын Дөрвөлж багийн Сэвхүүлийн булаг нийт 3 булаг, Даланжаргалан суманд "Мак"ХХК-ний 10,0 сая төгрөгийн санхүүжилтээр Далантүрүү булаг, Өргөн суманд "Монцемент билдинг материалс"ХХК-ний 10,0 сая төгрөгийн санхүүжилтээр Шувуун хөөврийн булаг, нийт 5 суманд 5 булаг, шандын эхийг хашиж хамгаалж тохижуулах ажил хийхээр төлөвлөн ажлыг эхлүүлээд байна.	
247		279. Сумдын ундны усыг чанарын шинжилгээнд хамруулж, цэнгэгжүүлэх төхөөрөмжийг суурилуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, стандартын шаардлага хангасан ундны усаар хангах,	2021 - 2024	100% 40 1	<p>Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 200,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын хүн амын ундны усан хангамжийн эх үүсвэрийн 1 худагт усны хатуулаг, хүнцэл бууруулах төхөөрөмж, Улаанбадрах, Мандах сумдад 40,0 сая төгрөгөөр 2 худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж, Орон нутгийн хөгжлийн сангийн 5,0 сая төгрөгөөр Өргөн суманд 1 худаг, Эрдэнэ суманд 100,0 сая төгрөгөөр 3 худаг нийт 7 ус хангамжийн эх үүсвэрийн худгуудад 345,0 сая төгрөгийн санхүүжилтээр ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулж усны чанар, стандартыг сайжруулсан.</p> <p>2024 онд Усны чанар, стандартыг сайжруулах ажлын хүрээнд Улаанбадрах суманд аймаг, орон нутгийн төсвийн нийт 240,0 сая төгрөгийн хөрөнгөөр тус сумын 2 дугаар багийн Хонгор, Цэвүүн нэртэй 2 худаг, 3 дугаар багийн Наймаа, Гүнсүхайт нэртэй 2 худагт ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх, усны хатуулаг, хүнцэл бууруулах төхөөрөмж суурилуулах, худгийн барилга байгууламж барих ажил хийхээр төлөвлөн ажлыг эхлүүлээд байна.</p> <p>Дэлгэрэх суманд үйл ажиллагаа явуулдаг "Дэртийн булаг"ХХК-ний 250,0 мянган төгрөгийн санхүүжилтээр тус сумын хүүхдийн цэцэрлэгийн 1 худагт бага оврын ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах ажил хийгдсэн. аймгийн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 2023 оны 186,4 сая төгрөгийн санхүүжилтээр Сайншанд суманд 2 цэгт цэвэршүүлсэн усны төв байгуулах захиалагчийн эрх шилжүүлсний дагуу "Баялаг говь" шалгарч 6 сард багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.</p>	100%
248	5.1.3. Гэр хороолол, аялал жуулчлалын	280. Ариун цэврийн байгууламжийг	2021 - 2024	500	Ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох чиглэлээр 6 удаагийн сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион	100%

	<p>газруудын ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох жишиг хэрэгжүүлж туршлагыг дэлгэрүүлнэ.</p>	<p>ариун болгох төсөл сайн</p>	<p>боловсронгуй болгох дэвшилтэт технологийг нэвтрүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулах</p>		<p>байгуулж нийт 2000 гаруй иргэнд мэдээ мэдээлэл өгч, фэйж хуудас цахим сүлжээгээр видео шторк, постерийг 30 гаруй удаа цахим сүлжээгээр дамжуулан 12000 гаруй хүнд хүргэсэн.</p> <p>2021 оноос хойш Замын-Үүд сумын хоршоог хөгжүүлэх сангаас эко кольцоо, лега блок үйлдвэрлэлийн чиглэлээр 1 иргэн 30,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлэнд 2023 онд хамрагдан бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэн үйлдвэрлэж, стандартын шаардлага хангасан жорлонг угсарч холбох үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд жилдээ 20 гаруй айл өрхийн жорлонг шинэчлэн ажилласан.</p> <p>"Нээлттэй Дорноговь" арга хэмжээний хүрээнд айл өрхийн бичил цэвэрлэх байгууламжийн худалдаа суурилуулалтын чиглэлээр "Юниос" ХХК, стандартын бие засах газрын чиглэлээр "Пластик центр" ХХК-ыг урьж оролцуулан, 14 сумын 1000 гаруй иргэнд танилцуулж гарын авлага материал түгээсэн. Энэхүү ажлын хүрээнд Гэр хороолол, аялал жуулчлалын газруудын ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэх чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2 удаагийн албан бичгийг сумдад хүргүүлж худалдаа үйлчилгээ, шатахуун түгээх станц зэрэг 13 аж ахуйн нэгж стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болсон. Орон нутгийн төсвийн 157,5 сая төгрөгийн санхүүжилтээр Сайншанд сумын наадмын талбайн 5 цэгт, Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын Энергийн төвийн орчинд 1 цэгт, Даланжаргалан сумын Халзан-Уул рашаан сувилал, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мод үржүүлгийн талбайд нэг нийт 8 стандартын шаардлага хангасан нийтийн ариун цэврийн байгууламж шинээр байгуулан ашиглалтад оруулсан.</p>	
249			<p>281. Хөрс бохирдуулагч эх үүсвэрийг бууруулахад олон нийтийн оролцоог эрчимжүүлэх.</p>	2021 - 2024	<p>1500 150</p> <p>Ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох чиглэлээр 6 удаагийн сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж нийт 2000 гаруй иргэнд мэдээ мэдээлэл өгч, фэйж хуудас цахим сүлжээгээр видео шторк, постерийг 30 гаруй удаа цахим сүлжээгээр дамжуулан 12000 гаруй хүнд хүргэсэн.</p> <p>Орон нутгийн төсвийн 157,5 сая төгрөгийн санхүүжилтээр Сайншанд сумын наадмын талбайн 5 цэгт, Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын Энергийн төвийн орчинд 1 цэгт, Даланжаргалан сумын Халзан-Уул рашаан сувилал, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мод үржүүлгийн талбайн стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламж, Худалдаа үйлчилгээ, шатахуун түгээх станц зэрэг 25 аж ахуйн</p>	100%

					<p>нэгж стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болсон.</p> <p>Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр Мандах сумын 88 өрхийг соруулдаг жорлонтой болгох ажлыг "Аранзал констракшн" ХХК гүйцэтгэсэн. Мөн Алтанширээ, Дэлгэрэх, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл сумдад цэвэр бохир, дулааны төвлөрсөн инженерийн байгууламж баригдаж дээрх сумд, Сайншанд, Замын-Үүд, Даланжаргалан, Мандах сумын төвийн 137 айл өрх стандартын шаардлага хангасан соруулдаг нойл, 378 айл өрх 48 аж ахуйн нэгж байгууллага төвлөрсөн шугам сүлжээнд холбогдож нийт 563 айл өрх аж ахуйн нэгж байгууллага ариун цэврийн байгууламжаа стандартын шаардлагад нийцүүлж, Айраг, Сайншанд, Даланжаргалан, Дэлгэрэх, Замын-Үүд, Мандах, Хатанбулаг сумдын 100 гаруй айл өрх, 15 аж ахуйн нэгж байгууллага хуучин ашиглаж байсан нүхэн жорлонгоо дарж булшлан хөрсний бохирдлыг бууруулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд 3400 гаруй нүхэн жорлон тоологдож давхардсан тоогоор 10000 гаруй нүхэнд жорлонд ариутгал хийсэн.</p> <p>Эрдэнэт үйлдвэр ТӨКомпани санхүүжилтээр БШУЯ-наас тендер зарлаж ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгүүдийн ариун цэврийн байгууламжийг шинэчлэх ажлын хүрээнд Улаанбадрах, Сайхандулаан сумдын ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжуудыг шинэчлэн боловсронгуй болгосон.</p>	
250	5.1.4. Ан амьтдын амьдрах орчныг тэтгэх, нүүдлийн замыг чөлөөлөхөд иргэн, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлнэ.	282. Зарим сумдад сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг худаг гаргах, бороо цасны ус харимтлуулах хөв цөөрөм байгуулж зэрлэг амьтдын ус хангамжийн эх үүсвэрийг бүрдүүлэх	2021 - 2024	1 1	<p>Аймгийн хэмжээнд 370 булаг, шандын эхийг хашиж хамгаалахаас 2008-2020 онд 67, 2021 онд 7, 2022 онд 6, 2023 онд 9 нийт 89 булаг шанд хамгаалж тохижуулах ажил хийгдэж өмнөх онтой харьцуулахад 66.6 хувиар өссөн. Айраг сумын Нард багийн "Эзгийт булаг", Иххэт сумын Баян багийн "Өлзийт булаг", Өргөн сумын 3 дугаар багийн "Живчид булаг", Улаанбадрах сумын 1 дүгээр багийн "Хоньч булаг", Эрдэнэ сумын 2 дугаар багийн "Бүлээн булаг" зэрэг нийт 5 булгийн аймгийн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 25.0 сая төгрөгийн хөрөнгөөр хашаажуулж гадаргын усан хангамжийг нэмэгдүүлсэн.</p> <p>Мөн Даланжаргалан сумын "Элдэвийн булаг", Мандах сумын "Шавартайн булаг", Сайхандулаан сумын "Дэврэхийн булаг", Иххэт сумын "Хөгцөт булаг"-ийг уул уурхайн чиглэлээр</p>	100%

					<p>үйл ажиллагаа явуулж байгаа 3 компанийн 7,0 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр тохижуулснаар нийт 32,0 сая төгрөгөөр 8 сумын нутагт 9 булгийг тохижуулж, усны сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулсан нь өмнөх онтой харьцуулахад 66,6 хувиар өссөн</p> <p>2024 онд Гадаргын усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 21.0 сая төгрөгийн хөрөнгөөр Сайхандулаан сумын Жаргалант багийн Арын булаг, Хатанбулаг сумын Сулинхээр багийн Хангийн булаг, Эрдэнэ сумын Дөрвөлж багийн Сэвхүүлийн булаг нийт 3 булаг, Даланжаргалан суманд “Мак” ХХК-ийн 10,0 сая төгрөгийн санхүүжилтээр Далантүрүү булаг, Өргөн суманд “Монцемент билдинг материалс” ХХК-ийн 10,0 сая төгрөгийн санхүүжилтээр Шувуун хөөврийн булаг, нийт 5 суманд 5 булаг, шандын эхийг хашиж хамгаалж тохижуулахаар төлөвлөсөн болно.</p>	
251	283. Дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэхэд ан амьтдад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх	2021 - 2024	Гүйцэтгэлээр	<p>Зэрлэг ан амьтдад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах бодлогын хүрээнд зэрлэг амьтдад зориулж 2021 онд 430 боодол өвс, 2022-2023 онд 950 боодол өвсийг бэлтгэж, зэрлэг амьтдын тархац газруудад байршуулан био техникийн арга хэмжээг хэрэгжүүлж ажиллан нь биотехникийн арга хэмжээний 86.5 хувиар өссөн. Өргөн, Эрдэнэ сумдын нутаг дэвсгэрийг дамжин өнгөрөх Улаанбаатар төмөр замын 839, 914, 958 дугаар хэсэгт замын 2 талын 1500м тор авсан. Айраг, Сайншанд, Өргөн, Эрдэнэ сумдын нутаг дэвсгэрт 2022 онд 1200м, 2023 онд 2020м нийт давхардсан байрлалд нийт 3220м төмөр замын торыг авсан нь 2021 онтой хариуцуулахад 87,2 хувиар нэмж төмөр замын торыг нээсэн.</p> <p>Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгийн замын 4-р ангийн хамт олон, Газрын тос боловсруулах үйлдвэрийн байгаль орчны албатай хамтран нүүдлийн амьтдын замын чөлөөлөх, торонд орсон амьтдыг гаргах ажлыг зохион байгуулсан. Үүнд: Улаанбаатар төмөр зам дагуу 120м газрын торыг нээж 300 гаруй цагаан зээр, Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт 1000 гаруй хулан адуу, газрын тос боловсруулах үйлдвэрийн чиглэлийн төмөр зам дагуу 1200м газрын торыг нээж 1000 гаруй цагаан зээрийн нүүдлийн замыг чөлөөлөх ажлыг тус тус зохион байгуулсан.</p> <p>Мөн "Оюутолгой" ХХК, Байгаль зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг Монгол дахь төлөөлөгчийн газар, "Улаанбаатар төмөр зам" ХНН хамтран Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт</p>	90%	

					<p>Улаанбаатар төмөр замын дагуу 700м газрын торыг дахин нээхээр төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын 2023 оны А/868, А/867 дугаар захирамжийн дагуу 1681 боодол өвс худалдан авч Даланжаргалан, Иххэт, Сайхандулаан, Өргөн, Сайншанд сумдад зэрлэг амьтдад зориулж био техникийн арга хэмжээг авч ажилласан. Мөн улсын хэмжээнд өвөлжилт хүндэрч Иххэт, Айраг, Сайншанд сумдын нутаг дэвсгэрийг дамжин Өргөн сумын чиглэлд цагаан зээрийн сүрэг дамжин өнгөрсөн. Иймд зүй бус хорогдол үүсэхээс урьдчилан сэргийлж газрын тос боловсруулах үйлдвэрийн төмөр замын хоёр талын 2.2 м торыг нээж нүүдлийн замын чөлөөлөх ажлыг зохион байгуулсан.</p>	
252	5.1.5. Хог хаягдлын менежментийг сайжруулж, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжинэ. дахин	284. Зарим сумдын хог хаягдлыг ангилан төвлөрүүлэх, аюултай хог хаягдлыг цуглуулах цэг байгуулах	2021 - 2024	200тн	<p>Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл, Даланжаргалан сумууд хувийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хуучин хог хаягдлын төвлөрсөн цэгийг түрж дарж булшлан шинээр 3.75 га талбайд төвлөрсөн цэгийг байгуулан хашиж хамгаалах, камержуулах ажлыг гүйцэтгэж бусад сумууд хогийн цэгийг түрж хумих талбайн хэмжээг бууруулах ажлыг гүйцэтгэж хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайг 139.6-аас 43 га талбайгаар бууруулж 96 га болсон. Айраг, Иххэт, Замын-Үүд, Өргөн, Сайншанд сумдын 8 ерөнхий боловсролын сургуульд хадгалагдаж байсан хугацаа дууссан химийн хорт болон аюултай бодис, тэдгээрийн сав баглаа зэрэг 257 нэр төрлийн 1.1 тн аюултай хаягдлыг эрх бүхий этгээдэд шилжүүлэн журмын дагуу устгуулсан.</p> <p>Аюулыг авдарлая аяны хүрээнд 16 ерөнхий боловсролын сургуулийн 2000 гаруй сурагчид хамрагдаж ахуйн хэрэглээнээс гарч буй хугацаа дууссан эм бэлдмэл, гар утас таблет, зай, чихэвч, цэнэглэгч зэрэг 900кг аюултай хаягдлыг ангилж цуглуулан түр хадгалах газарт төвлөрүүлсэн.</p> <p>Аймгийн нутаг дэвсгэрт уул уурхай, зам барилга, авто засварын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 38 аж ахуйн нэгжийг аюултай хаягдал үүсгэгчийн бүртгэлд бүртгэж дугаар олгон давхардсан тоогоор 60 аж ахуйн нэгж 247.8 тн аюултай хаягдлыг журмын дагуу ангилж цуглуулан эрх бүхий үйлдвэрт нийлүүлж устгуулж дахин боловсруулсан.</p> <p>Аюултай хаягдлыг ангилах цуглуулах чиглэлээр Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны санхүүжилтээр Сайншанд сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт аюултай хог хаягдал түр хадгалах агуулахын барилга угсралтын ажлыг</p>	90%

					<p>"Цонбонтоосго" ХХК гүйцэтгэсэн. Мөн Замын-Үүд сум сумын төвлөрсөн хогийн цэг шинээр байгуулах, хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхээр 4,0 тэрбум төгрөгийн зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн. Үүнээс 2024 онд орон нутгийн төсвийн 500 сая төгрөгийн хөрөнгөөр хэсэгчилсэн төлөвлөлтийн ажлуудыг санхүүжүүлэн хэрэгжүүлэхээр тендер зарлахаар бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.</p>	
253		<p>285. Хог хаягдлыг цэвэрлэх, ангилал, цуглуулах арга хэмжээг хэрэгжүүлж, дахин боловсруулах үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих</p>	2021 - 2024	<p>Дахин боловсруулсан хог- 2000тн, автопарк шинэчлэлийн тоо-1</p>	<p>Сайншанд сумын 8 дугаарт хэрэгжсэн тэгш гудамж төслийн хүрээнд 25 өрх хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын савтай болсон.</p> <p>Айраг, Алтанширээ, Даланжаргалан Дэлгэрэх Сайншанд, Замын-Үүд, Эрдэнэ суманд хог хаягдал ангилан ялгах зориулалтын 53 савыг байгууллага, худалдаа үйлчилгээний төв, нийтийн орон сууц, нийтийн эзэмшлийн гудамж талбайд байршуулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд хуванцар 125.2 тн, гялгар нийлэг-68тн, шил-64.5тн, цаас 30 тн, лааз 35.2тн нийт 322.9 тн дахивар хаягдлыг ангилан, цуглуулж Эко Говь үйлдвэр, Улаанбаатар хотын үйлдвэр, цехд нийлүүлсэн. Сайншанд, Замын-Үүд суманд хаягдал төмөр, лааз, зэс цайр гууль зэрэг хоёрдогч түүхий эд цуглуулдаг 8 иргэн ажиллаж хаягдал төмөр 500тн, зэс цайр, гууль, хөнгөн цагаан 50 гаруй тн нийт 550 тн хоёрдогч түүхий эдийг Улаанбаатар хотын үйлдвэр, цехд нийлүүлсэн.</p> <p>Аймгийн наадмын талбайн үзэгчдийн суудлыг шинэчлэх сандлын савхан бэлдэц 1900 ширхэгийг Эко говь хаягдал дахин боловсруулах үйлдвэрээс худалдан авсан. Тус үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэхээр Аймгийн Засаг даргын 2023 оны А/345 дугаар захирамжаар гадна цахилгаан хангамжийн ажлыг гүйцэтгүүлэхээр АТП дэд станц байгуулахад шаардагдах тоног төхөөрөмжийг худалдан авч угсрах ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Сайншанд сумын “Эко говь” хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжиж өдөрт 500-600 кг хуванцар хаягдал нягтаршуулах хүчин чадалтай хэрчигч төхөөрөмж, 400-450 кг гялгар уутыг дахин боловсруулах хүчин чадалтай хайлуулах төхөөрөмжүүдийг гэрээгээр ашиглуулан хэвийн ажиллахад дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Мөн Сайхандулаан сумын орон нутгийн хөгжлийн сангийн 11,0 сая төгрөгийн хөрөнгөөр хоёрдогч түүхий эд боож баглах төхөөрөмж, ангилан ялгах сав худалдан авч 2.5 тн хоёрдогч түүхий эдийг цуглуулан ашиглалтад оруулж, дахивар авах</p>	100%

					нөлөөллийн аяныг зарлан ажиллаж байна. Даланжаргалан сум хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, сав агуулахыг байгуулж 2,5 тн түүхий эдийг цуглуулж “Эко говь” үйлдвэрт нийлүүлсэн.	
254	5.1.6. “Ногоон Дорноговь” арга хэмжээг хэрэгжүүлж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.	286. Ногоон байгууламжийг нэмэгдүүлж, мод тарьж, ургуулсан иргэд, аж ахуйн нэгжийг дэмжиж, урамшуулах,	2021 - 2024	45000 10	<p>2023 онд Аж ахуй нэгж, байгууллага, айл өрхүүдийг ногоон төгөл байгуулах, эзэмшил газрын өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор мод бут сөөг тарихад дэмжлэг үзүүлж. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын санхүүжилтээр 56 аж ахуй нэгж, байгууллага, 431 өрхөд 7 төрлийн 25751 ширхэг тарьц, суулгацыг тараасан бол энэ оны хавар 12 ААНБайгууллагуудад 2959 ширхэг, 52 иргэнд 2162 ширхэг, 3 сумдад 475 ширхэг буюу нийт 7 төрлийн 5596 ширхэг модны суулгацыг тараасан байна.</p> <p>2021 оноос 2024 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх аймгийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд нийтийн эзэмшлийн 46 га талбайд 10 төрлийн 121489 ширхэг мод, 940 айл өрх, 201 аж ахуйн нэгж байгууллага өөрийн эзэмшлийн газартаа 10 төрлийн 73503 ширхэг модыг тарьснаар аймгийн хэмжээнд нийт 219270 ширхэг мод, бут сөөгийг шинээр суулгаж, 467 аж ахуй нэгж, байгууллага, 4933 иргэд оролцон ногоон байгууламжийн хэмжээг 103.2 га талбайгаар нэмэгдүүллээ. Уг ажилд орон нутгийн төсөв болон иргэд, аж ахуйн нэгж байгууллагын 767.6 сая төгрөгийг зарцуулан 67.9 хувийн ургалттай байна.</p> <p>2024 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд хаврын мод тарих өдрүүдэд 39166 ширхэг мод, бут сөөгийг тарьж, нийт 109 аж ахуйн нэгж байгууллагын 1147 албан хаагчид, ажилчид, иргэд оролцсон. Мөн мод тарих өдрийн хүрээнд Аймгийн БОАЖГазар Сайхандулаан сум болон Улаанбадрах сумын ЗДТГазартай хамтран тус сумдуудад томилолтоор явж мод тарих өдөрлөг зохион байгуулж ААНБайгууллагууд, иргэдийг хамруулсан.</p>	90%
255		287. “Монгол орны хуурай бүс нутгаас үүдэлтэй элсэн ба шороон шуурганаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах төсөл”-ийг дэмжин ойн	2021 - 2024	1 Таримал ойн зурвас 1 га	<p>2021-2024 онуудад Айраг , Даланжаргалан , Сайншанд , Өргөн , Эрдэнэ, Мандах, Хатанбулаг, Сайншанд сумдад нийт 46 га талбайд 8 төрлийн 30,000 ширхэг мод тарьж ойн зурвас байгуулсан. НҮБ-ийн цөлжилттэй тэмцэх конвенц, БОАЖЯ-тай хамтран “Монгол орны хуурай бүс нутгаас үүдэлтэй элсэн ба шороон шуурганаас хамгаалах, нөлөөллийг бууруулах” төслийн хүрээнд 2023 онд Замын-Үүд суманд 13,4 га талбайд ойн анги байгуулагдаж үйл ажиллагаа явуулсан.</p>	90%

		ангийн үйл ажиллагааг тогтмолжуулж, ойн зурвасыг нэмэгдүүлэх			<p>2023 онд аймгийн хэмжээнд тариалангийн талбайн хамгаалалтын зурваст- 2895 ширхэг мод, булаг шанд, хөв цөөрмийг хамгаалахад 5730 ширхэг мод, автозамын хамгаалалтын зурваст- 7933 ширхэг, төмөр замын хамгаалалтын бүсэд 480 ширхэг, нийт 17038 ширхэг, нэгдсэн дүнгээр 58838 мод, бут сөөгийг тарьж хамгаалалтын зурвасыг нэмэгдүүлсэн.</p> <p>Тариалангийн талбайн хамгаалалтын зурваст 1000 ширхэг, булаг шандын хөв цөөрмийг хамгаалахаар 1250 ширхэг, авто замын хамгаалалтын зурваст 3500 ширхэг модны суулгацыг тус тус тарьсан. "НҮБ"-ын төслөөр дэмжигдэн байгуулагдсан Замын-Үүд сумын ойн анги "Борхойн баян бүрд" ОНӨААТҮГ нь 2023 онд 1,2-р хүлэмж 640 м/квт говьд зонхилон ургадаг мод,сөөгний 11 зүйлийн 24 кг750 гр үрээр, ил талбайд 3 зүйлийн 31850 ш мөчрийн тарилт хийсэн. 2024 оны хагас жилийн байдлаар БОАЖГ-ын дэргэдэх Мод үржүүлгийн талбайд 2023 онд баригдсан хүлэмж болон гадаа талбайд агч (5кг), бүйлс (900гр), жигд (4кг), хайлаас (10кг) моддыг үрээр тарьж, бургас (1050 ш), сухай (1000 ш), улиас (5260 ш) моддыг мөчрөөр үржүүлэн суулгасан байна. Нийт 3200м2 талбайн хөрс боловсруулалт хийж тарилтын ажил хийсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 22,95%-иар нэмэгдүүлсэн.</p>	
256		288. Мод үржүүлгийн газруудын үйл ажиллагааг дэмжиж, заган ой, ховор ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх ажилд иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоог идэвхжүүлэх,	2021 - 2024	2	<p>2021-2023 онд Сайншанд сумын Захирагчийн ажлын албаны мод үржүүлгийн газар буюу “Буянт ухаа” цогцолборт 400 м газрыг шуудуулж, 2400 гаруй улиас, хайлаасны нөхөн тарилтыг хийж, 2 хүлэмжийг ашиглалтад оруулсан бөгөөд ажиллагаагүй байсан худгийн насосыг засч ашиглалтад оруулсан.</p> <p>Мөн хөрс, бордоо буулгах хэсгийг хашаажуулан тусгай талбайтай болсон. БОАЖГ-ы дэргэдэх МҮГ-ийн талбайд: *40*8 метрийн хэмжээтэй 3 улирлын хүлэмжийг барьж, хайлаасыг үрээр тарьж өсөлт 12 см-тай байсан.</p> <p>Усалгааны асуудлыг бүрэн шийдвэрлэхийн тулд 2022 онд шинээр гаргасан гүний худаг тог цахилгаан байхгүйгээс ашиглах боломжгүй байсныг 2023 онд нарны сэргээгдэх эрчим хүчний насосыг суурилуулан худгийг бүрэн ажиллагаанд оруулсан. Мөн 7 тоннын багтаамжтай 3 ширхэг нөөцийн савыг байрлуулж, 2023 оны байдлаар үржүүлэг хийхээр бэлтгэсэн 1 га талбайн усалгааны асуудлыг бүрэн автоматжуулж, усалгааны асуудлыг бүрэн шийдвэрлэсэн.</p>	100%

					<p>Сайхандулаан суманд сургалтын зориулалтаар "Ганц мод" ойн төгөл ногоон байгууламж төслийг эхлүүлсэн. 2024 оны хаврын бүх нийтийн мод тарих өдөрлөгийг Сайншанд сумын ЗДТГ-аас зохион байгуулсан бөгөөд уг өдөрлөгийн үеэр 5500 ширхэг мод тарилаа.</p> <p>Мөн ИТХ-аас зохион байгуулснаар иргэдтэй хамтран цэцэрлэгт хүрээлэнд 500 ширхэг модыг тарьж суулгасан. Сайншанд сумын хүрээнд хаврын мод тарилтын өдрүүдэд Доншен газрын тос 6000 ширхэг, Зүүнбаян 336-р цэргийн анги 400 ширхэг, ЕБ-н 4 сургууль, Спортын төв 100 ширхэг, Дезерт солар ваун ХХК 100 ширхэг, Ерөнхий боловсролын 1, 2, 5, 6 дугаар сургуулиуд 500 ширхэг модыг аж ахуй нэгж, байгууллагын орчин тойрон, нийтийн эзэмшлийн талбайд тарьсан байна.</p> <p>Мөн БОАЖГ-ын дэргэдэх Мод үржүүлгийн талбайд 2023 онд баригдсан хүлэмж болон гадаа талбайд агч, бүйлс, жигд, хайлаас моддыг (20кг) үрээр, бургас, сухай, улиас моддыг (7310 ширхэг) мөчрөөр үржүүлэн суулгасан нь өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 8,6%-иар нэмэгдүүлсэн байна.</p>	
257	5.1.7. Уул уурхайн олборлолт, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил болон эзэн холбогдогчгүй эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	289. Эзэн холбогдогчгүй эвдэрсэн газрын тооллого, судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулж, нөхөн сэргээлтийг үе шаттайгаар хийх,	2021 - 2024	2 10 га	<p>Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмал олборлогч иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрын тооллого хийж нөхөн сэргээлтийн зардлыг тооцох ажлыг Дорнын байгаль ХХК-иар гүйцэтгүүлж 77 байршилд 599 га талбай бүртгэн мэдээллийн санд оруулсан.</p> <p>Тус аймгийн Айраг, Даланжаргалан, Өргөн, Иххэт сумын нутагт уул уурхайн олборлолт, баяжуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Мин ли да ХХК, Монголын алт ХХК, Фриенд шип ресурс ХХК, Билэгт баялаг ХХК, Монголиан флюор спар ХХК, Чулуун завод ХХК, Ачир ХХК, Пауэрлэнд ХХК, Тэнүүн байгаль ХХК, Ялгуун интернэшнл ХХК, Монцемент Баянтэгш ХХК, Хөхбишрэлт ХХК-иуд нь "Яшил", "Майхан дэл" , "Хөх өндөр", "Хонгор", "Баруун бурхант", "Сээрийн булаг", "Хар толгой", "Хавцгай", Баруун хошуу нэртэй газруудад 14.18 га талбайд 46139,5 мян төгрөгийн зардлаар эзэнгүй орхигдсон газарт дүйцүүлэн хамгаалах зорилгоор техникийн нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэн өгч актаар баталгаажуулсан байна.</p>	70%
258		290. Уул уурхайн олборлолт болон төмөр зам, автозам,	2021 - 2024	100%	<p>Тус аймгийн Айраг, Даланжаргалан, Өргөн, Иххэт сумын нутагт уул уурхайн олборлолт, баяжуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Мин ли да ХХК, Монголын алт ХХК,</p>	70%

		барилга байгууламж барихтай холбоотой эвдэрсэн газруудыг нөхөн сэргээх			<p>Фриенд шип ресурс ХХК, Билэгт баялаг ХХК, Монголиан флюор спар ХХК, Чулуун завод ХХК, Ачир ХХК, Пауэрлэнд ХХК, Тэнүүн байгаль ХХК, Ялгуун интернэшнл ХХК, Монцемент Баянтэгш ХХК, Хөхбишрэлт ХХК-иуд нь "Яшил", "Майхан дэл", "Хөх өндөр", "Хонгор", "Баруун бурхант", "Сээрийн булаг", "Хар толгой", "Хавцгай", Баруун хошуу нэртэй газруудад 14.18 га талбайд 46139,5 мян төгрөгийн зардлаар эзэнгүй орхигдсон газарт дүйцүүлэн хамгаалах зорилгоор, Хатанбулаг суманд Их харгуйн зам ХХК төмөр замын бүтээн байгуулалтад ашигласан 11.65 га талбайд 104000.0 мян.төгрөгийн зардлаар техникийн нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэн өгч актаар баталгаажуулсан.</p> <p>Хатанбулаг сумын Агаруут, Эргэл багийн нутагт Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 484.4км хүнд даацын авто зам байгуулах төслийн ажилд ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалын 8 карьерийн 11.6 га талбайн нөхөн сэргээлтийг сумаас ажлын хэсэг ажиллан хүлээн авсан. Хатанбулаг сумын Агаруут, Эргэл багийн нутагт Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 484.4км хүнд даацын авто зам байгуулах төслийн ажилд ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалын 8 карьерийн 11.6 га талбайн нөхөн сэргээлтийг сумаас ажлын хэсэг ажиллан хүлээн авсан. Цагдаагийн газраас 2021-2024 оны эхний 6 сарын байдлаар нөхөн сэргээлтийн ажлыг зохих журмын дагуу хийгээгүй орхиж явсан байж болзошгүй 8 гомдол мэдээллийг Цагдаагийн газрын тоо бүртгэлд оруулан хэрэг бүртгэлтийн хэрэг нээн мөрдөн шалгах ажиллаа явуулж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд холбогдох ажиллагааг явуулж, ажилласан.</p> <p>Үүнээс: Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг зохих журмын дагуу хийлгэсэн болон хийгдэж байгаа 15 талбай буюу 709.21 га газар байна.</p>	
259	5.1.8.. Сайн дурын байгаль хамгаалагчдыг дэмжиж, байгаль орчны чиглэлээр ажиллах иргэд, олон нийтийн оролцоог идэвхжүүлнэ.	291. Иргэдэд экологийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлэх	2021 - 2024	3 80000	<p>Байгаль орчныг хамгаалах чиглэлээр Байгаль зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг WCS-ийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран хулган антай тэмцэх, төсөл амьтдад ээлтэй төмөр зам төслүүд, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх чиглэлээ Япон улсын Нийгата мужийн Гадаадтай технологийн талаар хамтран ажиллах нийгэмлэгийн санхүүжилтээр "Гүн суулган тарих аргаар Дорнын говийн цөлөрхөг бүсийн хуурай хүйтэн газар нутгийг</p>	100%

					<p>ургамалжуулах үйл ажиллагааг дэмжих техникийн хамтын ажиллагаа төсөл"-үүд амжилттай хэрэгжиж байна.</p> <p>"Биологийн олон янз байдлыг хамгаалах, хулгайн антай тэмцэх" чиглэлээр 5 удаагийн арга хэмжээ, "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох" чиглэлээр 2 удаагийн арга хэмжээ, "Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах"-ын чиглэлээр 30 удаагийн арга хэмжээ, "Усан орчныг хамгаалах, бохирдохоос сэргийлэх" чиглэлээр 3 удаагийн арга хэмжээ, Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх мод тарих чиглэлээр 5 удаагийн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж, байгаль орчны салбарын үйл ажиллагааны талаар цахим болон танхимын нийт 129 сургалт, нөлөөллийн ажилд давхардсан тоогоор 85,0 мянга орчим хүн мэдээлэл авсан.</p> <p>"Тогтвортой зэрэгцэн оршихуй", "Мод тарих, арчлан хамгаалах", "Зочлох үйлчилгээний стандарт", "Усны зохистой хэрэглээ", "1000 сургагч багш бэлтгэх" зэрэг сургалтуудад давхардсан тоогоор 700 гаруй иргэн оролцож, "Биологийн олон янз байдлыг хамгаалах, хулгайн антай тэмцэх", "Амьтны экологи эдийн засгийн үнэлгээ", "Хамарын хийд", "Их нартын байгалийн нөөц газар", "Бүрдэнэ булаг"-ийн танилцуулга зэрэг цахимд мэдээллийг 24872 хүн үзэж сонирхсон байна</p>	
260		292. Сайн дурын идэвхтэн байгаль хамгаалагчдыг ажиллуулж, урамшуулах	2021 - 2024	20 80%	<p>Аймгийн хэмжээнд улс болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг сайжруулах зорилгоор 31 байршил газрын 584037.51 га талбайг эзэнжүүлж 55 иргэнийг идэвхтэн байгаль хамгаалагч томилон ажиллуулж, Иххэт, Өргөн, Эрдэнэ, Хатанбулаг, Мандах сумдын ан агнуурын бүс нутгийг иргэдийн нөхөрлөлийн гишүүд, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн 92 малчин өрх, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн 1017 малчдад Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 110 дугаар тушаалаар батлагдсан "Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, ажлын үр дүнгээр нь урамшуулах тухай журам"-ыг танилцуулсан.Аймгийн тусгай хамгаалалттай нэр бүхий 32 газар, сумын тусгай хамгаалалттай 71 газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад бүртгэлтэй байдаг.</p> <p>Уг тусгай хамгаалалттай газар нутгуудын хамгаалалтыг сайжруулах зорилгоор нийт 61 иргэнийг идэвхтэн байгаль хамгаалагчаар томилон ажиллуулж байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт орших улсын тусгай хамгаалалттай "Бүрдэнэ булаг БНГ"-т 1, Сайншанд</p>	90%

					сумын нутаг дэвсгэрт орших "Хамарын хийд" орчмын орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг хариуцан ажиллах 1 иргэнийг идэвхтэн байгаль хамгаалагчаар тус тус томилон ажиллуулж байна.	
261	5.1.9. Аймгийн Тусгай хамгаалалттай газар нутгийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж, газар нутгийн хэмжээг нэмэгдүүлнэ.	293. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг 32 хувьд хүргэж, холбогдох мэдээллийн санд бүртгүүлэн баталгаажуулж, хамгаалалтыг сайжруулах	2021 - 2024	32% 10	<p>Аймгийн хэмжээнд улсын тусгай хамгаалалттай нэр бүхий 15 газар 811024.36 га, аймгийн тусгай хамгаалалттай нэр бүхий 32 газар 665360,95 га, сумын тусгай хамгаалалттай нэр бүхий 64 газар 2048454,1 га аймгийн нийт нутаг дэвсгэрийн нийт 32.2 хувийг эзэлж байгаа нь тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь 0,69 хувиар өссөн байна.</p> <p>Улаанбадрах, Мандах, Иххэт, Сайншанд, Даланжаргалан, Хатанбулаг сумдын улс, орон нутгийн тусгай хамгаалалттай 36 байршил газрыг 22,8 сая төгрөгийн санхүүжилтээр тэмдэгжүүлсэн. Тусгай хамгаалалттай 31 газрын 584037.51 га талбайг эзэнжүүлэх, хамгаалалтыг сайжруулах зорилгоор 55 идэвхтэн байгаль хамгаалагч томилсон.</p> <p>Аймгийн хэмжээнд улсын тусгай хамгаалалттай нэр бүхий 15 газар, орон нутгийн тусгай хамгаалалттай нэр бүхий 103 газар тусгай хамгаалалттай газар нутгийн бүртгэлд бүртгэлтэй байна.</p> <p>Замын булаг, Хонгил цав, Бор өндөр, Хоёр зааны хөндий, Бор овооны тал зэрэг экологийн хувьд ач холбогдолтой газруудыг 122247 га талбайг тусгай хамгаалалтад авахаар төлөвлөн ажиллаж байна.</p>	90%
262		294. Газар доорх усны орд, усан сан бүхий газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах	2021 - 2024	-	<p>Сайншанд сумын нутаг дэвсгэрийн усан хангамжийн эх үүсвэр болох Зээгийн хөтлийн газрын доорх усны ордын тэжээгдлийн мужийг усан сан бүхий байгалийн нөөц газрын ангиллаар 5817.45 га талбайг аймгийн тусгай хамгаалалтад, Алтанширээ сумын Хайлсан шанд, Холбоогийн уул, Баянбуурал нэртэй 28476.23 га газрууд нийт 4 байршил газрын 34293.68 га талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын бүртгэлд бүртгүүлсэн.</p> <p>Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргаа, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаанаас усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуй бүс, ус хангамжийн эх үүсвэрүүдийн тэжээгдлийн мужийн зааг, зураглал, холбогдох мэдээлэл, судалгааг шинэчлэн тогтоож 13 сумдын нутагт 69 булаг, 84 нуур тойром, 1 гол ашигт малтмалын ашиглалтын 27, хайгуулын 40</p>	90%

					тусгай зөвшөөрлийн талбайтай давхцалтай байгааг гаргаж Усны тухай хуулийн 22 дугаар зүйл, “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн хүрээнд тусгай зөвшөөрлийн талбайгаас хэсэгчлэн хасах тухай мэдэгдлийг 67 компанид хүргүүлсэн. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрт тогтоох онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийн зааг, эдгээр бүсэд мөрдөх дэглэмийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар төлөвлөж байна.	
<b>6. Орон нутаг, хөдөөгийн хөгжил</b>						
263	Орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	Зарим сумдын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах буюу өөрчлөлт оруулах.	2021 - 2024	1	<p>Айраг сумын 2040 он хүртэлх хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 62.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Инженер геодези” ХХК гүйцэтгэж сумын ИТХ-ын 2022.12.14-ны өдрийн 08/05 дугаартай тогтоолоор ерөнхий төлөвлөгөөг баталсан.</p> <p>Өргөн сумын 2040 он хүртэлх хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 34.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Тэнжин” ХХК гүйцэтгэж, 380 га газрыг хамруулан төлөвлөлтийг хийж байна.</p> <p>Орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тус сумын 7 багийн нутаг дэвсгэрт 337.7 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг “Инженер геодези” ХХК нь гүйцэтгэж хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 2022 оны аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит X хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.</p> <p>Орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хатанбулаг сумын Ханги хилийн боомтын суурьшлын бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 245 га газарт аймгийн Засаг дарга, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, орон нутгийн удирдлага, мэргэжлийн байгууллагууд, иргэдийн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулан холбогдох саналыг тусгаж, Барилга, хот байгуулалтын яамны мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.</p> <p>Орон нутгийн хөгжлийн сангийн 121 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Улаанбадрах сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд “Ланд-Овнер” ХХК, Орон</p>	90%

					нутгийн хөгжлийн сангийн 191 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хатанбулаг сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд "Голден мэл" ХХК, Орон нутгийн хөгжлийн сангийн 35 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд "Голден мэл" ХХК, Орон нутгийн төсвийн 60 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Иххэт сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажилд "Инженер геодези" ХХК тус тус шалгарч гэрээ байгуулах эрх олгогдоод байна.	
264		Сайншанд, Замын-Үүд сумдын суурьшлын бүсэд хот хөгжлийн хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулж, дахин төлөвлөлтийг үе шаттайгаар хэрэгжүүлэх.	2021 - 2024	-	<p>-Орон нутгийн төсвийн 126.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тус сумын 7 багийн нутаг дэвсгэрт 337.7 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг “Инженер геодези” ХХК гүйцэтгэж тус төлөвлөгөөг 2022.12.04-ний өдрийн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит X хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд Сайншанд сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт шинэ суурьшлын бүс байгуулж Мандах наран-5 орон сууцны хорооллын эхний ээлжийн 384 айлын орон сууцны 6 блок орон сууц баригдаж ашиглалтад оруулсан ба тус сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт 0.9 га талбайд гэр хорооллыг дахин төлөвлөлтөд оруулан орон сууцны хороолол барьж байна.</p> <p>Саран хөхөө театрын барилга угсралтын ажил 60 хувийн гүйцэтгэлтэй баригдаж байна. Түүнчлэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 2024 онд орон нутгийн төсвийн 250.0 сая төгрөгийн хөрөнгөөр Төрийн үйлчилгээний нэгдсэн цогцолборын зураг төсөл боловсруулах тендерийн ажлыг зарласан, улсын төсвийн 2025 оны төсөвт 400 хүний суудалтай спортын ордон барихаар зураг төслийг боловсруулж байна. Замын-Үүд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2030 он хүртэл хугацаатайгаар төлөвлөгдсөн.</p> <p>Энэхүү ерөнхий төлөвлөгөөг үндэслэн 3 дугаар багт 48 га талбайд шинэ суурьшлын бүс байгуулахаар шийдвэрлэж, 2017 онд “Нийслэлийн зураг төсвийн хүрээлэн” ХХК-д хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг боловсруулсан. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайн хэсэгт 50, 150 хүүхдийн цэцэрлэг, Иргэдийн хөгжлийн төвийн барилгууд</p>	100%

					баригдсан ба Соёл урлагийн ордон, 640 хүүхдийн сургууль, Өрхийн эмнэлгийн барилгуудыг барьж байна. Түүнчлэн Замын-Үүд сумын газар зохион байгуулалтын 2024 оны төлөвлөгөөнд дээрх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 3 га газрыг орчин үеийн стандартын шаардлага хангасан 116 айлын амины орон сууцны хорооллыг барихаар төлөвлөж, газар олголтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.	
265	Сумдад "Тэгш гудамж" төсөл хэрэгжүүлнэ	2022 - 2024			Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 04/01 тогтоолоор гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулах дахин төлөвлөх, төсөл хэрэгжүүлэх газрын байршлыг баталсан. Сайншанд сумын 7-р багийн нутаг дэвсгэрт шинээр суурьшлын бүс үүсгэх ажлын хүрээнд нисэхийн хэсэгт 317 өрхийн 30.37 га газарт дахин зохион байгуулж, ОНТөсвийн нийт 12.22 тэрбумын хөрөнгө оруулалтаар дулаан станц, цэвэр, бохир усны шугам, 1.59 км автозам, Өлзийт хорооллын айл өрхийг цахилгаанд холбох ажлыг гүйцэтгэж, инженерийн шугам сүлжээнд холбогдсон нам болон өндөр давхрын орон сууцыг барих нөхцлийг бүрдүүлсэн. Замын-Үүд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2030 он хүртэл хугацаатайгаар төлөвлөгдсөн "Тэгш Гудамж" төслийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Ди Вай Кей Би" ХХК шалгаран гүйцэтгэж байна. Замын- Үүд сумын Хилчин багт байрлах Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн урд талын хатуу хучилттай засмал замаас Хилчин багийн БОС-ын гудамж хүртэл 730 метр асфальт бетон хучилттай замыг хийсэн. Одоогийн байдлаар явган зам, ногоон байгууламж хашлага, тэмдэг тэмдэглэгээ хийх ажлууд үргэлжилж гүйцэтгэл 70 хувьтай байна. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайн хэсэгт 50, 150 хүүхдийн цэцэрлэг, Өрхийн эмнэлэг, Иргэдийн хөгжлийн төвийн барилгуудыг барьж ашиглалтад оруулсан ба 1 км автозам, 2.6 км дугуйн зам барих ажил хийгдсэн. Улсын төсвийн хөрөнгөөр тухайн байршилд 500 хүний суудалтай Соёл урлагийн ордоны барилга угсралтын ажил 90 хувь, 640 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй баригдаж байна.	70%
266	Сайншанд суманд "Шинэ найрамдал" суурьшлын бүс	2023 - 2024		80.0	ОНТ-ын 150,000.0 төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 1, 2, 3, 4, 6, 7, 8 дугаар багуудад хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлуулан. Дорноговь аймгийн Иргэдийн	90%

		байгуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлуулах.				<p>төлөөлөгчдийн хурлын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 11/13 тоот "Дахин төлөвлөлтийн газрын байршил, хэмжээ, хил зааг, зориулалтыг тогтоох тухай тогтоолоор Сайншанд сумын 7 дугаар багт Найрамдал хэсэгт 16.7га газар дахин төлөвлөлтөнд оруулах баталсан.</p> <p>Сайншанд сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу "Шинэ найрамдал" суурьшлын бүсэд 960 хүүхдийн суудалтай сургууль, 150 хүүхдийн цэцэрлэг, 1500 айлын орон сууцны хорооллыг төлөвлөөд байна.</p> <p>Сайншанд 7-р баг "Гор газ" ШТС-ын уулзвараас баруун тийш үргэлжлэх 1.59 км автозам, Сайншанд 7-р баг "Мандах наран-4" хороолол хүртэлх 0.141 км автозамуудыг барьж ашиглалтад орууллаа.</p>	
267		"Хашаандаа сайхан амьдаръя" санаачлагын хүрээнд амины орон сууц, гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг төр, хувийн хэвшлийн санхүүжилтээр хийх ажлыг үргэжлүүлэх.	2021 - 2024		50	<p>2023 онд Орон нутгийн төсвийн 647,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 6-р багийн гэр хорооллын гудамжаар цэвэр усны шугам татах, 4 дүгээр багийн гэр хорооллын гудамжинд цэвэр усны шугам татах, 8 дугаар багийн Үзүүрийн гудамжны цэвэр усны шугам татах, Алтанширээ сумын төвийн нийтийн орон сууцыг гадна дулаан цэвэр усны шугамд холбох ажлуудыг "Ингүүмэл-Оргил" ХХК, "Чандмань-Илч" ХХК, "Ивээлт баян буурал" ХХК-ууд гүйцэтгэж ашиглалтад оруулсан.</p> <p>Шинээр баригдсан инженерийн шугам сүлжээнд 162 айл өрх холбогдох боломж бүрдсэн ба одоогоор 64 айл холбогдоод байна. ОНТ-ийн 816.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Улаанбадрах сумын нэгдсэн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээний ажлыг "Түрүү гарав" ХХК гүйцэтгэж байна. Уг инженерийн шугам сүлжээ ашиглалтад орсноор 8 орон сууцны 31 айл төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох боломж бүрдэнэ.</p> <p>2024 онд төсвийн хөрөнгө оруулалтаар инженерийн шугам сүлжээний 31 төсөл арга хэмжээг 16,4 тэрбум төгрөгийн өртөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд: Мандах сумын төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ байгуулах ажил, Хөвсгөл сумын ЕБС-ийн багш ажилчдын байрны 4 айлын орон сууцны барилгад халаалт, цэвэр, бохир усны шугам шинээр хийх ажил, Айраг сумын Уурхайчин байранд сангийн шугам шинэчлэх, Өргөн суманд гэр хороололд дулаан цэвэр усны шугам татах зэрэг ажлууд багтсан болно. 2024 оны эхний хагас жилийн байдлаар Сайншанд сумын гэр хорооллын 31</p>	100%

					өрх, Замын-Үүд сумын 45 айл дулаанд, цэвэр бохир усны шугам сүлжээнд холбох техникийн нөхцлийг олгосон.	
268	Хот, суурин газруудад үерийн ус зайлуулах сувагчлалыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.	2022 - 2024		100% 0,5 км	<p>Хот, суурин газруудад үерийн ус зайлуулах сувагчлалыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх ажлын хүрээнд Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН3388 төсөл, Барилга хот байгуулалтын яам болон “Комфорт импекс” ХХК-ийн хооронд байгуулсан “Дорноговь аймгийн Цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээ”-ний ажил гүйцэтгэх А1.2.2-2021/84 дугаартай гэрээнд 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр “Дорноговь аймгийн Сайншанд сумын үерийн хамгаалалтын барилга байгууламж, замын ус зайлуулах шугамын ажил”-ыг санхүүжилтийг 640.6 сая төгрөг болгож ажлын тоо хэмжээг өөрчилж баталсан.</p> <p>Сайншанд сумын 1, 6-р багийн нутаг дэвсгэрт 520 м урттай борооны ус зайлуулах шугам хоолой, 380 м урттай үерийн хамгаалалтын суваг хийх ажлыг "Компорт импекс" ХХК хийж гүйцэтгэж дуусган 2022 оны 12 дугаар сард ашиглалтад оруулсан.</p> <p>2023 онд Сайншанд сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэр төв цэнгэлдэх хүрээлэн орчимд 1.3 км шуудуу, 104 м үерийн усны авто замын суваг, авто замын доорх ус зайлуулах хоолойг байгуулах ажлыг орон нутагт барилга бүтээн байгуулалт хийж буй ААН-үүд нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран гүйцэтгэсэн.</p> <p>Аймгийн төвийн нэгдсэн асрамжийн газрын орчимд үерийн усны далан барих ажлыг орон нутгийн төсвийн 107.8 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгүүлэхээр тендер шалгаруулалтыг зарлаад байна.</p> <p>2024 онд Сайншанд сумын хэмжээнд нийт 2885 га газрыг үер усны эрсдэлгүй, эрүүл, аюулгүй бүс болгох автозам, талбайн усыг зайлуулах, шугам сүлжээ, үерийн хамгаалалтын барилга байгууламжийн суурь судалгааны баримт бичгийг боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаад байна.</p>	100%
269	Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг сайжруулах,	2021 - 2024			<p>Сайншанд сумын 4, 7 дугаар багт төмөр замын гармаас Оргил худалдааны төвийн уулзвар хүртэл 2.4 км автозамд гэрэлтүүлэг шинээр хийх ажлыг 494.0 сая төгрөгөөр “Лэдсити” ХХК, Сайншанд сумын 7-р багт энэ онд 509, 509а байрны нийтийн эзэмшлийн талбайд бетон авто зогсоол байгуулах ажлыг 256.4 сая төгрөгөөр “Айсуй хөгжил” ХХК энэ онд тус тус хийж гүйцэтгэсэн.</p>	100%

		тохижуулах ажил хийнэ.			<p>2021 онд Сайншанд сумын 4-р багийн 34-36, 43-44, 87-91, 93-94-р байруудын дулааны шугам сүлжээ угсрах ажил 170.0 сая, 2022 онд Сайншанд сумын 4 дүгээр багийн нутагт 154 дүгээр байрны дээврийн засвар, 2021 онд Сайншанд сумын 6 дугаар багийн Чойлонгийн гудамжинд цэвэр, бохир усны төв шугам татах ажил 166.7 сая, Сайншанд сумын 3-р багийн гэр хорооллын гудамжаар 1050 м цэвэр, бохир усны шугам 82.4 сая төгрөг, 2022 онд Мандах наран хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажил 3.9 тэрбум, “Саран хөхөө” театр, “Мандах наран-5” орон сууцны хорооллын гадна дулаан, цэвэр ус, бохир усны шугам сүлжээний ажил 2.3 тэрбум, цахилгаан хангамж, дэд станцын 622.3 сая төгрөгөөр тус тус гүйцэтгэсэн.</p> <p>Алтанширээ суманд Спорт заал барих ажлыг гүйцэтгүүлэхээр 2024 оны төсөвт 2.0 тэрбум төгрөг тусгасан. Сум, суурин доторх авто зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, гудамж гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 9,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 15 байршилд 300 гаруй машины багтаамжтай авто зогсоол шинээр байгуулсан.</p> <p>Улсын болон орон нутгийн төсвийн 22,7 тэрбум төгрөгийн санхүүжилтээр аймгийн хэмжээнд нийт 29,7 км авто зам, 1,4 км дугуйн болон явган хүний замыг шинээр барьж Сайншанд-Хамарын хийд чиглэлийн автозамыг нөхөж, сэргээн засварлах ажлыг гүйцэтгэсэн. Зам, талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх зорилгоор 2023 онд Замын-Үүд суманд 170м авто зам дагуу гэрэлтүүлэг, Сайншанд суманд 2.4 км авто замын дагуу 494.0 сая төгрөгөөр гэрэлтүүлгийн ажил хийсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд 9 байршилд тоглоомын талбай болон нийтийн эзэмшлийн талбайг байгуулан тохижуулж иргэд зорчигчдын эрүүл, аюулгүй орчинд зорчих, нийтийн эзэмшлийн талбайн ашиглалт, өнгө үзэмж сайжрах, хөдөлгөөний аюулгүй байдал, иргэд дасгал хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх боломжийг бүрдүүлсэн.</p>	
270	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөтөлбөр, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг	Шилжин ирэгсэдийг дэмжсэн "Нээлттэй аймаг" хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх	2023 - 2024		<p>МУЗГ-ын 2022 оны 419 дүгээр тогтоолын хүрээнд АЗД-ын 2022 оны А/649, 2023 оны А/01, А/235, А/595 дугаар захирамжуудыг баталж, нийт 3 ажлын хэсэг байгуулан ажиллав.</p> <p>Аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/649 дүгээр захирамжаар "Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллах, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсэг" байгуулж, аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулан, агентлаг, байгууллагын 39 удирдлага холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан баталсан.</p>	90%

	сааруулах газрын хэрэгжүүлнэ.	Засгийн бодлогыг				<p>Тус ажлын хэсэг сум, агентлаг, төсөвт байгууллага, иргэний нийгмийн байгууллагад нөхцөл байдлын үнэлгээ хийж, судалгаа, санал авч нэгтгэн "Нээлттэй аймаг" хөтөлбөрийг боловсруулан, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11/01 дүгээр тогтоолоор "Нээлттэй Дорноговь аймаг" зорилтот хөтөлбөрийг батлуулсан.</p> <p>Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 5 зорилт 90 арга хэмжээтэйгээр боловсруулан баталж, 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажиллав. 2024 оны хагас жилийн байдлаар 789 иргэн Дорноговь аймагт шилжин ирсэн байна.</p>	
271			Орон нутагт иргэдийг шилжин суурьшихад дэмжих, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	2023 - 2024		<p>Аймгийн Засаг даргын 2023 оны А/595 дугаар захирамжаар "Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших аж ахуйн нэгж, иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг эрчимжүүлэн ажиллах ажлын хэсэг"-ийг байгуулан ажиллав.</p> <p>Тус ажлын хэсэг "Нээлттэй аймаг" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд Түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлж, АИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 12/02, 12/03 дугаар тогтоолуудаар "Дорноговь аймгийн зорилтот бүлгийн иргэдийг түрээслээд өмчлөх орон сууцанд хамруулах журам", "Түрээсийн орон сууцны сум, баг, байгууллагад олгох хувь хэмжээ"-г батлуулсан. Дээрх тогтоолуудын хүрээнд Түрээсийн орон сууц хөтөлбөрийн 1 дүгээр ээлжид 105 айлын орон сууцыг зорилтот бүлгийн иргэдэд, журмын дагуу олгосноос ХБИ-7, ахмад-11, Өрх толгойлсон эх, эцэг-2, Олон хүүхэдтэй гэр бүл-6, Залуу гэр бүл-10, эмч, сувилагч, асрагч-14, сургуулийн багш-16, цэцэрлэгийн багш-15, малчин-17 байна. Үүнээс 45 төрийн албан хаагч түрээсийн орон сууцанд хамрагдаж, аятай тухтай ажиллаж, амьдрах боломжтой болсон. Улаанбаатар хотоос нарийн мэргэжлийн 8 эмч, 3 багшийг орон нутагт урин, 5 жил тогтвор суурьшилтай ажиллуулахаар гэрээ байгуулан, тус бүр 45-54 кв орон сууцыг үнэ төлбөргүй олгоод байна.</p> <p>"Алсын хараа-2050" Монгол улсын Засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлогын "Хөдөөгийн сэргэлт" зорилтын хүрээнд орон нутагт шилжин суурьшсан иргэдэд ипотекийн зээлийг 2023-2024 онд нийт 28 хүнд 2.4 тэрбум төгрөгийг олгосон.</p>	100%
272	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт		Аймгийн хөгжлийн тэргүүлэх бодлого,	2023 - 2024		<p>"Сайншанд сумын газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар тусгагдсан нийт 43 нэгж талбарыг нийслэлээс хөдөө орон нутагт шилжин</p>	90%

<p>хугацааны хөтөлбөр, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулах Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлнэ.</p>	<p>чиглэлд тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг хангах, уул уурхайн үйлдвэрлэлийг дэмжих, газар зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар шилжин суурьшигчдын тоог нэмэгдүүлэх</p>			<p>суурьсан 7 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар эзэмшүүлсэн бол 6 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлсэн.</p> <p>Мөн сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэлийн зориулалтаар тусгагдсан 126 нэгж талбараас 45 нэгж талбарыг иргэн, хуулийн этгээдэд олгосон.</p> <p>Мөн барилгын салбарын төрийн болон төрийн бус байгууллагууд, зураг төсөл зохиогч, барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 50 гаруй аж ахуйн нэгжүүдийг хамруулсан "Нээлттэй Дорноговь-Барилга, орон сууц" үзэсгэлэнгийн арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулах ажлын хүрээнд Дорноговь аймагт ажиллаж амьдарч байгаа боловч шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгээгүй ажилтан албан хаагчдын судалгааг байгууллагуудаас авсан.</p> <p>Хүн амын тоог нэмэгдүүлэх, тэдгээрийг таатай нөхцөлөөр хангах зорилгоор аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд орон нутгийн инновацын хөгжлийг дэмжих төвийн барилгын зураг төсөв хийх, инженер программчлалын цогц хөтөлбөрийг боловсруулах зэрэг ажлуудыг нийт 125,0 сая төгрөгөөр хийхээр тусгасан.</p> <p>Аймагт тайлант хугацаанд бусад аймаг, Улаанбаатар хотоос 789 хүн шилжин ирсэн байна.</p>	
--	--	--	--	--	--

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Н.ХОНГОРЗУЛ

ТАЙЛАН ХЯНАСАН:  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ДАРГА

У.ШИНЭЧИМЭГ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

А.БАДРАЛ